

Эрдэнэ бандида Зая Гэгээдийн намтар цадиг

НОГООН ДЭВТЭР

Дөрөвдүгээр цуврал

Түвд судраас орчуулан эмхэтгэсэн
Монголын Бурханы Шашинтаны Төв Гандан хийдийн гавж
Доктор, Ph/D нэрийг зүүгч Ц.Отгонбаяр

Улаанбаатар, 2014 он

Хянасан: Ц.Бямбаа
Д.Саруул
П.Яньдий
П.Цэвэгмид
Г.Жалсрайжамц

Эх бэлтгэсэн: О.Ширавжамц
О.Ширавсингэ
Ж.Дагийжанчив
Ч.Мандалсүрэн

Printed for free distribution by

The Corporate Body of the Buddha Educational Foundation

11F, No. 55, Sec. 1, Hang Chow South Road, Taipei, Taiwan, R.O.C.

Tel: 886-2-23951198 , Fax: 886-2-23913415

Email: overseas@budaedu.org

Website: <http://www.budaedu.org>

Mobile Web: m.budaedu.org

This book is strictly for free distribution, it is not to be sold.

ЗАРЖ БОРЛУУЛАХЫГ ХОРИГЛОНО

АГУУЛГА

УЯЛГА ҮГ	5
АНХДУГААР ХУВИЛГААН ЖАНСИМЖАМБА БУЮУ МАЙДАРЫН ГЭГЭЭН ..	7
ХОЁРДУГААР ХУВИЛГААН ЧОЙЖАЛНЯНАНМЭД БУЮУ АШОКА ХААН	31
ГУРАВДУГААР ХУВИЛГААН ТОВУУ САМБУУ БУЮУ ВАБА САМУУ ТЭРГҮҮН ...	89
ЭНЭТХЭГТ ХУВИЛСАН ДӨРӨВДҮГЭЭР ХУВИЛГААН ШУБАМГАРА ТЭРГҮҮН	91
ТАВДУГААР ХУВИЛГААН ИХ БАНДИДА РАДНААСЭДИ	95
ЗУРГААДУГААР ХУВИЛГААН ЛОДОЙРАВДАН	98
ДОЛООДУГААР ХУВИЛГААН СОДНОМБАЛДУЙ	102
НАЙМДУГААР ХУВИЛГААН ВАНЧИН ЧОГЛАЙ НАМЖИЛ ИХ БОГД	106

ЕСДҮГЭЭР ХУВИЛГААН САЙН НОЁН ХАН ХӨНДЛӨН ЦОХҮР	110
АРАВДУГААР ХУВИЛГААН ХАЛХЫН ЗАЯ БАНДИДА ЛУВСАНПЭРЭНЛЭЙ	115
АРВАННЭГДҮГЭЭР ХУВИЛГААН ЛУВСАННЯНДАГ	183
АРВАНХОЁРДУГААР ХУВИЛГААН ЗАЯ ЛУВСАНЖИГМЭДДОРЖ	191
АРВАНГУРАВДУГААР ХУВИЛГААН ЛУВСАНЖИГМЭДНАМЖИЛ	196
АРВАНДӨРӨВДҮГЭЭР ХУВИЛГААН ЛУВСАНТҮВДЭНЧОЙЖИНЯМАА	202
АРВАНТАВДУГААР ХУВИЛГААН ЛУВСАНДАНЗАНПҮЛЖИНЖИГМЭД	210

УЯЛГА ҮГ

Эрхэм хүндэт уншигч номын нөхөр та бүгдийн амгаланг айлтган мэндчилье.

Энэ удаагийн ногоон дэвтэр дөрөв хэмээхүй номоороо Эрдэнэ зая бандида гэгээнтний арвантаван дүрийн намтрыг олон жил цуглуулан байж энэ удаа түвд судраас орчуулан зарим нэгийг нь эмхэтгэтгэн гаргаж буй билээ. Голчилон Ганжуурваа номын хаан Лувсанцүлтэмийн бичсэн Эрдэнэ Зая бандида Лувсанпэрэнлэй гэгээний түвд намтар Хот мандал далайн эзэн очир баригч Зая бандида Лувсанпэрэнлайбалсамбуугийн намтар жишээн бодролыг нийтэд хураангуйлан толилуулахуй хэмээх дөчин дөрвөн бүлэг наян хоёр цаас гар бичмэл сударыг монгол уруу орчуулан анх удаа нийтлэж буй бөгөөд тэрхүү намтар болон Гэгээнтний өөрийнхөө намтрыг өөрөө бичсэн ранги хоржүрцүл буюу миний орчилонд бядан явахуй гэх намтрыг үзэж байхад Майдарын таван номын аймгийг үзэж судлах үед дээд төрлийн багцаг сэргээд гэж гардаг бөгөөд Банчин эрдэнэ, Далай лам нарын түвд хэл дээр зохиосон түнрэв солдэв буюу төрөл тутмын залбирлуудад ч Бурханы гэгээнд алтан элс өргөж бодь сэтгэлийг үүтгэсэн жамва хэмээн гардаг Мөн Архангайн хөгшчүүл Майдар чулуу хэмээх Майдарыг олон зуун жил дамжуулан тахидаг, Хүндлүн Цүхүр ноёны гүдүн шарилаас гарсан А үсэг хорол Цагаан дун тэргүүтнийг жарайн дуганы Майдар бурханы сүншигт хийсэн ба 13-р Далай ламын гэвш нар номгүй дорд газар гэж басамжилахад Гэсгүй нь бид жалбаан авын буюу 5-р Далай ламын жаяг дүрэмтэй газар гэсэнд тэд нар үзүүл хэмээн шаардсанд гэсгүй Майдар бурханы сүншигт байгаа гэсэнд үзнэ хэмээн давшлах зуур Майдар бурханаас авиа гарч хөлөрсөнд тэд дороо мөргөж уучлал хүсэн “Танай гэгээн аргагүй Майдарын хувилгаан юмаа” гэсэн гэдэг. Бас Дээрхийн гэгээн 14-р Далай ламын намжил дацангийн хансүр Жүдо Дацангийн лама унзад Жадо ренбучи тэргүүн бээр ч Банчин болон Далай ламын түнравт гарч байхад яалтгүй анхны дүр Майдарын бүрүлваа гэсэнчилэн Майдарын товч намтрыг бичсэн болно.

Улсын төв номын сангийн монгол номын хөмрөгт буй Зая гэгээдийн хураангуй намтрыг дүр болгонд эшлэн түүн дээр түнрэв солдэвүүдийг харгуулан дээр нь Лувсанпэрэнлэй гэгээний товч намтар хэмээх түвд бичмэл судрыг орчуулан дүрүүдэд нэмэн зүйн баяжуулж бичсэн болой энэхүү судрыг Нямдаваа захиралтай ЭКО констракшин компаниас жил бүр гандан хийдэд хуруулдаг балин адислагын хуралд зориулан лам нарт зэдлэхээр эрхлэн хэвлүүлэв.

Номын цагаан буян дэлгэрэх болтугай

*М.Б.Ш.Т Гандан хийдийн ар мөрний лам
гавж нэрийг хүлээгч Ц.Отгонбаяр.*

ЭРДЭНЭ БАНДИДА ЗАЯ ГЭГЭЭНТЭНИЙ ЭНЭТХЭГТ ХУВИЛСАН АНХНЫ ДҮР ЖАНСИМЖАМБА БУЮУ МАЙДАРЫН ГЭГЭЭН

Зарлигаар тогтоогдсон Монгол улсын гүн вангүүдийн сурвалж бичгийн халхын сайн ноён, засагт хан аймагийн хутагт хувилгааднуудын нэрс намтар хэмээхүй гэх босоо монгол бичгээр бичигдсэн бичигт: халхын сайн ноён хан аймагийн Зая бандида хутагтын уг гарвал ээц бичбээс Анх дүрийн нэр Галданшону эрт цагт энэтхэгийн газар Шагжамуни бурханы гэгээнд амьтаны тусыг бүтээнэ хэмээн эрдэнийн сайн сав, алтан элс өргөж бодь сэтгэлийг үүсгэж явсаны хойно гэж бичигдсэн бол

Ванчин Балдан -иш богд бээр түвд хэлдээр Балдан лхүндэвма гэх Зая гэгээнтэний төрөл тутмын залбиралыг зохиосон ба түүнээс Жансимжамба буюу Майдарын гэгээнийг үзүүлсэн найман мөртийг орчуулан бичвээс:

Цог төгөлдөр аяндаа бүтэх бүхэнд тодорхой номын агаараас
Цэлмүүн билигт өдрийг ургуулж үзүүлэгчийн үлгэрт
Хоёрдугаар бурхан цолыг эрхшээн буй Зонхава тэргүүт
Хосгүй чухаг дээд гуравын адистэд хурчилан бууг
Багшийн хэрэг бүгдийг ёсчилон бараа болооч
Бурханы мөрийг сахигч ойрын шавь бээр багшдаа
Маш баттай бодь сэтгэл үүтгэх элс өргөсөн

Майдарын гэгээн жансим жамбад залбирнам гэж айлдсан байдаг бол Зая бандида Лувсанняндаг гэгээнтэний төрөл тутмын залбиралыг эрхэм тойн, жамъяантунгалаг билигт, нарын айлтгалын дагуу Шагжаан гэлэн Лувсангалсанжамц бээр бодлын өөрийн өргөөнд бичэхдээ мөн Ванчин богдын бичсэн Зая гэгээний төрөл тутамын залбиралыг баталгаажуулан анхны дүрийг Бурхан багшийн шавь Жансим жамба буюу ойрын найман бодьсадба Майдар бурханы урд дүрийн хувилгаан хэмээжээ. Иймээс Ванчин богд Далай лам хоёрын айлдвар дагуу Майдарын гэгээний дамжлага дүрийн хувилгаан учир, Майдарын гэгээний намтрыг түвд эх “бодь мөрийн зэргийн дамжлагын багш нарын намтар” гэх Ёнзон-Ишжанцангийн бүтээл судраас орчуулан оруулсаныг толилуулбасу:

Майдарын гэгээний товч намтар:

Бурханы гэгээний айлдсан зарлигийг дагасан шавь нарыг багцлан хоёрт хуваавал агуу явдалын дамжлага буюу практик, гүн үзлийн дамжлага буюу онол болох бөгөөд практик буюу агуу явдалын дамжлага сэлтийн анхдугаар төлөөлөгч нь Майдарийн гэгээн болно. Бурхан багш замбуулинд Санжээ-Одсүрэн заларч байх үед Гандангийн тэнгэр нугуудад ном номлож байгаад Замбуулинд ялж тугуулгасан бурхан болж залрахдаа Живзанжамбии-янг гандангийн тэнгэр нугуудад ном номлох ажилаа орлуулан орхисон учир жалцав Мэпамгон хэмээн нэрийдэх болов. Майдарын гэгээний үүх түүхийг судалбал: “додэгалсан” хэмээх сударт бодьсадба жамбаа загарбардийн хаан Намбарнанзад гэж нэрийдэж байхдаа бурханыг их хүндэтгэлийн байдалтай шүхэртэй залан тахиж, эхлэн бодь сэтгэлийг үүсгэж байжээ. Гэсэн лүндэнчилэн олон галавийн өмнө Намнан гэх Загарбардийн хаан байхдаа тэр үед Замбуулинд заларч буй Ялж төгс нөгчигсөн Бурхан Тувачинбутай уулзан бараалхаж Бурхан дор шүхрэн тахил өргөсөн ээц огторгуйгаар дүүрэн хамаг амьтан дор асрал энэрэлийн дээдийг зохион хамаг амьтаныг орчилонгоос гэтэлгэнэ хэмээн бодийн дээд сэтгэлийг үүсгэжээ. Мөнхүү тоолош үгүй галавийн урьд живзүн жамба дөрвөн тивийг эрхшээсэн загар бардийн хаан Сэрдогжин хэмээхийн үед тугуулгасан Бурхан Сэрсэнод бодьсадва нөхөр тоолшгүй олон шарвагаан хуврага сэлт дор Хаан баян тансаг буян хүч ихтэй ба гучин гурван тэнгэрээс ч илүү баялаг болон төрөл үгүй байгуулахуй дор тахил өргөх болон өргөл хүндлэлийг наян жива жил доройтуулал үгүй үйлдэж бодь сэтгэлийг үүсгэжээ. Басхүү урьд энэ орчлон ертөнцөд Галбаа Зэнва хэмээх нэгэн гарчээ. Тэрээр дөрвөн тивийн бурханы оронд дөрвөн тивийн загар бардийн хаан Зэвжийн мүчид-нэрт болон алдаршжээ. Түүний өмнө Барамсайжамц дул хэмээх нэгэн гарчээ. Түүний хүү их төрөлхтөн 32 билиг шинж, 80-н лагшин найраг төгөлдөр үзэсгэлэнтэйгээс гадна зуун цагаан буяны тэмдэг гэрэл нь бээрийн газраас гэрэлтүүлэж “Ноёода” мэт юугаар хаасан ч нэвт гэрэлтдэг нэгэн мэндэлвээ.

Мэндэлмэгц тэнгэр олноор тахиж үйлдсэнээс далайн шим буюу Жамцонянбу хэмээн нэрийдэх болов. Тэрбээр өөр нэгэн цагт гэрээс магад гарч тойн хуврага болон үс гэзгээ авч ил шар номын баринтаг таалан ханьцашгүй үнэхээр туулсан бодийн сэтгэлийг

эрхшээн тэгүүнчилэн ирэгсэн Ренбучинянбуу гэх бурхан болоод номын хүрдийг эргүүлэн амьтан олон зуун мянгаар сая бумаар арилсан орон өндөр язгуурт гарган хувилгав.

Тэгээд Барамсай жанцадул хэмээх бээр Загарбардийн хаан Зэвмүчод лугаа өөрийн шавь барамсай рэгжүд язгуурт логдон тэргүүтэд дахин дахин хүсэж айлтган, тэгүүнчилэн ирэгсэн Рэнчиннянбу бурханы өмнө бодь сэтгэл үүтгэсэн болой. Тэр цагт Зэвжийн мүчод хаан бээр Рэнчиннянбу бурханы мэлмийн өмнө бодь сэтгэлийг үүсгээд их амгалант Диваажин орныг оюуныхаа оронд байгуулан тэгүүнийг бүтээхийн тухайд олон тоолошгүй галавт төгсгөн, боловсруулан, судлах гурвын ажил явдалыг эцэслэн зохиогоод Диваажин орныг бүтээн илт тугуулсан бурхан болсон болой. Барамсай жамцдүлжийн шавь барамсай язгуурт Логданда ч тэгүүнчилэн ирэгсэн бурхан Рэнчиннянбуугын өмнө бодь сэтгэлийг үүсгэв. Тэгүүнчлэн ирсэн Рэнчиннянбуу бурхан бээр сайн цагийн мянган бурхан залрах цагт дахин Бурхан болох бошго айлдаад өөр өөрийн орныг зорив. Эхлээд орчлон эвдрэхээс эхлэн эцэс Мойва Нанзад хүртэл бүгд бээр өөр өөрийн бурханы оронг номхотгох амар ариун галдуугаас хэрүүл тэмцэл зуун жил үе энэ хийгээд ирээдүйн наян мянган жилийн хоёрдугаар үе энэ бөгөөд тэрчүү хэрүүл тэмцэлт зуун жилийн энэ цаг ануу цэвүүн цаг дор хувирч амьтны нас богино болж эд эдлэл ховордож, өвчин элбэгшин ихэнхдээ цаг бусын үхлийн шалтгаанаар нас барж харанхуй догшин, ач хариулаг буруу хувьтай учирч буйг эдгээр хаад нугууд хараад айж энэ адил муу мунхаг бүгдийг бүрэн арилгах сэтгэл тэсвэр, гарган Барамсай жамцодүл энэрэхүй сэтгэлдээ хөтлөгдөн ирж бодь сэтгэлийг үүсгэв.

Ирээдүйн 80.000 жилийн тэртээ цагт сав шим бүгд хотол чуулганаар дүүрч, эд баялаг нь, тэнгэрийн оронтой дүйхүйц болж, хүний нас уртсан, царайлаг эд баялаг ихтэй өөр хоорондоо хөнөөл өчүүхэн үгүй араншингаасаа буяны зам дор оршдог нь ихэнхи болж, эдгээр нь машид сайн болой хэмээн бүгдийг тэгш агуулсан биетэй болов.

Хутагт зөөлөн эгшигт Майдар бээр насны язгуур үйлдэгч Логдонгийн 5-р төрөл дэмид-од хэмээх болоод энэрэнгүй сэтгэлдээ хөтлөгдөн тэсэлгүй нас наян мянган жилийн үед амьтан тэдгээр тэгүүнчилэн ирэгсэн бурхад бүгд тэгш агуулан залрахуйд тэдгээр нугуудад, ном номлооч үгүй тул тэдгээр нугууд ахуй үесдээ орчлонгийн амгалан өчүүхэн төдий амсавч, үйл нясваанисийн эрхээр орчлонгийн хүлээснээс гарахгүй бөгөөд

дахин орчлонгийн ерөөлгүйд тэнээд зовлонгийн дамжлага мэт эдлэхүй тэд үнэхээр хөөрхий. Тэр нугуудын итгэл аврал болон би ямагт ирээдүй бурхан болтугай хэмээн залбирсан Ренчиннянбуу бурхан, тэр мэт сайн цагийн мянган бурханы тавдугаар болох бошиг лүндэн тавьсан болой.

Энэхүү их хэргийг Богд лам бээр болгоон баясаж зөөлөн эгшигт Майдарын гэгээнд магтаал өргөсөнийг орчуулбасу:

Тэгүүнчилэн ирэгсэд тэгш бясалгахад

Тоолшгүй амьтныг энэрэхээр тэсэлгүй

Тоост орчлонг болгоон залрагч

Тэргүүн Мэпамцоржид, залбирнам хэмээн магтсан болой

Бас урьдын цагт мэпамбийн өмнө Загарбардийн хаан Юулхорсүрэн хэмээгч гарч тэгүүн дор мянган хөвгүүнтэй болов.

Тэр цагт Тэгүүнчлэн ирэгсэн эрдэнэ хязгааргүй элдвийг байгуулагч хаан орчлонд заларч тэгүүн дор Загарбардийн хаан мянган хөвгүүнт Юулхорсүрэн бээр урт цаг хугацааны турш тахин хүндэлснээс тэгүүнчилэн ирэгсэн бурханы өмнө бодь сэтгэлийг үүсгэснээр ялж төгс нөгцөгсөн бурхан бээр хааны мянган хөвгүүний алдар нэрийг бумбанд хийгээд нэжгээд бээр дараалан гаргахад дээрхи иш бошиг лүндэнчилэн Вагарбардийн хаан Юулхорсүрэнгийн мянган хөвгүүний 4-рт Гарагжан хэмээх мөн тул бурхан бээр эдгээр 1000 хөвгүүнийг сайн цагийн мянган бурхан хэмээн бошиг үзүүлэв.

Энэхүү их үйлийг болгоогоод:

Эвийн ерөөл буян гайхамшигаас

Эдлэл төгөлдөр үйл явдал хувирах

Эгнэгт сайн цагийн мянган бурханд мөргөмүй.

хэмээн магтсан болой.

Басчүү олон бурханы өмнө нинжин сэтгэл үүсгэн таалж, ялж төгс нөгцөгсөн шагжтүв тэргүүт сайн цагийн бусад бурханд 42 галавт энэ мэт нинжээр сэтгэлээ тушааж бурхан залрах бүрд энэ урьд мэт хэмээн зарлиглав.

Энэ мэт Майдарын гэгээн бээр олон галавт билиг билгүүний болон буяны чугуулганыг хурааж, ялж төгс нөгцөгсөн бурхан Шагжатүв мөнхийн номонд уйсалгүй сонсож Шагжтүв бурханыг Ёнзон багш болгон хүндэлж магнай зүгдэрийн голд титэмлэн бясалгаснаас Майдарийн зүгдорт буюу титэмд бодь суврагатай болон тогтсон гэдэг. Одоо Майдар бурханыг бүтээхдээ магнайд нь суврагтай бүтээдэг учир нь энэ билээ. Энэ мэт Майдарын гэгээн

тоолшгүй олон галавт хоёр чугуулганыг хураагаад Тэгүүнчлэн ирэгсэн Ренчиндүг хэмээх орчлонд залрахын цагт Майдарын гэгээн хэмээх болоод бурхан Ренчиндүг дор өргөл хүндлэлийг 84000 жил нэг ч өдөр таслалгүй өргөж амьтан зуу зуугаар эхлэн сургаалын таван суурь лугаа суралцтал хоол идэхгүй амьтаны тухайд энэрэн олон хоног хоолохоос уйсаж амьтны тусын тухайд хичээн зохиож амьтан жива-таг тэг бум 36-г сургаалийн суурь тав дор оруулах болму.

Тэр мэт 84000 жил амьтны тусыг зохион амьтан гурван живааг их хөлгөний зам дор оруулмой. Тоолшгүй олон амьтаныг ч бас бага хөлгөний замд оруулмой эцэслэн хэлбэл хот, хөдөө, болон наймаанд явж буй аялж буй, орон нөхөр тэргүүт хэн хаана явж буй амьтан бүгд тэдгээр нүүр харах төдий зарлиг сонсох, адис авах, даган бараалхах нугууд бээр асрангуйн бясалгалаар хөтөлсөнд арван зүгийн бурхад сэлт сайн хэмээн магтав. Цагаан зүгийн тэнгэр бүгд бээр энэ адил хамаг амьтанд асрангуйн тусыг үзүүлсэн ямар сонин гайхамшиг болов хэмээн асар их магтсан учир арван зүгийн дээд сэтгэлтэн Жамба буюу Асралт хэмээх бурхан болно гэж Лүндэгнэсэн болой. Тэгээд Майдарын гэгээн таалалдаа билгэ билгүүн болон буяны чугуулган болгоныг хурааж 10-р газар дор оршихийн цагт их гэрэл цацруулан авшиг олсон бөгөөд энэ ёсыг дэлгэрэнгүй өгүүлэхэд үг олныг зүүх хэрэгтэй учир Богд гэгээнтэн Зонхова бээр шүлэглэн эмхэтгэсэн зарлиг ануу:

Амьтан бүгдийг амгаланд хөтлөхийн тухайд
 Асар олон орны Бурхад бүгдээрээ, бээр
 Алтрах их гэрлийн авшиг эрхшээсэн танд
 Ариун номын бурханд тушаав та таалаа.
 Арван газрын бясалгалд хүрэхийн цагт
 Арван бумын ёгүзор их бясалгалаар
 Бүхнийг мэдэх билгүүн ямагтыг эрхшээн
 Бясалгал нугууд илт хувирахын эцэст
 Гурван мянгийг сая хуваасны тоос ямагтад
 Гуа бадмын дэлбээ тойрон чимэглэн буйн
 Гол төвд эрдэнэ язгуурт занданы үнэрт
 Гоц үрэлэн чулуун шим цоморлоглон
 Их замбуу мөрөн алт мэт гялтганаж
 Их эрдэнийн чимэг машид хээлсэн мөчирт
 Игүүн бүгдийн төвд залран орших таны
 Их багаар тойрох цоморлог мэт шавь нарын
 Нигуурийн зүг дор тань саяуул бясалгаж

Таны өлмийн гарын толио хүйснээс
Тоолшгүй их гэрэл зүг бүхэнд цацарч
Түгэх зүгийн гурван заяаны төрөлтөн
Тэнгэр хүмүүн асрын зовлонг арилгаж
Урдах ардах мөр үүд бүхнээс түгэх
Урьдын гэрэл шарвагаан бардигааны 9 газар хүртэл
Бодийн сэтгэлийн орныг дараалан гэрэлтүүлж
Бүхий л номыг бясалгаж аргыг ёсчилон бүтээж
Урьд адил шар үсний нүх бүхнээс гарах гэрэл
Учрах зүг бүхэндээ сүр жавхаагаар гэгээрч
Авшиг айлтгал авсан бурханы шавь нар
Ариун лагшингийн хот мандалд шингэн зохиож
Гишүүн дээдэс гурван мянгийг саяд хуваасан
Гагцхүү тоосны тоогоор гэрэл нэвчин тусаж
Бурхан сэлтийн хот мандал тодрон үйлдэж
Бүхий орчлонг арав дахин тойрон эргэж
Гэрлийн нуман их хот мандал бээр
Гэгээн тахилын далай мэт хурчилан бууж
Орчлонг олон тойрох чадалт шавь нар нь
Орой дээрээ мөргөн өлмийн толионд шингэн
Тэгээд шавь сэлтэд баатар та бээр
Тийнхүү авшиг хайрлах цаг дор болгоож
Авшиг авч эрдэм олсон шавь сэлт нугуудад
Аяа очирт цаг өлзий утас зураг мэт дуриан

Тоолшгүй сая сая гэрэл гэрэлтэн цацарч Тэргүүн шавь хүн бүхэнд тусан ариусгагч Торолтгүй арвин ирт хувилгаан үзүүлэгч таны Торгон шар өлзий утас хээлэн очирт шингэв Тэгмэгч таны ирт хувилгааны хүчээр Тэрбум болон арвижиж, дахин дахин үржээд Арван зүг бүхэнд оршсон бурхан таны үс бүрээс Ахин гэрэл цацран орон бүхэнг гэгээрүүлж Хорвоог арав дахин тойрч ирт хувилгаан үзүүлж Хосгүй бодьсадба жива олон соёрхол талбиж Мууг арилган дүдийг омог сүрээр дарж Манлай Бурханг залж бүхэнд тодорхой үзүүлээд Гэрлийн уг төв гал таны магнай лугаа Гэгээрүүлэн сарнин хот мандал шингээд Тэр цагт бодьсадба нар урьд үзээгүй Түмтийн бясалгал ёгозүрийг олов. Энэ мэт эрдэнэт зааны алтан ширээ Элдэв чимэгтийн дээр Загарбардийн ханхүү Дөрвөн их далайн усаар дүүргэсэн алтан бумба бээр Дээрх магнайнаас дэлгэрүүлж авшиглан Шагж тив бурханы номын орлогчоор Шашин амьтаны тусыг илт бүтээж Үйл нисваанисийн

энэлэлт амьтан бүгдийг Үлдээгүй жинхэнэ амгаланд хөтлөн соёрх хэмээн айлдсан болой.

Ирээдүйд замбуулинд залрах Майдарын гэгээний бурханы их зохионгуйг үзүүлэх нь Шагжтув бурханы шашин 5000 жил оршоод төгсөж сүүлд нь 500 жил ёс төдий байгаад цэвүүн цаг ирж хүмүүс нисваанисийн эрхээр мунхаран доройтож өөр хоорондоо дайсагнан хилинцэд үйл голдууг үйлдэж буян нь доройтон доройтсоор хүний нас 20 хийгээд түүнээс ч багассаар эцэст нь хүний нас 10 хүрэх үе гарахуй цагт, зудын галба, өвчний галба, мэсэн галба, нугууд дараалан ирж хүмүүс өөр хоорондоо дайсагнасаар зовлонгийн туйлд хүрч тамын орон адил болох тэр цаг дор хутагт зөөлөн итгэлт Майдарын хувилгаан ариун лагшиндаа ил шарыг асааж үзэсгэлэн жавхланг бадруулан залрахад амьтан нугууд бээр хараад гайхан сүсэглэж энэ мэт лагшин үзэсгэлэнтэйг асууваас: Майдар бурхан бээр тэсвэр бясалгаж шим туйл болсон тиймээс та нар өөр хоорондын тэмцэлээ зогсоож тэсвэр бясалгатугай тэгвэл надтай адил болно хэмээн зарлиглав.

Зөөлөн итгэлт хутагт Майдарын сэтгэлийн хүчээр хамаг амьтан тэсвэрийг бясалгасны хүчээр буян нь арвин болж, нас уртасан 20 настай болж улмаар 30 хүрч уртассаар амгалан жаргалан дэлгэрч их замбуулингийн газрыг алган толио мэт тэгш агуулан уужууруулав.

Муу нөхөр, өргөст мод, ширэнгэ шивээн хулс тэргүүт үгүй болж нуур цөөрөм дэлгэрч дөрвөн хуруунаас дээш өвс ургамал голдуу ургаж Ой зөөлөн цог мэт, үр жимс, ногоо, огцом, халиуран дүүрч, хүчтэй их халуун үгүй, огцом хүйтэн үгүй, бур бур салхитай цаг лугаа зохилдсон, үнэр, амт анхилан тэнгэрээс хур бууж хөрс шороо дэлгэрч дэлгэнэн, элдэв өнгийн хээлэн урласан мэт үр, цэцэг газар хөрсөөр дүүрэн эргэн тойронд усан цэцэрлэгт хүрээлэн оргилоор эрдэм өгүүлэгч хүмүүн лугаа адил нэг гарчээ. Тэнд төрсөн хүмүүн ануу: биенээс нь зандангийн үнэр анхилан, гүша гэх өвсөөр үлэмжийн гоё гэж хувцасласан тэнгэрийн эд эдлэлээс илүү төгс хэрэглэгдэхүүнтэй 80.000 наслах боломжтой. Бие хэл сэтгэл гурав нь нүгэлээс хагацсан, өнгө зүс сайтай өндөр хүчтэй биетэй. Одоогийнхоор бол 80-88 тохой биетэй (21 алд орчим) биеийн эрхтэн бүгд хүч лугаа төгөлдөр ба тэдгээр хүмүүсэд хүсэх, идэх, хөгшрөх, зэрэг нь ор төдий, өвчиний нэрээс өөр өвчин үгүй өвчилдөггүй дээд тэнгэрүүдээс онцын ялгаа үгүй, болой. Бурхан багшийн шашин ёс төдийгээс шингэн түүнээс дээшлэх эхлэлийн галав дууссан гэж үздэг.

Хутагт зөөлөн итгэлт Майдар бурхан залрахын завсар олон бурхад заларсан байдаг үүнийг завсарын 18 гэж нэрлэдэг ба Майдарын гэгээн заларсан үе дор хамруулдаг. Хутагт зөөлөн итгэлт Майдар бурхан залрах орон ануу: Бурхан багш гаслангаас хагацахуй ёсыг үзүүлсэн хот гүшинагар гэх зүлэгт газар Догилодой гэх хааны ордонд мэндлэх ба ордон дотор зай 12 багцадын газар өргөн нь долоон багцад дотор эрдэнэ их долоо, гахайн соёо, хавирга мэт долоон давхар их эрдэнээс бүтсэн дали, үрийн эрх долоо бээр хүрээлсэн, хонх адил үзэсгэлэнтэй. Тэдгээр нь аясын салхинд хөдөлж, сэлнэн долоон гишүүн төгөлдөр аялгуу эгшиглэдэг. Амьтан хүн баясаж үйлддэг, тэнгэрийн үрээс ургасан мандарваа цэцэг гүмүда, удвал, цэцэгс хүний оронд баймгүй үзэмж чимэгтэй. Найман гишүүн төгөлдөр ус усан цөөрөм цэцгэн чимэгт нууранд усны шувуу олноор яруу дуу дуурсгаж, жаргалын цэцэрлэг, хотол чуулган цэцэг алагласан хотын дөрвөн зүг газар бүхэнд бусдаас ялгамжаатай эрдэнийн найлзуур мод хүсэл бүгдийг хангадаг тул түүгээрээ тэнгэрийн төгс эдлэл бүгдийг сүрээр дарах болой. Энд дөрвөн тивийн эзэгнэгч Загарбардийн хаан төрөл садан лугаа цөм цугларч долоон их эрдэнэ мянган хөвүүн наян мянган хатантай, орны ноён 4800 г захирдаг номт төрийг тэтгэгч хаан дун хэмээх буй түүний өмнө их Барамсайцанрав хэмээх үзэж дуулсан зүйл ихтэй язгуур ажил бүхэн дор мэргэн ба түүнд хатан Цанданмаа хэмээх усгал дөлгөөн ухаалаг эрдэм бүгдийг төгсгөсөн нэгэн байв.

Барамсай язгуурын хаан хатан хоёрын хөвгүүн болон хутагт зөөлөн итгэлт Майдар бурхан мэндлэх болой. Тэрчүү хутагт зөөлөн итгэлт Майдар бурхан цаг, болон орон, язгуур, яс эхийн таван шинжийг болгоогоод гандангийн орноос буун морилж замбуу тивд залрах болой. Мөн цаг ануу: хүмүүний нас 80000 болох, сав шим бүгд хотол чуулган бүрдсэн Майдар бурхан өөрийн хувь, зохист амьтан нугуудыг номхотгохуй цаг дор болгоомой. Орон ануу: Замбуулин тивийг болгоомой. Язгуур ануу: Тэдгээрийн тэр цагийн хүмүүн нугуудын Барамсай язгуур дээд болох учир тэр язгуурыг болгоон сонгожээ. Яс ануу: хаан хатан хоёр бээр яс угсаа дамжлага гэм үгүй тул болгоожээ. Ээж ануу: Барамсай Цанданмаа эрдэм бүгд лугаа төгөлдөр тул ерөөлийн хүчээр эжийгээ болгон соёрхжээ.

Тэр мэт болгоогоод цаг нь ирэх үед тэнгэр нугууд бээр тахилын үйл санаанд багтамгүй өргөн Гандангийн орноос морилон замбуулинд залрах ба ээжий Цанданмаагийн алтан

хэвлийд орших болой. Тэгээд арван сараа гүйцээгээд цагаан зүгийн тэнгэр орой болгон ном унших тэргүүтэй шавийн ажлыг идэвхийлэн зохиож, арван сар өнгөрөхөд хатан ээж Цанданмаа жаргалангийн цэцэрлэгт хүрээлэнд очиж Мядагсанжэ хэмээхүйд баруун мутраар модны мөчрөөс барьж өргөх агшинд баруун суганаас лагшин мэндэлж, гэрэл цацран орчлон бүгдийг дүүргэн нэгэн эгшинд хамаг амьтаныг зовлонгоос салган амгаланд түгээж, тэнгэрийн эрхэт шажин бээр тэнгэр газрын завсар зогсож, лусын хаан бээр огторгуйг рашаанаар угааж, дөрвөн зүг долоон алхам хийсний мөрөөр их сан цэцэгийн язгуур гарч урган, байхад Дөрвөн зүг дор болгоон: Миний төрөхийн эцэс төгссөн ануу мөн болой. Ахин төрөл үгүй ажгуу Цувралттай гаслан төгсөх болой хэмээн зарлиглана. Тэр цагт Майдар бурхантай нэгэн цагт Загарбардийн хаан Дунгаас мянган хөвгүүн бас орчлонд дээд язгуурын олон төрөлийн нэгэн гуу сан нээгдэнэ. Тэнгэр нугууд цэцэгийн хур буулгаж зөөлөн итгэлт Майдар бурханы тэргүүнд шүхэр өргөнө. Зүг бүхнээс хөгжмийн дуу тэргүүтнээр аялгуулан тахил элдэвээр дүүргэн үйлдэнэ. Тэгээд хаан аав хатан эжий хоёр бээр алдар хайрлагч дор шинжүүлэн Бодьсадба жамба-хэмээн алдар хайрламагц Бурхан болох болой. Хэмээх бошигтой Тэгээд Майдарын гэгээн бээр элбэ цог заль үзүүлэх залуустай тоглох зохионгүйгээр амьтан тоолошгүй нэгийг боловсруулан гэтэлгэж 20.000 жил гэртээ залрана. Тэгээд бурхан болох цаг дор хаан Дун бээр элдэв эрдэнийн тахил зул тэргүүт 64 алд өргөөшөө мянган алдыг Майдарын гэгээний аав Барамсай Цанрайд өргөнө. Цанрай нь цааш Барамсай нугуудадаа өргөнө. Барамсай нугууд авангуут хуваана. Хутагт Майдар тахил тэдгээрийг мөнх бус дор болгоогоод ааваас зөвшөөрөл авч Барамсай хийгээд ханхүү 4080 сэлт хуврага болж Луйшин хэмээх бодь модны өмнө нэгэн бээр газар хутагт мод түүний мөчир үр жимс салаа эргэн тойронд зургаан жан газар дэвсэгдэн өмнө нь оршиж хуврага болсон тойн нартай илт туулсан бурхан болох болбой.

Тэгээд сайн орны дээдийг олж
Тэсвэрийн орон бусад одох хэцүү
Эрлэг, хөгшрөх үйлээс гэтэлгэгч
Энэхүү рашааны үүдийг олов
Хэмээн долоо хоног ном эс айлдав.

Тэгэхэд Цанба бээр: цагаан дун алтан хашлагтай таван өнгийн, сувд мэт хонх барьсан бараа болооч гурван бээрээр дүүрэв. Тэнгэрийн их нар эрдэнээр чимсэн алтан хорол мянга

мянгаар өргөв. Цэцэг болон эрдэнийн хүжэн хур буулгав.

Хутагт зөөлөн итгэлт та бээр

Хосгүй номоо соёрхож хайрла

гэж залбирсан ч эс айлдав, цэцэг үзэмжтэй дэлгэрсэн цэцэрлэгт морилов.

Тэндээс, ирт хувилгаан ихээр үзүүлэн түүнийг харсан хаан, хөвгүүд хатад сэлт 4800, цанрав тэргүүт барамсай 4800, бусад амьтан тоолошгүй, ихээр цуглан хуврага болмой.

Тэгээд номын хүрдийг эргүүлэн цуглаад эхнийх есөн дүнчүүр зургаан жива архад хоёрдугаар дүн есөн дүнчүүр хоёр жива архад болов. Тэр цагт Бурханы гэрлийн хүчээр харанхуй газар үгүй болж нар сар хүртэл сүрээр дарагдаж цэцэг цоморлогоо нээвэл өдөр хаавал шөнө хэмээн нэрийдэв. Басхүү шувууд жиргэн аялгуулж дугарвал өдөр дуугүй байвал шөнө хэмээн нэрийдэв. Тэгээд ч зогсохгүй шөнийн харанхуй үгүй болж орон нөхөд бүгд энэрэнгүй баясангуй явдалтай, бүгд зөөлөн итгэлтийн хүчээр өөр хоорондоо асрангуй оршин номын явдалтай голдуу болов. Шарвагаан нугууд нэгэн арга бээр хотод гүнцэглэн, бадралж, жажин цамба тэргүүт тэнгэр бүгдээр тэнгэрийн зайтай элдэв цэцэг, эрх тахилын далайг хурчилан буулгаж, хааны залрах газар дээр, эрдэнийн сэнтий ширээ зөөлөн амгалантай олбог тавьж үйлддэг болой. Есөн төрөлхтөн бүгд магтаал аялгуулан тахил өргөж, тэр, мэт 60000 жил хүртэл амьтан тоолошгүй хэмжээлшгүйн тусыг зохион номын хүрдийг эргүүлэн огоот гаслангаас гэтэлгээд шарилыг нэгэн үрэл болгон оршоов. Хутагт Майдарын гэгээн Бурхан болох цагт аав ээж, нөхөд цуглан насны хэмжээ тэргүүтэн нь “додэгалсан” хэмээх номонд: Тэргүүнлэн ирэгсэн Майдар бурханы мэндлэх нутаг хааны ордон харш “доги-лодой” хэмээмой.

Язгуур нь: Барамсай язгуур болой.

Гэрэл нь нэг багцад болмой.

Аав нь Цансан хэмээх болой.

Эжий нь Цандагмаа хэмээмой

Шавь нь Содномдовчин хэмээмой

Ухаантан нугууд бээр: дээдийн билгийн гэрэлт хэмээмой. Ирт хувилгааны дээдэс нугууд нь: Бат хичээлт хэмээмой. Анхны цугларагсад ануу: есөн дүнчүүр зургаан жива болой. Хоёрдох цугларагсад ануу: Есөн дүнчүүр дөрвөн жива болой. Гуравдах цугларагсад ануу: есөн дүнчүүр хоёр жива болой. Насны хэмжээ ануу: 84000 жил болой. Дээдийн ном ануу: 80 000 жил оршмой. Гүдэн шарил нь нэгэн үрэл болой.

Суврага ануу: бас нэгэн болой. Хэмээн зарлигласан мэт болой.

Бурхан багшийн шашинд орж хуврага болон сургаалийн суурь нугуудыг сайтар сахин дуулах, санах, бясалгах гурваар шамдсан ч гурван хөлөгний үрийг олоогүй нугууд Майдар бурхан залрахад номын хүрд эргүүлж шашиндаа оруулна гэж бурхан багш зарлиглаж Майдартай ч учрах болой гэжээ, Майдарын бошиг үзүүлсэн судраас:


Шагжаан арслангийн шашин дор

Шамдал суртгаалийн сууринд сураад

Магад зарлиг бүтээлгүй нугууд,

Миний шашинд үлдэх болой.

Хэмээсэнчилэн дээр гандангийн оронд хутагт зөөлөн итгэлт Майдарын гэгээний өмнө бодь мөрийн зэргийн аньс шим нугуудыг сонсохыг хүсэж, сэтгэлээ даатган долоон гишүүн мандал сэлт дахин дахин өргөөд, ам авахын сахилыг ариун сахиад Бурхан багш, Майдар хоёр дор залбиран талибаад тэр мэт ерөөл өргөн бүтээхүйн судраас зарлиглав. Майдарын тангараг сэлтийн тогтоол тарина амны уншлаганд үйлдвээс ганданд төрөх ба Майдарын гэгээнд магад шавь орон учрана, урьдын дээдэс олон дуудан уулзсан нь жамба дамжайвийн сүн буюу Майдарын тангараг тогтоол таринийг амны уншлага болгон зохиож, Майдарын лагшин бүтээх Майдарын ерөөл унших, бусдад Майдарын намтар цадигийг ойлгуулах зэрэг болой. Бодь мөрийн зэргийн увидасын гол номлол хураангуй үндэс нь эцэслэн Ширчиндо буюу билиг барамид их эрдэнэ мөн. Билиг барамид, сударын аймагийн их эрдэнийн утга нугууд, бодийн замын зэргийн увидасанд найруулагддаг ба гол номлол нь хутагт зөөлөн итгэлтийн зохиосон билгийн чанадад хүрэхийн увидас илт онохын чимэг мөн билээ. Илт онохуйн чимэг нь сударын аймагийн утга бүгдийг өгүүлэгч мөнх бус найм, түүнийг задлан ялгаж далан утганд нотлон буулгасан. Түүний анхных нь сэтгэл үүтгэхээс эхлэн эцэс болох Прэнлэй буюу үйл хүртэл бүгд бодгаль нэгээс анхааран авах ёсыг тодорхой үзүүлэх нь бодь мөрийн зэрэг ба Зонхова бээр бодь мөрийн зэрэг бол илт онохуйн чимэгийн увидас мөн хэмээн нотолсон байдаг. Тэр мэт хутагт Майдарын гэгээн бодь мөрийн зэргийн увидасын гол үндэс илт олохуйн чимэг, түүнийг анхааран авахын аньс нь судар олноос хураан авч дэлгэр үзүүлсэн додэжан буюу сударын аймагийн чимэг, Бодь мөрийн зэргийн амирлангуй болон үлэмж, үзэлийг анхааран авахуйг тусгайлан үзүүлэгч нь үйнта намжид буюу төв хязгаарыг тийн ялгагч, чойдан чойняд



ХОЁРДУГААР ХУВИЛГААН ЧОЙЖАЛНЯНАНМЭД БУЮУ АШОКА ХААН

сү рхэ гэгдэ бидэ сува бхххэ хэ хэе вхххэ | ххххэ бидэ ххххэ ххххэ гэгдэ ххххэ ххххэ
ххххэ | ххххэ ххххэ ххххэ ххххэ бидэ ххххэ ххххэ | ххххэ ххххэ ххххэ ххххэ ххххэ ххххэ |

ЗАЯ БАНДИДА ХУТАГТЫН ЭНЭТХЭГ ДЭХЬ ХОЁРДУГААР ДҮРИЙН ХУВИЛГААН ЧОЙЖИЛНЯНАНМЭД БУЮУ АШОКА ХААНЫ НАМТАР

Мөнхүү дээрхи Майдарын гэгээний гурван ишлэл адил Зая бандида гэгээний хоёрдугаар төрлийн дүр нь босоо монгол бичгийн Зая гэгээдийн хураангуй намтар хэмээх архивын ишлэлд:

Хоёрдугаар дүрийн нэр Гаслан үгүй номын хаан энэтхэг газар хувиран гарч Шагжамуни бурханы шашиныг тэтгэн зохиож гольтийн тоот суварга бүтээж, амьтаны тусыг агуу ихээр үйлдэж явсаны хойно гэж байгаа бол

Ванчин балдан-иш богд, Галсанжамц Далай лам нарын түвд үсгэн дор зохион айлдсан зая гэгээний төрөл тутмын залбиралыг нэгтгэн орчуулбаасу:

Бурамын модны бодьсадвагийн ишлэл лүндэнгээр

Буртагт замбуулингийн амьтаныг сарны гэрлээр гийгүүлж

Гагцхүү чин сүжгээр шашныг тэтгэн найруулсан

Гаслан -үгүй номын хаан Ашокад залбирнам гэжээ.

Өөр нэгэн эх сурвалж болох өөрт байгаа Ганжуурваа номын хааны бичсэн Зая бандида гэгээний намтартай ав адилхан нэг л хүний бичиг мэт бичигдсэн урьд дүрүүдийн зая лувсанпэрэнлэйн хураангуй намтар хэмээх түвд сурвалж бичгийг монгол руу орчуулбасу:

Бурханы шашины орлогчийн дээд бодьсадва

Бүүр ирээдүйдээ Цэцэрлэг хэмээх хотод

Мэндлэн шашин төрөө дэлгэрүүлэн зохионо гэж Магадтай тодорхой үзүүлсэн иш бошигчилон

Авралт номыг тэтгэгч их хаан Ашока бээр

Амьтны тусад жива тоот суварга бүтээж

Хоёр чугуулганыг эцэслэн хурааж буян төгсгөөд

Хойд төрөлдөө диваажинд цэцэгнээс мэндэлж

Мэндэлмэгц Одвагмид бурхантай учирч

Мянган ерөөл цог учрал төгс бүрдэн

Бодьсадва ваба санбуу хэмээн алдаршив Буцаад таалал ерөөлийн хүчээр

Булингарт орны амьтаныг тэтгэгч багш Баатар Шубамгара хэмээн алдаршив

гэжээ тэгэхээр намтарт Вавасамбуу, Товасамвуу гэж бичигдэн

Энэтхэгт 1-рт Жансим жамба буюу Майдарийн гэгээн

2-рт Чойжил нян ан мид буюу Ашока хаан

Вава самбуу бодьсадва Диваажинд төрсөн учир энэтхэгийн дүрүүдтэй хамаарахгүй боловч 3-р дүрд тоцогдоно.

Ванчин, Далай лам нарын түвд хэл дээр зохиосон Зая гэгээний төрөл тутамын залбиралын тухайн хэсгийг монгол хэлэнд орчуулбасу:

Тоолшгүй хуврага чухаг дээд гуравыг шүтээд

Тоонд тааруулж тийн боловсруулан ачлаад

Тахил хүндлэлийн хүчээр зуун тэнгэрийн өмнө мэндэлсэн

Тэнгэрийн хөвгүүн төгс үзэсгэлэнт дор залбирнам гээд алдарыг нь Зэдүг Лхабү хэмээжээ.

Монгол бичгийн сурвалжид: Гутгаар төрлийн нэр ануу: Вабасамбуу ергөөлийн хүч бээр арилагсан сугабацийн оронд мянган навчит лянхуа цэцэгнээс хувилаж, Авидийн гэгээн лугаа учиран санахуй өгүүлэхүй бээр амьтаны тусыг үйлдэж явагсаны хойно хэмээн түвд эхүүдтэйгээ зохилдож байна.

Энэтхэгт 1. Майдар, 2. Ашока хаан, 3.Шубамгара, 4.Раднаа сэди, зэрэг дөрвөн дүр хувилсан бол Сугабацийн оронд мэндэлсэн Вабасамбуутай нийлээд таван дүр болж байна

Ингээд Ашока хааны түүхэн домогийг Жонон дарнатын зохиосон жагар чойнжүн буюу Энэхэгийн түүхээс түүвэрлэн орчуулан үзүүлбээсү:

ЗУРГАДУГААР БҮЛЭГ: НЯ-АН-МЭД ХААНЫ ТҮҮХИЙН ҮЕД ГАРСАН ДОМОГ

Тэр цагийн орчимд идэр залуу болсон хаан Ня-Ан-мэдийн үе бөлгөө.

Түүний домог нь Таругийн үндэснээ хамаарах Замба-Арна хэмээхүйд нарны язгуурын хаан Нэмвида хэмээх таван түшмэл лүгээ сэлт морилон ирж, хойт зүгийн орныг эрхшээсэн бөлгөө. Тэр хаан эхэндээ Гэважан, Шиндажан, Дүнжан, Норжан, Бадмажан, Сэржан хэмээх зургаан хөвгүүнтэй бөлгөө. Өөр нэг цагт худалдаачны ноёны нэгэн эхнэр хаан лугаа явалдан жирэмсэн болж, хааны эх нь нөгчсөний гасланг тайлахуй өдөр худалдаачны ноёны эхнэрээс хаан хөвгүүн төрсөн болохоор түүнийг гасланг тайлахуй өдөр төрсөний учир Гаслангүй буюу Ня-Ан-мэд гэж нэрлэжээ.

Том болохын үед биеийн хүчний жаран эрдэм, найман шинжлэл хийгээд үсэг, зурхай тэргүүтнээ машид сайтар суралцахуй үес нэгнээ олон ардын дунд нэгэн бэлгэч бярман байжээ. Хааны түшмэлүүд: “Хааны хөвгүүнээс хэн нь төрийг барих бэ?” хэмээн асууанд, “Идээний сайныг иддэг, хувцасны сайныг өмсдөг, суудлын дээдэд суугч тэр барих бөлгөө, хэмээвэй. Дараа нь түшмэлийн дээд болсон хоёр нь тэр үгийн учрыг бярманаас нууцаар асуусанд “Идээний дээд нь будаан зутан, хувцасны дээд нь зузаан бөгс, суудлын дээд нь газар дэлхий бөлгөө, хэмээн номлосон тул “Хааны бусад хөвгүүд нь хотол чуулганаар баялаг агаад Ня-Ан-мэд нь жирийн идээ, хувцасыг эдлэх тул тэр хаан болох нь” хэмээн мэджээ. Завсар үес нэгнээ Балба орон хийгээд Хашяагийн орон тэргүүтний уулнаа олон үхэр нь буруулан алга болов. Тэдгээрийг номхруулахад Ня-Ан-мэдийг цэргийн өмөг лүгээ илгээсэнд уулнаас үхрийг төвөг үгүй буулгаад, албыг өнгөрүүлж, барьцаа барин “Шинэ жилийн албыг өнгөрөөлөө” хэмээн Хаанаа айлтгахуйд, Хаан өгүүлрүүн: “Чиний оюун ухаан хийгээд баатар залиг би бишрэн хүндэлмүй. Алин хүссэнийг чинь өгсүгэй? хэмээхүйд тэр” Намайг энэ орноо ах дүүс хөнөөх тул Бадалибүдра хэмээх балгадад суулган өршөөнө үү? Хүссэн эд бүхнийг ч өгөх ажаамуй” хэмээхүйд түүнийг нь өгчүхүй. Тэр орноо үзэсгэлэнт цэцэрлэг таван зууг байгуулан, цэнгэлгээнийг үйлдэн, мянган эхнэрээр хүрээлүүлэн өдөр, шөнө бүхнээ хүслийн эрдмээр жаргасан бөлгөө. Тэгээд Магадын орноо Замаша хаан насан болж, түүний арван хоёр хөвгүүн буйн заримыг хаан төр барихуйд тушаасан ч хаан төрийг барьсангүй. Анцүлсавба хэмээх бярман түшмэл хэдэн жил хаан төрийг барьчихуй.

Тэр үед Нэмида хийгээд Анцүлсавба тэр хоёр дайсагналцаж, Гангын хөвөөнөө удтал байлдаж, хүч тамиртай зургаан хөвгүүн дайнд ялж, тэр орчимд Нэмида ч таалал төгссөн болой. “Хааныг үхсэн хэмээх сургийг тараавал Магадынхан хүчирхэгжинэ” хэмээн нууцлав. Хаан төрийн хэргийг хоёр түшмэл үйлдэж, долоо хонохуйд хот балгадын ардууд мэдэж, тэр хоёрын хэлийг тасдаж үйлджихүй.

Тэр үед “Өмнийн бярманы эш үзүүлсэн тийн хэмээн сэтгээд, Ня-Ан-мэдийг хаан орноо суулгав. Хааны зургаан хөвгүүн Магадыг ялаад, зургаан хот балгадыг авсан тэр өдөр Ня-Ан-мэд хаан ширээнд суусан болой хэмээн сонсож, таван зуун түшмэлийн чуулган лугаа сэлт Гангын хойт зүгт ирээдүйн хааны нийслэл тэргүүтэн таван хот балгад хийгээд зургаа дугаархи нь Анга хот

болон зургаан хот балгадыг хаан хөвгүүд тус тусдаа захирав. Тэр ч хан хөвгүүний анх дугаар нь ертөнцийн Жанибаны нууц үгээр сүсэглэх болой.

Хоёрдугаар нь Лхачэнд сүсэглэх болой.

Гуравдугаар нь Чавжүг, дөрөвдүгээр нь Вэд даяарын нууцыг өгүүлэгч, тавдугаар нь нүцгэн Сэржан, зургадугаар нь бярман Гүша хөвгүүн хэмээх ариун явдалтад сүсэглэх болой. Тэдгээр ч өөр, өөрийн орны үндсүүдийг үйлдэх бөлгөө.

Ня-Ан-мэд нь Вригү Язгуурын арш, дагинас хийгээд мангасыг тахин үйлдэгч нарын үгэнд шүтэх бөлгөө. Үма дүртод мамо сэлт охин тэнгэрүүдийг тэнгэр болгон тахих бөлгөө. Тэгээд хэдэн жилд хүслийн эрдмээр ихэд цэнгэн, наадан оршсон тул, “Гама-Ашога” буюу “Хүслийн Ня-Ан-мэд” хэмээн алдаршвой. Тэгээд хэзээ нэгнээ ах нар лугаа үл тохирон, олон жил тэмцэлдсэний эцэст зургаан ахыг таван зуун түшмэл сэлттэй нь хамт алвой.

Бас, бус олон хот балгадыг ялж, Цастан хийгээд Вигжэд хоорондох орон бүхнийг эрхшээлдээ хурааж, маш их ууртай хэрцгий болсон тул цаазаар авахуй үйлийг үл үйлдвээс сэтгэл нь амрахгүй болж, хоолыг ч үл идээд, өдөр эхлээд алахуй, хүлэхүй, жанчихуй тэргүүтэн цаазлахуй үйлийг тушааж, түүний хойно сэтгэл нь амар болж, хоол ундаа зооглодог болжээ. “Тэр мэт энэ хааны цэргийн домог нь маш их боловч хэрэггүйн тулд үл номловой” хэмээн Савансанбо зарлигласан байна.

Энэтхэгийн зарим нэгэн домог уламжлагдан ирсэн ч энд бичээгүй болой. Тэр үед буруу үзэлт бярманууд дурдаад, амиар тахилыг үйлдэхүйд хичээсэн ба ялангуяа Вригү язгуурын арш Валаннава хэмээх нэгэн: “Түмэн хүмүүнийг алан тахилын өглөгийг үйлдвээс хаан төр ч дэлгэрэн, гэтлэхийн үндсэндээ одмуй” хэмээн номлож, тахил өглөгийн байшинг барив.

Нэгэн түмэн хүмүүнийг алан чадагчийг зүг бүхнээ эрсэн ч нэгэн хэсэгтээ үл олдов.Эцэст нь Рахүди алуурчны язгууртан нэгнийг олсон бөлгөө.

“Алин алахуй зохистой бүхнийг тэр байшинд илгээж, нэг түм хүрэхийн хооронд тэнд очсон бүхнийг алтугай! Энэ нь хатуужилт буцааж үл болохуй тангараг болой” хэмээн Хаан амласан бөлгөө. Тэр ёсоор мянга буюу хоёр мянган хүмүүн алахуй үед алуурчин нь хот балгадын гадна бядан явахүйд нэгэн гэлэн түүний явдал мөрийг буцаахын тухайд амь таслахын гэм эрүү хийгээд тамд төрөхүй хийгээд тамын элдэв домгийг ярьж номлохүйд, буяны үндэс нь сэргэсэн үгүй, тэр яргачин сэтгэрүүн: “Урьд хүмүүний

толгойг таслан алж байлаа. Одоо тэр гэлэнгийн ярианаас сонссон мэт түлэх, хэрчих, арьсыг нь хуулах тэргүүтэн элдэв аргаар алж болмуй” хэмээн сэтгээд, тэр мэт олон хүмүүнийг алж, тахил өглөгийн тэр байшинд таван мянга орчим хүмүүнийг алсан бөлгөө. Тэр үед урьдын нэр нь урваад, “Зандала-Ашога” буюу “Хэрцгий Ня-Ан-мэд хэмээн алдаршвай.

Тэр үед Архад Дагвын шавь, олноо сонссон буяны мөрийн онолд оршихуй нэгэн гэцэл замаа мэдэл үгүй тахил өглөгийн байшингийн дотор хүрчүхүй.

Алуурчин илд барин цавчихыг завдахуйд учир шалтгааныг асуусан болой. Тэр урьдын домгийг номлосноор “Тийм болвоос долоо хоногоос алтугай. Түүний хооронд би ч өөр газар үл одмуй. Тахил өглөгийн энэ байшинд суух бөлгөө” хэмээн өгүүлсэнд, алуурчин ч “Тэр мэт болгоно” хэмээв. Тэр ч тэр тахил өглөгийн байшинд мах, цус, ясаар огоот дүүрсэнийг үзсэн шалтгаанаар мөнх бусын шалтгаан тэргүүтэн арван зургаан үнэнийг огоот олоод, долоо хоногийн өмнө архадын хутгийг олвой. Рид хувилгааныг ч бүтээв.

Долоо хоног болсон өдөр “Энэ мэтийн ахуй ёсон урд өмнө энэ байшинд үл гарсан болохоор урьд хийгээгүй нэгэн аргаар альяа” хэмээн их зэс тогоог гүнчодийн тосоор дүүргэсний дотор гэцлийг хийж, гал тавин түлснээр өдөр, шөнө хоёр гал бадруулан түлсэн ч түүний биед өчүүхэн ч гэм болсонгүй.

Хаанд айлтгасанд, хаан онц гайхамшиг төрж, түүнийг үзэхээр тахил өглөгийн байшинд ирвэй. Түүнээ алуурчин сэлмээ бариад гүйж ирэхүйд, хаан учир шалтгааныг асууваас, “Энэ нь хааны тангараг болой” Түмэн хүмүүн үл гүйцэхийн хооронд энэ байшинд хэн ирсэн ч бүгдийг алах болой” хэмээв. Хаан өгүүлрүүн: “Тийм болвоос миний өмнө чи энд ирсэн болохоор өмнө нь алах болой” хэмээн тэр хоёртой хэрэлдэхүйд, гэцэл хур буулган, цахилгаан татуулан, огторгуйгаар одох тэргүүтэн рид хувилгааныг үзүүлснээр хаан хийгээд алуурчин хоёр үлэмж сүсэглээд, өлмийд нь мөргөн, бодийн хөрөнгө агуу ихэд сэргэсэн болой.

Тэгээд тэр ном номлосноор хаан хилэнцэт үйлэндээ маш их гэмшээд, тахил өглөгийн байшингаа ч тэр даруй эвдэв. Хилэнцийг арилгахын тулд гэцэлийг “Сууж өршөө!” хэмээн айлтгаснаар “Хаан таны хилэнцийг арилгах аргыг би номлож чадахгүй. Зүүн зүгийн Жагаг хотол баясгалангийн хүрээнээ Хамба архад Дагважанцан хэмээх суун бөлгөө. Тэр л хаан таны хилэнцийг арилгах болой” хэмээн эш үзүүлсэн мэт хаан ч архадад захидал илгээгээд,

“Хутагт Бадалибүдра залраад миний хилэнцийг арилгах ажаамуй. Хэрвээ хутагт энд үл ажирваас би тэнд очих болой” хэмээн айлдаж, Архад Дагва бээр Бадалибүдрад заларсан бөлгөө.

Өдөр бүр хаанд ном номлон, шөнө бүр вихар хийдэд заларч, дөрвөн зүйл нөхдөд увьдис шингээх болой. Архад Дагва лугаа учирсанаас хойш хаан маш их сүсэгтэй болж, өдөр, шөнө бүр ямагт буяны үйлээр цагийг нөгчөөж, өдөр бүхэн гурав, гурван түмэн гэлэнг тахиж үйлдэх болвой. Завсар үесээ архад Дагва бээр Магада тэргүүтэн өөр орноо оршихуй нэгэн үед хаан таван зуун худалдаачныг эрдэнийн тивд эрдэнэ авахуулахаар илгээж, тэд ч сайн онгоцыг бүтээгээд элдэв эрдэнээр дүүргэн инагш ирж, далайн хөвөөнөө алжаалыг тайлан суухуйд, лусууд далайн давалгаан талбиж, эд бүгдийг далайд аваачвай. Тэгээд тэд бусдад дайгдан буцан ирэхүй болж, хэзээ нэгнээ долоо хоноод худалдаачид Бадалибүдра ирнэ гэж дуулджээ.

Тэднээ юу тохиолдсоныг сонсоогүй бярман, хотлоо бядагч хийгээд ардын чуулган хэмжээлшгүй чуулж, “Эрдэнийн өнгө хийгээд онц гайхамшигтай эрдэм алин буйг үзэх болой” хэмээлдэж, долоодох хоногийн өдөр хаан, ардын чуулган лугаа сэлт үзэсгэлэнгийн цэцэрлэгт одож, тэдгээр худалдаачид хоосон, ядарч доройтон ирэхуйд, ардууд маш ихэд дургүйцэн, инээлдэж, тарж одсон болой. Хаан учир шалтгааныг асуухуйд, худалдаачид ч учир явдлыг өгүүлэлдэв. Тэнгэрээр лусыг номхотгон үл зохиовоос хойшид ч эрдэнэ авахыг дурлагчид огт гарахгүй тул тэнгэр аргыг зохиох зохистой болой хэмээн айлтгав. Тэгээд хаан тэр үгүйг дотроо бодож, мэргэдээс аргыг асууваас бярман ба хотод бядагч нар эс мэдэв. Түүнээ зургаан илт мэдэл лүгээ төгссөн нэгэн архад ийн сэтгэрүүн: “Түүний аргыг тэнгэрээр номлуулвал мэдэх болмуй. Хэрвээ архад ямагт номловол энэ нь гэлэнгийн ёсыг баригч мөн болой хэмээн хаан ч эргэлзэн гэмших болмуй. Тэрсүүд нар ч хэлэх болмуй” хэмээн сэтгэж, “Их хаан үүнээ арга буюу. Өнөө шөнө гэрийн тэнгэрээр номлуулах болой” хэмээн зарлигласан болой. Тэгээд үүр цүүрийн үед гэрлийн огторгуйд оршсон тэнгэр “Хаан аа! Бурханыг агуу ихээр тахих болтугай. Лус номхорох болой” гэв. Тэгээд газраа оршихуй тэнгэр “Хаан аа! Архад, бурсан хуврагуудыг тахих болтугай. Тэр номхоруулах болмуй” хэмээв. Маргааш нь ардын чуулган бүхнийг хурааж, тэнгэрийн бошгыг номлож, үүнийг ямар мэтээр үйлдэх вэ хэмээхуйд түшмэд өгүүлрүүн: “Өчигдөр эшийг айлдаач архадаас асуутугай” хэмээсэнд түүнийг урин залаад айлтгахуйд,

“Түүнээ сэтгэл итгэмжилэхийн аргыг үйлдтүгэй” хэмээн “Хаан Ня-Ан-мэдийн зарлигийг лусууд сонстугай” хэмээх тэргүүтнээр барилдуулаад, “ Худалдаачдын авсан эрдэнэ алин буйг худалдаачнаа эргүүлэн өгтүгэй!” хэмээх үгийг зэс номонд бичээд Ганга мөрөнд орхив.

Хот балгадын дөрвөн замын бэлчирт их өндөр хөшөө чулууны оройд Асдададү саванд хаан хийгээд лусын дүрийг алтаар хийж тавив.Түүний маргааш харваас лусууд хямраад, их хүчтэй салхи гарган зэс номыг орд харшны үүднээ гарган орхив.Хааны дүр хөрөг лусын хөргөнд мөргөн одсонд Хаан архадаас асуусанд “Эдүгээ лусын буян их болохоор жич бас хааны буяныг үүсгэхийн тухайд бурхан ба бурсан хуврагуудад тахилыг өргөтүгэй” хэмээн хүссэнээр Бурхан багшийн дүр хөрөг хийгээд сувраганд өмнөхөөс долоо дахин их тахилыг өргөв. Тэр Архад тэнгэр, лус тэргүүтний оронд гагц агшинаа одсон бөлгөө. Архад бүхнээ яруу сонсголыг буулгав. Хаан ч цагийн хуримын их барилыг бариад, тэр архад ганд модыг дэлдсэнд Сүмбэр уулийн ойр орчмоос наашхи архад бүхэн хураад, жаран мянган архадын чуулганыг гурван сар элдэв эдлэлээр тахин үйлдвэй.

Тэр үед өдөр бүр хааны хөрөг дүрс дээшлэн одоод, дөчин таван хоног болохуйц хаан, лус хоёрын хөрөг тэгш болоод, түүнээс хойш өдөр ирэхүйеэ лусын хөрөг доош бөхийн одсон бөлгөө. Дахиад дөчин тав хонохуйд лусын хөрөг дүрс хааны хөрөг дүрсийн хөлд нь мөргөн одвой.Ард бүгдээр ч “Чухаг дээдийг тахихын буян энэ мэт болой” хэмээн их гайхамшиг төрцгөөв. Тэгээд урьдын зэс номыг Ганга мөрөнд хаяснаар түүний маргааш лусын элч хүмүүнээ хувилан гарч ирээд, “Их эрдэнийг далайн хөвөөнөө авч ирсэн тул худалдаачид автугай! “хэмээхүйд, хаан тэр мэт үйлдэхийг завдахын цагт урьдын тэр архад “Хаан аа! Энэ нь онц гайхамшигтай бус ажаамуй. Та нар долоо хоногт тэдгээр эрдэнийг үүрээд энд иртүгэй!” хэмээн захиваас тэр мэт болвоос онц гайхамшигт ажаамуй” хэмээн зарлигласанчилан үйлдсэнээр долоодох хоногийн өдөр хаан олон ард лугаа хүрээлүүлсэний дотор лусууд худалдаачны дүрээр ирж, эрдэнүүдийг өргөв. Хааны өлмийд шүхэрлэн сөгдөж, төрөлхтөний чуулганаа үзмэрийг үзүүлээд, цагийн их хуримыг хийжээ. Тэр үед хаан Шиндаа хэмээх ягчисийн арвис тарнийг бүтээгээд, заан мэт морь, дал мод мэт хүмүүн тэргүүтэн ягчисийн дөрвөн гишүүний нөхөд сэлт олныг гаргаад, Вигжэдийн өмнө зүгийн орон тэргүүтэн бусад орон бүхнийг ч эрхэн дороо оруулчихав.

Хойт зүгийн Цастан, Ли орны арын цас хийгээд зүүн, урд, баруун гурван далайд тулсан Замбуутивийн газар дэлхий хийгээд тавин жижиг тивийг эрхэндээ хураасан бөлгөө. Түүний хойно архад Дагва Үнэхээр туулсан Бурхан багшийн эшийг номлоод, “Түүнчлэн ажирсаны шарилын шим болсон суврагаар газар дэлхийг чимтүгэй” хэмээн айлтгасанд, Бурхан багшийн шарил хэрэгтэй болж, Мажэйда хааны ясыг хааны ордны их сувраганы доор санд нуусныг гаргахын тулд хаан хийгээд архад Дагва нар ардын чуулган лугаа тэнд заларч, газрыг ухваас босоо хүмүүний орчим олдсоны доор гал бадарсан төмөр хүрд хүчтэй эрчилэн эргэлдэж, авах газар олдохгүй байхын цагт тэр орны нэгэн хөгшин эм аргыг ийн заан “Тэр газраас гурван бээр орчим баруун зүгт буй нэгэн уулын хормойд ус урсаж буй түүнийг эргүүлсэнээр хүрд эргэх нь зогсож гал нь унтарх болой” хэмээв. Жич бас газрыг ухваас зэс номон дээр “Энд түүнчлэн ажирсаны шарил Магада их суулга нэгнээ буй бөлгөө. Ирээдүй цагт ядуу нэгэн хаан гарах бөлгөө” хэмээн бичсэнийг үзэж, Ня-Ан-мэд хаан омгийн эрхээр” Үүнийг гаргагч нь би биш бөлгөө. Ядуу хэмээхийн тухайд өөр нэгнийг ойлгох хэрэгтэй” хэмээн буруу харан суусанд, бас дахин архад Дагва дуртгаад, цааш нь долоон босоо хүмүүний орчим газар ухваас төмөр хайрцаг тэргүүтэн гадна, дотно долоон буйн амыг нээвээс урьд нь Магада нэгэн суулга дүүрэн байсан Бурхан багшийн шарил арвидаад, зургаан ачмаг орчим болсон ба хайрцагны дөрвөн өнцөгт өөрөө нэг хөрш орчим газар гэрэл цацруулан нижгээд, нижгээдийг тахилын эд болгон тавьсаныг харж, тэр эрдэнэ нэгний үнийг нь гаргаваас Ня-Ан-мэд хааны хаан төрийн эд, эдэлбэр бүхэнтэй жишихийн арга үгүйг мэдэж, хааны омог дарагдсан болой. Тэгээд нэгэн суулга их эрдэнийн шарилыг аваад, жич бас өмнөхчлөн оршуулан нуун соёрхоод, төмөр хүрдийг ч байгуулав. Нууц усыг ч өмнө мэт буулгаснаар өмнөх мэт гал бадраад, эргэхүйд жич бас дээрээс нь булсан болой. Тэгээд их сүсэг лүгээ төгс ардад зарлиг буулгаж, элч хийгээд үйлийн нөхөд бүхнийг хүчит ягчисуудаар талбиж, найман их орны суврага хийгээд бас бус хойт зүгийн Ли орноос нааш Замбуутивийн улс бүхнээ Чадагчийн шарилын шимт суврагыг босгосон ба нэгэн өдөр, шөнөд найман түмэн дөрвөн мянган суврагыг босгожээ.

Тэгээд орон бүхнээ зарлиг тушаагаад, суврага бүхнээ зул хийгээд хүжис, цэцгийн эрхис мянга, мянгаар өдөр бүр тахин үйлдсэн ба бодь модыг арван мянган алт хийгээд мөнгө, биндэръяан хумхыг сайхан үнэрт ус хийгээд таван зүйлийн

рашаанаар огоот дүүргэн тахин үйлдсэн ба өнө холоос хүжис хийгээд арван мянган зулаар тахиж үйлдсэн бөлгөө. Тэнд гурван сарын турш жаран мянган архадыг урин залаад, өдөр бүр Бадалибудрагийн дээд огторгуйд оршоон соёрхуулаад, элдэв эдээр тахив. Хутагт, шавь нар хийгээд тус, тусдаа төрсөн бурсан хуврагуудыг газрын дээр тахиж үйлдсэн бөлгөө. Түүний сүүлд гэлэн нижгээд, нижгээдийг буман хувцасаар хангасан буй. Түүний шөнө суврагуудыг харуулахын тулд хаан нөхөр сэлтийг хүчит ягчисууд мөрөн дээрээ аваад, долоо хоногийн дотор Замбуутивийн газар бүхний чухаг дээрээ аваад, долоо хоногийн дотор Замбуутивийн газар бүхний чухаг дээд гурвын суврага бүхнийг тойрсон ба тахилын үйлийг арав дахин арвижуулсан ба Бурхан, шаравагын суврага бүхэнд нижгээд, нижгээд алтан чимэг өргөсөн буй. Бодь модыг их эрдэнэ бүхнээр үлэмж чимэн үйлдсэн бөлгөө. Наймдугаар өдөрт: “Миний буяны үндэс үүгээр хүмүүний дээд бурхан болтугай! Хэмээн ерөөлийг дахин, дахин тавьсан бөлгөө. Ардын чуулганд “Машид баясахуйгаар даган баястугай! хэмээн өгүүлсэнд олон ард “Хааны энэ зохиол нь их үйлтэй ч үр багатай бөлгөө. Нэгэн хэсэг дээр үгүй бодь хэмээх ч үгүй болвоос хааны энэ ерөөл хаанаас бүтэх билээ” Хэмээхүйд “Хэрэв миний энэ ерөөл бүтэх болвоос их газар дэлхий ч хөдлөх болтугай! Огторгуйгаас ч цэцгийн хур буухуйд, тэдгээр ардууд ч сүсэглэн ерөөлийг тавьсан болой. Алины үед суврагыг мялаахын тухайд гэлэнгүүд гурван сарын туршид тахилыг үйлдэж хайлан завсарлахуй өдөр тус, тусдаа төрсөн олон гэлэн гэнэт ажиран ирж, хаан ч үзэсгэлэнгийн цэцэрлэгт их тахилыг үйлдсэн ба тэдгээрийн эхэнд нь суусан нэгэн өвгөн гэлэнд тахилыг үлэмж их үйлдсэн бөлгөө. Тэр өвгөн гэлэн нь сонссон нь өчүүхэн ба маш мунхаг, ганцхан шүлэг номыг ч уншиж үл чадах нэгэн бөлгөө. Залуу гэлэнгүүд дотор аймаг савыг баригч нар ч олон буй бөлгөө. Зоог барьсаны сүүлд доод суудалд суусан гэлэнгүүд: “Хаан таныг илүү хүндэлж буйн учрыг мэдэж байна уу?” хэмээн асуухуйд, өвгөн: “Мэдэхгүй байна” хэмээв. Тэд: “Үүнийг бид мэдэж байна. Одоо хаан ном сонсох цаг боллоо. Та ном номлох хэрэгтэй” хэмээхүйд өвгөн гэлэн түүний аньснаа буусан мэт болжухуй. “Би гэлэн болж жаран жил болсон ч нэг ч шүлэг ном мэдэхгүй болохоор хэрвээ өмнө нь энэ хэргийг мэдсэн болвоос энэ сайн идээг өөр гэлэнд өгөөд ном номлуулах байлаа. Эдүгээ зоогийг идсэн болохоор яавал сайн бэ?” хэмээн сэтгэж, ихэд зовж ахуйд, тэр цэцэрлэгт оршсон тэнгэр бээр: “ Хэрвээ хаан энэ гэлэнд

сүсэг төрөхгүй бол үл болно” хэмээн сэтгэж, хувилсан дүрээр тэр гэлэнгийн өмнө ирээд, Хаан ном сонсох болвоос, “Их хаан аа! Уул лугаа сэлт энэ их газар дэлхий эвдрэх тул хааны хаан төрийг ч хэлээд яах вэ? Их хаан үүнийг санаваас зохистой! хэмээн хэлтүгэй” гэв.

Тэгээд хаан ирээд, эл шар хувцас нэгнийг өмсөж, ном сонсохуйн тухайд суухуйд, өмнөх тэнгэрийн үгийг өгүүлсэнээр хаан сүсэгтэн мөний тул “Энэ үг ихэд үнэн” хэмээн сэтгээд, шар үсээ сэрвийлгэн байж түүний утгыг сэтгэсэн бөлгөө. Тэгээд цэцэрлэгийн тэнгэр бээр: “Өвгөн гэлэн та сүсэгтний өглөгийн эдийг бүү бүрэлгэтүгэй!” хэмээв. Тэр ч багшдаа увдис айлтгаад, нэгэн үзүүрт сэтгэлээр бясалгаваас гурван сараас архадын хутгийг олоод, гучин гурван тэнгэрийн оронд Ёндүсадол хэмээх цэцэрлэгт яр хайлан хийсэн бөлгөө. Жич Бадалибүдра бурсан хувраг хийгээд олон ардын голд ирсэнээр хааны өгсөн хувцсанд Ёндүгийн сайхан үнэр тогтсоноор тэр орон бүхнээ сайхан үнэр баясган түгэв. Бусад гэлэнгүүд тэр өвгөн гэлэнгээс учир шалтгааныг асуусанд тэр ч урьдын түүхийг номлосонд бүгдээр онц гайхамшигтай болцгоов. Тэгээд тэр түүхийг хаан ч сонсов. Ухаан нь машинд мохдог гэлэн ч архадын хутгийг олсон нь номын эрдэм хийгээд тэр ч өөрийн хувцсыг өргөсөн шалтгаанаар гарсаны тул болой. Өглөгийн бусад хэргийн тус эрдмийг сонсож, бас дахин гурван буман гэлэнд таван жил цагийн их хуримыг үйлдээд, наран цухуйхуйн анхдугаар хувьд архадуудад, хоёрдугаар хувьд хутагт шавиудад, гуравдугаарт тусгаар төрсөн бурсан хуврагуудад хоол, дээл хувцасын тахилыг өргөсөн болой. Тэгээд тэр хааны насан титэмийн сүүлийн цаг үес нэгнээ Ни-Огийн зүг хийгээд Хачэ болон Тогар бурсан хуврагуудад зуун живаа алт өргөхөөр тангараглаж, Хачэ хийгээд Тогарын бурсан хуврагуудад төгс өргөсөн болой. Эд хэрэгсэл бусдыг ч түүн лүгээ адил өргөвэй.

The lethal war with Kalinga transformed the vengeful Emperor Ashoka to a stable and peaceful emperor and he embraced Buddhism. This led to the expansion of Buddhism in the Mauryan empire and other kingdoms during his rule, and worldwide from about 250 BCE.^[17] Prominent in this cause were his son Mahinda (Mahendra) and daughter Sanghamitra (whose name means "friend of the Sangha"), who established Buddhism in Ceylon (now Sri Lanka).

Death and legacy

Ashoka ruled for an estimated forty years. Legend states that during his cremation, his body burned for seven days and nights.^[18] After his death, the Mauryan dynasty lasted just fifty more years until his empire stretched over almost all of the Indian subcontinent. Ashoka had many wives and children, but many of their names are lost to time. His supreme consort and first wife was VidishaMahadeviShakyakumariAsandhimitra. Mahindra and Sanghamitra were twins born by her, in the city of Ujjain. He had entrusted to them the job of making Buddhism more popular across the known and the unknown world. Mahindra and Sanghamitra went into Sri Lanka and converted the King, the Queen and their people to Buddhism.

In his old age, he seems to have come under the spell of his youngest wife Tishyaraksha. It is said that she had got Ashoka's son Kunala, the regent in Takshashila and the heir presumptive to the throne, blinded by a wily stratagem. The official executioners spared Kunala and he became a wandering singer accompanied by his favourite wife Kanchanmala. In Pataliputra, Ashoka heard Kunala's song, and realised that Kunala's misfortune may have been a punishment for some past sin of the emperor himself. He condemned Tishyaraksha to death, restoring Kunala to the court. In the Ashokavadana, Kunala is portrayed as forgiving Tishyaraksha, having obtained enlightenment through Buddhist practice. While he urges Ashoka to forgive her as well, Ashoka does not respond with the same forgiveness.^[12] Kunala was succeeded by his son, Samprati, but his rule did not last long after Ashoka's death.

The reign of AshokaMaurya might have disappeared into history as the ages passed by, had he not left behind records of his reign. These records are in the form of sculpted pillars and rocks inscribed with a variety of actions and teachings he wished to be published under his name. In the process, Ashoka left behind the first written language in India since the ancient civilisation of Harappa. The language used for inscription was Prakrit.

In the year 185 BCE, about fifty years after Ashoka's death, the last Maurya ruler, Brihadratha, was assassinated by the commander-in-chief of the Mauryan armed forces, PusyamitraSunga, while he was taking the Guard of Honor of his forces. PusyamitraSunga founded the Sunga dynasty (185 BCE-78 BCE) and ruled just a fragmented part of the Mauryan Empire. Many of the northwestern territories of the Mauryan Empire (modern-day Afghanistan and Northern Pakistan) became the Indo-Greek Kingdom.

In 1992, Ashoka was ranked No. 53 on Michael H. Hart's list of the most influential figures in history. In 2001, a semi-fictionalized portrayal of Ashoka's life was produced as a motion picture under the title Asoka.

King Ashoka, the third monarch of the Indian Mauryan dynasty, has come to be regarded as one of the most exemplary rulers in world history.

ЗАЯ БАНДИДА ГЭГЭЭНТНИЙ ЭНЭТХЭГ ОРОНД ХУВИЛСАН ГУРАВДУГААР ДҮР ШУ -ВАМ ГАРА ТЭРГҮҮН “СУГАБАДИЙН ОРОНД МЭНДЭЛСЭН ВАБАСАМБУУГ НЭМЭН ТООЛБОЛ ДӨРӨВДЭХ ДҮР”

Монгол эх сурвалжаас нь дурьдваасу: Дөтгөөр төрлийн нэр ануу Шубамгара энэтхэгийн газар хувилан гарч олон ном номлохуй бүтээхүй бээр мянган гэрэл цацруулан алдарт мэргэдийн оройн чимэг болчихуй явагсануу хойно гэсэн бол

Зая Лувсанпрэнлайн хураангуй түвд намтарын тухайн хэсгийг орчуулбасу:

Ерөөлийг хүчтэй хатуу ихээр талбиж

Ертөнцөд эргэн бууж амьтаны тус хийж

Арилаагүй орны амьтаны тус үйлдэгч

Ачит багш шу вамгара мэргэдийн туйл гэж бичжээ.

Ванчин, Далай лам нарын түвд хэл дээр зохиосон Зая гэгээний төрөл тутамын залбиралын тухайн хэсгийг орчуулбасу:

Урьдаас сайтар бэлтгэсэн дээд хөрөнгөөр

Ухаан билгийн модны мөчрийг сагсайлгаж

Ухвар мөч шавь нарт бусдад туслах үр суулгасан

Ухаант багш шувамгара дор залбирнам хэмээжээ.

Жонон дарнатын зохиосон “Дээдийн ном их эрдэнэ хутагтын оронд ямар мэт дэлгэрсэн ёсыг тодорхой үзүүлэн хүсэл бүгдийг гаргагч” хэмээх түвд хэл дээр буй зохиолын 23-р бүлэгт Ловон чожи лонбуу тэргүүтний үеийн домогт Гэнэншивигочоо бээр бодолаад хүрсэн цаг адил буюу нэгэн цаг дор, Бүндани хэмээх орны ой шугуйд хутагт Арьяабалын хувилгаан бүтээл хийж гүйцсэний шинж нь гарч ШУВАМХАРА гэх хааны зүүдэнд Арьяабал хутагтыг залбал энэ оронд зуд турхангүй болно хэмээн хамаг гэнэнгүүдийг дуудаж Сувдан эрхийн хамт урин залсан болой гэж зухас дурдагдав. Тэгэхээр Арьяабал бурханыг хаана заларч буйг зүүдээрээ мэдэрдэг хосгүй нэгэн байсан нь тодорхой байнаа.

Бас 25-р бүлэг Сэнгэ -ава тэргүүтэний домогт Сэнгэ-ава хэмээх машинд хүчтэй хаан нэгэн гарч түүний хөвгүүн Сэдазандраагийн Ваалазандраа бээр хаан ВАМХАЛА гаас орныг аваад Дэрахүди төр тэтгэсэн болой гэж гарч буй нь энэтхэг дотроо тэмцэл ихтэй байсныг харуулж буйзаа.

Мөн тус бүлэгт Зэндраагийн язгуурын олон хаан гарсан ч төрийг тэтгэсэн нь үгүй бөгөөд Вамгара, Одивиша тэргүүтэн зүүн

зүгийн орны аймгийн хаан язгуур хийгээд бярман тус тусын гэртээ ноёд болжээ гэж гарсан бол.

Ахин 39-р бүлэг зүүн зүгийн гого оронд шашин дэлгэрсэн домогт Энэтхэгийн өмнө зүгийн орон нь гурван хэсэгт хуваагдах бөгөөд Вамгара, Одишива, Ни -огт харъяалагдах тул зүүн зүг дор багтаамой гэж гарсан байна.

**ЗАЯ БАНДИДА ГЭГЭЭНТНИЙ ЭНЭТХЭГ ОРОН
ДОР ХУВИЛСАН ДӨРӨВДҮГЭЭР ДҮР БА
СУГАБАДИЙН ОРОНД МЭНДЭЛСЭН ВАБА САМБУУГ
ОРУУЛЖ ТООЦВОЛ ТАВДАХ ХУВИЛГААН
ЛОВОН РАДНА СЭДИ**

Монгол бичигт гарсан товч намтраас дурьдвал :

Тавдугаар төрлийн нэр ануу: Их бандида Раднасэдэд энэтхэг газар хувилгаан гарч мэргэн шидийг олох болюу магуу тэрсүүдийг номхотхон бурханы шашиныг дэлгэрүүлж явагсаны хойно гэж дурьдагдсан бол Түвд бичгээр зохиогдсон зая бандида Лувсанпрэнлайн хураангуй намтараас эшлэвэл:

Шашин амьтаны тус амгалангийн хэмжэшгүй гуу сан мэндэлж Шамдалаар дахин хувиран хичээж мэргэдийн үзүүрт очиж

Бэрх тэмцэлийг тууривал бүтээлээр шашинаа хамгаалж

Буруу явдалт тэрсүүдийн хахирган дууг хорин цагдаж

Бурханы шашины үнэнч итгэл болон манлайлагч

Банчин Радна сэди ловон ялан дийлэх болтугай хэмээсэн бол Ванчин богд Далай лам нарын Зая гэгээнтний төрөл тутмын залбиралаас эшлэвэл:

Бурханы шашин цастай өндөр уул мэт оршихуй хийгээд Бумбан цоргоор маш хүчтэй таван язгуурын билгэ билгээр Буруу өгүүлэгчдийг бутраан урсгаж эцэслэн зохиогч

Банчин Раднаасэд дор залбирнам хэмээн үсэг үг өөр боловч утга чанар нэгэн бээр өгүүлж буй сурвалжууд хоорондоо маш сайхан утга төгөлдөр таарч байна .

ЗАЯ БАНДИДА ХУТАГТЫН ТҮВД ГАЗАР АНХЛАН МЭНДЭЛСЭН ЗУРГААДУГААР ХУВИЛГААН ЛОДОЙРАВДАН ТЭРГҮҮН

Монгол бичгээр үйлдсэн Зая гэгээний хураангуй товч намтараас энэтхэгт хувилсан тавдугаар хувилгаан Лодойравдангийн намтрыг дурьдвал:

Зургаадугаар төрлийн нэр ануу түвд газар хувилгаан гарч бурханы эрхэм зарлиг хийгээд энэтхэг түвд хэл дор төгс мэргэшиж мэргэний манлай болоод янагш түвдэд шашин үлэмж дэлгэрүүлж явагсаны хойно гэсэн бол

Зая гэгээний товч хураангуй түвд намтараас эшлэн монголчилбол

Хутагтийн хоёрдох орон болох цаст түвдэд

Хоцроолгүй дээдийн номыг дэлгэрүүлэн зохиож

Хос хэлээр өгүүлэхийн мэргэдийн дээд манлай

Хосгүй лозава ловон Лодойравдан тэргүүн гэж магтсан байдаг. Ванчин, Далай лам нарын түвд хэлдээр зохиосон Зая гэгээний төрөл тутамын залбирлаас эшлэвэл:

Хутагтийн орны мэргэдийн өндөр ууланд сайшаагдан зохиогдсон

Хосгүй дагшин ариун гангийн рашааныг салаалан шуудуулагч

Хувь төгөлдөр их тэрэгтэн орчлонгийн нүдэн болсон

Хэлмэрч мэргэн Лодойравдангийн өлмийд залбирнам хэмээжээ.

Тэгвэл Жонон дарнатын зохиосон энэтхэгийн түүх гэх түвд судрын 23-р бүлэгт тэр үед хачи оронд олноо өргөгдсөн хаан заларч байхад, зүүн зүг дор ловон Лодойдамба, Чогжилонбу нар шашин амьтаны тусыг агуу ихээр зохиожээ гэсэн бол ахин тэр бүлэгт Ловон Лодойрадан ловон Егнэнтэй “ерэн зургаанбуман аймаг сав номыг нигуураараа уншихын цагт суварганы завсар суусан тагтаа маш их сүжигтэйгээр сонссон ажгуу. Тэрбээр үхээд өмнө зүгийн худалдаачны хөвгүүн болж төрөөд, төрсөн даруйдаа ловон хаана байна хэмээн асууж магада оронд ловон Егнэнг сурсаар очив. Ловонгийн хажууд ном сонсонгуут багчаг нь сэргэж заалгалгүй сурч байв. Тэр үед нэгэн атаг буурцаг олоод иддэг юм билүү хэмээн сэтгэж хутагт дарь эхэд дээжийг өгөлгүй идэж болохгүй хэмээн бодож дуустал буурцаг нь хэвээрээ байсанд хөвүүн уйлжээ. Тэгтэл хутагт эх нигуураа үзүүлэн бүү уйл

адистэдилсэн юм. хэмээн зарлиглав гэж зухас дурдагдсан бол мөн тэр бүлэгт ловон Лодойравдан бээр төв үзлийн язгуурын таалалыг тийн ухаанд нэгэн сэдвийн ялгалыг тайлсан зохиол бичсэнийг тэмдэглэсэн байна. Басхүү энэ номын 24-р бүлэг анцүл хааны домогт Их ловон Лодойравдан бээр Сударын аймаг хийгээд авидармийн аймаг сав номыг нэгэн удаа сонсоод бүгдийг мэджээ. Түүнчилэн Вэдийг баригч ловон нянмидба хэмээхээс зарлиг ишийг хүртэж жанрайсиг, дарь эх бурхадын нигуурыг үзэж ихэд мэргэн болов гэж энэтхэгийн түүхэнд нэрээ үлдээсэн том ловон байжээ.

ЗАЯ БАНДИДА ХУТАГТЫН ДОЛООДУГААР ХУВИЛГААН СОДНОМБАЛДУЙ

Монгол бичигт тэмдэглэгдсэн хураангуй намтраас дурьдвал:

Долдугаар төрлийн нэр нь Содномбалдүв түвд газар хувилгаан гарч санваар сайтар сахиж чадал еэр гарчухай, сайхан үнэр түгээмэл анхилам хувь төгөлдөр амьтны санваар сахихийн сайн мөр дор удирдаж туслан явугсаны хойно гэж анх түрүүн сахил санваар сахиж болдог гэдгийг мөн сахил сахисанаар шагшаабодийн үнэр анхилам болдог винайн ёсыг зөрчилгүй даган үр дунд хүрч гэлэн сахил сахивал ийм хүндлэл гайхамшгийн туйл болдгийг практик дээр нотолсон анхны түвд санваартан байжээ.

Зая гэгээнтний намтрыг хураангуй үзүүлсэн түвд сударт:

Шашины үндэс сахил санваарын аньсыг

Шамдал ихээр зөрчилгүй ёсчилан сахисан

Аминаасаа илүү сахилаа сайтар хамгаалагч

Алдарт винайва Содномбалдүв богд хэмээн яруу сайхнаар магтсан бол

Ванчин, Далай лам нарын айлдсан Зая гэгээн Лувсанпэрэнлай, Зая гэгээн Лувсанняндаг нарын төрөл тутмын залбиралд: Асар ариун шагшаабодийн маш бат малайн цэцэрлэгт Агуу бясалгал билгэ билгийн хайри зандан мод Цоморлогоо дэлгэж ашдийн амгалант үнэрээр сүрчигч Цуут богд Содномбалдүвийн өлмий дор забирнам гэж яруу үгсийн чугуулганыг уралдуулан байж магтсан нь цаанаа шашин дэлгэрч буй үгүйг сахил санваар сахисан хүн байнуу үгүй юу гэдгээр хэлдэг шашины жинхэнэ шим болохыг харуулсан ба үнэхээр их богд гэдэг нь батлагдаж байх шиг.

Бас түвдийн ёнзон иш жанцанбогдийн зохиосон “Ламрим лама жүдвийн намтар буюу Бодь мөрийн зэргийг дамжуулагч багш нарын намтар хэмээхүйд Хайнзүн Содном балдүв хэмээн товч намтар буйг түвдээс орчуулбаасуу: Түвдийн ари ман хэмээх орны хааны, язгуурт лагшин мэндэлж багаасаа бэтүв хийдэд орж сахил хүртэн гэнэн сахилтай болж, улмаар занд очиж Дашилхүнбү хийдэд орон шалгадаг ухаан, билиг барамид, төв үзэл, винай, илт номын аймгийг судалж мэргэдийн туйлд хүрчээ. Тэгээд үйд хүрч Дүйби ванчиг аграмба гэндэндаши багшаас Чагдор хорчингийн авшиг тэргүүтэй ван лүн олныг авчээ. Тамжид чинба Содномжамцаас нянбу дон сүмжийн тайлбар тэргүүт олон ном

сонсож, Ти ренбучигээс богд ламын зохиосон бодь мөрийн зэргийг дэлгэрэнгүй тайлбартай нь сонсож анхааран авч үг бүрийн утгыг нарийн судалж орхигдуулалгүй ёсчилан судалсан бөгөөд бодийн зэргийн багш нарыг ээлж дараалан шүтэж аглагт очин бясалгаж мэргэдийн туйлд хүрсэн тухай бэсрэг товч намтар өгүүлбээс энэ буйзаа.



НАЙМДУГААР ХУВИЛГААН ВАНЧИН ЧОГЛАЙ НАМЖИЛ ИХ БОГД

དབྱངས་ ཅན་ བྱིན་ ལྷབས་ རོར་ བུ་ ཀེ་ ཉ་ ཀས། །ལེགས་ བར་ བསྐྱེདས་ བྱས་ ལྷིང་ དབུས་ ལུ་ མཚོར་
ཆེར། །མཐའ་ཡས་ཤེས་བྱས་འཆར་པའི་གཟིགས་མོ་ཅན། །སྤྱོདས་ལས་རྣམ་པར་རྒྱལ་ལ་གསོལ་བ་
འདེབས།།



ᠠᠨᠴᠢᠨ ᠴᠣᠭᠯᠠᠢᠨᠠᠮᠵᠢᠯ ᠶ᠋ᠢᠬᠤ ᠪᠣᠭᠳᠠᠨ ᠳᠦᠷ
 ᠳᠠᠪᠤᠠᠭᠤᠨ ᠳᠡᠭᠡᠷ ᠪᠠᠷᠯᠠᠨ ᠤᠯᠳᠡᠭᠡᠰᠢᠨ ᠡᠬᠤ ᠵᠢᠷᠠᠭ

Ванчин Чоглайнамжил их богдын дүр давуун дээр барлан үлдээсэн эх зураг

ᠲᠦᠪᠠᠭᠤᠨ ᠶ᠋ᠸᠠᠨ ᠶ᠋ᠸᠠᠨ ᠶ᠋ᠸᠠᠨ ᠶ᠋ᠸᠠᠨ ᠶ᠋ᠸᠠᠨ ᠶ᠋ᠸᠠᠨ ᠶ᠋ᠸᠠᠨ ᠶ᠋ᠸᠠᠨ ᠶ᠋ᠸᠠᠨ
 ᠶ᠋ᠸᠠᠨ ᠶ᠋ᠸᠠᠨ ᠶ᠋ᠸᠠᠨ ᠶ᠋ᠸᠠᠨ ᠶ᠋ᠸᠠᠨ ᠶ᠋ᠸᠠᠨ ᠶ᠋ᠸᠠᠨ ᠶ᠋ᠸᠠᠨ ᠶ᠋ᠸᠠᠨ

**Цог төгөлдөр охин тэнгэрийн адистэдээр
 Чугуулган үйлсийн их далайг
 Цэцнээр гатлах онгоцыг жолоодогч
 Чандмань эрдэнэ Будан гэгээнд залбирнам.**

ЗАЯ БАНДИДА ГЭГЭЭНТЭНИЙ НАЙМДУГААР ХУВИЛГААН ЧОГЛАЙ НАМЖИЛ ИХ БОГД

Монгол бичигт тэмдэглэгдсэн эх сурвалжаас дурьдвал: Наймдугаар дүрийн нэр их бандида Чоглайнамжил түвд газар хувилгаан гарч ухааны орны бүхий л бэрх оньсыг бүгдийг мэдэн номлохуй, тэмцэхүй, зохиохуйн, мэргэдийн орон дор өндөр самбагааг эрхшээгсэн шашин хийгээд амьтны тусыг үйлдэж явагсаны хойно хэмээн бичсэн байдаг бол

Зая гэгээнтний товч намтар гэх түвд судраас эшлэвэл:

Дуун эгшигийн охин тэнгэрийг илт дагуулсан

Дээд язгуурын ухааны орон бүгдийг ухаарч мэдсэн

Маргаан мэтгэлцээний мэргэний дээд болсон

Манлай богд чоглай намжил тэргүүн богд гэжээ.

Ванчин богд Далай лам нарын зохиосон Зая гэгээдийн төрөл тутамын залбирлаас эшлэвэл:

Янжмаагийн адистэдтэй эрдэнийн гэдага

Сайтар мэндэлсэн ухааны шимийн далайд

Ямарваа мэдэгдэхүүнийг болгоогч хур болох

Сайн мэргэдийн дээд Чоглайнамжилд залбирнам хэмээн магтаж бичсэн байна.

Миний номын багш Дээрхийн гэгээн 14-р Далай лам Данзан жамц тэргүүний Намжил дацангийн хамба жүд дод дацангийн лам унзад гэвш лхарамба, аграмба Жадо ренбучи бээр энэхүү Чоглай намжилтай холбогдох Ванчин богд, Далай лам нарын түвд хэл дээр зохиосон тунрав солдэв буюу төрөл тутмын соёрхолыг үзээд Бүдон Чоглой Намжил яг мөн харин Бүдан ренчиндүвтэй андуурч болохгүйг анхааруулсны дагуу би бээр БүдонЧоглайнамжил гэгээнтний товч намтарыг түвдээс орчуулан оруулав.

Бүдончоглайнамжил нь зургаадугаар жарны модон эм туулай жил 1375онд түвд газар лагшин мэндэлж эрдэмд суралцан мэргэдийн оройн чимэг болон бурханы шашиныг өндөрт өргөсөн ба наймдугаар жарны төмөр эм хонин жил 1451он лагшин номын агаарт оршин гаслангаас хагацав.

Үлэмжийн тэнгэр дуун эгшигт охин тэнгэр даган барьсан ба ухааны таван орныг эцэслэн шавхсан торолт үгүй өгүүлэгч маха бандида бүдонванчин хэмээн алдаршив. Цастны орны мэргэдийг ухааны таван орноор мэтгэлцэн дийлэв. Иймээс дунта буюу

тогтсон тааллын зөрүүтэй хэсгийг хооронд тааруулан зохисон тул хойших шавь нар нь бүдонлүг буюу бүдонгийн ёсыг дагах болов. Түүний алдар Бүдон чоглайнамжил, Жигмэддагба, Чойжижанцан гэх зэрэг олон алдартайн зэрэгцээ шавь нар нь шашиныг бүрэн мэдсэн их ловон хорин гурав, увидасыг дамжуулан авсан гурав, их тарничин нэг, хоёр хайдав, мянга гаран гавж, болон ном заасан шавь нар нь арван мянга гаран байв. Мөнхүү түүний бүтээл нь билиг барамид, төв үзэл, шалгадаг ухаан, илт номын аймаг, винайн чиглэл болон элдэв бүтээл дуун ухаан, яруу найраг, зурхай, эм зүй, хэлзүй түүх зэргийг нэгэн дор эмхэтгэн туурвисан нэг зуун гучин хоёр боть номтой болно. Тэдгээр номон дотор эрт дээрийн мэргэдийн бүтээлээс оруулсан нэгээхэн ч зүйл үгүй болно.

Орчин үеийн эрдэмтэн мэргэд түүнийг бүтээлийг ихээр тайшаан ширээний ном болгосоор ирсэн билээ.



ЕСДҮГЭЭР ХУВИЛГААН САЙН НОЁН ХАН ХӨНДЛӨН ЦОХҮР

བདེ་གཤེགས་འོད་མཚན་སྣོད་འབར་གླ་མ་ཡིས། །མྱ་ངན་མེད་ཅེས་ཡངས་པའི་རྒྱལ་ཁབ་སྲུ། །ཕན་
བདེའི་ ལེགས་ ཚོགས་ སྤེལ་ བར་ དབང་ བསྐྱར་ བ། །ཚོས་ ལྷན་ རྒྱལ་ བོར་ གྱུར་ ལ་ གསོལ་ བ་
འདེབས། །

ЗАЯ БАНДИДАГИЙН ЕСДҮГЭЭР ХУВИЛГААН САЙН НОЁН ХАН ХӨНДЛӨН ЦОХҮР

Монгол үсгэн дэх хураангуй намтрыг дурьдвасу:

Есдүгээр дүрийн нэр ануу сайн ноён хэмээн алдаршчухай халх еэн хоёрдугаар Чингис хагаану сүрт, хорин есдүгээр үеийн онохуй үйзэн ноёны гутгаар хөвгүүн болюу, Хувилгаан багаатар шидтэй, халхын долугаан хошгууны шашин төрийн үйлийг товчилжу байгсану дэгээр халх ээцээс түвд дор нэн тэргүүн одох замыг гаргажу баруун зан дор хүрчү Далай лам, Ванчин Эрдэнэтэй бараалан мөргөгсөн дор ману эндэх шарын шашин улгаануу шашин хоёр ихэд тэмцэл болугсан дор үлмэж туслав. Чи эрт бурханы үеэс инагш бурханы шашиндуу ихэд тустай бологсогоор ирэгсэн, идүүгээч шарын шашин дор их тустай болов хэмээн шагжаа муни бурханыг тэтгэгч Гаслан үгүй номын хагаан хүндүлэн цүхүр хэмээх үсэг мөнгөн дээр сигилэжу өгчүхэй. Жанч халагсан дор тэгүүний хэгүүрийг хайлан үйлдэгсэн цаг дор тэргүүн ээцээс Авид бурханы дүр, шилбэн ээцээс номын “А” үсэг, зүрхэн ээцээс баруун эргэсэн цагаан лавай илгугдан өвөр еээн тус тус тодорхой бүтэгэсэн. Энэхүү тэмдэгтэй болугсан учиртуу Далай лам бээр эндүүрэл үгүй Логушарын хувилгаан мөн хэмээчухай. Эгүүн ээц дэгээш энэтхэг түвдийн газардуу найман үе, халхдуу нэг үе хувилгаан гаругсан жанч халсану он сарыг байцачуухуй тэмдэглэл үгүй.

Хэмээн тэмдэглэн бичсэн бол Зая гэгээний товч түвд намтарт дурьдсаныг орчуулбасу:

Цэвүүн цагийн таван тэмдэгт монгол оронд

Цохлон муу үйл боловсорсон ч барилдлагат

шавь нараа болгоохоор

Зузаан мунхагын харанхуйн үндэсийг булга татан өгч

Зуурдын бус ашидын цог амгаланг байгуулахаар

Таван болгоолтоор аав эжий хаан язгуур сонгон

Тэнгэр газрыг эзэгнэсэн суут Чингис богдын

Дараалан залгамлах гуч дах үеийн баатар ухаалаг мэргэнээр

Долнуурын чуулганаар шашин төрийн тамгийг

таалалдаа авсан

Хойт зүгийн тахав газар амьтны тусыг сайтар бүтээн

Хөгжүүлэхээр түвдэд одогсодын замын журмыг нээж

Хоёр зову бурхан шүтээн Ванчин чойжин тэргүүтэй
Хосгүй шүтээнд мөргөн дээдэст бараалхан золгож


Син бэрэ гээ сүм дашилхүнбү гэх хийд орон олноор
Соёрхол талбин манз цав зэд барин дэлгэр буян хийж
Бүхнийг болгоогч Далай лам монгол Ёндонжамцын
Буяны хойд мөрд мөнгөн суварга бүтээлгэн өргөж

Мөр дуурсгахын тухайд мөнгөн дун дотор нь залав
Эвдрэлцэх шашныг зохицуулан энгүй буян хийсэнд
Эрдэнэ Ванчин богд бээр эргэлзээ үгүй болгоон
Чойжил нян ан мид хаан хүндүлүн цохур мөн хэмээн
Мөнгөн дээр сийлэн тамга хийж хоёр зовугийн
өмнө лхүнсэдэнд
Чойж цуургаар хааж хүн оруулалгүй гурав хонуулаад
Маргааш өдөр нь ноёнд билиг дэмбэрэлтэй өргөсөн гэдэг

Тэгээд ноён тагаалал барихийн цагт их гэрэл цацарч
Тэргүүнээс нь Одбагмидийн дүр өлмийнээс нь А үсэг
Тагаалал зүрхнээс нь цагаан лавай дун зөв эргэсэн гарсаныг
Тусгайлан хойд мөрт бүтээсэн Арьяабал бурханы
сүншигт хийв.

гэжээ. Мөн Ванчин Далай нарын айлдсан Зая гэгээний төрөл
тутмын залбиралдаа шүлэглэхдээ:

Бурханы мянган гэрлээр огоот бадарсан их багш
Буддагийн сургаалыг хамгаалагч агуу уужим хаан
Тус амгалангийн сайн чугуулганыг арвидуулан айлдагч
Түвшин их номт хаан Хүндлэн Цохурт залбирнам гэжээ



АРАВДУГААР ХУВИЛГААН ХАЛХЫН ЗАЯ БАНДИДА ЛУВСАНПЭРЭНЛЭЙ

བསེལ་ལྗོངས་དམ་པ་དུ་མའི་ཞལ་སྐྱོ་ལས། །འོངས་ལེགས་བཤད་ཚུ་གཏེར་ཆེན་པོའི་བཅུད། །འབྲུང་
བྱས་མཁས་དབང་མཐུ་གྲུབ་ཨ་ག་སྟ། །ཇི་ཡི་བརྗིད་ལ་གསོལ་བ་འདེབས། །

АРАВДУГААР ХУВИЛГААН ЭРДЭНЭ ЗАЯ БАНДИДА ЛУВСАНПЭРЭНЛЭЙ

Энэхүү Зая бандида Лувсанпэрэнлэй гэгээнтэний шавь Ганжуурваа номын хаан Лувсанцүлтэмийн түвд хэл дээр зохиосон наян хоёр хуудас бүхий гар бичмэл өөрт хадгалагдаж буй судрыг монгол хэл үрүү орчуулан анх удаа уншигч та бүхэнд толилуулж байна.

Хот мандал далайн эзэн очир баригч Зая бандида Лувсанпэрэнлэйбалсамбуугийн намтар жишээн бодралыг нийтэд хураангуйлан толилуулахуй хэмээх судар оршвой.

Багш очирдар дор мөргөмой,
Хязгааргүй галав дор билиг буяны,
Хоёр чугуулган огоот төгссөн, билэг тэмдэгт
Үлгэр дууриаллын цог машид бадарсан
Үзэсгэлэн төгөлдөр ариун лагшинтай,
Тоолош үгүй амьтны хүслийг хангагч
Татах түлхэхийн сайтар номлолын
Төгөлдөр гишүүн зарлигийн эгшиглэнтэй
Мэдэгдэхүүн бүхнийг хоцролгүй мэдэхдээ
Мутарын толион дээрх жүр үр мэтчилэн
Илт болгоогч нигүүлсэх тагаалалтай,
Ирээдүй одоо өнгөрсөн 3 цагийг ялан мэдэх,
Энэрэхийн хүч эрхийг огоот баригч
Эрхэм дээдсийн мөргөлийн орон,
Цэвүүн цагийн амьтан бүгдийг зүрхлэн энэрэхийн тулд
Цэцэн хүний дүрээр заларч олон бурхад дотроос
Цагаан лянхуа мэт онцлон гарахын бадрангуйн цог
Цэгц ном бүгдийг хоцролгүй илт болгоогч сэвлэгээ үргээж,
Цэвэр гэгээрэл ил шарийг баригч гайхамшиг
Цөхөрсөн амьтан нугуудын нисваннис болсон түйтгэрээс
Цаг алдалгүй аврахуйн тулд ариун бүхнээр дүүргэсэн
Атаархмаар бурхан бүгдийн ууган хөвүүн мэт
Ачит, гурван намба төгөлдөр очирийг баригч та ямагт болой.
Машид цагаан буян билгийн 2 чугуулган сангаас гарах
Мяралзах усчилан бүхэнд тунгалаг таны тагаалал

Оюун ухааны сайн хумхын дээд, дээдийн сайн чухаг
рашаан бээр доорд төрөлхтөнгийн хүсэл, уур,
мунхаг гурван өвчинг анагаах эм,
Эмийн дээд номын лагшин дөрвөн түм найман мянган
гурван ертөнцийн амьтан бүхэнд нэгэн дор
энэрэл үзүүлэгч багш,
Багш танаас өөр авралд мөргөхүй тул та би тэргүүтэй
өвчтөн бүгдийг аврах сонин
Сонин гайхамшигт билэг тэмдэг (үлгэрлүүштэй тэмдэгт)-ийн
цог бадрагч очир баригч,
Баригчийн чимэгт болсон өндөр оюунт бурханы ёсч,
Ёсчлон бүтээхийн мэргэн хуврага сайн цогт,
Цогт төгөлдөр багш мэргэнээр шийдэх бүхний туйл,
Туйлийн ачийн дэгээд нугууд бээр удирдагчийн
номхотгохуй бэрх
Бэрх амьтан дор очир хөлгийн номын хүрдийг
сайтар эргүүлсэнээс боловсрох
Боловсрох гэтлэхийн зам дор тасралтгүй байгуулан
зохиосон бурхан
Бурхан бүхнээс алжаал умартан болгоосон энэ нь
гайхамшигтай
Гайхамшигт Сумади гирдийн тагаалалийн наран
үйлсийн мянган гэрэл
Гэрэлтэн хойд зүгийн харанхуй тивд тус амгалан
жаргалангийн цэцэрлэгээр үзэж
Үзэсгэлэнт эрдэнэ бүгдээр дүүргэсэн зарлигийн ач
ханьцашгүй таны намтар
Намтрын эрдэнэ гарахын орон усан далайгаас ширхэг
үс дүрэхэд тогтох
Тогтуун усан дуслын төдий сүслэхийн үүднээс миний буян
Буян арвижуулахын тухайд өчүүхэн төдий хэлье .

Гэгээнтний сайн явдал бүхэнд мэдэгдэх огторгуй мэт боловч
үүнээс зүүний нүх төдийг огторгуй мэт өгүүлэхүй цагт махагала
тэргүүтэй номон сахиусийн чуулган барцад арилган үүлсийг
сарниулахүй бүтээхийн ачийн дээд,

Дээд хувилгаан удирдагчийн энэ биеэр оршигсон үлэмжийн
санаа сайн намтарыг нь бүдүүн тойм төдий сайн явдалд даган

баясах сэтгэлийн хувь доройтсон бүхэнд амгалан баясал аялгуулан дуулан мэдрүүлэх бидний ачийн дээд

Дээд энэрэлээр, урьдын цагт шагжа мүни Бурхан дор эрдэнийн сайн сав өргөж бодь сэтгэлийг үүсгэж Бурханы гэгээнээс “гандан шанну” хэмээн алдаршиж яруу алдарийн дувааз гурван ертөнцийг хөдөлгөв.

Бурханы Гэгээн хан хөвүүн энэ бээр Ирээдүй цагт дончир мядогжан буюу “ цэцэрлэг” хэмээх хотод мэндэлж шашин төрийг тэтгэнэ хэмээх Бурханы гэгээний лүндэнчилэн Хүн эрхт” чойжил нянан мид” Ерөөлийн хүчээр суврага олныг бүтээсэн Энэ мэт сонин гайхамшиг хоёр чугуулганыг хураасны хүчээр Диваажинд 1000 дэлбээт линхуа цэцэгнээс мэндэлж, мэндэлсний дараахан Одбагмид бурхны нигууртай золгож машид баясаж Бурханы гэгээний лүндэнчилэн бодьсадба “Вабасанба” хэмээн алдаршив.

Тэгээд тагаалал ерөөлийн хүчээр алаг хорвоод амьтныг татах багш шубамгара хэмээх мэргэдийн түүх, шашин амьтны тус амгаланг шаардлагагүй бүтээхийн сан мэндэлж,

Тэрээр хувилгаан мэргэдийн үзүүрт очиж номлол туурвилаар Бурхан багшийн шашныг барихийн цагт тэрсүүд буруу үзэлтнүүдийг дарж, бурхны шашныг дэлгэрүүлж бүхний итгэл “Ванчин раднаа” хэмээн алдаршив.

Хутагтын хоёрдугаар орон цаст уулын түвд оронд гадна дотно таван оронг хоцролгүй дэлгэн зохиогч орчуулагч” монлодой равдан” хэмээгч мэргэдийн туйл шашны ёзоор сахилийн аньсийг хорио цээрийг сайтар сахихийн Винайба Содном балдүв богд, дуун эгшиг лхамбу бээр илт даган баригч таван ухааны бэрхтэй аньс бүгдийг мэдэгч, номлох туурвихын мэргэдийн ажилд самбага өндөр Чоглай намжил богд болон хувилмой . Урьд гарсан ариун бүтээл санаанд багтамгүй энэтхэг түвдийн шашны хүрээг тэлсэн намтрын найлзуур модны мөчир лугаа анхдугаар.

Өгүүлрүүн: завсрын чимэг үгс

Багшийн дээд Зая бандид Баруун этгээд түвд лхасад

Ванчин, Далай ламын итгэл дааж

Багтаж санамгүй эрдмийг

Багцлан хурааж 60 хасаг тэргэлсэн

Багсайн саглайх намтарын мөчир лугаа нэг

Цэвүүн цагийн хойд зүгийн Монгол нутгын шавийг номхотгох цаг болгоогоод Үндэс язгуурын аав ээж болгоох тэнгэрийн

тагаалал зам төв хязгаар үгүй билиг, тэмдэг төгөлдөр огторгуйн их заан, мэдэх энэрэхийн даган одохийн хүчийг санаад гадаад тэрсүүдийг дарахын тэнгэрийн хэнгэрийн дуугаар лалын омгийг муужруулан буруу үзэлтэнг үр үндсээр булга татаж мөндөр, аянга цахилгаан машид бадарч харшлах зүг бүхнийг ялж үйл ерөөлийн барилдлагат хувь төгөлдөр шавь нугуудын өтгөн харанхуйг үндсээр нь цэлмүүлж ашдын амгалангийн үрийг болгохын тухайд газар тариалах мэт хааны язгуур эрхэмийн тул Чингис хааны язгуур төрсний өгүүлэхийн найлзуур мод урьд байгаагүй мэндэлсэн нь багшийн ач мөн хэмээн өгүүлэх бурхны сургуулиас

Тэр мэт хотын лам харчуулийн ялгадас баасаар, бордоход

Тэртээ ургах бурамийн мод цэцэглэхэд тустай

Тэрчилэн бодьсадба нарын нисванисийн хаягдал

Тэгээд бурханы ном үүсгэхэд тустай хэмээн зарлигласан мэт

Аврал итгэл ямагт сонин гайхамшигт их давалгаан ерөөлийн эрдэнэ баригчийн шимийг сайтар судалж мянган үзүүрт хорлоор тэргүүлэшгүй хувирах Асурын хөвгүүн арван (хоолой)уянга хэмээх Рамана хэмээгч оюуны хүч яруу дурсах хязгаарын Ладак гурван давхар хотын эзэн буруу үзлийн шилэн байшинд элдэв дүрс ургахчилан эндүүрэх үгүй болгоогч хану манда хоёр хамт хавсрах ёсыг хослон зарлигийг сахиж лалийн омгийг дарж шашин төрөө хөгжүүлж, Рэгдэн буюу шамбалийн хаадууд ч алжаал умартан гантай цагт буяны үр тариа боловсронгуй төрөлхийтөн ажил бүгд бууралт үгүй ашид арилгахын тухайд дээдийн номыг хурчилан буулгаж үргэлж сайн явдалд тасралтгүй тус амгалангийн үрийг тарьж өндөр язгуурын хүний биеийг олоод ээлэг буюу тарва олохын үрийг ишээр холбоод хэзээч доройтохгүй тагаалал нь гурван ертөнцөд түгэж хойд зүгийн төрөлхтөнгийн их эзэн огторгуй газрын эса шура Чингис хаанаас гучин үеийн Баатар цэцэн мэргэнээр(7хошуу) Цодунгийн шашин төрийн үйлийг тагаалалдаа үүрч умар урдын хязгаарын төрөлхтөн сайн ажлын чугуулганыг арвижуулан түвдэд одохын замын журмийг анх нээж “зандан зуу” болон Ванчинлуvsан Чойжий жанцан, Симба чинму дэмү хувилгаан тэргүүтэй дээдэс нугуудтай уулзаж Сэнбэрээ гэсүм, Даши лүнбү тэргүүтэй их бага хийд бүгдэд манж зэд барьж Ёндон-жамц далай ламын нас эцэслэхэд мөнгөн суварга бүтээхэд түмэн лан мөнгө өргөж гавлыг нь шүтээний дээд болгон залж мөнгөн бунхан хийхэд өглөгийн эзэн болсон тул Ванчин богд

бээр “Чойжил нян-ан-мид, хүндлүн цохур хэмээн алдар хайрлаж алдарыг нь мөнгөн дээр сиилж мөнгөн тамга хийж Зандан зуугийн лхүнсэд дотор гурав хонуулаад хайрлажээ. (Одоо сэмчинд нь хүн бүгдийн шүтээн болжээ). Тэгээд номын хаан гэгээн шашин төрийн ёсчилон тэтгэж ард түмэн арван буян дэлгэрч их өндөрлөгт хүрсэн сайн замын ул мөр хэзээ ч арилахгүй өнөд оршино.

Ертөнцийн ёсыг дагасан шавь нугуудын хүслэн огоот биелэж номын ёсыг тэтгэгч их бага ноёд түшмэл лагшин дүрийг бунханлах чандарлах үед магнайнаас нь одбагмид бурхны лагшин тодорч өлмийнөөс нь түвд “А” үсэг өөрөө гарч зүрхэн тушаа лавайн дүрс гарсан түүний ихэнхийг хойдийн буянд зориулж бүтээсэн Жанрайсаг бурхны сүншигт залжээ. “ А” үсэг одоо байгаа тэдгээрийг үзсэн хэмээн айлдсаныг би сонссон. Өгүүлрүүн: завсрын чимэг үгс

Тэр мэт хязгаарын харанхуй монгол нутгын
Тус амгалангийн гэрэл машинд гийгүүлэхийн цагт
Шөнийн итгэл саран авхай туяагаараа
Шинээр мандах наранд атаархахчилан
Бодьсадва нарын агуй явдал зохиол
Бусдад дарагдан замхардаггүйн адил
Буян цаглашгүй намтарын мөчир лугаа хоёр

Сонин гайхамшигт ерөөлийн хүчээр, цэвүүн цагийн эцэс доройтсон амьтан дор үлэмж энэрэлийн эрхээр цастны ууланд мэндэлж хордлоготой ундааны шалтгаар жанч халж төрөл буцаж дахин Монголд буяны тэмдэгт арав лугаа төгөлдөр хан хэмээх хангай газрын нэгээхэн хэсэг машинд өлзийт хасу голын хужирт хэмээх орны дээдэд ёроол сууриас лянху цэцэг дэлгэрч тэгүүн дээр огторгуйтай эн цацуу олон үзүүрт хорол мэт түүнийг тойроод дашидагжид буюу өлзийт найман тахил, энэ адил буян бүгд, зайжидбуюу зайт найман тахил хуран солонго татан сонин гайхамшигийг үзүүлэн лагшин мэндэлсэний эцэг нь сэтгэл сайт эд бараагаар элбэг Сүнтор хэмээн алдаршсан эх нь төв шударгуу бусармаг бус араншингийн сүсэгтэй гончигсүмийг баясан тахигч буяны эрдмээр биеэ чимэгч эхийн хэвлийд залрахийн цагт элдэв сонин зүүд зөнгөөр эх эцэг хоёроос элдэв хэмээх усан эр морь жилийн сага сарын шинийн арван тавны гурван дүйцэн давхарласан өдөр, өглөө нар мандахын өмнө, долоон морьтон тэнгэрт гарч, Солонго үүлнээс гэрэлтэн үнэр анхилан,

маш гайхамшигт, үзэгдэл болон лагшин мэндэлжээ. Тэгээд нялх үедээ бусдаас ялгамжтай, санаанд багтамгүй, хэлэхэд ч хэцүү зохионгүй дурдатгалаас тойм төдий өгүүлбэл 3-4 сартайдаа үдэш дээр доороос нь боож дээрээс унинд уяж тогтоосон модон тэвшнээс уяаг тайлангүй бууж гадагш гаран завилан сууж Аръяабал бурхны байдлыг магад үзүүлжээ. 6-7 сартайдаа ээжийнхээ өвөр дээр тэврүүлж байхдаа баруун зүг залбирч олонтоо мөргөн аман гэгээнээрээ маань уншиж байсан нь эхний гайхамшигт бодьсадийн явдлуудын нэгэн билээ. Гурван сүүдэр дөнгөж хүрч байхдаа лагшин чилээрхэж Гаадамбын судраас иш үзүүлэн Номын хаан Содномбал бээр аман гэгээнээр таринаар адистэдлэн өвчин илааршиж, зарлиг авшиг хайрласныг мэдсэн хүн байхгүй юу гэж айлдсан гэдэг.

Өгүүлрүүн: завсрын чимэг үгс

Энэрэл их тагаалалын ерөөл сэтгэлчилэн

Эргэн хойд зүгт шашин амьтны тусд

Энэхэн газарт цэвүүн цагийн авралын тэмдэгт

Эхлэн ургаж буруутын омгийг дарж

Эгнэгт арилгах авралыг баригч

Үйл муу боловсролоос хагацахийг хүсэж

Үзэсгэлэнт гүмүда цэцэглэх рашааны гэрлээр

Эхийн хэвлийд золоор оршиж

Элдэв явдалаар дүүрэн мэндэлж

Эрдэм хураах өлзийт сайн сав

Эгшинд дүүрэх эрдэмийн гүү сан

Эдгээр намтарын найлзуур модны

Энэхүү бүлгийн мөчир лугаа гурав

1645 он буюу Газар тэтгэгч хэмээх жил Винайг Баригчийн дээд равжамба Лодойжамцийн өмнө ариун явдалд гэнэнгийн сахил залж, сургаалын таван суурийг нүдний цөцгийчилэн сахин 1646 он буюу үл тасрах хэмээх жил унзад Ширэнгийн зарлигийн рашаанаар ямандаг 13 тэнгэрийг цээжлэн таалаад, тэрсүүд хэмээх 1649 он Шороон эм үхэр жил, махгал, чойжил, лхам, намсрай тэргүүт сахиус, харанга магтаал ихэнхийг нь таалалдаа багтааж баясгалан хэмээх 1652 онд сандуй, дагжид дүнжидтэй бүхэлд нь тогтоож Энэ мэт шашины үүдээр орж, хуврагийн явдлаар цааш шашин их мөрөнд шамдал хичээлээр хөлөглөв, Богд лам жи ренбуучи өргөөнд нь морилон баруун

синтийд залран илт бараалхасныг нууцлан зүүдэнд энэ мэт болсон хэмээжээ. Айлтгал хариултын эрдэнийн эрих номонд ч энэ адил эрдмээ нуусан байдгийг би мэддэг. 1653 он буюу Тийн ялагч хэмээх усан эм могой жил энэтхэг түвдэд мэргэдэд олон төрлөөр таалсан Жамъяан Цорж түүний хувилгаан умар зүгийн Монгол оронд шашин амьтаны тус хийхээр сайтар мэндэлсэн хутагт багшийн дээд Лувсанданбийжалцанбалсанбуугийн алтан нигүүрт бараалхан насны авшиг хүртэн Ноён хутагт хэмээх алдар соёрхож, Шашин төрийн үүднээс мэлмий сунган тэтгэн зохиов. Богд ламын орлогч Сар ренбуучийн хувилгаан Чойжил Агваанлуvsанбалсамбуугийн өмнө Ямандаг Важиг, гомбу, Чойжо, лхам Жамсрангийн жинан сонсож 1654он буюу ялагч хэмээх модон эр морь жил, тагаалал зүүдэнд өчүүхэн зөвчөө орж, лагшин чилээрхэхэд чухаг дээд гуравт даатган залбирч түргэн илааршив. 13 настайдаа “Ванган Чагжаа” хэмээх номын тус эрдэнийг болгоогоод тагаалалд нь баясал төрж, тэр цагаас эхлэн урам сүжиг орон хичээл зүтгэлээр 10000 уншиж өдөр бүр таслалгүй 21 дээш уншиж таслаагүй хадон болгожээ. Тэрчлэн 13 настайгаасаа 64 нас хүртэл өдөр алгасалгүй уншсаны адистэдээр өндөр наслаж, ажил хэрэг нь бүтсэн. Түвд үсэг, бичих дүрслэх хийгээд анагаах ухааны үг хэллэгийг сурахынхаа үед хэцүү үгийг бүгдийг тайлан зохиосон. 1657 он буюу сүрчан хэмээх гал эм тахиа жилийн хавар Цорж Гэндэнсодномтой хамт өндөр гэгээнд бараалхан насны авшиг бүтээлд сууж Ванчинбогдийн зохиосон Очирдарийн лам налжарын лүн, долоон гишүүний лүн, болон зуугийн зайтай цац хэлбэрийн лам налжарын лүн, долоон гишүүний лүн, болон зуугийн зайтай цац хэлбэртэй суврага тэргүүтэй адистэдтэй зүйл олныг хайрлав. Тэр намар Янлагжунай тэргүүт дээдийн хойд дүр болох Лувсанданзанпэрэнлэйжамцын өмнө бараалхан цагаан дэмчиг, Аюуш Арьяабалын жинан хүртэж Элдэв Чам бүжиг 80 орчим түргэн сурав.1658он буюу Намчан хэмээх шороон эр нохой жил номын хаан маха Бандидаагийн өмнө орчуулагчийн увидас заалган урт хугацаа сунгалгүй түргэн сурсанд багш хала хэмээн уулга алдаж магтав. Дорж намжамын жавтүйг Монгол хэлэнд орчуулан Өндөр гэгээнд барьсан нь бүтээл туурвиллийн эх нь болж сайшаал соёрхолд багтав. Хувирагч хэмээх шороон эм гахай жил буюу1659 оны Намар Дол нуурын чуулганаар ноёд дээдэс Өндөр гэгээнд бараалхалын үед Зая

гэгээн ч бас заларсан бөгөөд их ерөөл хурах үед Гаарамба нар Цог лам босон хоорондоо ном хаялцан хариулт өгч алга ташихийн чимээг сонсож, сэтгэл ихэд хөдлөн баясаж, цаашид цанид чойрын ном судлахгүй бол авъяас төрөхгүй гэж хатуу ойлгов. Түүнээс эхлээд урьдын ерөөл авъяас сайны шалтгаанаар түвд оронд залрахын хүсэл байхын нөлөөгөөр багш нар нь ч таалал нэгтэйгээр есөн хүсэл биелэн зөвшөөрөл бүтэв. Чухаг дээд гуравын хүчээр зорисон хэрэг саадгүй болж, 1648 он буюу бүхэн төгөлдөр хэмээх төмөр эр хулгана жилийн намрын эхэн сард төрсөн нутгаасаа заларч цагаан буян дэлгэрч, зохилдох шалтгаан бүрдүүлэн, харшлах шалтгаан бүгдийг хаахын нөхөрт зам зуур тэр намартаа богд ламын мэндэлсэн Гүнбүм хийдэд заларч, Жамбаалын хийдийн арын зам дээр Майдар эргэж байгаатай тааран дэмбэрэл сайхан болов. Өгүүлрүүн: Завсрын чимэг үгс

Хуурмаггүй аврал бүгдийн мөн чанар та
Хувьгүй цагийн амьтан бид бүгдийг
Хайрлан энэрэхийн дардам дөт замыг
Хувьтай тус амгалангийн зам дор таалж
Хүчтэй сайн ерөөлийг талбисны үрээр
Хотлоор боловсрох иш онолын эрдмээр
Ховор эрдэнийн жимсээр дүүргэсэн
Хосгүй гайхамшигт номын мөчир лүгээ дөрөв.

Тэгээд гүмбүм жамбаалин хийдийн ерөөл хуралд уригдан нүүрний эгнээний

Баруун синтий дээр залагдаж, бурсан хуврага нартай хамт ерөөл тавьж, чуулсан лам нарт манз, цав барьж зэд өргөв. Гүмбүн хийдийн ширээт байсан Жалмогийнд хамт байхад Зонийн Цорж хэрэглэл бүгдийг бэлтгэж намрын адаг сарын шинийн нэгэнд цааш хөдлөв. Их амгалант Боромдомбо гэгээний байгуулсан лүнсар радэн хийдэд заларч Жамбалдорж гол шүтээнтэй гурван бурханд хадаг өргөж, лам нарт манж барьж зэд өргөн ерөөл айлтгав. Зам зуур Даглунд бараалхан өргөл өргөжээ. Эрдэнийн чулуут буюу ренчинбрагд очиход лам нар угтаж дуганд урин синтийд залан дэнбэрэл дэглэв лам нар баяртай байв. Гэгээнтэн, ч тэдэнд манж барьж, зэд өргөн цааш Гандан чойнхорлин хийдэд морилж шүтээнд мөргөж, манж барин өглөг үйлдэхэд лам нар ч хүндэтгэж байв. Тэгээд гурван орчлонгийн амьтныг тэтгэгч дээд багш зөөлөн итгэлт Номын хаан Зонхов богдийн алтан дээвэрт Гандан хийдэд

морилон мөнгөн дун тэргүүтэй гурван шүтээн ном, суврага, бурхан 40 зүйлийн эрдэнэ өргөв. Богдын ширээ залгамжлагч, Балданжалцангийн өмнө залбиран адислуулж хуралд манж барьж, зэд өргөн, Богд ламын шашин өнөд мандахын тухайд ариун ерөөл тавив.

Өгүүлрүүн: Завсрын чимэг үгс.

Урьдын үүсгэсэн ерөөлийн чийгийг ухаж

Урагш шуудуулан урсгах хүслийн рашааныг

Ухаарч гээхийн номлолын гүн далайд аваачин

Улбаа эрдмийн онгоц жолоодох нь та гагц

Бурханы шашны ариун номыг таалан

Булд олныг буянд дагуулсан гандан

Бүхий оронд алдар түгэн дурссан

Буяны өлгийд заларсан мөчир лугаа тав.

Хоёрдугаар бурхан Зонхов хутагтын оронтой сайтар танилцаж, Монголын намрын илүү эхэн сарын шинийн 29нд хоёрдугаар дорждан Лхасд заларч, маргааш өдөр илт тугуулсан Бурхны адистэдээр бүтээсэн, “хоёр зуу” Майдар, өөрөөсөө бүтсэн хэмээх Арьяабал тэргүүтэн шүтээнд дэнсүм буюу, бурхан, ном, суврага хадаг сүсгийн сэтгэлээр зуу лан мөнгөөр хийсэн мандал өргөж, энэ мэт шашин амьтны тусын тулд хүсэл бүгдийг хоцроолгүй тэр үесэд нь тохируулан санах, сурах тэргүүтэн хориг үгүй тагаалалын дагуу иш онолын эрдэм бүгдийг эрхшээхийн асар ариун ерөөлийг шашин хийгээд ялангуяа Богд ламын судар тантарын шим хэзээч доройтолгүй арван зүгтээ дэлгэрэхийн ерөөл тавив. Илүү сарын шинийн нэгэн буюу баясгалант” хэмээх өдөр Арьяабалын авшиг авах ёслол дээр оройн сэрвэлэг үргээж аяга тахимал болон ил шарыг нөмөрч Далай ламын алтан нигүүртэй анхлан учирав, мутрын адис авч тагаалал дээдээр цэнгэв. Далай богд мишээнгүй залуу дүрээрээ болгоогоод, энэхүү газрын адистэдэй, үзэх номыг олдоход бэрх, үзэх бодьгалыг учирахад бэрхийн учир Далай багш уулзангуутаа л бодь мөрийн зэргийн, лүн, ишлэл өгч, нас лагшин бат байхын дэмбэрэлээр насны авшиг, арьяабалын жинан хүртээсэнд, төрөл тутамдаа хагцалгүй хамт төрөхийн залбирал талибан 50 лан мөнгөөр бүтээсэн мандал 1000 зул тэргүүтэнг сүсэглэх сэтгэлээр өргөж Увашийн санваар хүртэж бүгд баяраар цэнгэв. Сэр браиван

хийдүүдээр мөргөж Доод нуурын их хамба ламын хойд дүр нитон хийдийн дээгүүр ламын нэг Лувсанжамцын зөвшөөрөсний дагуу анагаах ухааны 4 үндэсийн зажүд буюу үндсэн бүлгийг заалгав. Сайн сурч буйг мэдсэн багш нь ч бид урьдын барилдлагаар учирч хойшид ч барилдлагаа таслахгүй байх хэмээн бурхан багш адислан хайрлав. Ингээд Чойнцам буюу номын чөлөөгөөр судас барихийг заалган анагаах ухаанд суралцан багагүй зүйлийг сурч баяр хөөртэй болов.

Өгүүлрүүн: завсрын чимэг үгс.

Цаст цагаан шовх оргил уулсыг

Цаана наана тойрон орших түвд орон

Тус амгалан гарахын хүрээ хязгаар

Тэнгэрлэг үлэмж гайхамшигт орд харш

Тэгүүн дээр шагжтүв бурхан заларч

Тэсэхүй бэрх цог ариун бусыг болгоож

Авшиг хайрлалгүй бясалгалд унбах шиг

Ачит багш минь бурхантай ялгалгүй

Агуу сургаалиа надад авшиглан

Алдарт түвдийн номын эх орноос

Анхлан Далай багштай золгож

Авшиг хүртсэн бүлэг мөчир лугаа зургаа.

Таалал баясаж гол зову шүтээнд мөргөж, эрдэмтэй дээдэстэй холбоо тогтоон шавь орж, Занд очихийн бэлтгэл хийж дээд мөрнөөр дамжиж баруун зүгт морилон Дашилүнбэд монголын 11-р сарын 8-нд очиж, маргааш нь шинийн 9-нд Ванчин богдод бараалхан мутарын адис хүртэж, өөрийн сурсан түвд хэлээрээ амарчилан ярилцаж, цанид чойрын ном сурах хүслээ илэрхийлсэнд ловжин сайн сурсаныг нь болгоон ихэд таалжээ. Гэгээн аль дацан, хийдэд сууж ном үзэхээ асуухад ялимгүй мишгэлзээд хоёр мутраа магнайдаа хавсран залбиран адислаад маш сайн шамдан сурахыг айлтгав. Маргааш өдөр нь донироороо дамжуулан синбэрээ гэсүм, Дашилүнбийн хаана ч ном үзсэн болно ялгаалгүй хэмээн айлджээ. Тэгэхээр нь гэгээн өөрөө шоо болгоон Сири хийд дашилүнбэ хийд хоёрыг шодож Дашилүнбэ хийдэд суухаар болов. Одбагмид бурханы хувилгаан зовсон олныг онцгой энэрэлээр аврах ерөөлийн хүчээр Ил шарыг баригчийн итгэлт Эрдэнэ ванчин Чойжижанцангийн Алтан хумх, аман гэгээнээс Арвин ихийг хүртэж амжаагүй ч шамбалын ерөөлийн

авшиг, бас бус номын лүн тэд, сахиусны” гагой” ялангуяа Дүйнхорын номлолын үед туслах Човонба тахилчийн үүрэг хүлээж, Ерөөл тавьсан түүгээр үл барам Ванчин богд их баясаж, ямандаг бурхан гагц, хагацалгүй хамт төрөхийн дамжаагаар ядам жигжид, номон сахиус балдан лхамын жинловтой шүтээн ховор утлага, дээдсийн баринтаг Чойго, тэрэм зэргийг гэгээнд барив. Найм хоног гэгээн лам нарт зэд мөнгөөр бүтээсэн мандал голлон зуу зуун тахил дэлгэрэнгүй өргөв. Зарлиг баригч халх ноён Дармагэрди сүсэглэн залбирч өглөгийн эзэн болов. Ингээд зангаас үйрүү хөлгийн жолоо залав.

Өгүүлрүүн: завсарын чимэг үгс.

Гаадамын номын бошогчилан

Гайхамшигт богдын сургаалчилан

Машид гарахуй жилийн миндүг сардаа

Манлай Далай лам богд Ванчин, нартай

Намжил хийгээд Дашлүнба дацанд

Найрсаг ерөөлөөр учиран золгосон нь

Урьдын хийсэн ерөөлийн хүч

Увьдас багчаг сэргэсний мөчир лугаа долоо.

Энэхүү хийдийн тагаалал итгэлийн шим Гурван ертөнцийн амьтаны удирдагч Зонхов богд түвдэд заларч ном суралцсан дагуу Юм Жайварандүсүмийн гол номлол ондогжин билиг баримидийн номонд эхлэн суралцаж шамдалаар мэргэн болов. Улмаар дэс дараалан алхам алхамаар ложин ном уруу орж додойжангийн мэргэдийн гишүүн дор сурав. Бурхан багш няндайн задба зохиосны тухайд

Чойнаднамжид, хорвоо эцэс төгсгөлийг хорихын тухайд зохиосон үйнтанамжид, номын хоосон чанар үзүүлсэн Дэшигнянбу, Жүдлам, Майдарын 5 ном үзэж мэргэдийн туйлд урьдын дээдсийн намтар адил хүрч, шашин амьтны тэтгэгч далайгаас майдарын 5 номын ишлэл, авшиг хүртэж, хар ус хэмээх газар хүртэл Дарма гэрдэ ноёнд газарчилан туслахаар цагаан сарлахаар баруун зүг хөдөлж Монголын 1-р сарын 29нд Дашилүнбү хийдэд очив. Замд холочийн Гүжи, Рагданхамбын туслахаар томилсон түшмэл зам зуур 7-8 хоногт өнгө цагаан улаан тэргүүтэй дагсал хаях хариулах ёсонд ярилцаж бага саг ойлгосон ба цааш лавиран мэдэгдэхүүн бүр бумба байх албатай үгүй талаар асууж албатай гэвэл багана чойжин бумба мөн

үү мэдэгдэхүүн биздээ гэх төдий мэдэж хийдэд очсоны дараа монголын 2-р сард цээжлээгүй сахиусаа цээжилж, хажуугаар нь цанцан буюу билиг чанар, нэрийн тухай чойрийн номд суралцан цааш уг үрийн талаар мөн дагсал бага зэрэг мэдэв. 29-ны өглөөний чогцин хуралд дацангийн 4н хуврага голд сууж дамжаа барьж лам нар ээлжээр босож дагсал хаялцан тантай манж барих тэр агшинд гэгээнтэн билиг дэмбэрэл бодож өлзийт 8н тахилын аль нэг нь дун болох албатай үгүйг асуухад хэргээр албатай гэж хариулахад Гэгээн номын хүрд чойжин дун мөн биздээ өлзийт 8н тахилын нэг шүү гэхэд албатай тийм гэж ахин хариулахад ахиад шүхэр алтан загас хоёрыг хэлье гэж бодож хажуугаар уг үрийн дагсал хаяж байхад хажууд суусан дээдэс лам нар хэл хатуу байх юм амду хийдээс ирсэн болов уу гэцгээж байх нь сонсогдож байв.

Өгүүлрүүн: Завсрын чимэг үгс.

Судар тарнийн номлолын далайд орохын үүд

Суут таван ухааны эхлэн орох босго

Судлахуй бүгдийн эхлэн цанид чойрын номд

Сааралгүй орсон салаа мөчир лугаа найм

Шинийн 10наас хийд тэр аяаараа Богд ламын нярваан дүр барьсны манж хурал болсны дараахан шинийн 13нд дээдэс Дулжа Содномийн лагшин чилээрхэж Дамби донмэ тэргүүтэн дээдэс удирдан Гандан хийдийн Майдарын өмнө соёрхол талбиж, ээжээсээ хагацсан хүү шиг байсан ч арга эс олон нярваан дүр барьж хойдийн буянд тасралгүй хурал хурав. Тэгтэл ловон хуралд морилоогүй учир би овоо олон удаа тавилаа. Овоо тавихийг харж байсан дээдэс лам нар урьдын авъяас багчиг байгааг харж бахархан магтаж байлаа.

Хаврын чойроос зуны чойр хүртэл зурхай ламрин ложингоо хойш тавин дүйрэний ном үзэж заваа цээжлэн нягт судлав .Энэ мэт богдын адистай номын орноос бусадтай адил ном үзэж байтал ус таарахгүй улмаас биеэр гүвдрүү туурч идээ ундаандаа зохихгүй идээ бээр гарч эхлэхэд эмчилгээ арга хийхээр чүжан явж, урдын танил холочийн Гүжи Рагдан хамбын хийдэд очив. Хамба хүндэлж хүлээн авч 3 хоног асарч тордуулан цааш явж Чүнжинла очиж 7 хоног рашаанд суугаад гүвдрүү ор мөргүй алга болов. Лагшин тунгалаг болж буцаж Дашилүнбү хийддээ урамтай ирэв. Намрын чойроос өвлийн чойр хүртэл Ванчин богдын зарлигийн Ранвансодномжамцыг багш дор барин ном заалгаж

байтал удалгүй халхын нутагт номын эзний багшаар залагдав .Явахаасаа өмнө багш маань Гачин Содномжамцаас өөр ном сайн мэдэх багш үгүй хэмээн түүнд шавь оруулж, үр, 6, талжор, Гагш, Жийн Жибарга, Цанцон тэргүүтэй дүйрааг бүхэлд цээжлэв. Дараа нь цадма намдэлийг цээжлэв. Дэлба тайлбарыг сонсож намдэл завааг өдөр өдрөөр ахиулаж дэлбэ тайлбартай нь тулган цээжлэн өдөр бүр уншиж байв. Өвлийн ном буюу өвлийн намдэлийн дамжаагаар эхний өдөр рэглам бэрэн хүртэл ном хаялцаж мөн намдэлийн 4-р бүлгийн тажод мэргэдийн дээд Шантэдиваагийн зарлигийн тайлбарыг тайлан хөтлүүлж гаг, шаг, Вон, Сүм буюу бусдын сөрөг ёс, өөрийн барих ёс, харцуулалт гуравыг тус тусд нь болгоож, 2-р бүлгийн жидан буюу ерөнхий утга номыг 1000гаас дээш олон уншиж байж цээжилсэнд ном хаях, хариулахад хялбар болж буруу гэжсэн дамжааваад арслангийн дууг дуулсан үнэг шиг болгож мэргэдийн бишрэлийг төрүүлж эхлэв Нацаг хэмээх жилийн өвлийн дамжаанд ерөөлийн үеээр тарлам салжид, нэг хоёрдугаар бүлгийг бүрэн цээжлэн 3-4-р бүлгийг ихэнхийг цээжээр мэддэг болов.Мөн Рэгвийн жамцо хэмээх номонд хийсэн Хайдүвжийн тайлбар, Намэ болон Тэгчинрегжин номыг болгоон ном хаях хариулахын хайв мэргэн болив . Өгүүлрүүн: Завсрын чимэг үгс

Гол номлолын гүн цэнхэр далайд

Гатлах онгоц цанидийн номыг болгоож

Иш онолоор сав юугаа дүүргэн

Их ерөөлийн хүчээр эвийн санаа нэгдэж

Эрдмийн түлхүүрийг хүсэл сэтгэлдээ тээсэн

Элбэг баян түүхийн намтрын мөчир лугаа ес

Их тэргэтэн Нагаржунайн ёс энэ дэлхийд түгэн дэлгэрч эрдэм бүгдийн суурь болсон басхүү Винайн магтаалыг тэр мэт модны үндэс ёзоор (нампэл)(түйн түгэх) бүхнийг барих (гүнзэн)хоёрын суурь бөгөөд Тэрчлэн дээдийн ном бүгд Винайн ёсонд суурилдаг.

Үүлшин үр хуралдсаар Винайд очиж суурилна,

Үнэхээрийн буян явсаар Винайд очиж суурилна,

Винайн гол явдал Шагшаа бодийн эрдэм, энэхүү эрдэмийн түлхүүр нь Сотордомбо буюу найман сахил эдгээр бүгдийн шимийн шим гэдгийг үнэн таалалаасаа ухааран, хорин насныхаа босгон дээр төмөр үхэр жилийн есөн сарын сүүлээр өдрийн сайнаар 999 хуврагийн эхэнд босоогоороо цувж, Жанрайсаг бурхны хувилгаан, ил шарийг баригчийн эзэн Далай лам Жалван

тамжидчин, Агваанлуvsанжамцбалсамбуу бээр хамбын синтийд заларч ёнзог 4 гэлэнтэй ёсчилон гэчүлийн сахилийг залж Сарлаг анчинд алуулах аюул байсан ч модонд сүүлээ хавчуулж тасдахаас болгоомжилон зогсож сүүлээ заавал гаргаад хөдөлдөг шиг энэхүү залсан эрдэнийн сахилаа нүдний цөцгий мэт хаа явсан газраа хайрлан сахиж байв. Хорин гурван сүүдэр зооглохын үеэсд монголын 3н сарын шинийн нэгний өдөр Поталын ордонд аяга тахимал буюу гэлэнгийн сахилыг өглөөний нар нэг хуруу мандах тэр агшинд Намжил дацангийн гярган лам нар эгнээс суудлаа эзэлж, Далай багш хамбын суудалд заларч, Агваандэнзэн лам лайрав хийж. Гүнчиндондүв ламтан нууцыг шалгаж дуусаад болно хэмээхэд Жамъяандагва ламтан хөтлөн лагой намжираа соёрхож, хагон уншиж лам нарын дэргэд ёнзог гэлэнгийн сахил хүртэж шашин лугаа эргэлт буцалтгүй оров.

Өгүүлрүүн: Завсрын чимэг үгс
 Иш онолын шашины шим туйл
 Их нярваанд одохын амар арга
 Анхааран ёсчилон сахиж чадваас
 Агуу винайг бүтээхийн дээд болох
 Ачит багшаа шүтэн сахил хүртэж
 Гурван төрөлхтний шашин амьтныг тусыг
 Гуйлгалгүй үүрч лагшингаа чилээгч
 Сонин гайхамшигийг ханахгүй зохиогч
 Сод далай Ванчин богд нараас
 Гол номлол бүхэнд орохын үүд
 Гоц нээгч журам ёсыг үйлдэгч
 Бохир хирийг үлдэн хөөгч
 Бодийн мөрийг эцэслэн баригч
 Хутагтын орны мэргэдийн чимэг
 Хосгүй мэргэн чоглон, чойдогийн
 Хойшид дамжуулах их мөрнийг
 Ховилдон татсан шуудуу мөчир лугаа арав

Дахин үйгээс занд заларч, мэргэд дээдэсийн өмнө буруу үзэлтэн үзэлийг хориг дуун буюу тогтсон таалал болон Тэжээхүй ухаан тэтгэхгүй ухааныг голчлон судалж, лянхуа цэцэг дэлгэрч яруу алдар нь түгэн бүхний өмнө үзэсгэлэнтэй болов. Тэрчлэн уг, үр болон хоёр хөлөгний гол номлолыг алагчаалалгүй барин ёсчилон суралцаж алдар нэр тэнгэрийн хэнгэрэг мэт цагаан зүг

тэтгэж есөн үйлс дэлгэрэв. Элдэв хэмээгчээс, сүрээр дарагч, мичин жил хэмээхүй 3-н жилийн дотор, төв үзэл, винай, билиг баримад, Илт үзэл зэргийн гол номлол гүйцэт болгоон тэдгээрийн тажид буюу эцэслэн шинжлэлийг, жидан буюу ерөнхий утга, түүнд холбогдолтой бусаг жижиг ном хоцроолгүй болгоон мэдэгдэхүүний огторгуйд шилэн толин дээр нарны хот мандал ургаж элдэв бусын дүрийг гийгүүлдэг шиг элдэв зүйлийн санаа бодол арилан мэргэдийн замд баясгалантай бээр оров.

Номын чөлөөгөөр мэргэдийн манлай Лхавашавдүнгийн өмнө шавилан орж Ямандаг, цагаан шүхэрт, ширнэн, Майдарын дамжайвийн сүн, Ламдон, бодьсадын явдалд орохуй дэлбэ, Дэлбэдонсүл, дозава, жамдэлийн зова Манзуширийн магтаал, далан ерөөл, Дархи, Доржнамжил, Ерөөлийн хаан Дүншаг, ламзуву , Зовуужийн намтар Гаадамбын увидас бүгдийг, Вибумийн тайлбар, намтар сэлт, сажа лигшад Вудонгийн лайчо, Гармашадамжийн тайлбар Вудан гэгээний, ламрим чинму, аграмчиму, гурван суурийн ном, гэлонгийн сургааль, эмийн 4 үндэс, Мичой гадон, гурван сахилын засал, Задүнгийн намшаг Вавигийн айлдсан Воромдамбийн өөртөө айлтгаж талбисан түгдэм, Зову 3 н шавийн Майдарын ерөөл, Тогта ерөөл, Диваажингийн ерөөл, Сандүй ерөөл, Дэмбэрэлдодва, гавсүм, Жамбий гүсүгма, Дэчинлхүндэвма, Хайнам, Савюүм Балдансасүм, Мэгзэм, Жамбал шаллүн, Жанчиводжийн Жамдаантэд, Манзуширийн магтаал Хайдүвжийн гэгээний, Жанагийн ТогморложинВарижарзэ, ондогжангийнсинбэрээ, Ванчинбогдийн сүмбүмээс Насны авшиг, намжилчого, сангийн чого, Сүмбүмийн торва номууд, 352хуудаснаас дээш сүнцангаас бусад таван боть бүрэн, Манаг регбунгийн доторхи Ерөөл цагаан Манзушир, Махагал, Очирваань насны 5н тэнгэрийн жинан лүн авшигийг бүрэн дамжуулан залав.

Өгүүлрүүн: Завсрын чимэг үгс

Итгэлдээ: Эргэлзээ шинжлэлийн тэнгэрийн зам орхиж

Эгнэгт одохын хязгааргүй мөрөнд

Энэ мэт одохуй бэрх мэдэгдэхүүнийг

Эзэн хичээн багшийгаа чилээж

Мэргэдийн алдрыг сар лугаа ханьцуулж

Мэдэл бүгдийг үлдээлгүй судалхаар

Ханашгүй тааллаар тэнгэрийн усыг

Хагацалгүй хүртэхийн буяны үйлээр

Алгасарахын дайсныг үлдэн хөөж

Амьтаны тусыг үүлдэх мөчир лугаа арван мэт

Элдэв хэмээх 1665 оны хавар ловонгууд Үйд ирж Лхасад цугларахын үед госо өндрийн улмаас дээдэс олны өмнө синтийд сууж “Сожингийн до” айлдахдаа тасрал үгүй тодорхой маш яруу айлдсанд мэргэд өгүүлэх, ном хаялцах, туурвихдаа торолт үгүй гэж сайшаав. 1666 он буюу сүрээр дарахуй жил нянанд сууж, ном болгоох, жорлох, чойрт таслалгүй явж маш их хичээлийг барив. 1667 он буюу мичин жилийн хавар хойш морилон язгуур бүхний түгээмэл эзэн очир дор Лувсандамбадаржаабалсанбуугийн өмнө Ямандаг 13 тэнгэрийн авшиг гүйцэт сонсож, Жам ёсны насны таван язгуурын жинан, Жарз айлтгаж байхад мэргэдийн дээд Жилхамба шавь нарын хамт тэнд цугларсан олны дунд байсан бөгөөд олны өмнө гэгээнтнийг сайшаан магтав. Мичин жилийн Монголын 10-р сард Одбагмид бурханы хувилгаан Ванчинлуvsанчойжийжанцан бээр Дашилүнбэ хийдэд анхлан залж, сэнбэрэмийн шар шүхэрийн хойхны нь зүүн талын эгнээнд хамт заларч анхлан золгов. Цугласан олны дундаас гэгээнтнийг онцлон таалж тааламжтайгаар хандав. Шинийн 2-ны ачид хурах өдөр Лосоолингийн мэргэд дээдэс лам нар цугларч Дашилүнбэд ирэн зангийн хуврагуудтай нийлэн бат оршил синбэрэм тахил өргөж бэлэг дэмбэрэл бүгдийг гүйцээв. 1668 он пүрвүү хэмээх жилийн Монголын нэгдүгээр сард цугласан олны дунд яруу тахил өргөсөнд Хаймчоглхава, Содномдагва тэргүүтэн ихэс баясан магтаал хайрлав. Шантидива гэгээний зохиосон төв үзэлийн уматанжүрбийн эрхин хэмээхийг цээжлэн түүний дэлбэ тайлбарыг бусад төв үзэл болон илт онолын үндэсээр өдөр бүр цээжээр хадан хийв. Зун лхасад морилон 2 зууд мөргөж Далай ламтан бараалхан Зони цоржтой хамт бодь мөрийн зэрэг дунд төрөлхтний горийн лүн айлдаж Цэда ишчүнтайн жинан залж, Лхасад залрах хугацаандаа ууланд суугч Гандангийн ловон сүүлдээ Түшаг Ренбуучигийн сойван эрхшээсэн Цоржийн өмнө Сандуйн Зажүд Жадамбо, Далай ламын зохиосон хураангуй Намжилмайн сүн, сүнчин Дэн, а, одсоржамайн сүн, Жамба дамжайбийн сүн, Мэнтүгийн сүн, Дашидондов, Латид, Сиришүнма, Чойжидравсал, Лүгүсүнгийнлавжа, Жамъяан чойгор, Гэндүнжамцын,

едамийнбүтээл, Гомбо, ЛхамнамсрайнГанс, гэлонгийнлавжа, сац тавих ёс, Цэвандүвжал, зэрэгийн лүн жинан, тэд, таилбарыг заалган тагаалал машид цэнгэв.

Өгүүлрүүн: Завсрын чимэг үгс.

Алин бээр оюуны эцсийн цэнгэлээр

Алгасарал үгүй мэдэгдэхүүн бүгдийг

Мэдсэний гэрлээр төгөлдөр өдрийн цэцэг

Машид баясгалангаар боловсорч амьтны тухайд

Сонсох судлахын харшгүй онгоцоор

Суут гангийн урсгал мэт цагаан үйл

Саран наран барилдсан мэт

Санасан эрдэмээ бүтээх мөчир лугаа 12

Тэр мэт номлол бүтээлийн аньс бүхэнд харилтгүй үргэлжлүүлэн таалалыг шамдалаар зохиож, яруу алдарын жанцан зүг бүхэнд торолтгүй шилэн намирч байлаа.Гэвч магтаалын оронд очивол омог уурын сав болно хэмээн зарлигласанчилан рашааны давалгаа мэт айлтгалгүй нууцалж байв. Жалханба шавь нартайгаа ирээд та манай цогчинд гэсгүй болооч гэж айлтгал олон өргөсөн боловч Госо өндөр, тэгээд ч гэсгүй хүн журам сахиулах олонд таагүй харагдах учираас татгалзсан хариу өгсөн билээ. Энэхүү хариугаа Далай ламын өмнө нарийн тайлбарлаж, хажууд буй лам нарч тийм байна гэж саналыг зөвшөөрөн хүлээн авлаа.1668 он пүрвүү хэмээх жилийн өвөл Өглөгийн их эзэн” Номон эзэн” замдаа бие чилээрхэн Лхасад очихын урьд нас барав. Хойтийн буянд хоёр зууд мөргөн даатгаж энэ жилдээ лхасад байж зурхайд гарсан ном буяныг айлтгаж хойд төрөлийг даатгахаар Сири хийдэд очиж, лам нарт зэд цав барьж хойдийн буяныг гүйцээн буцаж ирэв.

Тэр үед ноёныг дагаж буй бараа болооч нарт өөрийн сургаал мөнх бусыг айлдаж тэд ч бишрэнгүй хүлээн авав. Мөн ноёны хатан буяны мөр хөөж, уваши сахил залахаар занд очиж хамт Ванчинбогдоос номын авшиг айлтган 1669 он буюу амирлуулагч хэмээх жилийн зун Лхасад очиж Далай багшийн хажууд буй лам нараас авшиг авсан номоо мартагчийн тухайд санёг хөтөл гэсний дагуу алдарт сонсож дуулсны бичгээ эхлэн хөтлөв. Энэ үед Сир хийдэд заларч байгаад Түвдийн хам гэх төвийн Дорждан павонхару заларч мэргэдийн дээд бүтээлийн Налжарваа Жамъяандагвад гурван суурь шүтээн барин золгож хүссэн номоо заалгахыг айлтгахад савны чинь хэмжээгээр зааж өгнө хэмээжээ.

Зун, намар павон хайвийн лавранд заларч Жамьяандагвийн өмнө Сан дэ жиг сүм гүнрэг, Цэвагмид Жанрайсиг, Шүхэрт, Мэнтүг, Дамдин янсан, Жигжид Важиг, эдгээрийн ван Лхобрагханчингийн гамбумаас намжам Цэвагмид 9-н тэнгэртийн авшиг Ямандагийн агийн хураангуй жинан Дамдинсандүв, Синдом, Дүртоддагва Лхамудонжинма, Цагаан ногоон дархи Мэеэ гомбо цагаан хөх хоёр, чагдор хар Манзушир, Дамдинжагрэнжан Янжан цагаан, улаан, ложанма, зүгдэрнамжил Цагаан шүхэрт, найжү, манал, Товумэгзэма, цэвагмид 5-н тэнгэрт Намжам 2 нигуурт дөрвөн мутарт Гомбо, чойжил, лхаму, Балганнамсрай Бэгзэ, Жамьяан, лхаму одсиржан Цагаан манзушир, бари дархи, лхобраг Гамбумаас бурхан багш ойрын 8-н шавийн аймаг, чинагш сэмжэд Чагдархорчин, Чагдарчүна, Дүмү хоёр мутарт, зэргийн жинан, Цэвандүвжалийн бүлэг, Дэмчигзажүд Дүйнхордүйжид, Догсүмгонжид Дөрвөнзуут, Цадмагүндүй Ламдон, Ренпэрэнрэдүг, Шивмунянтаг, Дониддүгжүва Пагдоддамжаг манаг, Ламиддодва, эхлэн сурагчдын Ламжүг, Жамдо, Ширчин Манаг жамдо дүнжүва 6 гишүүн, Дэнбэрэлнянбийн Намшад, Намбаржидбалавдүй Ондог галсан Жанпэрэнманлын дочог, маань Ганбум, Лхобрагганбум, Гонбийн Вивам, Гарнаг шогдэл, сундуй, палчин домбо нишүва Дүвтавжамц, Жавш данбарма, уманжүг, Ламаадан, Налжор аг рэм жилчог, Жилчогренчинпэрэнба, Лүйжилдүвтав, Дүдлайнамжил, Рем “а” Салдон, Вайдонгүнсэл Доджайба, Жинсрэгчинму, Ойдовжамц, Лам авжуба Намшад, Сэрэ пойдан санег дүмбүү Рэг” а” синбэрээ, чагдордайва, ламиджинлав Шаджүддорпэрэн сэнбэрээ, Еджисүн гэгээний айлдвар

Торов гүнрэгийн дамжлага утга түүний тайлбар Додвийжүчаг, Сандуйнжидрэм, Ойдовжамцийн Ложин нямайн одсэр, Жанайвийн Латид, Шанпаньямбуучагдүгвийн ондог дэлгэр хураангуй, Шанбийн зохиосон Мэдражарзэ, Гэндүнжамцын равнай, Лүйвийнжидрэм Ньюнай, Дархийн дэлбэ, зачодийн дэлбэ Жигжидийн ерөөл даши, 10н орны магтаал, умийнжидан, дунта, Парчин, Тидчиннянбуу, Хажид, Гомбийн Няншүг, Повотид, Балжирлүндэвийнжигжидийнчойжүн, Жамдонамшад, Дэмчигмоллом, Далай ламын янсангийн түүх, Содномжамцын намтар, Ванчин богдийн Санвуйн намтар, Рэгзэн, Павонхайвын намтар, Лачодииндэлбэ, хаврын охин тэнгэрийн дуулал, мэнтүгийн чого дэлгэр хураангуй хоёр, умийн намшад, Умийн тэд,

түгжэчин бул дор, Санчогдашичилба Мьялангийн тайлбар, Лхасын гарчаг Ловонгийн өөрийн зохиосон лайчо, Нямбу дон сүмжиин лүн айлтгаж, ловонгийн сэтгэлд тааруулан зарим номыг нууцлах хэрэгтэй хэмээгсний дагуу гэгээн бүтээлийн тахил өргөж хутаг жадонгийн эрхний лүн, Вибумийн тайлбар, Жансаагийнлавдүй Вигэренчинбумба, үйжинчойжадравсал, Ванчин хэсэг торво ном, гэх мэт нандин увидас олныг авсан боловч тэр бүгдийг тодорхой бичсэнгүй.

Өгүүлрүүн: Завсрын чимэг үгс:

Эрдмийн хумх нь онол номын далай мэт

Эгэх орхихийн ухаан нь тунгалаг хурдан

Эртний гүн ерөөлийн даган барих хувьтай

Элдвээр өгүүлэгчийн буцаах эрдэм лугаа төгөлдөр

Цастны орны мэргэдийн манлай охь

Цанид чойр, номын Ванчин богд

Мэдэл энэрэхүй үйлс цогийн хүч бадарч

Мэдэгдэхүүний хоёр тус бүтээгч хосгүй саран

Багш дээдийн нууц гурван эрдэмээр бүжигч

Бахдах эрдэм төгөлдөр мөчир лугаа арван гурав

Намар сира хийдэд урьдын ноёны хойдын буян ном хуруулахуу гэж гуйсан гэчилмаагийн захиасыг бүтээхийн тухайд Галсантай хамт очив. Хайшиндүйвий Ванчиг Жамьяан Лхүндэвийн шавь нар Дацаг хувилгаанд туслах үүрэг авч чойрт жижиг жавдан дээр гэгээнтэй хамт заларч дамжаа барьсан нь сайхан харагдаж хариултыг номуухан өгч хариулаж байв. Шавь нарын нэг нь та нэг өдөр дамжаанд морилхуу хэмээхэд дээдсийн явдалаар байхын тухайд гэгээн бээр намдэл ума хоёроос жаахан хараад өөр ном үзэлгүй дамжаанд залрав. Ном хаях олон мэргэдийн асуултанд уг учирийг тайлан зохилдуулж хариулж байсанд хажууд буй гэвш нар тааламжтай магтаж ярьцгааж байв. Мөн ренбучи умын “шүнсаравагийн зиндаанды лам нараас эхлэн Баримадийн гавданбуунаас эхлэн дамжаа барьж ум хүртэл госо, госооны лам нартай ном хаялцав. Номын завсараар дүлбийн суурь дээд доод тасарсныг Жидан хоёрыг цээжлэн уналын 5 аймагийн сүүлийн үлдсэн бүлэг жилхан дацангийн зодийн тайлбарийн Найданбуу, Найсүмба, хоёрыг гүйцэт цээжлэн Найнивагийн сүүлрүү орхисныг гүйцээн цээжлэв. Билиг баримадийн анхны ботийг тал хүртэл цээжлээд өдөр бүр хичээл шамдал бээр тасралтгүй номоо

үзэв. Тэр үед баруун номын эзэнтэй хамт Далай Ламын бараа болоочтой хамт, насны авшигийн бүтээл айлтгалд сирагийн ловон гэсгүй албаны лам хамтдаа бат оршил өргөв. 1670 он нийтийн хэмээх жилийн хавар зангийн зүгт морилох үед Ванчин Ренбүчи Лувсанишийн залбирал зохион хайрла хэмээн Ванчин богдын шанзав айлтсаны дагуу зохион дашилүнбийн цогчинд уншиж Жагар Түвд Монгол 3 дэлгэрсэн Бурхны шашин адилхан гэдгийг түмэнд үзүүлвээ. Гоцан ханба бээр өмнө шамдангуйгаар манагжүд, Жижүдийн лүн өгүүлэв. Хавар балжирийн чойр уруу хэсэг лам нартай 45 хоног заларч тэр үе болсон дамжаа Их манал хурах үед ном айлдаж Их багаар тааруулах, мөн зуны дамжаанд цагаан лаврангийн цогломд Билиг баримад Винай хоёрын талаар тайлбар айлдсанд орон хийдийн лам нар болон Хамбын магтаал сайшаал хүртэв. Яруу алдар нь түгэн дэлгэрч байсан ч багш чухаг дээд гуравын ач хэмээн бодож надад илт одоогүй гэж бусад дээдсийн намтар адил даруухан байв.

Хамба дуудан цуглуулан нартангийн жарзэ хийх үеэр, нартангийн жарзийн жинан, лүн, манла, товомэгзэм болон Луванжалбийн жинан, хайрласныг сонсож рейтод гандангийн шүтээнд залбиран мөргөж, долоон сарын сүүлээр Дашилүнбэд заларч, дулба, Зод Билиг баримадыг нэг нэг гүйлгэн болгоогоод дондонжүгийн номыг эмхлүүлэн болгоогоод хаймчоглуvsанчойдогийн өмнө сүмдог заалгаад түүний сүүлээр яруу найргийн утгын 35 чимэгтийн гол номлолыг цээжлэн тогтоов. Тэгээд шүнг ловонгоор тайлбарлуулан хөтлүүлэв. Зурхайн дүёгийн хүснэгт гүйцэт зурж утгын чимэгийн жишээ бүгдийг бичиж ловон болон бандида Лувсанноров хоёрт шалгуулсанд тэр хоёр маш ихээр таалан магтав. Махабандида Лувсанноровын өмнө Галабае ийн 3-р бүлэг хүртэл айлтгаж үзэж дуусаж байтал лагшинд тууралт гарч амгалан бус болон дөнгөж гайгүй болж байтал төрөлх нутаг 1674-он бар жил Монгол орондоо буцах хэрэгтэй хэмээн заллага айлтгахаар хүмүүс ирлээ. Тэр үед сэтгэл таалалтай Рэгнай бүгдийг эцэслэн сурсан боловч аг тарни бага 5 ухаанд сурч гүйцээгүй хэмээгээд Аг тарнийн ёсонд суралцах эрхэм гэж бодоод тэр жилийнхээ зуны номоор Агва дацанд морилон хайдүв-намхай Жанцангийн залуу хувилгаан айлдгасны дагуу Чавдоггэндэндондүвбалсамбуугийн Дүвчинмэдразогийн Дорпэрэнгээс зургаан хот мандалын авшиг

аван баясал хөөрөөр дүүрэн болов .Жидмод хувилгаан бид хоёр Ава ёсны Доржпэрэнгийн авшиг авахийг айлтгахад намрын ном дээр агийн лам нарын дуганд 500 лам нарт дүйнхороос бусад Ава Дорпэрэнгийн хот мандалын 4 авшигийн рашааныг Доржчангэндэндондүвээс залав.

Өгүүлрүүн: завсрын чимэг үгс
 Алин бээр эрдэмийн хумхийг иш онолоор
 Арвитган дүүргэснийг гурван цагт
 Ажиглан шинжилж өгөх алдар нь
 Мэргэн, номхон, сайн гураваар
 Мэдэл аяндаа бүтэж шавь нарын үзэл дор
 Машид уужим судар тарнийн гол номлолд
 Сайтар судласнаар номлох, хэлцэл туурвихийн үйлс
 Сайн мэргэдийн ачаар мууг дарж
 Шашин амьтны тусын төлөө
 Шар малгайтны шашины журмыг
 Саатаалгүй зохиох намтарын модны
 Сагсайн дэлгэрэх мөчир лугаа арван дөрөв

Өвөл нь жидшод бүрэлгүүгээс 11 мутарт Жанрайсиг, намхайчожүдийн ван Гомбын гачин 13-н жинан, гомбын бибум, Нагвийн чойгор, дэмчигзажүд, додэ занлин Цанжийн хорол, Вудончойнжүн, Зогрэм Налжор, Хайдүвжий хийгээд Лодойчойжонгийн Ямандагийн жидрэм, зогрэм, намшад игчүн Бавуудоржийн зод юүлтээ, иг бүрүү гигсэл Шилжээннамсүмийн жинан, ондог, сандүвжийн жинсрэг, чэвэл манаг, сануйн игчүн Жигжидийн ерөөлийн тайлбар, Сандуйн Зогрэмийн тайлбар, дардас, тову мэгзэмийн бүтээл, жавтүй, Далай ламын зохиосон ламын налжор Симсүмзэгва, намтарийн лүн авч 29-ны Чойнпэрэл ерөөлийн эмхэтгэлийг шалгуулж, тэр хавартаа Чавдагдоржчан Гэндэндүвийн өмнө могой суурьт синдом Нагжийн дархи, 21 дархи, Манзушир, Барижарзийн жинан, 4 лхамын айлтгал дамжлага, сандуйн жинсрэг, дүлбийн тайлбар Лхасрайбогдын жамнагдүвтав, Хайдүвсанжай Ишээжийн сүмбүм бүрнээр лүн хүртэв. Хавартаа зарлигийн ачит ханицашгүй багш Гачин Содномдагвийн зарлигчилан өөрийн буянд зориулан Шагжтүб бурханыг зуран бүтээсэндээ маш их баярлаж буян ихээр хураав Түүнийг харсан шавь жидшодбээр ихээр таалан надад цагаан шүхэртийн загал хэрэгтэй хэмээн бүтээн өгөхийг хүсэхэд түүнийг

зуран бүтээж Ламид ёсны дээд тахилийн нэг болов. Зун нь Далай ламтан гүмбүм морилож соёрхол талбисны сайшаалд ловонгуудыг цайллаганд дуудав, тэр үед агва дацангийн шавь нар гэгээнтнийг санваандүйвийн дүвцод бүтээлд Дорж ловон болж өгөөч хэмээн хүсэлт өргөсний дагуу

Мөн чанар төгөлдөр ловонгийн чаглинг сэргээхийн тухайд, урьд нь элсэн хот мандал хийгээгүй зэргээс хамааран Ловон гэндэндаржаагаас, журам, чаглин сэргээн асууж мандалийн дамжлага айлдварын дагуу элсэн хот мандалын ёс төгөлдөр бүтээж гал мандал жинсрэг өргөх ёсыг горимын дагуу олон мэргэдийн өмнө аг тарнийн ёсонд нэвтэрхий болсон гэдгээ харуулав. Мөн түүнчлэн түвдийн мэргэдийн цуглаан болох сахилтай лам нарын сожингийн хуралд До уншиж бүхэнд гайхагдав. Бүтээл хурахын өмнөхөн Чавдагдорчин Гончогжанцанбалсанбуу бээр хийдэд залархын үесэд Нүрзад ишээжийн гомбо Чагдүгва, Дүмбү, Намсрайсирчин, Жинан сонсож Ванчинэрдэнийн усан тахил Намши Цэвагийн жинан, дэлгэрэнгүй Ванчингийн сүрвэ бага номуудыг ихэнхийг аман гэгээний жинан хүртэж, бүтээл тараад жишод хувилгааны хүсэлтээр ямандаг 13 тэнгэртэй догжир хэмээх жижиг хот мандалын зураг зурах гээд хэрэглэл байдаггүй болохоор бийр, будаг тэргүүтэн хэрэглэлийг бусдаас авч ёсчилон зураад өргөв. Хувилгаан маш ихээр таалан баярлав. Жилханба шавь нартайгаа ирж 2 жил гаруй манайхаар ирсэнгүй хэмээн гэгээнд гомдоллоход багш шавийн шүтэн барилдлага ёсыг сануулж элдэв арга хичээлээр тэдгээрийг баясгав.

Өгүүлрүүн: Завсрын чимэг үгс:

Агуу хоёр чугуулган зүүн уулын оройд тусаж
Асар хоёр үнэний мэдэгдэхүүн огторгуйд оршиж
Ашид номлолын үйлсийн буман гэрэл цацарч
Ач амгалангийн цэцэгс дэлбээлэх наран эрхт
Алин бээр судалахад гүн мэдэлийн хүч цогт
Аяндаа бүтэх эртний ариун раншинтай
Арвин олон шавь нартаа номын далай
Адилгүй мэргэн Лүдэв гэгээн мэт саран болсон
Аяа Гайхамшигт эрдмээр бүжин цэнгэгч
Алив эрдэмийг сааж гайхуулах

Аварга номын модон мөчир лугаа арван тав

Намартаа годцанд заларч шүтээнд мөргөөд лам нарт манж барьж хэд хоног залрах зуур тэндэхийн Рэтодва Жүвзүн тэднээс Вибум Онбийн тайлбар зэрэг хүссэн зарим номын лүн өгөөд дээр нь ноён цоржийн айлдсан номын лүнг өгөөд өөрөө Лхаврагхайдүб Чогийн ойрын шавь зундуйжамц нарт бараалхан багш нь төрөл арилжаж номын агаарт үзэгдсэний 17 хоногийн уншлага таарч их хөлгөний 20-тийн лүн айлтгаж, түүнийг нэг бүтэн үсэг тоолон уншиж түүний хэрэглэж байсан гарын эрх, усны сав, чавэр зэргийг дүвлэх газар тавьж, зохистой явдал бээр зохицуулан үйлдэвээ. Түүний дараа хэсэг хугацаанд хүний хойдоход оролцсон гэж үзэн сожинд очоогүй билээ. Тэгээд бардо 49 хоног өнгөрөөгөөд сожингийн до уншиж эхлэвээ. Годцан хэмээх Ванчин богдын хамгаалагч Чойжин Вэгз сахиус бүтээгээд өгөхийг хүссэнд ёсчилон гүйцэлдүүлэв. Тэр үеэр Халхын хөндлөн ноёны Хатанд Очирвааны жинан хайрлаж Гэгээнд өргөл хүндлэл ихээр үйлдэв. Баруун ноён бунд дайчин болон түүний бараа бологч нар хутагт Манзуширийн жинан хайрлахыг айлтгахад гэгээн түүнд ойлгогдохоор Монгол хэл дээр жинан өгөхөд тэд маш ихээр баярлажээ. Зүнсанхайван содном дагвийн өмнө Диваажингийн ордон бүтээх лоолин босгох, Зава ширавжанса, мөн номлохуй бэрх Ложин хэсэг, бодь мөрийн гол номлол биеийн хот мандалийн авшиг, Хайдүвжийн задүн намшад, жинан, Сүмбүмээс ложин шандондониржийн тайлбар Гэлонгийн сургааль шанпэннянбуу, датед дай ан мүнсэлжийн тайлбар, буяны тарниа, бодь сэтгэл чухалчлахуй бодид чухалчилахуй, дасүншанжид гонбо равсал Ложиндогсол, Лаглинравсэл, Тэцэмгүнсэл Лэгшэд эдон, Мэдагравжид, Чойнодийг дараалан Донжан, Ложан, Тэгчинжаяг, Лавжаа надгаг Дойдавдүнжүү, Хайдүвжийн гэгээний габуу бүтнээр, дорзэнгончигжалцанжий Лүйжил ондог, дондүнзүүгийн тайлбар зэрэг номны лүн, жинан, авшигийг хүртэж гурван жил дотор тарнийн номыг эмхэтгэн бичив. Ванчин богдийн айлдсан Дамбажидан Дэлбэдонсол, Сандуйн жидрэм, зэрэг тарнийн зүгийн бүтээлийг эцэст нь хүртэл үзэх зохих хэмжээндээ хүрсэн гэж бодох бодол төрөв.

Өгүүлрүүн: Завсрын чимэг үгс:

Алин бээр мэдэл энэрэхүй хүчээр бүжиж

Ариун рашааны гэрлээр Гүмүда цэцэг нээж

Атгаг хороор дүүрсэн цэвүүн энэ цагт
Балар шөнийн итгэл, оюунаар харанхуйтган
Бусдын тусад навчис дэлгэрэх цогийг үүтгэн
Баясгалант өдрийн нар мэт биеэ чилээгч
Энэ мэт гайхамшигт цагаан үйлс бүтээгч
Эгнэгт мандсан нар адил гийгүүлэгч
Эрхэн хэлхээт намтарын мөчир лугаа 16

1673 он Багмэд буюу сэрэмж хэмээх усан эм үхэр жил хот мандалын далайг эрхшээсэн очир баригч Гэндэндодүвийн өмнө таван зэргийн номлол нанжад тарлам салжид, судрын дамжлага намжаднянбужан Гэндэндүвжийн намтар, хоёр шавийн нь багшдаа бичсэн магтаал буяны чугуулга дүгживагийн тэг татах ёсын лүн авч зун нь багшийнхаа өмнө зарлигчлан хуучин сахиус бүтээх тэр үед нэгэн шөнө зүүдэнд Год цадаас ирлээ хэмээн хоёр Азар сахиусанд заллага балин тахил магтаалыг нэг шүлгэнд багтаан бүтээ гэж хэлээд нойр сэрэв. Хайдүвсодномдагвын өлмийн өмнө айлтгахад багшийн адистэд юм боловуу бүтээ хэмээн айлдсанд нэг шүлэг ном бүтээв. Сахиусаа зурж дуусгаад өргөхөд маш ихээр таалав. Өвөл нь Цэвагмид ёсен тэнгэртийн их авшиг бишрэнгүйгээр сүсэгээр хүртэв. Түүгээр үл барам хайшиндүйвийванчүг Ловон чоцүмэдлуvsандондүйвийг өөрийн ёнзон багшаар өргөмжилсөн бөлгөө. Гачинсодномдагвабалсансамбуутай хамт Винайн дөрвөн аймаг, Вавардойвийн бясалгал, намэ, сосор тар бийн до Жарзэ, -аас Чойлицандонсүм, Вүдангийн зохиосон Бурхан багшийн намтор, задүн намшад

Жүгийн дэлбэ, Тогмидганбумийн шижахаянма

Түүний намтар дэлгэр, хураангуй Жонжүгийг тайлбарлах зодбийнцом Манзуширийн магтаал дүйсүмжалма Намзодланцойн пунцаггилэгма, Гэндүнжамцын Жанрайсиг, замба лха, шар хар хоёрын усан тахил, Сүрү баадан дормо жарз далан ерөөлийн тайлбарийн хөтөлбөр бат оршил, хадон, гүрэмийн бүлэг Лодойвайбийн гүрдэл чавшогийн тухай Далай ламын нижүд цэтидийн жинан игча, намжолчого, сүн өргөх тухай Лхазүнбийн лхамын ганс дэчиндүв Чиүмэгийн гадон, догжид, тэргүүтэн Хувилгаан Дагжангийн зарим хэсэг ном шавь дорзэнба агчинжийн зохиосон Дүйнхор түгжилийн уншлага, Жаналожинбийн зохиосон ложин тэргүүтэй сүн зарим Балжорлхүндүвжийн зохиосон сүн

зарим Балдансасүмийн тайлбар орц олом гэх мэт дээдийн номын увидас олныг хүртэв. Цаашилбал багшийн тагаалалаар Гэндэндүвжийн дүлдэгрэнчинпэрэнба Дэмчогийн их тайлбар вайдан гүнсэл Доджо намшад, тарламсалжид, Намшаднянбу тэргүүт олон лүн, ялангуяа багшийн таван гишүүний явдал, зургаан номын дотроос эм нохойн бөөлжис, сум мэт харвахуй нум мэт хөвчлөхүй, гэх салхи хөдөлгөх бясалгалд өчүүхэн төдий судлахад лагшин чилээрхэж буй тул бясалгалаа түр боливоо Ловонгэндүндаржаа бээр залж дүншагийн 35 бурханд сүншаг өргөж өгөхийг хүссэний дагуу гурван шүтээн босгохийн буяныг бодон хилэнцээ арилган чугуулганыг хураахын тухайд сүншигт ёсчлон өргөв. Өгүүлрүүн: Завсрын чимэг үгс:

Гайхамшигт сэтгэлийн давалгаа ерөөлийн гэгээгээр
сахин оршиж

Гоц асрангуйн усаар чийглэсэн нинжийн хөрөнгөөр
Сайтар төрөх бодьсадбийн саглагаар салаа мод
Сургааль гурваар дэлгэх навчис оюуны үр
Сурах тэвчихүйн эрдэмийн санг эрхшээн олж
Сонсох санах бясалгалийг өдөр шөнгүй
Сааралгүй алжаалыг шүтэх итгэл юугаарч
Аяа би тэргүүт шавь нар хичээл дор зүтгэ
Айлтгал тухайлан зохиолын хэрэгтэйг барьж
Асар цагаан үйлээр цэвүүн цагт дор
Амьтан бүхнийг энэрэхүй намтарын мөчир лугаа 17

Үхэр жилийн сүүлээр халх баруун талын Дорж түшээт хаан Лхастай танилцахаар Зангаас морилон бүхэнд баясгалан хэмээх бар жил 1674 он Монголын нэг сарын шинийн хоёрт Чойнпэрэлээр Лхасад тааран уулзаж хаан гэгээнтэнийг өөрийн угтсан гэрт залжээ. Хаан гэгээнтэнээс урьд буцах залсан заллагийн хариу авч номын хурим хойшлуулалтгүй хийх тухай дотно ярилцав. Мөн хамтдаа сувраганд мөргөн, хоёр зуу, Ранжун хэмээх 11 нигуурт Жанрайсиг тэргүүт гурван шүтээн, цастны сир брайбун хийдийн шүтээнд мөргөж, Чойнпэрэл ерөөлийн үеээр их чогчинд хаантай хамт олон удаа хүндлэгдэн залагдаж олон хуврагуудтай хамт ерөөл талбиж ерөөлийн дараагаар Далай ламаас Цэвагмид 9 тэнгэрийн гүйцэт авшиг ном дагуу дэлгэрэнгүй, Түгжийчинбу Зонхорсүм, долгар, цэвагмид цагаан Дамдин сандувийн жинан, жалбууд-аг Гомбын дүвтав, жинан лүн, Гандантива Лувсандонёд,

Жалсрайренбучи, павонхайвийн шавь Жамъяандагва, нарын өмнө, мөн ёнзон багшийн өмнө сан дэ жиг жүд ван жинанг хаантай хамт хүртэв. Хаантай хамт сувраганд өдөрт олон удаа сунаж мөргөж Далай ламтанд олон бараалхаж өргөл ихээр өргөж чин сүсэгийн сэтгэлээ илэрхийлж чадав. Тэгээд хаан бээр зан уруу явахаар хамт ранчин дайраад Занд очив. Занд очсон өдөр нь хаан гэгээн хоёрын заларсан өргөөнд туслах болон аль хэрэгцээтэй зүйлийг бэлтгэж гүн хүндэтгэлтэйгээр хүлээн авав. Маргааш нь Ванчинренбучийд бараалхаж мутарын авшиг авч тахил дэлгэрэнгүйн хамт гадна дотно суурь гурван шүтээн өргөн машид дотно бараалхаж Ванчин богд урьд дүрийн зохиосон ламын Чодва, латид цөөн үгст лүгма хоёрыг, Оточ маналын хураангуйг Цагаан шүхэрт цэнянбуу тэргүүтнийг аман гэгээнээр лүн өгч хаантай хамт айлтгаж агийн шавь нарын дэргэд Чагдор хорчин, гүнрэг, явдалын дамжлага голлон намнан онжингийн их авшиг айлдав. Хааныг зангаас заларахын үеээр угтуул гаргаж хүлээн аван хоёр зууд мөргүүлэв. Бурханы шашин дэлгэрэхийн ерөөл талбиж тэр цагт хаан бээр төрсөн нутагтаа надтай хамт буцвал яасан юм бэ хэмээхэд нь би бээр Далай ламаас сунтаг асуухад энэ жилдээ бие лагшингаа тэнхрүүлж бэлтгэлээ базаасан нь сайн хэмээн зарлигласан дагуу үлдэв. Энэ завсар хааны намтарыг монгол хэл дээр бүтээж срайбу бандидагаар дамжуулан өргөхөд маш их баярлаж надад маш их өргөл өргөв. Тэгээд хааны морилсоны нэг сарын дараа Сирагаас Повонхайд заларч Ловон Жамъяандагвийн өмнө гүнрэг үндэсний хот мандалын их авшиг Важигийн авшиг, Дамдин янсагийн авшиг Гэндүнжамцын айлдсан явсрай Хоёр шавийн намтар ладодцог 5-р Далай ламын нүйнайгаас нярхосүржин хэмээх Нүнайн уншлага, мөн өөр лам нарын айлдсан олон ном лүн авшигийг хүртэв. Намартаа Сирад заларч Очирдаржидшод хувилгааны өмнө цагаан шүхэрт, гаадамын тигли Мэнтүг, дэмчоглха, ролон 8ийн тухай, намжил 9н тэнгэрийн авшиг, жигжид нэг баатарт, Доржсимба, дүйцанма Луйванжалбу тэргүүт олон едамын ван хүртэж Шибрангийн тайлбар, зажүд, чимажүд, игчүн 21 Зодийн тайлбар сирлэрэн, жалсрай тогмиджийн ложингийн тайлбар, Далай ламын зохиосон Цагаан шүхэртийн бүтээлийг бүрэн гүйцэт авшиг хүртэв.

Өгүүлрүүн: Завсрын чимэг үгс:

Янагш, чинагш эрдэм мэдэгдэхүүн бүгдийг

Ямагт сурсан ч ханалт гэж байдаггүй ч
 Эрдэм мэдлэгийн энгүй их далайд
 Энгийн би бээр яаж тайлж барах бэ
 Гайхамшигт зохиол тус амгалан бүгд нь
 Гагцхүү амьтаны тусын тулд ханьцашгүй
 Сансар нирвааны замыг сайтар баригч
 Сааралгүй аврал ухаантан танаас өөр хэн
 Онц гайхамшигт цагаан буяны үйлс
 Орчлон оршин байх энэхэн хугацаанд
 Тасрал үхэлгүй рашааны үргэлжлэл шиг
 Тансаг нахиалах намтарын мөчир лугаа 18

Өвөл нь зан руу залрахын замд Ва-са Хийдийн Дандарын шавь нар урин залж очив. Тэндэхийн хийдийн шүтээнд мөргөж, шавь нарын айлдсаны дагуу маналын дожэжайва, тэргүүт цээжилсэн номын лүн сонсгож цааш нь Винсайва лувсангийн габум, палчингийн лүн, тэргүүт хэсэг ном айлтгасныг сайтар лүн сонсов, тэр жилийн хээ өвлийн номоор агва дацанд морилов. Гүдор буюу 29-ны сахиусан очиж 1675 он Сэрэнбу хэмээх модон эм туулай жилийн Чойнпэрэлийн их ерөөлөөр хуралд сууж олон мянган лам нартай хамт сайтар ерөөлийг талбив. Тэгээд тэр хавараа очирбаригч гэндэндндүвт амар мэнд мэдэж золгуут хийж 3н хот мандал жигжидийн их авшиг Гаадамын 4-н тэнгэрийн жинан, мажиг Дүвлүгийн цэван, чагдүг гомбо, Жамьяан, Долгор, чойжилийн нууц гадна дотны жинан Пойтэд алтан үүд нээхүй, жинанд даган баясаж даллагийн сум өргөв. Хайдүвжийн хэсэг ном болох шалдам, Рэг “ а”, Дүлжингийн хорчин ондог зэргийн аман гэгээний лүн хүртэв. Хавраас намрын дунд сар хүртэл Жанчин ламтай хамт ямандагийн Нянба гол тарниар 100000 буюу бум тоолж иш ван тодорхой тэмдэг ирэв. Бумшийн дайвны сүүлээр шиивийн буюу амирлангуй гал мандал жинсрэг 100 удаа өргөж нянбийн үе үргэлжлүүлэхээр лагшин чилээрхэх байдал үзүүлэв. Үүнийг миний үйлийн үр гэж бодон тэсвэрийг сэтгэлдээ барин алгасалгүй төгсөв. Ванчин богдийн латид цэглүгма, багшийг шүтэх ёсны тайлбар бүхнийг мэдэхээр одохын амар мөр, Гончигжанцангийн дамжлагаар зохиогдсон Бодь мөрийн шүлгэн зохиолыг бүрэн цээжлэж буяны садан хэмээх 1672 он усан эр хулгана жилд Буяны садан багш дээдсийн өмнө өөрийн зам мөрийн тухай айлтгаад 25 хоног эргэцүүлэн бодож тунгаасны

хүчээр замын эргэлзээ сэтгэлд төрж, нууц байдалтай ийн хэмээн зам одвоос гэрийн орон болох болов уу үргэлж тийм бус тийн алгасралын эрхэнд орох дагавар үгүй яв зарлигийн эрдэмтэй номтой хэмээн бүү баярх хэмээсэнд утга нь миний сэтгэлд магад буулаа. Намар Дашилүнбэд залрав .Асар ариун цагаан үүлийг нэг дор хормойлж, Алгасарал бусдад хөдөлгөөн үгүйгээр, Ертөнцөд зохилдохуй мэргэн аргаар, Эрхтэн дархтаныг асрал өглөгөөр эерэг болгон бараалхахаар түвдэд залрав. Өгүүлрүүн: Завсрын чимэг үгс:

Алин бээр тийн судлахуйн уужим тэнгэрийн замыг
Ачтан таны буянт үйлсийн цагаан гэрэлээр
Алдар төгөлдөр багш долоон морьтноор түгээлүүлэн
Амьтны оюуны харанхуйг гийгүүлж
Зөөлөн итгэлт багшийн номлол бүтээлийн цэцэг
Зөв тус амгалангийн үрээр ишлэн цоглож
Зөвхөн таныгаа түших сэтгэлийн үзүүрт та
Зөн билгээрээ мэдэх бүхний эцэст хүрч
Зориг шантралгүй судлах гайхамшиг
Зон олондоо үлгэрлэхүй намтарын мөчир лугаа 19

Тэгээд занд морилон өвөлжингөө тэнд байх хугацаандаа жидшод хувилгаанаас Хорчин дэмчоглүйвийн хот мандалын авшиг жинан хүртэж бас бус ном айлтгахын завсраар агийн номын шалгалтаа өгч, хорин есны сахиусанд 1676 он гал хэмээх гал луу жилийн Чойнпэрэл Ерөөлийн хуралд тасралтгүй морилож, Шашин дэлгэрэх ерөөл талбиж, Монголын 3-р сарын хаврын адаг наг сарын шилийн 15-нд дүйнхорийн Ловон Чавдаггэндэндондүвийн өмнөөс Жидшод хувилгаан тэргүүтэй агва дацангийн лам нартай өнгөт элсэн хот мандалтай Цагийн хүрдний авшиг, хүртэж шамбалын ерөөл талбив.Хавар сандуйн бүтээлийн дараа үйд Жамъяандагва ганжуурва жинба Жамцын өмнө ганжуурын лүн ихэнхийг хүртэж домангийн сүүлийн 3-н боть Жүдийн ботийн лүн хүртэх үед шавь Жамдагтай хамт лүн авав. Түүнээс хойш жамдагийн хүсэлтээр Додэгалсан, алтангэрэл, доржзодов Маналын додэжаав, сундуй, зэргийн лүн авав. Мөн бидэн хоёрт дүвтавжарз, нартан жарз 21 дархийн жинан жалбаан авын намтар, Багшантишэнгийн лүн, зэрэг дээдийн номын увидасыг хүртэв. Тэр жилийнхээ өвөл ноёны ахай гэцүл Элдүн ноён дайчин хошууч, мэргэн Ахайн охин магада, сэцэн ноён Үйзэн Ноён тэргүүтэй

албаны ихэс Лхасад морилж, гэгээнтэн хориод өглөгийн эзэдтэй таарч магада Үйзэн ноён тэргүүт хэсэгт ямандагийн авшиг айлтгасны дагуу ямандаг 13 тэнгэрийн ван айлдав .бусад ноёд ч гэсэн номын лүн авав. Лхасад элдэн ноёны лагшин-чилээрхэж банзад зэргийг холин эм хийн өгсөнд ноёны бие илааршиж таны эм тус болсон үргэлжлүүлж таны эм ууна гэсэнд анагаахын ном гүйлгэн үзэж эм найруулж өргөсөнд бие тэнхэрч сайжирав .Гэгээнтэнд эмчлэгч эмчлүүлэгч хоёр буяны барилдлагатай хэмээж сүжигийн хүч хэрэгтэй хэмээн өвчин үгүй эдгэрэв. Занд заларч Ванчин богдод ирсэн өглөгийн эзэд бараалхан өргөл хүндлэл өргөж Лхасад түргэн буцаж морилон Далай ламтанд бараалхаж өглөгийн эздийг буцтал лхасад байж, байгаад буцахаар нь павонхай уруу ганжуурийн лүн хүртэхээр залрав. Лүн хүртээхээс өмнө жамъяандагвийн хэлсэнчилэн дүлбийн лэнбум, лүн, чагдар хорчин 2нигүүртийн авшиг хүртэж, 1677 он шаргачин хэмээх гал эм могой жилийн монголын 3-р сарын эхнээс эхлэн Гончиг зэгвэ Палчин, ширчин, ёнзог, няндай, доман эхэнхийн лүн аваад байхад зарим шавийн сэтгэлд тааруулан өргөөний чойнзод, лувсанахайнзүнгийн сонирхол дагуу, дүлбийн линбум, домангаас 25 ботийн лүн, сажай маналын сүн, жийрав сажи, Жалбангийн ламын латидийн лүн сонсож, мөн шавь агваанлодой тарбачинбуу боть 4, Гэндүнжамцын сандэжигсүмийн дэлүүба ёсны лагшингийн жинхор, жидрэм, дэлүүба ёсны дэмчиг жинсрэг, гэлонгийн лавжа, гонхан ламын айлтгасан жалбийн солдэв, гаржама тэрүүтнийг аман гэгээнээрээ лүн хайрлав.

Өгүүлрүүн: Завсрын чимэг үгс:

Удирдагч 4-р бурханы номын цэцэрлэгт

Улаан шаргал дэлбээ 12- ийн эзэн

Хоёрдугаар бурхны судар тарины

Хосгүй номлол бүтээлийн үйлсийг заагч та

Хувь төгөлдөр амьтны баясгалангийн хурим

Хувирашгүй жаргалыг арвидуулан зохиогч

Хэмжээлшгүй эрдэнэ гарахын орон

Хэт саглагар намтрын мөчир лугаа 20

Дүйвиванчиг Лувсангончигийн өмнө ёндонжамц далай ламын намтар, ерөөл дашийн гор хүртэл 38 цаас түүнээс цааш овоо, гарчаг гороос 105 цаас дагом дүвжалжийн лүн, хандо ламын налжор лүн, гиза ёнсү зэнбийн до буяныг огоот барьсаны судар

хүртэл Монголын 7-р сарын 11-ны өдөр гэгээнтэн халуун өвчин тусаж Ванцад чихэрлэг хэрэглээд ч шээс хаагдаж эм ч янз бүрийн эм өгөөд нэмэрийг үл оров. Тэр үед гэгээн өөрөө симасүмтан найруулж уугаад шээс гарч сэтгэл уужрав. Далай багш болгоож өвчин ужигдуу боловч амь насанд гэмгүй хэмээн айлдаж засалд жадонба, сундуй, 100 удаа амин золиг олон гарга, часүм 100 удаа уншуул гэж айлдав. 22-ны өдөр асруулж лагшин дээрдэв. Нэгэн шөнө гэгээн зүүдэнд бүхнийг мэдэгч Ванчин богд дүрийг тэвэрч өрний хойно залаад дамдин чойжил бүтээгээд өлмийд нь залхад Ванчин богд халуунаа хоцроолгүй арилгая гэвэл рашаанд ор гээд нойр сэргэв. Сэтгэлд баясал төрж Гомо рагвийн бие лагшин арчилсны дараа, нэг сар 6 хоног эмчлүүлээд эмчээ сольж өөр эмчилгээ эхлэж, ломо чойжин, дүншаг нэг бум уншиж залбирав. Хоёр сар болсон боловч сайжирах засал тааруу байв. Гэвч түгсрай ренбучигээс ганжуурын лүн айлтгаж дутуу байсан 6 ботийнхоо лүнг гүйцэт хүртэж, Далай ламын зарлигаар лхасад байв. Ванцод сүмга бээр зүү төөнүүр хийсээр л Дожай ламтанд бараалхаж мутарын адис хүртэх зуур тагаалал нь баясгалантай гаго хүртээж 1678 он буюу илч хэмэх шороон эр морин жилийн хавар вам ромийн рашаан ор хэмээсний дагуу рашаанд орж бага гэсэн тус нэмэр болов. Монголын 2-р сарын шинийн 16-ны өглөө үүрээр нар хоёр хуруу ургах цагт Далай ламаас Ванчин богдод нянзаг гэлэнгийн санваар хүртээв.

Өгүүлрүүн: Завсрын чимэг үгс:

Тоолшгүй зузаан үүл тэвчигдэхүүн бүгдийг

Тоолон эцэслэж ахуй үед нь илт болгоож

Энгийн шавь нарын эрх дүр дарууханаар

Эрдэм бүгдийн оргилд хүрсэн мэргэдийн чимэг

Лагшин чилээрхэж хүндээр муудсан ч

Лагчаг үйлийн үр хэмээн эс тоож

Туурвил бүтээлээсээ санах шамдлаар

Тууштай шамдалын намтар лугаа 21

Монголын 4-р сард Ловон дарам судас үзэж сайн болоогүй байна гэдгийг хэлэв. Дараа нь Вонцод шинжилээд хоол унднаас болсон гэсэнд далай лам ямар хоол унднаас болсон гэсэнд Далай ламын ямар хоол идсэнээс болсныг тодруул хэмээн эмч ахин ахин ирж сонгино сармисийн төрөл зүйлээс хамааралтай хэмээн зассан ч үр дүн багатай л байв.

Тэр үед жүдмад дацангийн лам нарын байр лхасад босгож намартаа дуусгав. Сага сарын 15-нд Дүвчинлуvsанчогийн өмнө түгжий чинбу жанрайсигийн нүнайн сахил ам авч нэг удаа сахихад лагшингийн чилээрхэл арилаж, лагшин амгалан болов. Ловонлуvsандонёдбалсанбуугийн өмнө дүлбааны лүн бүрэн, Гаадамын ном рэдот пэрэндаваа 3 дахин, жамбалцанжидий -н тайлбар рэгтаг, өөр жүдвийн зодвийн регва, Жидшод бүрүлгүүгийн зохиосон жигжидийн авшиг номлохуйн эрх, Жамъяангийн номоос лхантавийн лүн, гомбо чойжилийн чүнтайн лайцог, бүрүлгүүданзангийн лам зову намсүмийн тайлбар, зэрэг лүн хүртэж, Зун нь Вонцод сүмга бээр зүүн гарын рүтэн хатгаж намрын хур усанд оров.Тэгээд эмч Дарма нэгэн өдөр цомбон магнай зэрэг 3н газар хатгаж хатгуур тавьсанд бие сайжирав.Хятад янз бүрийн хүмүүс Далай ламаас Цэдасүндэлжийн жинан хүртэх үед цогнин дуганд шавь нар дүүрэн сууж хурав.Далай лам настай хятад хүн хоёр бусдыг гарган бид гурвуул үлдэж бид хоёрт өглөг ихээр үйлдэв. Төрсөн нутаг монголоос урилга заллага айлтгасан хүмүүс лхасад ирж халх морилохын заллагийг Далай ламд айлтгахад багшийн чилээрхүү байна.Энэ жил азнан бие тэнхрүүл одоо болон ирээдүйдээ зориулж мэгзэм жива, ширавнямбуу мөн адил унш монгорчүжин морил хэмээн айлдсан дагуу зан уруу морилж Дашилхүнбэ хүрээд Ванчин богдтой хэд хоног бараалхаад мангарчүжинлаад очив. Гашаг хийгээд Лхазонгийн зөвшөөрлийн дагуу чүжинлаад сайхан амрав. Дашилхүнбү дацангийн цогчинд 25-ны манз хуруулж өглөгийн эзэд Васоганданравжаа, Винсай хийдийн Годцаджанчиндаржаа нар олон дахин манз барив. Өвөл 29ны сахиус 1679он дондүв хэмээх шороон эм хонин жилийн чойнпэрэл ерөөлийн хуралд морилж бурсан олон хуврагуудтай хамт шашин амьтаны тусын тулд ерөөл табив. Дээдэс мэргэд бээр Далай ламаас Вудангийн зохиосон дүлбийн лэнбум, Чойжиднамчин додвий дэлам, эйнжүнпунцаг хэмээх солдивийн лүн зэргийг хайрлав. Лаврангаас одвагмид бурханы хөрөг бурхан багшийн хөрөг, далай багшийн үда буюу үс, пэлдэн тэргүүт адистэд, чойго хувцас тэргүүтнийг хайрлав. Тэр сарын 25-нд Дашилүнбээс хөдлөж донир ханцангийн багш лам хол гаргалцаж өгөв. Монголын хоёрдугаар сарын шинийн 9-ны өдөр лхасад морилож ирснийхээ нөгөөдөр далай лам, болон албаны хүмүүстэй уулзав.Түүний дараа далай ламын лагшин чилээрхүү

тул нэг сар орчим бараалхсангүй. Монголын 3-р сарын шинийн 15-нд Поталын ордонд дээдсийн зарлигаар чавдагаграмба агваандондүв өөр алдар нь намхайсан бээр Дорж пэрэнбиванжүд арвидуулахын тухай ванчийн дагон айлдав. Шинийн 16-ны үдээс өмнө дээдэс чи авшиг авах хэрэгтэй айлдахад би бээр поталын өргөөнд ирэв. Даган айлдаад ван ойш айлдаж 21 хоногийн хугацаанд хосгүй том мөрөн нийлэх мэт 45 хот мандалын авшиг гүйцэт авч сэтгэл цэнгэлээр дүүрэв.

Өгүүлрүүн: Завсрын чимэг үгс:

Үй хийгээд зангийн барилдлагат дээдэс

Үнэхээр багшийн төгс шинжийг ёсчилон

Сайтар дагаж судар тарнийн номын далайд

Судлан эцсэлж мэргэн, номхон, сайн гурваар

Яруу алдар орчлонд бүхнээ түгэж

Ямагт иш онолын зэндмэн эрдэнийг

Боловсруулж шашин амьтаны тус бүгдийг

Бүрэн хүслээр хайрлан цагийг үргэлж цэнгээж

Урьдын ерөөл таалалын хүчээр

Умарын орны амьтаны тусыг зохиогч

Гүн тагаалал саран эхчилэн мэндэлсэн

Гүнзгий углуургат намтарын мөчир лугаа ч 22

Тэр үед гэгээнтэн бээр өдөр бүр авшиг авахын өмнө хайванванчиндагвийн гүдэнгийн өмнө шүнлигжамцаас шүлэг 18 нянбийн хураангуй, живаренчинсүрэл нямыг жарзийн лүн хүртэж өөрт хүртээсэн ач бодож урьдын сүсэгээр хойтийн буянд зангийн их бага хийдүүд сэнбэрэгэсүн, дацан тус тусд нь манз зэд давтан өргөж мөн жүдийн 2 дацан, Далай ламын дацан павонхайва, Радон хийд тэргүүтэй их бага хийдүүдэд манз барьж зэд өргөв. Дээдсийн зарлигийн дагуу гүрэм засал олныг хийлгэв. Гэндүнярва гүнтанд заларч манз барьж, зэд өргөж, шүтээнд мөргөж дуусаад дахин лхасад морилов. Дээдсийн зарлигчилан зүүн хаалганы ловон Агваанданзангийн өмнө дамдин сандүв, цэвагмид хосолсон жинан жарз, тэргүүтэй хэсэг номын лүн хүртэж, чавдаг намхай санбуугийн өмнө их бага алтангэрэл, найдан чого, санчог, зэргийн лүн хүртэв. Хоёр зуу сэнбэрэгийнисүм, павонхайвийн шүтээнд мөргөж, монголын 5-р сарын шинийн 1-ний өдөр дээрхийн гэгээнтэнд бараалхахад синтийнээсээ морилж урьд дүрийн нандин номын хувцас, мутраараа барьж

эрдэнийн си хэмээх хүзүүндээ зүүдэг алаг зүүлт, уда буюу үс, чулуун тамга тамганы гэрийн хамт хайрлаж дээрхийн гэгээн нэгч дагуул үгүй бид хоёулахнаа эхлээд богд ламын бүтээл яруу үгийн дамжлага гүн замын ёгүзорийн аман гэгээний ишлэл, 3-р манз цай хүртэл дээрхийн гэгээн онцгой захиас зарлиг хайрлав. Та шашин амьтаны тусыг хангаж 2-р бурхан богд ламын иш онолын сургаалыг аривдуулан дэлгэрүүлж хувирашгүй хичээлээр зүтгэх хэрэгтэй. Өөр үзэл баримтлал дүнтатай хүмүүс хуучин ёс нямаба, шар толгойт исүс нартай би ярьж байгаа юм шиг хариулт бичиг, өгч аврал одуулах, сахил сахих, нүнай хатуужил, дормо жарз, гадомын ном, бодь мөрийн зэрэг, болон доод 2 жүд буюу дамжлаг голчлон бага багаар үйлдэх нь сайн, энэ үе болон ирээдүй хойчид сургааль номлолыг нарийн айлдав. Үүний хариуд гэгээнтэн бээр зарим нэгэн иш онолын эрдэм надад байгааг зарлигчилан бүтээхэд хүч үл хүрвээс тан дор залбирал талбиж номончилж та шашин амьтаны тусд адислаж хайрла хэмээн айлтгахад ордонд гүнцэг өргөв. Гүнцэгийн дараа хэнтэй ч үг гаргалгүй вачин мэргэн тайж зонин, түүний охин, сэцэн ноён зөвхөн бид 5д нүрзад ишээ гомбо чагдүгвийн жинан барцадгүнсэлийн жинан айлдав. Гомбо төрийнхөнтэй уулзахад дээрхийн гэгээний хайрласан алтан бурхан багш махгалийн танг бурхан, алтан хайрцагтай хэрэглэл, цэмбэ торго, бурам, эмээл бүрэн тоноглолтой том луус хайрлав. Сайд дээрхийн гэгээний алтан цүр, найдангийн танг, лагой, номын хувцас тэрэм, цэмбэ тэргүүтнийг өргөв. Шинийн 5-нд тамга өргөмлөлийн хамт өргөж билэг дэмбэрэлтэй ёслол төгөлдөр хүндэтгэлийн байдалтай ерөөл тавин уншиж сүүлд нь дээрхийн гэгээнээс өргөв хэмээн гардуулав.

Замбуулин орчлонгийн чимэг бурханы
 Завсаргүй гангийн урсгал мэт буян нь
 Бодь сэтгэлийн саран эх мөнхөд бууг
 Баатар чингисийн үрс хаан язгуур
 Одод гаригийн тойрох адил дагах амьтан
 Огоот нярваанд хөтлөх үйлийн их тэргээр
 Хамгийг болгоогч богд зонховийн сургааль
 Хориг саад бүхнээ гэтэлж цэнгэлд очоод
 Хотол олныг минь адислаж айлтгануу гэж
 Хоногийн сайныг харан хошуу соном хадаг өргөн бичвэй

Өгүүлрүүн: Завсрын чимэг үгс:
Таалал ерөөлийн том бөх онгоцоор
Тэнгис гэтлэх мэт зарлигийг эрхшээж
Эрдэм бүгдийг эрхшээсэн хаан
Эмч адил заяасан билиг ухаанаар
Эгц оргилд хүрч элт өндөрийг магад олж
Эрдэмт хувь төгөлдөр шавь их сүжгээр
Энх амгалан гарах үрийг ишлэн
Энэ мэт судар тарнийн номыг умар тарихаах
Эрдэм билиг төгөлдөр гэгээний намтарын мөчир лугаа 23

1679 он тус бүтэхүй хэмээх шороон эм хонь жилийн монголын 5-р сарын шинийн 11-нд цаст түвдийн нийслэл лхасаас умарт монголын оронд номлол бүтээлийн ерөөлийн хурыг буулгахаар далай лам Ванчин богдод бараалхан хоёр зууд мөргөн багш нартаа ээлжлэн бараалхан сэтгэл уйсал төрсөөр аян замдаа морилохдоо дахин уулзахын ерөөл талбисаар Гибу гандан хийдэд заларч жиренбуучийн чандраар сүншиглэсэн мөнгөн лавай тэргүүтэй гурван шүтээнд мөргөж умарт нутагт зонховын шашин дэлгэхийн ерөөл өргөж манз бариад ширээттэй нь уулзав. Түүний дараа гаадамбын шашины төв радон хийдэд морилж манз цав барин ерөөл талбисаар нагчүүд хүрч тэнд 10 хоног орчим байгаад жанламаар дамжин брэгү мөрнийг гатлан брончү хэмээх газар хүрэв. Гэтэл гол нь үерлэж гарах аргагүй болсонд гэгээнтэн дээдэс багш нартаа залбирч мэгзэм, лувсанжалба хоёрыг хавсран залбирсанд түүний хүчээр ус багассаар бид гатлав. Цааш гүмбэн хийдээр морилож мөнгөн суврага тэргүүтэй шүтээнд мөргөж, лам нарт манз зэд барьж хамба ламтай дотно бараалхав. Зонийн цорж, Далай хунтайж Содномцэван тэргүүтэй өглөгийн эзэд баяр хөөрөөр угтан номын хурим хийв.

Өгүүлрүүн: Завсрын чимэг үгс:
Аль бээр ил далд нууц бүхнийг тодруулж
Атгат, тэвчигдэхүүн үүлэн цогцсыг үзэсгэлэнтэй болгож
Хатуу хүчтэй ерөөл талбин биедээ хурааж
Хавар цагийн хурчилан эрдмийг буулгах
Хосгүй гайхамшигт тэнгэрийн хэнгэрэг
Хувь сайт тогосны зүрх энд мэдрэгдэж
Ховор номлол дэлгэрэх мөчир лугаа 24

Монголын 8-р сарын шинийн 1-ний өдөр хуучин хааныд бараалхаж (хааны төрөл) Монголын 9-р сарын 19-нд аргатүр хэмээх газар хүрэх өдөр бандида болон номын эзний гэчилма, илдэн ноён нар бээр угтахаар ар араасаа ирэв. 21-нд хэрээ хүрэв. Тэгээд 7-8 хоног ном жорлож чангаар уншиж саатав.9-р сарын 29-нд Түшээт хаан Данзэн тойн бээр олон хүнтэй угтав. Нэгэнд дэвэр дор бандидад зам зуур идээ шүүс бэлтгэж дайлав. Шинийн 3нд аавтайгаа золгов.Мэнд байгаа аав ээж ахмад настан Данзантойн ахай, тэргүүтэй танил хүмүүстэйгээ золгов. Тэр өдөр Хайдавчинбу бандида хутагттай золгож одбагмид бурханы хөрөг далай багшийн саняг дөрвөн боть номын хувцас хүн тэргүүтнийг хадагтай өргөхөд маш ихээр баярлав. Гурав хоног залрах хугацаанд өргөл хүндлэл үзүүлэв. Туслах нар нь зарим нэгэн номын лүн хүртүүлэв тэд монгол гэр нэг томыг хүрэн торгон тэрлэг, хоёр тэмээ, зуун адуу өргөлд өргөв. Номын эзэн гэцүлма илдэн ноён лувсантонёд, лхазүндэнзэнжамц, дайчин ноён тэргүүтэй өглөгийн эзэд номын хуриманд өргөл өргөв. Гэчүлмааг 100 адуу тэргүүт өглөг өргөв. Хүмүүс хир чинээгээрээл өргөл өргөж би таарсан харамж өглөө. Хүсэж байгаа номын жинан лүнг хайрлав. 11-29ны өдөр данзан тоненгийн босгосон хийдэд залрав. Тэд сэрдэн дээгүүр синбэрэмтэй хүндэлж угтав. Тэнд бараг мянган хүн багтах том гэрт насны авшиг зарим нэгэн номын лүн өгөв. 12 сарын шинийн 3-нд өдөр гэгээнтэн өөрийн хийддээ буцав. Түүнээс хойш монгол орны бураны шашины гэрэл өндөр гэгээний эрхэм шавь, ловон тэргүүтэй олон хүмүүс бараалхаж өдөр шөнөгүй байсанд лагшин чилээрхүүг бодьсадийн явдалаар бусдын тусын тухайд өөрийн сэтгэлийг чангалан шахаж өөрийн биеийг нулимдас үнэсчилан орхиж бусдын тусыг зөвхөн бодон өдөр шөнийг өнгөрөөж, загас ус уруу ордогчилон сэтгэлээ оруулж байв. 23-наас авхуулаад 29-ны сахиусанд 1680 он буюу хатуу хэмээх төмөр эр бичин жилийн чойнпэрэл ерөөлийн үеээр 16-17-нд хүртэл өглөгийн эздийн хөлд дарагдаж байсан хурал өнжилгүй шашин дэлгэрэхийн ерөөл талбив. Ерөөл тараад дээрхийн гэгээн далай ламын айлдварын дагуу монгол оронд нянба хийх, нүнай сахих ёсыг дэлгэрүүлж 25 шавь нартаа балму ёсны 11 нигүүртийн авшиг өгч үргэлжлүүлэн нүнай сахиусан сандуй жигжиү, цэвагмад, цагаан шүхэрт, мөнтүгийн авшиг лүн өгөв. Хавар нь дээрхийн гэгээнтний төлөөний хүн морилон найр хийж 30 морь хадаг

тэргүүтэй өргөл барьж цэнгүүлэв. Түүний дараа эрхэт дайчин ноён жигжид хураангуй жинан хүртээж, 168 он Монголын 6н сард өндөр гэгээнд бараалхахаар морилж төр шашины байдлыг дотно ярилцан дотносов. Рэбү гижалин буюу буян дэлгэрүүлэх шинэ хийдэд заларч эмхлэх зүйлийг зааж өгөв. Хагас сарын хугацаанд залрахдаа цагаан дархийн авшиг цэвагмидийн жинан айлдсанд гуулин бурхан, олбог, торго, мөнгөн сав, 10-н лан алт, арван булганы арьс зэрэг 30-н сайн морь өргөл хайрлав. Нааш ирэхдээ намжил номын хааныд заларч нижүд цэтидийн лүн жинан айлдаж морь тэмээ хадаг тэргүүтнийг өргөв. Тэгээд жирэмтийн халуун рашаанд Дорж түшээт хаантай уулзаж хэд хоног байсанд хаан бээр хүндлэл үзүүлж 100 морь голлосон өглөг өргөв.

Өгүүлрүүн: Завсрын чимэг үгс:

Маш цагаан хоёр чуулганы эрдэнэ гарах орон

Магад тусах таны сэтгэлийн цагаан гэрэл

Номлол бүтээл бус амгалан эрхээр цэнгэж

Ноён оргилоос мандах таны их эрдэм

Хойд зүгийн оронд ерөөлийн хүч биелэж

Хосгүй дээдийн номын рашааны салаа мөчир лугаа 25

Гэртээ морилоод удаагүй Бандидагийн шавдан болон ялгуугсан нарын шавданд морилов. Өргөл ихээр өргөв. Монголын 8-р сард дайчин хошууг заллага айлтгаж 100 морь өргөв. Барчид арилгахийн тухайд гүрэм ном айлдав. Ахай гурвуул охин 1000 хонь 300 адуу, 200 үхэр, 43 тэмээ гэр тэргүүтнийг өргөв. Үйзэн ноён заллага айлтгаж тэндээ хэд хонож ном авшиг тэргүүтнийг хүртээж 100 адуу голлосон өргөл ихээр өргөв. Даеги хунтайжийн заллаганд 21-н дархийн жинан насны авшиг зэрэг номыг хүсэлтийн дагуу айлдсанд далай манзуширийн гүжэ түүнийг угтаж найр дэлгэр хийлгэж луус нэгийг өргөв. Даеги тайжийн заллаганд угтуул олон ард, номын мэргэд ялгуугсан хутагт лам, Дарбабандида, тэргүүтэй олон хувраг их бага ноёд заларч даео хунтайжийн лагшин чилээрхэж явж чадалгүй сэцэн ноён угтуул явуулан найр өргөн дэлгэрхийж морь үхэр 200, 2000 хонь, тэмээ ачаа дүүрэн хувцас хүрэм монгол гэр зэргийг өргөв. Сосорбарамын жинан, цэтид зэргийн лүн айлдав. Ялгуугсан хутагт, Дарбалам тэргүүтэй хуврага, ноёдуудад ямандаг авшиг жинан лүн олныг айлдав.

Өгүүлрүүн: Завсрын чимэг үгс
 Огторгуйд таалал нь бүрэн түгэж
 Орхил үгүй нярвааны замд хөтөлж
 Арга мэргэнээр алдар нь бадарч
 Аз хувьтайгаар алгасарлыг үл тоож
 Авах гээхийн эрдэм бүлгийг эцэслэж
 Авшиг лүнг шавь нартаа ёсчилон хайрлаж
 Агшин бүрийг алдалгүй зохион туурвих
 Арвин намтрын мөчир лугаа хорин зургаа
 Өөрөө бичсэн 26 бүлэг болой
 1680 он буюу хатуу хэмээх төмөр мичин
 Жилээс намтарын хэлхээг гэгээн
 Эндээс эхлэн гүйцэг оюунаар төгс бичмой

Хоёр дээдсийн зохиолын тусгалаас шавийн манлай эрхэм тоён бээр өөрийн намтарыг монгол хэл дээр орчуулаж өгөхийг хүссэнд багшийн зарлигчлан тунамал унзад бээр намтарын бүдүүн тойм нэгийг дээдэс үзүүлэн намтарын бичээс нугуудаас хураангуйлан намтарын найлзуур модон хэмээхүйд мөчир нэмэн байгуулахуй дор 1681 он буюу муу оюун хэмээх төмөр эм тахиа жилээс 1685 он буюу уурт хэмээх модон эм үхэр жил хүртэл таван жилийн хугацаанд гэгээнтэний лагшин зарлиг тагаалалын зэрэг зүйл намтар тэргүүт тодорхой бус тул тэгш дор агуулан орхив. 1686 он буюу тасархай хэмээхүй гал эр бар жилд гандан тива 44-р Агваанлодойжамцбалсансамбуу бээр халх, ойродийн тэмцэлийг таслахын тухайд Түвдээс заларч хүрэн бэлчирт цуглаан чуулахын үед дээрхийн алтан зарлигтан харон лома ачит цорж, арни алихамба тэргүүт их бага ноёд олноор цугларсан байв. Тэр үед гэгээн хайдүвдамба жанжа хутагтын өмнөөс цэвагмид 9-н тэнгэрийн хот мандалын авшиг лүн тэргүүт дээдийн номын олон хүртэв. 1687он буюу машид гарсан хэмээх шороон эм туулай жилээс тийн гарахуй хэмээх луу жил халх ойрадын хоорондын тэмцэл гарч хийддээ өдөр бүр ном уншин залбирч бурууд орших дайсан болсон хоёр талын үл эвлэрэхийн харанхуйг авралдаа барин галдангаас зугтаасан нугуудын, үзэх, сонсох, санах мэдрэмж төдийгөөр хорт сэтгэл бүхэн үндэслэн тогтсоны үзүүрээс нарны гэрэл эгшинд тусган амирлуулах аврал бодон эртийн ерөөлөөр бүтсэн орны огторгуйг тамгалагч хаан язгуурын удам дамжсан тодо хунтайж дээдэс сэлт ноёд бүгд сайнаар угтан

улиран золгож гэм буруу байхгүй хэмээн наашаа залрахтун гэж номын айлтгал өргөн хүндлэл үзүүлэв. Тэгээд Жамъяан дээдэс хаан үйл ерөөлийн урьдын барилдага багчигаар учирлаа хэмээн морилох замд мэргэн жонон, хатанбаатар тэргүүт өглөгийн эздэд зарлиг ном олныг айлдаж ар араасаа ирэх хуврага бүгд амгалан байхын тухайд бүхнийг айлдагч содномжамц далай ламын зохиосон юулчог бүхэнд хүртээв. Шашин төрийг хослон баригч цог төгөлдөр харон буюу хөх тэнгэр хэмээгч хятад түвд монгол тэргүүтэн улс гүрэнд алдартай тэр орны номын хэргийг баригч ачит цоржийн заллагаар түүний хийдэд залрав. Алсаас харагдах баланд дурлах зөгий 6-н хөлтэйч суух аргагүй дурлан дүнгэнэн эргэлддэг шиг сайтар номлолын гүүсан хаана байна тэнд хувь төгөлдөр нярваан хүсэгчид хуран цуглаж ахуй үес алс ирээдүйн төлөө асар сүжгийн гохоор дэгээддэг шиг авшиг лүн олныг хүртээж, олон хүнийг сахил авахуулж хуврага болгож багшийн зарлигийг зуны хурчилан арвидуулав.

Өгүүлрүүн: Завсрын чимэг үгс:

Хоёр чуулганы цогоос аяндаа бүтсэн лагшинт

Хосгүй сүүт шидийг гаргагч зэндмэн

Хямах цагийн салхинд хөдлөл үгүй баригч

Хамаг хүмүүний тус амгалан баригч танаас өөр хэн

Манзуширийн хувилгаад шашин төр барьж

Манай шашиныг хятадууд дээдлэн залж угтсан

Маргаан тэмцэлд намтарын мөчир лугаа 27

1689 он буюу цагаан хэмээх шороон эм могой жил, машид галзуу хэмээх төмөр эр морь жил хоёр намтар тасраад төрөл эзэн хэмээх (1691) төмөр эм хонь жил манай ноёд дээдэс манзушир дээдэстэй уулзаж хоорондоо тохиролцоонд хүрэлгүй хар он буюу хөх тэнгэр тэмцэлдэж эхэлсэнд дахин өндөр гэгээнээр тэргүүлсэн ноёд хар он буюу хөх тэнгэрт бараалхан (1691) төмөр эм хонин жилийн сүүлээр тэндэхийн шинэ сүм дуганд аравнай өргөж гурван суурь шүтээн залж гэгээнтэй хамт “тайхү” хаанд эв эер айлтган дээрх хурцадмал байдлыг намжаав. Тэрхүү хийдийн цогчин хуралд хоёр гэвш дээдэс уруу өчүүхэн үг өдөж муу ус сойдог ган шиг байсанд гэгээн босож тэр гэвш нартай ном хаялцаж амыг нь таглан алга хавсрах дуу нь сайн номлолын шимээр арслангийн архираа мэтээс айсан үнэг мэт болгосонд хурсан түмэн магтаалын үг хэлж дээдэс баярлажээ. Тэгээд буцан залрахдаа хар он буюу

хөх тэнгэрийн байдаг газар очин ачит цоржийн шашин амьтаны тусд байгуулсан Дашибалбар дуганд (1692 он) ангир хэмээх усан эр мичин жилийн сүүлээр хийдийн сэнтийд залан цорж голлон лам нарт судар тарнийн олон ном айлдав. Хоёрдугаар бурханы шашинг дэлгэн зохиов. (1693 он)цогт хоншоор хэмээх усан тахиа жилийн чойнпэрэл ерөөлийн үед төр баригч засаг ачит цорж, баруун түмэд, зүүн түмэдийн эзэн ноён хоёр өглөгийн эзэн болж зуугийн синтийд залж ерөөл айлтгаж өргөлж хүндлэв. Бүхний сүжиг бишрэл ихээр төрж сүсэгтэн арвижав. Тэр жилийн намар гандан тива жалбийн жалцав дээдэс 24 ширээт жамбажамцын айлдсанчилан монгол нутагт мэндэлж гандан шашин их дэлгэрүүлэв. Шавь нар цуглан монгол нутагт содномбээлийн хөвгүүн болон өөрийн эрхээр төрсөн хувилгааныг оройдоо залж равжүнгийн сахил хүртээж авшиглүнжинан тид зэргийг арвин ихээр хүртээвээ.

1694 он буюу бодьгал хэмээх модон эр нохой жил чойнпэрэлийн сараар тоён хутагт бага зуугын дуганд залж, ямандаг, цэвэгмид 9 тэнгэрийн авшиг жинан лүн тэргүүт дээдийн ном олныг айлдав. Тэр үед үйзангийн зүгээс хариу бичиг: хадаг алт мөнгө авч хоёр зуу, хоёр дээдэс, дашилүнбэ, синбэрээ гэсүм, их бага хийдүүдэд дээдэс багш нарт өргөж манз барьж зэд өргөв гэж бичсэн захидал ирсэнд гэгээн баясав. Наг сард хүмүүсийн хүслээр ном хэсэг айлдав. Ялангуяа ловон ноён цоржийн гүжи лувсанванжил тэргүүтэнд жинан тид лүн хайрлав. Зуны эхэн сарын нэгнээс чагдүгийн гачин, зүсүмбийн жинан бүрэн, гомбын вибам гарнагийн лүн тэргүүтийг хүртээв. Тэгээд хатанбаатар залран бараалхаж Ванчин далай богдын сүмбүмийг бүхэлд нь лүнгий нь авч хүсэл цэнгэлтэйгээр буцав.

Өгүүлрүүн: Завсрын чимэг үгс:

Сайн хувьт зөгийн буудагсан сайтар номлол
 Салаалан дэлбээлэх навчит модны шим балын үүр
 Санаандаа амьтан бүгдийг өдөр бүр хучиж
 Сүжигийн хүчээр давалгаа эргэн татах шиг
 Таны эрдэмийг өгүүлэх мянган дуун
 Миний нарийн хоолойгоор яаж багтаж гархав
 Хэрэгтэй эрдэм бүгдээр яруухан бүжин
 Хэн хүнийг ялгалгүй таалалаас үл гаргаж
 Сонин гайхамшигт иш онол лүнгээр

Сав ертөнцийн эрдэмийг нээж хоригийг хааж
Сандран тэвдэх галтгүү аюул бүгдээс
Санаачилан зайлуулах намтарын мөчир лугаа 28

Дээдсийн зарлигчилан нямбанд бараалхах замд гэгээн дагуул нарыг өөрийн залрах дацан хийдэд заллага айлтган өргөл хүндлэл үзүүлэв, дүвтавжамцын жинан 144 цөмийг дуусган ондогжангийн лүн маналын лам налжор тус амгалангийн рашааны цацал саран шил хэмээн алдаршсан Ванчин богдын зохиосон маналын дочог нямтангийн зохиосон нууц дамжлага лүн сайтар хүртээж, цоржийн дуган дашибалбарт мэргэн жононван урилгаар гүшо бээр орчуулан 16 архадын тухай, манла, жанрайсиг, цагаан дархийн жинан тавьж, мэргэн жанванцангийн багш ноён хутагт норжин биеийн эрхшээн бурхан болсонд тэнд залагдаж жинан ван тэргүүт их бага ном лүгсүнгийн сургааль мөнх бусын сургааль айлдаж хойтийн ерөөл талбив. Шинээр босгосон суурь 3-н шүтээнд равнай өргөж жинсрэг цутгав. Барчид арилгах жинан хэсгийг ван болон хатан хоёрт хүртээн бат оршил уншив. Тэгээд өглөгийн эзэд баяраар үдэв. Бошигт ван, Хатанбаатар хоёр олон янзын элч илгээж урин залж баяртай уулзан ван лүн авшигийг хүссэн бүгдийг хүртээж баясгав. Цэваандорж, Данзанэрдэнэ нар урин тийшээ очиж ном хэсгийг хүртээж номын хурим болов. Дахин мэргэн жонон вангийн лагшин чилээрхэж залагдан эм найруулан өгч гүрэм хийв. Удалгүй бие тэнхэрч түргэн эдгэрэв. Бүгд баясан бишрэв. Гэгээн өөрийн өргөөндөө морилов. Ард олон номын авшиг авч баяртай болов. Тэр жилийн намар, живзүндамбийн өргөө долнуурт байхын үед бараалхаж цэвагмид, долгорын жинан хүртэж хуралд манж өргөж, зэд барин өглөгийн эзэн болж гэртээ морилов. Тэр даруйдаа дээдсийн цам гардаг ордонд очоод 1695 он цондон хэмээх модон гахай жил их ордонд цагаан сарлаад тэр ордонг түвд номын дуган гэж нэрлэв. Хайдүвдамба жанжа хутагтын өмнө лхачог, чагдор цагаан цэвэл, намсрайн гачой 15-н жинанг гүйцэт хүртэв. Дээдэс өргөл хүндлэл ихээр үзүүлэв. Буцан залрахын замд хувилгаан егүзорийн гэрт морилов. Егүзор өөрийн хүү Нямаа нар өөрийн лам нарын тоонд багтааж Цэвагмидийн жинан, хайвийн чог бавуугийн зохиосон лама авжүгийн лүн өгөөд өөрийн өргөөндөө ирэв. Дашивангийн элч явуулж урин залж өргөн хүлээн авав. Суурь шүтээнд гэлэгжамц равнай өргөх үед үүлгүй тэнгэрт солонго татаж буйд ирсэн хүмүүс харж гэгээнтний

ид хэмээн бахархахад багш нартаа залбирсны хүч хэмээн шар үсний нүх маан хүртэл хөдөлж ихээр сэтгэл хөдлөв. Цэнгэсэн түмэнд мижид доржийн их авшиг хүртээж цэвэгмид 9н тэнгэрт лүн, жанрайсигийн ван айлдав. Хүмүүс сүжиг орж бодь мөрийн ногоо монгол газар ургаж эхлэв. Тэр үед гагцаар одох гөрөөс адил их авшиг хүртэж хүмүүс цамын бүжиг үзүүлэхээр залж очиж үзэв. Ван жамба, даши гүн 2 уулзаж олон ном сонсож манай тийш залрах тун хэмээн хүсэж би тийш хөдлөв. Зам зуур харчин нутгийн хүмүүс мөргөн сүсэглэж гүнгийн өргөөнд хүрэхэд сүсэгтэн олон зуны бороо шиг олноор цугласан байв.

Суурь шүтээнд равнай өргөх тэр үед тэнгэрт солонго татаж бүгд хөх тэнгэрт сүслэж мөргөж тойрч гороолож байв. Багш бурхадын илт харж буй адил хувь сайтан хэмээн ерөөл молон тавилаа. Тэнд жигжид вавужигийн авшиг лүн тэргүүт хүссэн номын лүн хайрлаж тэд ихээр сүслэн уулыг тал болтол мөргөцгөөж байлаа. Буцаж залрахдаа харчингийн ноёд тус тусын дуганд гэгээнтнийг залж, тэр бүр номын хур буулгаж ерөөл талбисаар даши вангийн өргөөнд морилов. Түүний айлдсан дагуу номын лүн ван өгч ерөөл тавиад буцан өөрийн хийддээ морилов. Хар шар түмэн олон бурханы шашинд оров.

Өгүүлрүүн: Завсрын чимэг үгс:

Удаан хураасан хоёр чуулган эрдмийн далайгаас
Уламжлан мэндэлсэн лагшингаар бүгдийг эрхшээж
Мэргэд олны үзүүрт түмнээр хүрээлсэний төвд
Машид дээдийн номоор цэнгэлийн далайд давалж
Сайн хувьтаны чихний чимэг баясал дүүргэгч
Санах анхаарахын яруу дуун тасралтгүй
Сагсайн ургах найлзуур модны мөчир
Сайтар үзэсгэлэнт намтарын салаа бүлэг 29

1696 он буюу баригч хэмээх гал эр хулгана жил өөрийн дацанд шинэлэж номын хурим хийв. Наг сарын шинийн 6-наас эхлээд сургааль нүйнансалдам, нямба хийх лаглин, нанжиднорву, Зонхова богдийн зохиосон лама авжүба, Наробийн 6н ном, гэлонгийн чиржа, гэнэн сахилын чоги, Балдан ишээ богдын зохиосон ложин, өөрийн зохиосон ламан чодбийн лүн, тид тэргүүт увидас хайрлав. Хаврын адаг сарын 18-нд дээдсийн ордонд залрах замд сартуул сэцэн вангийн бандида номын хааны лагшин чилээрхэж залагдав. Эм болон гүрэм жинан тавьж түүний

лагшин түргэн эдгэрэв. Ордонд заларч дээдсийн цамийг айлтган бүтээгээд өглөг өргөн даган баясаад буцаж мориллов. 4-р сарын 11-нээс эхлэн жалсрай тогмидийн габуумаас лажүдийн магтаал 11 нигүүрт жанрайсигийн бүтээх арга, өдөр шөнө мөргөх ёс, сан тэргүүтний лүн, Гү шири тоён ёгүзэр ламын чүжигор рэтод дэм зэргийг сайтар хүртээж, 12-нд Тоёнгийн гүжэ бишрэлт тэргүүт 7н лам нарт 11 нигүүртийн ван өргөв. Тэгээд нүнай сахиж 20-н хүртэл байгаад 22д зуны гүрэм, 24-ээс ловон цорж, эцэг шавь 25 дор дэмчиг 5н тэнгэрийн авшиг гүйцэт хайрлав. Тэр үед Далай Манзушир хутагт өөрийн бие болон эд адгуурс хуврага лам нарыг хурал хуруулж бодийн сэтгэлийн уг дор зориулан өргөв. Яах тухай заавар зөвлөгөөг гэгээнтэн өгөв. 1696 он хулгана жилийн зун Дэмчиг дацанг шинээр барив. Түүний дээр гүнрэг дацанг нээж урдын 3н дацан 5 болон өргөжив. 25-нд ерөөл хурж маргаашнаас нь долмийн юүлдог үүлдээд, 27-ноос Жалбанренбуучийн түнрэв солдэв мажунгалвама, Ванчинлуvsсанчойжижанцанжгийн дэмчиг 5-н тэнгэртийн бүтээл, Намжомийн жавтүй, мандочүн, жанчивсимбийн чиржа, хорин сахил, язгуурын унал 14-г боох, лама ажүгээс задүн 14, Вомбожад, зэрэг санваар сахихийн хураангуй, тамжидчинбийн лүдор бага, павон хайвийн дүлбаанаас лайчогийн лүн, зэргийг айлтгав. Тэр сарынхаа битүүний өдөр дүлзэндагважанцангийн зохиосон лаваа ёнзон, суурийн 3-н чоги, соторлавжа зэрэг дээдийн номын гарын авлага заав. Халх өөрийн нутгаас зугтсан үед бошигт ван эрх ахай нар өглөгийн эзэн болж номын заллага айлтгав. Цугласан хар шар түмэнд номын хурыг буулгаж баясал дүүрэн буцав. Мэргэн вангийн өргөөнд залагдаж байх үед манзушир дээдэсийн цэрэг Бошигтийн цэргийг хөөж, дээдэс гэгээнтнийг өргөөндөө дуудсанд бараалхаж эв аяыг нь олж зохицуулан танилцуулж тохируулав. Мэргэн вангийн өргөөнд очиж сэтгэл амрав. Ван болон хар шар түмэнд номын хур буулгасаар тэд дээдийн ном дор сүсэглэсээр буцаж мориллов. Заллага урьд айлтгасан бошигт, хатанбаатар тэргүүт өглөгийн эзэд таньдаг хүнээр чихэнд сэмхэн заллага айлтгасанд шашин амьтаны тусыг бодон тэдэнд хүссэн номыг айлдан өгч өөрийнхөө дацанд буцав. Тэгээд дээдэс хаан ханон буюу хөх тэнгэрийн морилох замд тосон бараалхаж өөрийн номын ажлаар бошигттой холбоотойг эв эээр зохицуулан танилцуулахад хаан бээр би танд өөрөө хаач очиж ном айлдах зөвшөөрөл олголоо хэмээн зарлигдав. Гэгээнтэнийг

өргөөндөө заларч байхад Ванчин дээдэс мутрын бичиг болгоож танд өдөр бүр сүсэглэдгээ уулзахын билиг дэмбэрэл болгож бурханы хөрөг тэр дунд цагаан дарь эхийн хөрөг маш цэвэрхэн нэгийг өргөж, таны надад өдөр бүр өгдөг байсан шинэ тараг их ач санагдаж байна гэж бичээд илгээв. Гэгээнтэн хаантай уулзахдаа бат оршил өргөхийн тухайд дуган сүм босгох чухалыг айлдахад тэгье миний орлогч лувсандаржаа засагт даалгалаа хэмээн машид баярлангуй байлаа. Эзэн ордосоор дайран морилохдоо гэгээн та миний зөвлөхөөр ажиллахыг санал болгов.

Учрыг сонсвол унзад намайг номтой мэргэн гэдгийг магтсан бололтой. Хааны зарлигаар өдөр болгон шавдан гүрэм айлдаж байв. Нэгэн өдөр унзад часүм уншихын үед хонх цохиж чогжаа хийхийг хаан бээр хараад бишрэнгүй бахархаж байлаа.

Тэндээ хэдэн хоног сууж байгаад буцаж өргөөндөө морилож хуучин номын горим яндан, хэнгэрэг чагжа, бүжиг, дун үлээх, матар болон булуу ганлин үлээх зэргийг заан давтуулж шашины ажлыг доройтуулалгүй сэргээн зохиож, Ванган чагжаадон, санжид моллом зэргийн лоржү бясалгал, жанрайсигийн авшиг 4 мутарын бүтээл, одбагмидийн анхааран авахуй авлага, орчлонг амирлуулж, энэрэлийг арилгах, Ванчин богдын дорж хандын жинсрэг, гэгээний өөрийн зохиосон зонховатай ялгалгүй жанрайсигийн бүтээл тэргүүтний лүн, бүгд цэнгэлийн манлайг олов.

Өгүүлрүүн: Завсрын чимэг үгс

Энэрэл мэдэлийн хүч жор нь бүрдэж дэлгэн

Эгэл огторгуйн байдал бүгдийг эрхшээж

Үйлийн галавт хүсэл таалахуйг хааж

Үелзэн давлах эрдмийн цагаан үйлс

Үнэнч шавийн ундаалах рашаанаар чийглэн

Сүжигийн оронд буяны цэцэг дэлгэрч

Сүсэггүйн шаварт ялаа батгана эргэнэ

Муу цагийн талыг тэвчил хоригоор гаталж

Молом ерөөлийн үнэрийг хүчтэй уугуулж татан

Сайн номлолын рашаанаар чийглэн ургах

Саглагар намтарын модны мөчир лугаа 30

1697 он буюу Ванчиг хэмээх гал эр үхэр жил чойнпэрэлийн сарын ерөөлөөр ачит чойржийн дуган дашибалбард заларч хавар хүзэ хэмээх газар хийд байгуулж тэнд заларч буй үед

харон буюу хөх тэнгэр нийж тойн хутагтыг залан шүтээнд равнай өргөж гэгээнтэн гачо олон тавьж номын хүр буулгав. Дараа нь дахин өргөө хүрээ цацарт залрав. Хавар нь лхан дуган барих гэж догчийнтэг татаж, газрыг аргадав дээрхийн зан үйлийг аграмчинмуугаас зарлигласанчилан бүгдийг ном дагуу газар болон газрын савдагийн дагон хийж засах арга бүгдийг лам нартай хамтран хийв. Тэгээд дүлзэндагва жанцонгийн гүнрэгийн чого зан үйлийн лүн, 5-р далай ламын ерөөл мончогийг, түшээт дорж хаан айлтган лүн хүртэж, бат оршилийн лүн, Ванчинлуvsанчойжийжанцанийн зохиосон намжамын чого тус амгалан гарах орон хэмээх дархийн юүлдог, лхамын дорбул, Гэндэнжамцын Жамъяангаравын бүтээл, равнай даши ням, жавши, хутагт дээд 4 мутарын бүтээл лүн, 10 Зохионгуйн магтаал, тавхай, түгжима, чогуүмүнсэл, пиважураг, Жоржайсүн, Дүдцарзодби аг, адишаагийн зохиосон бодь мөрийн зул, гэгээн өөрийн зохиосон солдэв, бат оршил, ерөөл зэргийн лүн, 11 нигүүрт, цагаан шүхэрт хоёр мутартын жинан айлдав. 3-сарын 6-наас эхлээд хааны тушаасан ноён хутагт хэмээн дууддагын аав, Ловон болсон дүзэн авгай гэлон, дацан лаовон, гол номлол баригч Равжамба цорж зурхайн ухааны мэргэн судлаач ловон тунамал эрдэнэ, жихан дацангийн лам эрдэнэ, Гүшири тоён, тунамал унзад, эрхэн зураач хувилгаан, ёгүзор лам зэрэг олон хуврагуудад тамжидчинбасодномжамцийн зохиосон ламрим сирж яншүнгийн тайлбар лүн, шинийн 8-нд шинэн дэнцүлийн тайлбар номлож байх үед нь харчин даши ван ирж гүрэм айлтгаад шинийн 9-нөөс дорчин хийж 10-нд дууссаны өргөл хүндлэл үзүүлэв. Дүнта цагаан шүхэрт, очирвааний жинан айлдахад гэгээн номын хурим 11-нд зохиож ирсэн дашиван нөхөр сэлт баяр хөөртэй буцав. Ламримгийн тайлбар номлож байгаад 18-нд урьдын тэг татсан лханд очиж үзэж ирээд нижүд солдэв болон өөрийн зохиосон сүмбэмд ороогүй зарим номын лүн өргөв. 27-нд Манзу дээдсийн алтан гэрэгт Жанжа хутагт түвдэд морилов. Хар он хөх тэнгэрийн өргөө цацарт бараалхаж шинэ баригдах хийдийн сууринд ерөөл даши айлдав. Найр дэлгэрэнгүй зохиож лам харгүй гомбу 6н мутарт, цэвагмидийн жинан айлдаж бүгд баяртай буцав. Илүү сарын шинийн 10-нд ламтид гүйцэт айлдаж 25-нд цахар даянчийн гүжи, ноён хутагт, Данзан хутагт зэрэг гэлон гэцүл 100 гаруй лам нарт жажид цагаан шүхэртийн 17 нөхөртийн гаван, лигдан

чидсүмжийн жинан тавьж бүхэн баяраар цэнгэв. Нинжа хэмээх өргөөнөөсөө манзу хаан залрах үед гэгээн бараалхахад хаан бээр өндөр гэгээн та хоёр түвд номыг эмхлэж монгол хэл рүү орчуул гэж зарлиг буулгав. Гэгээнтэн жанчхүүгээс хаалган хүртэл хаанд бараа болж явав. Буцаж ирэхэд живзүндамба хутагтад бат оршил өргөж буйг билигшээв. Эфү цэрэн, момогэцүлма, хонгор эрх тайж тэргүүтэнд жинан лүн айлдаж гүйцээд даагын булагт мориллов. Сартуул цэцэн ван номон хаан, лам хуврагын хамт луун хөлөгт замбалгарав түүний таван хор (нөхөртэй) жинанг дэлгэр хүртэв.

Буцахдаа засаг Түхангийн өргөөнд залагдаж өнгөрсөн хатны хойтийн буянд ерөөл ном уншиж сэтгэлийг нь засав. Тэгээд өөрийн өргөөнд морилон сүсэгтэн олондоо хандаж эдийн тэнгэр замбалгаравын жинан айлдаж ард олон баярлаж гэгээнтэнд бат оршил дэлгэр өргөв. Тэр үеээр Хатанбаатар, сэцэнхунтайж нар морилон ирж бурхан багш, ямандагийн их авшиг хүртэв. Тэд буцаж морилон нянбанд суухын тухайд авшиг авсан учир ордондоо нянба бүтээлдээ оров. Өндөр гэгээнд заяын гэгээн бараалхав.

Өгүүлрүүн: Завсрын чимэг үгс:

Итгэлт таны таалал тэсвэрийн уужимд

Их сэтгэлийн маш цагаан дээдийн номын хур бууж

Хувь төгөлдөр шавийн сүсгийн оронд мөнхөрч

Хаттай сэтгэлийн үрээр ерөөлийн цэцэг дэлгэж

Дэлгэрсэн шашин цэцгээс дэлбээлж эрдэнэ түгнэ

Дэргэдэх сүжиггүй хожүүлд хорхой бүхэн дайсагнана

Гэвч дээдсийн явдал өчүүхнээр гэмийг дарж

Гоц сайхан үнэр хүн бүхэнд дамжуулагч

Гол намтраас салаалан мөчир лүгээ 31.

1698 он буюу үр тариа хэмээх шороон эр бар жилийн цагаан сараар хаад дээдэстэй хамт их ордонд тэмдэглэж өнгөрүүлэв. Буцаж морилох замд лагшин чилээрхэж өөрийн өргөөнд заларч гүрэм, эм тан зооглож лагшин тунгалаг болов. Тэр үед санег салбийн мялан буюу нууцын билиг тодорхой толь хэмээх бүтээлээ хэнч гүллэж бичих тухай айлтгаагүй байхад өөрөө туурвиж эхлэн өдрөөс өдөрт нэмэн бичсээр байв. 3-р сарын 16-нд тамжид чинба Гэндэнжамцын зохиосон янжинлахмын бүтээлийн аман гэгээний лүн хүртээж ном айлдав. Лагшин чилээрхэж буй шалтгаанаар зун нь шар мөрөн хэмээх газарт заларч нууцын бичиг сангаа

ихэнхийг дуусгав. Намрын эхэн сарын 28-ны өдөр гэгээн өөрийн зохиосон сүмбүмээс санчу даши гарвивийн бат оршилийн нэг хоёр шадын лүн тайлбартай нь айлдав. Өвөлжингөө өөрийн лам нарт сургааль айлдав, ном чого чаглин, ая дан бүрээ бишгүүр үлээх, жаяг журам тогтоон хичээл хөтлөв. Монголын 11-р сарын шинийн 3-нд бүх лам харчуул цуглан гэгээнтэнд бат оршил өргөв. Шинийн 4-нд Тунамал эрдэнэ ламаас Пагорширавсалжидийн жинан бүтээлийн лүн өгөхийг айлтгахад гаржаам буюу нууцлаж зөвхөн 4-н хүнд хүртээв. Шинийн 5-нд Ванчин богдод Лувсанишийн зохиосон жалбан буюу Далай багшийн солдэв, Залуу ванчин Далай богдын зарим зохиол пагму марбуун бүтээл, аавд даншиг өргөх ёс, ерөөл зэргийн лүн айлдсанд хар шар түмэн олон баяр хөөртэйгээр даган баясаж, номын өглөг хэмээн хүлээн авч эд эдлэл, амьдралаа цаашид сайн байхын тухайд үргэлжид гүрэм ном, сайн явдалд, ном лугаа зохицох, үйлд лугаа шудрага байх хэрэгтэй болон хуучин номоо хуруулах, цагаан сараар чойнпэрэл ерөөлд даган баясах мөн дөрвөн тив гарагийн талаар тайлбар айлдсанд сүсэгтэн олон машид баярлав.

Өгүүлрүүн: Завсрын чимэг үгс:

Цэвүүн цагийн жаварт дарагдан мунхарч

Цаглашгүй буян номын үнэр ч байхгүй

Цангасан түмэнд номын хур буулгасан

Цадиг намтрын мөчир лугаа 32

1699 он буюу согтуу төгөлдөр хэмээх эм туулай жил өөрийн лам нартайгаа цагаан сар гаргаад хаан зарлиглан өргөөнд нь заларч цагаан сарын уламжлалт цам гарах ёслолд оролцон шинэ дуган нээх ёслолд оролцон ганжуур бүтээн залалцаж шинэ дуганы нэр өг хэмээсэнд содномжодлхан буюу буяны их сан хэмээн нэр өгөв. Тэр үеээр ном тавиулахаар айлтгасан сүсэгтэй Пагмо, болон өөрийн зохиосон амирлангүй болон хилинт Манзуширийн бүтээлийн лүн жинан өгөөд буцаж морилохдоо даагын булагт заларч номын хаан, сэцэн ван хоёрын өргөөнд залагдаж зарим нэг ном айлдав. Мэргэн бандида вангийн лагшин чилээрхэж заллага айлтгаж чадахгүй байгааг сонсоод өглөгийн эзнийг хүндлэн урилгагүйд зочилж эм гүрэмийн засал хийж удалгүй эдгэрэв. Ноён хутагт ван хоёрын шинээр бүтээсэн суурь гурван шүтээнд равнай өргөж, мэргэн ван тэргүүтэй хэсэг хүмүүсэд зүгдэрнамжилийн их авшиг, Даши ноён хатан Балму нарт 21 дархийн жинан гүйцэт,

гэндүн хуврага нарт доржжигжэдийн, 11 нигүүртийн авшиг зэргийг тус тусд айлдав. Мөн вангийн хүү Равдандоржийн бие муудаж гүрэм хийж эм өгөн, дой дорийн жинан хүртээж өвчин түргэн арилсанд баяр хөөр болон найр хийцгээв. Урьд нь заллага айлтгасан бошигт ван хатанбаатар, илдэнгүн, уваши засаг нарын зарлигаар заларч номын авшиг айлдан бүгд баясалаар гийв. Өргөл хүндлэл үүлдэж ерөөл ихээр тавив. Гэгээн жамбаадайчиван, хамба номын хаантай золгож харилцан ярилцаж дотносов. Өргөл хүндлэл ихээр үйлдэв. Хатанбаатарын өргөөнд морилж түмэн олонд адис хайрлаж бурхан багш, цагаан шүхэрт, сандуй, 21 дархи зэргийн ван лүн айлдаж хоёр талаасаа төрөл тутамдаа хагацалгүй хамт төрөхийн ерөөл өргөв. Дахин хамба эрдэнэ номын хааны хийдэд морилж урьдын барилдлагаар ном сонсож буй хэмээн энэ жил ирж өөрийн сүмбүмийн лүн авшиг хайрлахыг дахин дахин айлтгаж хоор хоорондоо бат оршил өргөв.

Өгүүлрүүн: Завсрын чимэг үгс:

Дээдсээр магтагдсан мэргэний намтар
 Амтат балаас урган гарах цэцэг
 Дэлгэрэх үйлст багшийн мянган гэрлээр
 Алаг зөгийн хувь хишгээр арвидах номын хурим
 Дорд заяат одохын аглагийн нээгч гэлэн
 Амсаж мэдрэлгүй муу идээ хайгчид нугууд
 Дээд үгүй энэрэлийн гохь дэгээгээр
 Аварч татаж загасчилах дээдийн явдалаар
 Дэндүү гайхамшиг цагаан үйлийн үргэлжлэл
 Амьтан бүгдийг хоцроолгүй дагуулах
 Даамай олон эрдмийг төгс өгүүлэх бэрхтэй
 Арвин их намтрын модны мөчир лугаа 33

1700 он буюу Баатар ч гэдэг тийн дарагч гэдэг төмөр луу жил цагаалаад хөдлөх гэж байтал дайчин ван мэргэн ван гэх өглөгийн эзэд ирж бүх лам нарыг урин залж гэгээнээр ном тавиулан сүсэгтэн олонд болон шавь нарт өглөгийг дэлгэрэнгүй түгээв. Тэгээд хурал дуусмагц гэгээнтэн өргөөндөө дагж морилоод хааны цамд морилж өндөр гэгээнтэй хаантай хамт олон дагуул нартай Чанчүнён хэмээх цэцэрлэгт залрав. Тэнд янз бүрийн мод, цэцэг, цөөрөм, ус олон шувууд цуглаж дуу гаргасан, элдэв үзмэртэй жаргалын цэцэрлэгийг балжоргүндан голлон тайлбарлав. Хараал муу үг ч хэлмээргүй, өглүүлж тайлбарлаж чадамгүй олныг үзэж

тэдгээрийн сэтгэл баясав.Харчин Дашивангийн бие чилээрхэн заллага айлтгасан ч гэгээн зав ховор заларч амжихгүй гэв. Гэтэл эфү Галсан дахин дахин шургуу заллага айлдсанаар мориллов ван голлосон сүсэгтэн нарт ном айлдаж ванд гүрэм хийж эм өгсөнд өвчин түргэн илааршив. Ван ихээр баярлаж найр хийв. Гэгээн ван голлосон сүсэгтэн олонд лха таван тэнгэрийн авшиг хайрлаж зарим нэгэн уваши сахил равжүнгийн сахил тус бүр 10аад хүн хүртэж бурхан шашин нарны гэрэл адил түгэв. Лохой дуганд залагдаж суурь шүтээнд равнай өргөж цугласан хуврагуудад санвандүйвийн ван гүйцэт хүртээв.Жамбаа, Даш гүнгийн заллагт морилох замдаа ноёд тус бүрийнд залагдаж шүтээнд равнай өргөж олонд жанрайсигийн ван, айлтгасан номын тайлбар өгөв. Гүнгийнд заларч жигжид важигийн болон дэмчиг таван тэнгэрийн авшиг хүртээж зарим номын тайлбар сургааль хийж хамтдаа ерөөл тавив. Ахин даш вангийн морилож цагаан шүхэртийн ван тэргүүт ном айлдаж бүгд ихээр сүсэглэв.Цам болгоохоор өвөл хааны өргөө явах зүгт номон хааныд залагдаж жинан айлдаж мөнх бусыг үзүүлсэн сэцэн вангийн хойдийн буянд овоо ерөөл лүгсүнгийн сургааль хайрлаж сэтгэл засаж цааш их ордонд мориллов. Дээдэс хаантай цам найр соёрхож дуусаад 10-р сарын 12-наас эхлэн 24-ныг хүртэл хайдүвдамба Жанжаа хутагтаас дүвчинжадзү жинан гүйцэт хүртэв. Завсараар нь тунамал унзад егүзорийн Гүжи тэргүүнд дүццаржибийн аг, сүнжиндэн, а, өндөр гэгээний сагжан, янлаг дүнба, тогмидийн зохиосон жалсрай лаглин 37, гэгээнтний зохиосон солдив, зэргийн лүнг хүртээв. Буцаж морилох замдаа номон хаан, сэцэн вангийн хатан нарын зарлигаар өргөөнд нь заларч мутрын адис хайрлаж, ном айлдаад, цааш өөрийн хийдэд морилж лам нартаа өөрийн бэлгээс түгээж лүгсонгийн сургааль зэрэг номын тайлбар айлдав. Тэр үед гэгээнтний аав гэлон бие нь муудаж засал гүрэм хийсэн боловч номын биеийг эрхшээж, бурхан болов. Өндөр гэгээн, хамба номын хаан тэргүүтэнд хойтийн буяныг айлтгаж, цогчинд манз барьж зэд өргөж буян хийв. Жанжа хутагтад ерөөл айлтгуулж манз зэд өргүүлэв. Хар он хаан 6 дацанд манз зэд өргөв.Сүр тавьж, жинсрэг өргөхийг гэгээн надад даалгав.1700 он төмөр луу жилийн өвлийн адаг сарын шинийн 6-нд жинсрэг гал мандал өргөж огторгуйд үүл солонго хүрээлж цэцэгс мэт харагдан байхыг хүмүүс үзэн баясав. Гал тэнгэрийн 12 зайг өргөж дуусмагц бэлэг

дэмбэрэл сайныг үзүүллээ хэмээн гэгээнтэний сэтгэл уужрав.
Өгүүлрүүн: Завсрын чимэг үгс:

Чуулган хоёр суртгаал гурвын нийлэмжээр мэндэлж
Чимэг гоёлоор давхарлах мөнхийн төгөлдөр лагшин
Чанх өөдөөс харах хүмүүсэд нялхын дүртэйг
Худал хуурмаг юуг ч шүтсэн номхотгож чадах
Хилинцээр нэрвэгдсэн амьтан бүхнийг
Хэцүү ч элдэв аргаар, татах замын үзүүрт очсон
Хосгүй дээдэс эгэлийн ёсонд ээж ааваас мэндэлсэн ч
Хорвоогийн алгасаралд хөдөлгөөн үгүй
Хөвүүн болон шашин амьтанд тусалсан
Хөрөнгө арвин намтарын мөчир лугаа 34

1701 он чимчог хэмэх төмөр эм могой жил лам нартайгаа хамт цагаалаад гэгээнтэнд бат оршил даншиг өргөв. Аавын хойтын буянд зориулаж гэнэн гэчүл, гэлэн санваарыг 10 хүнд хүргэв. Хаврын дунд сарын 13-наас лам нартаа жалбаан 5-р регсүнгомбын, зонховын солдэв, ламанчодвийн чого, гончигжанцангийн дэмчиг таван тэнгэрт, Ванчинлуvsанчойжижанцангийн латед, гэгээнтний өөрийн ламанчодбийн лүнтэд, жалбаан авын сосортарвийн сургааль, нүн ү намсал донмийн лүнтэдийг хүртээж завсараар нь зарим айлтгасан номыг тайлбарлав. Төмөр эр луу жилийн дундуур урьдын ерөөл увидасын ачаар нийтэд их нууцын дөрвөн дамжлагат орохийн үүдгүүр болсон очир эрхийн боловсруулан үйлдэхийн их авшиг анхлан өгөхдөө чавдаг лама доржчан бээр сав төгөлдөр шавь нар та бүгд учир айлтгуулах шаардлагагүй хэмээн өөрөө баясан хүртээж байж билээ. Тэрчлэн би бээр чүмчог гэх могой жилийн” Во” сараас нянбанд сууж тавих номынхоо тайлбар энэтхэг түвд лам нарын гол номлолыг болгоож, ялангуяа илтийн хот мандал, нарийн судалж, бас цанид чойрын ловон багш нар нь ч анхааран авч байх нь эрдэм арвидах суурь мөн. Равжам жинхор гүнчав Доржчан бээр:

Энэрэнгүй сэтгэл мэдлийн хүчээр гийж
Ээх мянган гэрэл цацрах зам их тарини
Дэлгэх цагт шавах хувьт зөгийн чуулган
Дээдийн номын авшиг орох амьтан бүгд дамжлага 4
Үүдийг нээх хувьтан үүл сарнайн орж
Сүсгээр айлтгах нь үүл ерөөлийн барилдлага

Санаж үргэлж хичээх дор шамд гэхчилэн 3-р сарын 24-ны өдөр дүвчинмидра зогийн өөрийн ёсны жажүд дэшин шиг рэггүнзий зовуу тува зонхор 35-ийн хот мандалтай холбоотой дагон зэрэгийг дэлгэрэнгүй айлдав. Шавийн тэргүүн хар он буюу хөх тэнгэр, равжүнба сойрег гүнчин хайван цорж, ганжуурва нэрт, ойр мэргэн дажүр равжинба, чойжав даяанчийн гүжэ лүнрэгмарайва мэргэн гавж, тунамал эрдэнэ лам тэргүүтэй сүсэгтэн олон 3000 гаруй дор бэлтгэл номыг машид дэлгэрэнгүй айлдаж, мэдрозогийн намтар зэрэг ном айлдаж бүхэнд баясал төрөв. 25-нд их авшигийн гол өдөр аль бурханы язгуур хийгээд ямар дамжлага жүдтэй нь тохируулан айлдав. Үе үеийн утгыг тус бүрт тайлж номлоход бүгд таатай байв. Сүүлд нь энэхүү дамжлага жүдийн тангараг сахих талаар увидас нугуудыг тайлбарлаж сүүл сарын 25-н хүртэл вангийн бэлтгэл ван авшиг илт хүртэх өдөр, данрагийн буюу төгс авины өдөр зэрэг 3 хуваан дэлгэрэнгүй хүртээв. 16-нд цогмид өргөж сүүлд нь нас буян арвижихийн тухайд мэдрэ ёсны цэвагмид цагааны жинан дүйвиванчүг агарын ёсны дорж пэрэнбийн авшиг, жалбаан авын хойдийн буянд ерөөл айлдав. Гэгээнтэний тааллын дагуу ойрын шавь нар залбирал талбиралыг ёсчилон үйлдэв. Гэгээн нянбанд сууж их авшиг бэлтгэв.

5-р сарын 11-ны өдөр дагон айлдаж ван айлдахын үед 3000 гаруй сүсэгтэн цуларсан байв. Түүний дунд Дитангийн туслах данзан хутагт, хар он буюу хөх тэнгэрийн туслах эрдэнэ, мөн туслах амгалан гэлон, егүзор ламын гүжэ, тэргүүтэй арав гаруй хутагт хувилгаад, гаарамба, чойрж, ууланд бясалгаач нар гэлон гэчүл нийлсэн 700 гаруй лам нар, их бага олон ноёдуудад санваан дүйваа, жамдор зонхар 19-ын хот мандалтай холбогдуулан вангийн дагон номлож дараа өдөр жидорийн авшигийг бодитой тавихын үед үлгэр түүхтэй холбон бүрэн төгс тайлав. Чүдод сарын шинийн 7” -н хүртэл ава ёсны хот мандал 42, гүйцэт номлосны дагуу айлдаж их нижийн зарлигийн ач дээдийг хайрлав. Сүүлд нь чогчид өргөж номын хурим ихийг хийж ерөөл тавьж буянаа хураацаав. Энэ үед нууцын түргэн зорчих замыг нээгчийг, тус хийдийн шаь нарт шинийн 8-наас ямандагийн 13 тэнгэрийн авшиг хайрлав. 9-нд 10-аад хуврага гэлэн сахил хүртэв. Энэ сарын хуучаар чавдогламийн лагшин чилээрхэж жанжа хутагтаас асуулгаж буулгасан гүрэм засал, эмийн засал аль болох

талаас хийхийн тухайд морилж цамхаг хэмээх газар өртөөлөж байхад өдөр шөнөгүй гүрэм хийлгэж, орчлонгийн тэнгэр болон орчлонгоос гэтэлсэн тэнгэр бүгдийг өөрийн хүсэлт тахил өргөж лам хуврагуудыг нэг сарын турш бат оршил нас тоолон өргөж, насны ном, амин золиг лүжин тавиулан чогчид өргүүлэв. Ялангуяа гал мандал 1000 удаа 2 өөр газар өргүүлэв. Хамба номын хаан заларч эм засан гүрэм жинан өгч лагшин жаахан илааршив. Гэгээнтэн тэнд цугласан лам хуврага нарын өмнөөс номын хаанаас ван лүн жинан өгч хаан буцаж морилов. Гэгээнтэн 11-р сарын 3-наас нянбанд сууж, нянбанд байх зуур лагшин сайжирч 24-нд нянбаанаас гарч шавь нар нь лагшинд бат оршил өргөж, номын хурим өргөнөөр зохиов.

Өгүүлрүүн: Завсрын чимэг үгс:

Үйл ерөөлийн барилдлагат хувьт шавь нар
 Үнэхээр нууцын барилдлагат дамжлагийн далайд
 Түргэн одохын дөрвөн авшигийн онгоцонд шүтэж
 Төгс эрдэнийн тив дор хөтлөх мэргэн та
 Гурван нууцын дээдийг төгс удирдагч
 Гүн далайн давалгаа мэт үйлс нь түрэн орж
 Хотол олонд хувирашгүй нинж хайрлагч
 Хорвоогийн дээд ачтан танаас өөр хэн
 Ач зүйлийг өгүүлэхүй лугаа намтрын
 Найлзуур модны салаа лугаа 35

1702 он элдэв хэмээх усан эр морин жил шинэ хийд байгуулан номын хурим хийж хавар нь шинэ лханд лам нар цуглуулан шинэ хурал нээв. Лувсаншива, эрхэмбилэгт эд эртнээс сайн байдаг. Ялангуяа лхан дотор дөрвөлжин модоор маш сайхан бүтээсэн унтаж амрах гүрэх ор бүтээсэн нь ихээр таалагдаж яг л миний хүү шиг чухал зүйл байна гээд чухал гэж нэр хайрлав. Бусад зүйлийг гүжэ лувсанванжил болон лам егүзэр хоёрт та хоёр намайг гэж бодоод өөрсдөө санаагаараа хийхийг даалгаад гэгээн даагын булаг уруу морилов. Тэнд биеэ засангаа лхамийн бүтээлийн лүн, 5-р далай ламын барин өргөх ёсны лүн, шар улаан манзуширийн гүргүлийн сүн айлдав. Гэгээн өөрийн сүмбүмээс лхамийн ганс, 21 дархи, бурхан багшийн бүтээл, манзуширийн ондог, цагаан шүхэртийн ондог, майдарын бүтээл, очирваан дамдин, намнан, мэжидва, дэмчиг таван тэнгэрт, очирвааний бүтээлийн лүн важигийн тайлбар айлдахад хувь төгөлдөр шавь мэргэн вангийн

лам нар гэлэг тэргүүтэй ноёд түшмэл байцгааж номын авшиг хүртэж сүсэглэв. Өвөл их ордонд хааны дэргэд хуврага лам болгохоор морилж тэндээ цагаан сар гаргав. Дээдэс монгол оронд шашин амьтаны тусад энэ байгаа лханаа засаж сэлбээд нааш цааш явах хүмүүсэд зориулсан сүм хийвэл хэрэгтэй гэж айлтгав. Энэ айлтгалыг бүгд зүйтэй хэмээн дэмжин хүлээж авав. Дашиван дорпэрэнгийн их авшиг айлтгаад морилох зам зуур жамби даши гүнгийнх залж вари жарзэ жинан бүтээл, энэтхэг гал номлол сэлтийн лүн, Дорж гангийн жинан айлтгав. Нямбуу 73, Бодалаад зорчсоны тийз хэмээх ванчинбогдийн зохиосон жигжидийн зогрэм гажумийн лүн, 109 биндэръяагийн тийз, нантан ёсны мэжидвийн жинан тэр мэт гачой олныг хайрласанд жамбаагүн, тэргүүтэй сүсэгтэн ихээр баярлав. Мөн зам зуур ухарын халуун усанд морилоход гүнгийн хатан зэрэг сүсэгтэнд лусын хааны жинан хүртээв. Тэр үед гэгээнтний лагшин ахин чилээрхэж дашиван дуулангуут шууд морьдож дээдэс, жанжа хутагт хоёрт айлтгаж даатгал гүрэм засал хийлгэж, үлдсэн лам хар сүсэгтэн эм тан арга чарга хайсны эцэст лагшин тунгалаг болов. 5-р сард мэдра ёсны хот мандал 66-гийн бүрэн дагон авшиг хүртээхэд цугласан даши ван тэргүүтэй түүний хатан хөвгүүд, ноёд гаднаас цугласан нь жадамбаа хувилгаан үзэмчин цэцэн ван, түүний хөвгүүн лхаванжамц, хатан хөвгүүдийн хамт, жамбаа даши ноёны хатан хөвгүүд, хорчингийн зүгээс эрдэнэ тайж, гэлондадчин рэтод бясалгаач гүши гэлон дагвасэнги тэргүүтэй олон 1000 орчим сүсэгтэн цугларав. Тэд их шамбалаар ерөөл тавьж их тарнийн амар хялбар замыг боловсруулахын аргын дээд дөрвөн авшигийн рашааны шимийг амсав. 6-р сарын 6-наас гэгээнтний өөрийн зохиолоос доримбийн ондог, жанрайсигийн бүтээл, тид, ламын налжорийн тайлбар пово, Галсан эфүгийн айлдсан 4н шүлэгтийн унших арга, үзэмчин цэцэн вангийн хатанд залбирал ламын налжор, ванчин богдын зохиосон дэмчиг 5н тэнгэртийн бүтээл, жалбаан авын зохиосон сахиусанд балин өргөх ёсны лүн жинан хүртээв. Үзэмчин цэцэн вангийн хатанд цэрэнчида буюу 75 махгалийн жинан хүртээв.

Ванчинлуvsанчойжижанцангийн зохиосон бодь мөрийн зэргийн шүлгэн, богд ламын зохиосон бодь мөрийн зэргийн хураангуй, гэндүнжамц далай ламын зохиосон нүнай сахих чого, лүн тайлбар, содномжамц далай ламын зохиосон бодь мөрийн

зэргийн тайлбар сирж яншүнгийн лүн хүртээв. 19-нөөс вангийн хатан, хэсэг лам нарын хамт Дүвтавжамцаас айлдсан зарим жинан, Энэтхэг Түвд номлолын бүрэн тайлбар айлдав.

Мөн Ванчин богдын мэнтүгийн чогийн лүн. Жанжа хутагтын сорийн мэгрэмчинбийн лүн, хар манзушир, цагаан дархийн бүтээлийн лүн одбагмид бурханы бүтээлийн жинан хүртэв. Гэгээнтэний өөрийн зохиосон ламын налжор залбирал, зэргийн лүн айлдав.

Ванчин богдын тусгайлан айлдсан жигжиддагжүг номон хааны сорлай намжагүде хэмээхийн лүн дэлгэрэнгүй айлдав. Хувилгаан содном ишийн зохиосон ганданлхасан жигжидийн бүтээл машид хураангуйнлүн, жамнагдамдүн жамсир одсэржан синги да хэмээх бүтээлийн лүн.

Лувсангамбумаас тарнийн сургаалийн лүн айлдаж бүгд баясалаар дүүрэн болов.

Өгүүлрүүн: Завсрын чимэг үгс:

Итгэл таны эрдэм энэрэлийн лагшин тунгалаг бус ч

Ирэмгүй хичээлээр шашин амьтанд тусыг үүрч

Аяга тахималын дүрээр залран ажирч

Амьтан бүхний төлөө гагцаар зүтгэх гайхамшиг

Няцралтгүй энэрэлийн голыг урсгаж

Нэрвэгдсэн олонийг чийглэн ургуулагч

Дээдийн номыг хурчилан буулгаж

Дэлбээлэх цэцэг шиг амьтныг тэтгэж

Сайн хувьтаны цог сан зарлигийн ач

Саалийн үнээ мэт дүүргэх найлзуур

Модны намтарын мөчир лугаа 36

Даши ван бээр номын ачид талархан өглөгийн эзэн болж элдэв өнгийн бэлгэ сэлтийг сайтар шамдамой. Энд буй хүмүүс баярласан сэтгэлээ илэрхийлэн Зхоног бараалхан сүнтогийн адис хүртэв. Залрахуй цагт “Санёг” туурвиж 1-р бүлэг 8-н сар 10 хоног бичиж гүйцээн морилов. Тэнд хайдүвдамбаа жанжа хутагтад бараалхаж түүний сүмбүмээс 40 гаруй лүн хүртэв. Тэгээд өөрийн хийдэд 9-р сард морилов. Урьдын амласан ёсоор хангийн зүгт морилохоор шийдвэрлэв. 9-р сарын 17-нд жамсир, намжом хоёрыг айлдаад, 9-р сарын сүүлээр хар он буюу хөх тэнгэрийн лханд морилож их зуугийн дуган ширээт зуугийн дуганд бараалхав тахил өргөв. Тоёнгийн гүжэ залж найр хийв. Равжинчойржи

залж гүнцэг өргөв. Маналын жинан, жалбангийн сүмбүмийн лүн гэндэнжамцын нянбу донсүмийн тайлбар гандан номын ордонд морилохийн шат хэмээхийн лүн айлдав. Мөн өөрийн зохиосон лүгсүнийн сургааль зэрэг зарим ном айлдан морилов. Чойжавийн хийдэд 21-нд морилж суурь 3 шүтээн өргөөд өөрийн лам нартаа хангийн зүгт морилох тухайгаа айлдаж, бурханы дүр ихэнхийг нь шинэ дуганд 30 лам үлдээж тэднийг удирдаж байхаар далай ёгүзэрийн гүжид тушаан ловон болгов. Цагаан даяанчийн гүжи тэргүүтэй жиндагт Жамъяангарав, Магсоржам, жинан хүртээв. 10-р сарын сайн өдрийг харж шинэ дээр хангийн зүг эхлэн морилов. Хар он буюу хөх тэнгэрийн талын лам өглөгийн эздүүд хагацаж чадалгүй дагалдан байж үдэн гаргав. Мутрын адис хайрлахаар мэргэн вангийн дээр залрав. Өндөр гэгээнд бат оршил өргөж, шашин амьтаны тусад шавдан бат байхыг бодон ганжуурын лүн айлдахад бусад бээр хүндлэн суув. Өндөр гэгээн болон бусад лам нар өдөр бүр ном айлдаж лүн ван хүртээхийг айлтгав. Өвлийн үеэс бошигт ван, Хатанбаатар нар урьдын ерөөлчилэн заллага айлтгаж номын лүнг, ишлэх авшигийг хүсэнчилэн буулгав. 1703 он буюу наран хэмээх усан эм хонь жил тасраад 1702 он буюу элдэв хэмээх усан эр морь жилийн өвлийн сард хатанбаатар бошигт ван хоёрын заллагаар цагаан сарыг тэнд өнгөрүүлэв.

Өгүүлрүүн: Завсрын чимэг үгс:

Бүх шашны зүрхэн шар малгайтын ёсыг
 Мөнхөд мандуулахын үүрэг танд оногдож
 Мандах нарны туяа мэт багшийн үйлс дэлгэрч
 Богд зонховын шашин өнөд дэлгэрч
 Буман навчит судар тарни нь номлол нь
 Нянваан хүсэх зөгий баланд дурлах чинан
 Нийтээр бурханы шашины утга тусыг мэдэж
 Буруудсан нугууд гэмээ мэдэн эргэж
 Бусдын тусын төлөө шашины нарыг мандуулж
 Харанхуйг гийгүүлэх авралыг одуулж
 Хаяж авахын буруу эндүүрэл цагийн эрхээр
 Хан огторгуйд мандах эрдэнэ болох шашин
 Хар бараан үүлэнд далд орох тэр цагт
 Харин таны итгэлийг өгүүлэхүй
 Хичээл номлол намтрын мөчир лугаа 37

1704 он буюу наран гэтэлгэгч хэмээх модон эр мичин жил

Хатанбаатар нартай хамт цагаачилсан гэдэг бас эндүүрч байж ч магадгүй ямартай ч тэр жилийн хавар лам нартайгаа тамирт залрав. Ахай засаг болон мэргэн засаг тэргүүтэй өглөгийн эзэд өргөнөөр хүлээн авч зуны эхэн сард шинлэвлий буюу хавтгай мод хэмээх газар хүрээ барьж номын хурим үүлдэв. Тамирын хүрээнд Лхавав буюу бурхан тэнгэрийн 33 тэнгэрийн орноос буусанд тэмдэглэлт өдөр ганжуурын лүн эхлэн айлдаж байхад өндөр гэгээний хүрээнээс номч монгол равжүн, гүн лам, эрхэм лам самдон эрдэнэ, унзад гунгаадаши тоён тэргүүтэй сүсэгтэн үүл мэт хуран равданвангийн бандид цорж, цохур ари лүгсан тонён, хурц билигт хар он буюу хөх тэнгэрийн равжинба гол номлол өгүүлэгч цорж, мэргэн гавж, ойрад равжунба, зэрэг лам хуврага олноор хатанбаатар тэргүүтэй ноёд олноор ирж Ганзогоос эхлэн жайврэндүйсүмийн лүнг дараалан хүртээхийн цагт сонсохын шалтгаан бээр лам ёгүзэрийн хөвгүүн нямаа, гунга хоёр сонин гайхамшигийг үзүүлэв. Үзэмчинван, мэргэн ван, нар хоцорч ирсэн ч завсарын зову ёсны дархи, зэрэгт гүйцэт лүн хүртэв. 9-р сарын 20ноос 12-сарын 30 хүртэл 54 ботийн аман гэгээний иш лүн хүртээв.

Өгүүлрүүн: Завсрын чимэг үгс:

Сайн идээт хааны хөвгүүн

Сайваар одогчийн 4-р залагдаж

Зарлигийн далай мөрнөөр үерлэснийг

Залгиж балгасан эрдэм төдийхөнөө

Чухаг дээд гурваар буулган үргэлжлүүлж

Чин сүсэгт хувьтны их тэргээр татаж

Чиний сэтгэлийн галт гууг арилгах хүмүүн

Чадагчийн эрхт дээдсийн таалалаар

Эрдэм төвлөн цэнгэх хөлөг нэгийг

Эдлэхүй араш ачит багшийн энэ мэт өгүүлэх

Гайхамшигт намтарын мөчир лүгээ 38

1705 он буюу газар тэтгэгч хэмээх модон эм тахиа жилийн цагаан сар номын хурим зохиов.Шинийн 2-нд гэгээнтэн лам нартайгаа их хөлөгний сожин авч маналын чоги дэлгэрэнгүй айлдав. Энэ сарын шинийн 3-наас эхлэн 2-р сарын 15-наас гэгээнтний лашин чилээрхэж цааш номлоогүй өндөр гэгээнээс насны бүтээл хийвэл сайн хэмээн зарлигласны дагуу шавь 10 гэлон цэвагмид болон ламын налжарын үүднээс нянба хийж

насны сүн тарни 11 бум тоолж, лам хуврагууд дархи буман удаа уншиж, харшлах дэрээг буцаан хаяж адаг сарын шинийн 9-нд лагшин тунгалаг болж шинийн 10-наас лүнгээ эхлэн 4-р сарын 20-н хүртэл ганжуурийн бүрэн лүн хүртээж гүйцээв. Дахин билиг дэмбэрэл бодож-галсан-гаас хураангуйхан эхлээд орхив. Түүний дараа лама авдзүвийн намшадийн лүн, 26-наас мэдражарзаас туваан 30-н нөхөртийн дагон, 27-нд бүрэн авшиг хайрлав. Мөн лама авжүбийн болгон шалши ондог ганс зэргийн ишлэл хүртээв. 28, 29-нд ганжуур уншиж, 4-р сарын 1-ний өдөр цогчид өргөв. Намсрай цагааны жинан айлтгав. Шинийн 3-нд Равжинцорж тэргүүтэн бат оршил өргөв. Вари жарзийн жинан эхлээд шинийн 6-нд морь уралдуулж даллага аваад шинийн 7-нд жинан айлтгаад жамлха гарбийн жинан, усан балан өргөхийн лүн, га-ү-ийн манаг бүтээлийн жинан, ондогийн лүн, цэвагмидийн бүтээлийн лүн варижарзийн лүн, дэмчиг таван тэнгэртийн бүтээлийн лүн айлдаад 17-ны өдөр өндөр гэгээнд бараалхаж уулзахаар одов. Замдаа бошигт вантай бараалхаж, чойжидравсил бүрэн лүн, болон айлтгасан зарим номыг айлдсан бүхэн баясав. 5-р сарын 4-нд өндөр гэгээнд бараалхан харилцан бишрэлгүйгээр дотно харилцан уулзалдав. Дараа өдөр лам хуврага нарт зонховын игчүн 21-ны гүн ишлэл, өндөр гэгээний намтар болон едамийн горийн лүн, мэгзэмийн лүн, Ванчин богдийн сүмбүм бяцхан а ботийн ишлэл эхлээд, өндөр гэгээнд бат оршил өргөөд 12-ны өдөр 10 хуврага гэлэн санваар залав. 12-нд дээрхи ванчин богдийн сүмбүмийн лүн ишлэлийг бүрэн хүртээв. Өндөр гэгээн өмнөөс ванчингийн зохиосон сонгодбийн лүн, Цэвагмид, Долгорын жинан зэргийг хүртээж, 17-нд гэгээнтнээс өндөр гэгээн, самдон унзад тэргүүтэй хуврагууд лүн авшиг хүртэж бат оршил өргөв. Тэгээд гэгээнтэн залрах замдаа гүнгийнд залагдаж хайдавжийн дамжлаг лам налжорийн ишлэл, цэвагмидийн чого айлдав. Бүгд баясал дүүрэн номын хурим хийв. Тэр сарын хуучдаар гэгээн өөрийн дацан хийдэд мориллов. Намар дээдсийн таалалд тохируулахаар залрав. Дараа нь Дашивангийн заллагаар ном айлдаж буцахдаа долнуурийн хийдэд морилож харилцан дотно ярилцаж ширээт лам хэмээх цол хайрласны билиг дэмбэрэл зохиов. Тэгээд халх цэцэн ханы мэлмий хараа муудсан тул эм засал хийж эдгээв. Урьдын ерөөл барилдлагын үрээр барилдсан хэмээн дорпэрэнгийн мэжидийн авшиг алдсаныг ёс дагуу хүртэж бүгд

цэнгэлээр бялхав.

Мэсад хэмээх гал нохой жилийн намтар тасрав.

Өгүүлрүүн: Завсрын чимэг үгс.

Нууц таалалын эрдэмийн их сангийн

Нээх түлхүүр нигүүсэл амьтаны үүдийг

Гийн нээгч сайн хувьт шудрага олон

Гэтэлгэгч ховор эрдэнэ гайхамшигийг

Буяны цагаан рашаанаар шимлэн

Бузар муу амьдралын амийг эргүүлж

Болгоомол алт лугай тунгалаг дээдсийн ёсоор

Бүхнийг удирдан байгааг зохицуулан

Амгалан гарах ертөнцийн дамжлагаар

Араасаа дагуулан арга, элдэвээр

Шамдал ихээр үр шимийг авах ёсоор

Шалгүй цагаар хувирах араншинг

Өөрийн сэтгэл зүрхнээс залбирч

Өрөөл дээдсийн ёсыг дагах

Намтарын мөчир лугаа 29

1707 он буюу бүгд номхорох хэмээх гал эм гахай жилийн хавар боржигон хошууны ноён Дулам тэргүүт хувьт шавь нарын айлтгалын дагуу доржпэрэнгийн авшиг хүртээж энэ мэт амьтны тус түргэн боловсрох зам дор урьдын авъяас сэргэн зохиов. Зун дээдэсийн таалалд тохируулан айлтгал хийхээр морилов. Их өргөөнд бараалхах рэбу зэнатай танилцан хариу айлтгал өргөв.

Буцаж морилох замдаа ус зооглоогүй удсаны улмаас бие нь чилээрхэж хар он буюу хөх тэнгэр равжүн цоржийг илчээр явуулав. Элч ирэхээс өмнө бие лагшин илааршив.Төв цагт дондүв ван угтав.

Ганзой бараалхан заллага айлтгаж залав. Сүсгээр угтан мөргөн хүндлэв.Гэгээнтнийг дуганд залсан боловч сүүлд морилов.Рэбузан хэмээх газар бие сул байсан тул модон тэргээр явах хэцүү тул тэнд саатан морилж 8-р сард явахын замд гэндэнжамцийн зохиосон жанбалцанжидийн тайлбарын шилүн ширго хэмээхийг айлдахад хятад олон тойрон ирэв. Ёви хэмээх харшин цэргүүд угтан хүн олон байв. Вимаян хэмээх газраар дайжин мөргөж пүсандэнла залрахад мөргөлчид тойрон мөргөж манж барьж өргөл хүндлэл үйлдэв. Равжүнгэцүл болох хүн олон байв.

Лоухусэл хэмээхэд заларав. Дуганд мөргөж уул тойрон залрав. Тэдэнд хүссэн номыг нь айлдав. Тэгээд 11-р сарын 15-нд хар он буюу хөх тэнгэрийн равжүнба цорж тэргүүт лам хуваргуудад гүнрэг, сандуй, намхай гождийн авшиг хүртээж, маргааш нь хангийн зүг залрав. Шавь нар ерөөл тавин үдэж мордуулав. 1708 он буюу бүхнийг баригч хэмээх шороон эр хулгана жил илжгэн номын хаанд зонхов богдийн сүмбүмийн аман гэгээний ишлэл айлдаж урьд нь бусад лам ирж байгаагүй газар номын хөрөнгө үүтгэв.

Өгүүлрүүн: Завсрын чимэг үгс:

Гэм бүгдээ номинчлан бусдын тусыг үлэмжсэн

Мөнх язгуурын номлон бүтээлийн рашаанийг

Мушгирах могой мэт яаж хүртэж чадахав

Муу цагийн халуунаар энэлэх төрөлхтөн

Магад эрдэм төгсгөж ууж чадах адил

Дээдсийн явдал ёс чийглэгч огторгуйн заан

Дэндүү хүчээр буулгаж урсгана хөрсөнд

Сэргэн ургах үр жимс машид саглайн

Салаалан намтарын мөчир лугаа 40

1709 он буюу харш хэмээх шороон эм үхэр жилийн сар нь тодорхойгүй зуны сард урьдын ерөөлт үзэмчин цэцэн ван бээр заллага айлтгаж тэнд доржпэрэнгийн мэнжидийн авшиг нугуудыг айлтгалын дагуу хүртээв. Өглөгийн эзэн хатан хүүгийн хамт, 10н ухаан төгөлдөршсөн молон равжинба, тэргүүтэй гаарамба, гэлэн, гэнэн, гэчүл нийлсэн 1000 гаруй цугларсан байв. Тэдэнд ава ёсны хот мандал 42, дэээ ёсны гэлүгбийн хот мандал 3 дээр нэмэн бүрэн гүйцэд авшигийг 4 дамжлага тус бүрийн онцлого чаглинг ёсчилон дадмаг гайхамшигтайгаар хүртээв. Тэр жилийн намар хар он буюу хөх тэнгэрийн лханд морилж равжимба цорж тэргүүтэй 100 гаруй лам нарт Ванчин богдын сүмбүмээс аман гэгээний ишлэл айлдаж бүгд дор баясан зохиов.

Өвөл хангийн зүгт залрах замд мэргэн гавж, Дорж ламын эмч оточ, ойрад мэргэн лозова равжинба гунгаажамц нар тус тусын өргөөнд залж, өргөл хүндлэл үйлдэв. Мөн халх равданвангийн заллагаар өргөөнд нь морилов.

Өгүүлрүүн: Завсрын чимэг үгс:

Хувь төгөлдөр сүсэгийн эрдэнэ уудамд

Буян төгөлдөр хөрөнгө хөрслөх жимд

Төгс төгөлдөр дээдийн номыг заагч багш
 Хур төгөлдөр увидас 4 буулган уламжилж
 Тус төгөлдөр амгалангийн гэрэл түгэх уудамд
 Сонсохуй төгөлдөр бүхний магтаалийн уудамд
 Эрх баялаг төгөлдөр бүхний магтаалийн уудамд
 Нирваан төгөлдөрийг хүсэгчийн зүрхний баясгалан
 Зохионгуй төгөлдөр үүлсийн дардам замд
 Авч орхихуй төгөлдөр сайн хувьтан залрахуйн
 Намтар төгөлдөр найлзуур модны мөчир лугаа 41

1710 он буюу урвахуй хэмээх төмөр бар жил равданвангийнд цагаалав. Хатад хөвгүүдийн айлтгасан номыг хүртээж цэнгэл баяраар дүүрэн засаг анурийн урилгаар заларч замбал цагааны жинан хүртээж гал мандал өргөв.

Лам хуврага нарт жигжид болон сандуйн авшиг, намжил засагийн заллаганд хар манзушир, намзом манла, зожингийн жинон, жигжидийн тарнийн хураангуй, гончойлхасүм -ийн жинан зэргийг хүртээж номын авшигийг хурчилан буулгав. Ноён эрдэнэ ван, эрх ахуй, хөвгүүдийн айлтгасан манзушир улаан шарын жинан, гал мандал, өргөх, хар манзу-шир улаан шарын жинан, гал мандал өргөх, хар манзуширийн авшиг зэрэгийн номыг хүртээв. Тэгээд өөрийн хүрээнд мориллов. 4-р сарын 1 шинийн нэгэнд лам нар өтгөн цугларч бат оршил өргөв. Шинийн 8-нд хамба номын хаан түүний зохиосон дэмчиг 5-н тэнгэртийн даг цүн бумба вангийн хамт гүйцэт аман гэгээний ишлэл айлдав. Сарын хуучдаар өндөр гэгээнд бараалхахаар морилж нас урт байхын тухай бат оршил өргөв.

Шавь нарт нь насны авшиг хүртээв. Лувсан лам тэргүүтний айлтгалын дагуу Ванчин богдийн чагжачинбуугийн тайлбар содномжамц далай ламын мажиг балх солчидийн лүн, зэргийг айлдаж, өндөр гэгээн зая гэгээнд урьдын адил бат оршил өргөв. Ингэж билиг дэмбэрэл дүүрэн хүрээндээ буцаж ирэв. 6-р сарын 6-нд санёг буюу сонсоны бичиг тодорхой толь хэмээхийн лүн буюу ишлэлийн гол наймаас цагаан шүхэртийн авшиг 25 хүртэл сонссоны бичигийг дуусгасан лүн хүртээж мөн дэмчиг 5н тэнгэртийн авшиг, нартан ёсны дэмчиг 5н тэнгэрийн авшиг, нартан ёсны чагдоржийн жинан, хүртээв. 1711 он буюу илжиг хэмээх төмөр эм туулай жилийн намар дээдсийн бараалхалд морилох үед түвдэд морилох хэрэгтэй хэмээн зарлиглав. Хааны

бараалхалын дараа хэсэг сүсэгтэнд хар манзушир, синдонма, маналын жинан хүртээж маргааш нь хунтайжийн лханд мөргөн 10-р сарын 13-нд Тайху-д бараалхан цайллаганд оров. 12-р хаан хөвгүүн, Ава 13-р хаан хөвгүүн эфү нар гэгээнтнийг залж өргөөндөө дайлав. Лханд алтадсан бурханд мөргөн 13-р хөвгүүнийд залагдаж баярт багшийн айлтгалын дагуу жигжид важигийн ван хүртээв. Шадар Амгалан бээр синдомийн ганс, майдар хутагтад цагаан шүхэрт мянган мутартын хот мандалын авшиг хүртээв.

Дээдсийн зарлигаар өвчин хуучтай би бээр түвдэд 2 зууд мөргөж, Ванчин Далай багш нартайгаа золгож баясан олон хийдүүдэд манз барьж зэд өргөн дээдсийн таалалын айлтгал дуусгав дээдэс лам ихээр баярлаж миний шар морьт тэрэгийг аваад морил гэж хэрэглэл зүйлийг сайн бэлтгэж өгч буцаж морилов. Зам зуур бэлтгэж өгч буцаж морилов. Зам зуур егүзэр ламын гүжэ заллагаар заларч лханд дашичойнпэл гэж нэр хайрлаж түүний хөвүүн Нямаа, Содномжамцийн гүжэ, хоёрт гэлэнгийн сахил хайрлаж дацан шинээр байгуулсан шавь нарт түгжийчинбу, жигжидважигийн авшиг хүртээж морилохдоо хар он буюу хөх тэнгэр ойрын шадар хэсэг ноёдод ловончинбуугигвий доржийн ёсны цагаан манзуширийн бүтээлийн лүн, жинан сайтар айлдаад хангийн зүг уруу морилов. Энэ туулай жилийн намтар бас тасарсан болой.

Өгүүлрүүн: Завсрын чимэг үгс:

Гурван сургаалийн бат үндэс ёзоороос
Голлон дэлбээлэх иш онолын навчис чимэгтэй
Тус амгалангийн үр дүн төгс эдлэл таны ач
Тарчлах амьтан цагийн эрхийг болгоож
Туслах арга элдэв олноос номхотголоор татаж
Тэр мэт гайхамшиг нь бурхан бүгдийн үйл
Төгс мөн чанарт эрдэмийг эрхшээсэн таны
Намтрын мөчир лугаа 42

1712 он буюу баясгалан хэмээх усан эр луу жилийн зун өндөр гэгээнд бараалхахаар морилж түвд явсан тухайгаа нарийн айлтгав. Өндөр гэгээн насан өндөр болсон хууч өвчин байгаа зэргээс гэгээнтэнийг морилохыг азна хэмээн айлдав.

Өгүүлрүүн: Завсрын чимэг үгс:

Зан үйзэнд орших дээдсийн шашины үйлийг

Загасны дэгээгээр баригч таны таалал
 Цаг бусдын эрхээр баригч таны таалал
 Цаст түвдийн дээдэст урьдын адил золгож
 Шашин төрийн ажлыг шантрал үгүй тааруулж
 Шаналах таалалын гүнд түмэн олноо болгоосон
 Таны мэдэл энэрэлийн хүч эрдэмийг хоцроолгүй
 Тоолж өгүүлэх чадал хүрэхгүй баялагт
 Тэнгэр мэт Намтарын мөчир лүгээ 43.

1713 он буюу тийн ялагч хэмээх усан эм могой жилийн эхэнд модон дуган барьж цогчин хурал нээв. Тэгээд өвөл өндөр гэгээнд бараалхаж, буцаж морилоод егүзэр хэмээхийн гүжэ Лувсанванжил ирж цэвагмидийн жинан ложингийн тайлбар айлтгаж хүртэж бат оршил өргөв. 1714 он буюу ялахуй хэмээх модон эр морь жил ойрадийн равдан вангийн хатан өвөл заллага айлтгаж залран доржпэрэнгийн авшиг хүртээв. Өндөр гэгээний туслах ажилаар заларч өөр хоорондоо дотно ярилцаж өөр газар залрахаар морилж лагшин чилээрхэж эм болон гүрэм тасралтгүй хүртсэн ч 1715 он согтуу хэмээх модон эм хонь жилийн чойнпэрэлийн сарын 18-нд өдөр мөнх бусын дүрийг барьж гайхамшигтай билиг тэмдэг тэнгэр, охин тэнгэрүүд цэцэг өргөн элдэв хөгжим эгшиглэн сайны шинж бүрдүүлэн номын биеийн агаарт залрав.

Өгүүлрүүн: Төгсгөлийн чимэг үгс.
 Эвдрэл хагацлаас очирт лагшинг олж
 Эргэж хувирахгүй их амгалант таалал төрж
 Тагаалал лагшин ялгалгүй магад 5 лугаа төгөлдөр
 Тойм махбодь элдэв гэрлэн биед шилжэн
 Арга мэргэнээр зохион амьтан бүгдийг
 Ачлан номхотгож хувилан бүжиж
 Амьдрал үйлээс татан амирлуулах
 Ашид дээдийг байгуулах бурханы үйлээр чийглэн
 Мөнхдөх нугуудын ёсыг ойлгуулахын тухай
 Мөн чанарын агаарт гэрэл цацрахын цагт
 Тэнгэр язгуурт охид хөвгүүд үүл мэт жигд
 Тэнүүн тэнгэрт бүрхэн яруу хөгжим эгшиглэн
 Сайн цогийн тэмдэг энд тэндгүй үзэгдэж
 Саруул диваажин едга чойнзэнлинд заларч
 Жалцав жамбалд бараалан золгож
 Жинхэнэ бурханы суурийг эзэлсэн

Намтрын өргөн гол мөрнөөс
Нарийн чийг төдийг бичлээ би
Төгсгөлийн бүлгүүд тодорхой бус тул
Түмэн олноос дуулснаа эвлүүлсэн
Төгөлдөр намтарын мөчир лугаа 44 гэжээ

ЗАЯ БАНДИДА ГЭГЭЭНИЙ АРВАННЭГДҮГЭЭР ХУВИЛГААН ЛУВСАННЯНДАГ

Монгол улсын шастирын зарлигаар тогтоогдсон ван гүнгүүдийн 8-р бүлгийн 49-т бичигдсэн Зая Лувсанняндаг гэгээний товч намтар:

Гуравдугаар үеийн хувилгаан Лувсанняндаг Түшээт хан аймгийн ван Цэвэгрэмпилийн хошууны мэйрэн Банжуурын гэрт хувилгаан гарчээ. Найралт Төвийн тэргүүн онд харьяат шавь нарт нийлүүлэн суулгажээ. 6-р онд Нийслэл хотноо орсонд хадаг, хавтага олгуулжээ. 10-р онд дайны хөлөөс зайлж Авгын хийд зэрэг газар очсонд сайшааж 500 лан мөнгө олгуулжээ. 11-р онд эрдэнийн шүншигтэй хүрд эрхи хадагтай олгуулжээ. Дараа Шангийн газар одож 6 жил номын сургууль үйлдэж хэтэрхий мэргэжсэн учирт Далай ламаас Чоймачойлин хэмээх сүмийг албат шавь нараас дөхүүлж өглөгийн эзэд ба тариалангийн газар сэлтийн хамтаар тусгайлан олгуулжээ. Тэнгэрийн Тэтгэсний 2-р онд харьяат шавь нарыг захирах тамга олгуулжээ. Дараа Баруун шанд сууж ном эрдэмд сайтар боловсорсон учирт Далай лам Банчин Эрдэнэ нараас Шажныг тодруулагч эрдэнэ хэмээх цол хамба ямба, гүйцэт очир жинс шүхэр нижгээд, дадар зургаа, бишгүүр хоёр, барсын сүүл дөрөв, улаан бөгтөг есийг хэрэглүүлэх болгожээ. 26-р онд хадаг хавтага, 7 эрдэнэ, 8 тахил, шил сав оруулжээ. 30-р онд жинч халсанд хойтын буянд 25 лангийн мөнгөн мандал нэг, мөнгө 50 лан, бага хадаг 50 хүж хоёр боодлыг буулгажээ.

Л.Чинбатын Огторгуйн чандмани хэмээс номноос эшлэвэл:

ЗАЯ БАНДИДА ЛУВСАН НЯНДАГ

Түшээт хан аймгийн Халхын умар замын баруун гарын зүүн этгээдийн ван Цэвэгрэмпилийн хошууны мэйрэн Банжуурын гэрт хувилгаан гарчээ. Найралт төвийн тэргүүн (1723) онд харьяат шавь нарт нийлүүлэн суулгажээ. Шашны эрдэм номд шамдан суралцаж, өмнөх хутагтаасаа олон зүйл уламжлан үйл хэрэгтээ тусгасан байна. Эл хутагтын 23 сүүдрийн гал могой жил (1737) Түвэдийн Баруун Зуугийн зүг залраад 6 он сургуулийг судалж,

29 сүүдрийн усан гахай жил (1743)-д өөрийн Халх орноо залран иржээ. Хойд хулгана жил (1744)-д хааны амгаланг эрэхээр бараалхан, хоёр оны нүүр хулгана жил (1744)-д цогчин агва ялгараад, Цастын орноо Дашлхүмбэ хийдийн дэг дэглэм их тиг ямарчлан нарийн нягтад тогтоожээ. Өөрийн Халх орноо хийдэд Жанрайсэг дүвчилийн зан үйлийг үүсгэн хурах нэгэн сүм байгуулсанд нэр айлтгах мөн түүнд үргэлжийн унших жасаа хурал, эрхэмлэн залж оршуулах шүтээн нэгийг хайрла хэмээн айлтгаснаар шинэ дацангийн нэр Ганданчоймпэллин, үргэлжийн уншлага Доржжигжид тэргүүтэн олон зүйлийн уншлагыг айлдаад Бурхан багшийн лим гүнда нэгийг залах шүтээнд хайрлажээ.

Энэ дацанд 4 цагт Жанрайсигийн чога дүвчид зэрэг жасаа хурал номын сургууль тогтоон дагажээ. Шавь ахуйн бүртгэлийг нарийвчлан хийж, хүрээ дуганыхаа зохион байгуулалтыг өөрчлөн өргөжүүлжээ. Манж чин улсын эзэн хаан Тэнгэрийг Тэтгэгчийн 2-р (1737) онд Зая хутагт Лувсаннандаг шавь захирах тамга олгожээ. Үүнээс хойш түүний харъяаны сүжигтэн олныг Зая бандида хутагтын шавь хэмээн нэрлэн, Сайн ноёны аймгийн Цэцэрлэгийн чуулганд захирдаг болов. Зая бандида Лувсангэлэгнамжил шавь, аж ахуйгаа эмхлэн зохион байгуулж, нутаг дэвсгэрийн зааг тогтоолгон, хилийн цэсээ Цэцэрлэгийн чуулганаар батлуулсан байна. Энэ хутагтыг ном эрдэмд сайтар боловсорсон учир Далай лам, Банчин эрдэнэ нараас “Шажныг тодруулагч эрдэнэ” хэмээх цол, хамба ямба, гүйцэт очир жинс бас бус зүйлийг хэрэглүүлэх болгожээ. Тэнгэр тэтгэгчийн 30-р (1765) онд жанч халсанд хойдын буянд 25 лангийн мөнгөн мандал нэг, мөнгө 50 лан, бага хадаг 50, хүж 2 боодлыг гаргажээ.

Зая Лувсанпрэнлайн товч намтар хэмээх түвд бичмэл судраас орчуулан эшлэвэл:

ЗАЯ ГЭГЭЭН ЛУВСАННЯНДАГ

Түшээт хан аймгийн Ван Цэрэнпилийн хошууны мээрэн Ганжууржавын гэрт төрсөн. 1723 онд Зая гэгээний хойт дүрд тодруулан өргөмжилсөн болой.

1733 онд Түвд оронд очиж ном эрдэмд 6 жил суралцаад онц боловсорсон учир Далай лам, Ванчин-Эрдэнэ нар түүнийг шашныг тодруулагч цол зэргээр мөн 7 эрдэнэ, 8 тахилаар шагнажээ.

Далай лам Чойр дацангийн сүм бариулж өгсөн байна. 1735 онд Манжийн хааны зарлигаар Лувсанняяндаг хутагтын тамга олгож хошуунаас нь тусгаарлан харъяат шавь ардыг захирах Шанзав яамны газрыг байгуулжээ.

1738 онд Жанрайсэгийн сүм, 1939 онд Ханчин сүмийг бариулжээ. Зая гэгээн Лувсанняяндаг 1765 онд таалал төгссөн ажээ.

Зая бандида Лувсанпринлэйн дараах хоёрдугаар дүрийн хувилгааныг хуучин үг, монгол бичиг зарим тэмдэглэлд Чингис хааны язгуур угсаанд төрсөн халхын чин ван Цэрэнпэлийн мээрэн Балжирын хатнаас Согтууруулагч хэмээх хөхөгчин хонин жилийн өвлийн эхэн сард (1715) сонин гайхамшигт бэлэг тэмдэгтэйгээр лагшин мэндэлсэн. Таван наснаасаа үсэг бичигт суралцаж Манжийн эзэн хаан Найралт төвийн анхдугаар он үзэсгэлэн үйлдэгч хэмээх харагчин туулай жилд (1723) аймшиггүй арслант ширээнд залж даншиг өргөжээ. Манж эзэн хааны зургаадугаар он шар бичин жилд (1728) манж эзэн хааны амгаланг айлтгасанд эзэн хаан баясгалантайгаар хадаг тэргүүтнийг хайрлан шашныг дэлгэрүүлэхийн билэг дэмбэрэлээр эрдэнийн шигтгээ бүхий хорол, гартаа барих эрх тэргүүтнийг хайрлажээ. Хоёрдугаар хувилгаан бээр арван найман насныхаа хар хулгана жилд (1732) ойрдын цэргээс зайлж Айбага хэмээх газарт залрахад эзэн хаан бээр асрал нигүүлсэлээр Асаа ханы амбан Наянтад элч илгээж явуулаад 500 лан мөнгө тэргүүтнийг хайрласан. Түүний дараа харагчин үхэр жилд (1733) Манж эзэн хааны амгаланг айлтгасанд. Бас хорин хоёр насныхаа гал луу жилд (1736) Тэнгэр тэтгэгч хааны амгаланг айлтгаад Түвдийн Үйзанд хүрч хамгийг айлдагч Галсанжамц далай ламд бараалхаж мөргөж сонсох, судлахыг айлтгаж соёрхолыг олоод тэнгэр тэтгэгч хааны хаан суусан эхний жил гал могой жилд (1737) Үйзангийн орон руу морилж тэр жилд Жунгаарын туслагч жанжин хошоо чин ван эпү Цэрэн таны газраас айлтгаснаар эзэн хаанаас мөнгөн цутгамал тамга намрын дунд сарын шинийн дөрвөнд хайрлавай. Хувилгаан бээр Гүнбүм зэрэг хийдүүдэд дараалан морилоод шар морин жилд (1738) Түвдийн Үйд морилж Далай ламын алтан нигуур лугаа учирч мөргөж, мөргөл адис айлтгаад сонсох судлахыг зохиосныг Жанжаа хутагт Ролбийдоржийн бичсэн Долдугаар Далай лам Галсанжамцын намтарт умард зүгийн шашныг тодруулагч Зая бандида хутагт бараа бологчтойгоо морилсонд урьд өмнө журам байхгүй ч өмнөх дээд дүр энэ зүгийн шашинд машид тус хүргэсэн байгаа донир тэргүүтэн дэргэдийн бараа бологч хар шар

хорь орчим хүн угтаж Найчүнгийн симхан дуганд бат оршилтой барилдсан хуримын дээр Зая бандида, гурван хувилгаан, Гэлэгдархан тойн тэргүүтэн Жэвзүндамбын Билэгт тойн, Жанжин вангийн Цогт дайчин тайж зэрэг бараа бологчид олноороо бараалхсанд мөргөл тавьж тус тусынх нь хэргэм зэрэгтэй таарсан бэлэг сэлтийг хайрлажээ. Зая бандидагийн хувилгаан бээр дахин ирж Намжил дацангаас Дүвжал ёсны насны зан үйлд шүтсэн даншиг өргөсний дээр бодитой бэлтгэсэн өргөлийг агуу ихээр өргөн өлмийн лянхуа зуун галавт баттай оршихын залбирлыг айлтагасан. Түүний адил жанжин эпү Цэрэн тэргүүтэн зарим ноёдоос айлтгалын бичиг жамжиг шүтээн тэргүүтнийг ч өргөсөн. Түүнээс гурван өдрийн хугацаанд Зая бандида хутагт голлосон зуун хорин таван шавь нарт гэцлийн санваар хайрласан. Хутагтад алдар нэр Лувсаннандаггэлэгнамжил хэмээн хайрлав. Сэрад сууж ном үзэхийн угт бурхан багш, Богд Зонхавын том дүр тэргүүтнийг өргөсөнд шашин амьтанд туслах сонсох, санахыг эцэст нь хүргэж зохиох хэрэгтэйн зарлиг сургаал хайрласан. Халхад дацан шинээр байгуулсанд нэр хийгээд гол шүтээний дүр хөрөг, үргэлжийн уншлага тэргүүтнийг айлтгахад дацангийн нэрийг Ганданчойнпэллин, үргэлжийн уншлаганд Балдорж Жигжэдийн чого, Сандуй, Дэмчигийн аль зохих, Цэвагмэд, Манлын чого, Шүтдэг сахиус Гомбо, Чойжил, Лхам, гол шүтээн, Бурхан багшийн дүр сэлтийг хайрлав. Хамт ирсэн Жанжин цэцэн чин ван зэрэг зарим ноёд хүмүүсээс гэдрэгээ буцахад нь зарлигийн хариу шүтээнтэй хавсарч буцаж явахын мөргөл соёрхол өглөг тэргүүтэн, Цогт дайчин тайж зэрэг хар шар арав орчим хүмүүсд хэргэм зэрэгт нь тааруулсан цол хайрлав. Тэндээс Зангаас Зая бандида хутагт хийгээд Санригаас эцэг Богд дээдсийг морилох сэлтэд уулзах, уулзуулах цайны суудал айлдвар яриа зарлиг асуулт тэргүүтнийг нарийвчлан хайрласан. Намжил дацангаас жилийн эцсийн дордог зэргийг үйлдэхэд шүтэн барилдлагаа сайтар жигдлэв. Шарагчин хонин жилийн 1739 цагаан сарын шинийн үүрээр Сэмчүнд Лхам сахиусыг урин залсан. Түүний дараа Их ордоны дээд давхарт Намжил дацангийн хуралд морилоод Балдан лхам бурханд тахил балин шүтээнийг өргөж ансал тэргүүтнийг дэлгэрэнгүй зохиов. Түүнээс хуучин Цомчинд хоёр өдрийн турш баясгалангийн хуримын дээр хуучин өлзийн найман тахилын эдлэл найман тэмдэгийг өргөх тэргүүтнийг урьдын журмын дагуу хайрлав. Тэндээс Зая бандидаагийн Шанзов тэргүүтэн гэдрэгээ буцахад нь буцахын мөргөл хайрласан байна. Зая бандидагийн Шанзовт Эрдэнэдархан хэмээх цол хайрлав.

Цагаан мичин жилийн (1740) цагаан сарыг уридын адил үйлдэж Зая бандидагийн бараа бологч унзад гэлэн Лувсаннамдолийн айлтгасны хариуд Лувсаншива ширээтийн төрөл дарааллын залбирал, Зая бандидаад шүтэх ламын налжирыг ч бас зохиож хайрласан. Цагаагчин тахиа жилийн (1741) цагаан сарыг урдах журмын дагуу өнгөрөөв. Тэндээс Сэрагийн Агваа бонлов аграмба Чойнжор бээр голлосон Агва дацангийн хурлынхан Сэраан ловон Ти дансар, Зая бандида хутагт зэрэг 1280 орчим хүмүүсэд Жигжид лха жүсүмийн даавуун зургийн хот мандалд даганг урд нь одуулж дөрвөн авшигийг ёнзог бүтнээр нь дэлгэрэнгүй хайрлав. Чүдод сарын дүйчэн өдөр Банчин тамжад чинбийн дээд хувилгаан Лувсанбалдан-Ешийг лавран жанцан томбод залж арслант ширээнд өргөмжилж шүтэн барилдлагаа жигдэлснийг ноён Полха, Дэдүг хамба Лувсанноров зэргийг илгээж Дээд хувилгаанд өлмий бататгах зохиол үйлсийг зүг хязгаарт дэлгэрүүлэх хэрэгтэйн ёсны захиа бичиг хийгээд Эрдэнийн мандал, тэнгэрийн эдлэл сэлт хийгээд лагшин, зарлиг, тааллын шүтээн, навс, ойрын хэрэгсэл, сайн хувцас, лавир, суудал сэлтийг хайрлав. Хар нохой жилийн (1742) цагаан сарыг өмнөхийн адил өнгөрөөв. Тэр жилд Зая бандида халуун рашаанд морилохын угт явах мөргөл, гагой хайрлав. Харагчин гахай жилийн (1743) цагаан сарыг урьдын адил өнгөрөөв. Зая бандидийн хувилгаан, Ноён цорж, жанжин вангийн лам зэрэг зуу орчим хүмүүст Зүгдор намжилма лха гүүн жинан Богд түүний зохиосон Годүгвийн сүнгийн тайлбар, Царчин Лосолжамцын айлдсан Лхаморигжидмаан дүвтав сэлтийн лүн хайрласан. Тэр үед хоёр өдрийн турш тавин дөрвөн ламд гэцэл санваар, Зая бандидын хувилгаан голлосон зуун далаад хүмүүст гэлэн санваар хайрласан. Зая бандидын айлтгасаны дагуу Чусан хутагт, Дэмо хутагт зэрэг цөөн хүмүүст Бажиг дүдлай намжилын ван даган сэлтийг хайрласан. Зая бандида хутагт, ноёд бараа бологчидод буцахын мөргөл нанжинг дэлгэрэнгүй хайрлаж гашаг тамга хамбын хэрэгсэл бүрэн гүйцэдийг хайрлаад Зая бандидын дээд дүр нь тавдугаар Далай ламын шавь болж байсан бөгөөд шашинд тустай дээд төрөлхтөн мөн байсныг сайшаан хувилгаан түүнд сонсох, санах, бясалгах гурав, заах, хэлцэх, туурвих гурвын үүднээс шашны үйлийг агуу ихээр үйлдэх хэрэгтэйг сануулсан сургаал хайрлаж байв. Зая бандидын бараа бологчоор явах Сэра жэ дацангийн равжамба Лувсанчойдарт Эрдэнэ цорж хэмээх цол хайрлав. Түвдийн Үй занд зургаан жил сонсох санахыг ямагт зохиосон ялангуяа үй зангийн хурлын уншлагын дэг дэглэм, гар тиг ян сүмийг нарийвчлан нарийн сайнаар суралцаад хар гахай

жилд (1743) судар, тарнийн шашин эрдэнэ нэг зулнаас нөгөө зуланд дамжин асахын ёсоор урин залахын адил өөрийн хийддээ мориллоо. Хөх хулган жилд (1744) Манжийн Тэнгэр тэтгэгч хааны наймдугаар онд амар мэндийг айлтгасанд шашин ихэд дэлгэрэхийн бэлэг дэмбэрэлээр эзэн хаан бээр баясгалантайгаар Хаан төрийн долоон тахил, өлзийт найман тахил тэргүүтнийг хайрлав. Хилэнт хэмээх хөхөгчин үхэр жилийн (1745) шинэдээр Сэра жэ дацангийн дэг дэглэмийн дагуу Сэра жэ хайнан дацанг байгуулж шашны дуазыг гурван газарт илтээр босгоод дээш дээш арвижуулан зүг бүхэнд дэлгэрэх боллоо. Түүний хойдох улаан бар жилд (1748) Дашлхүмбэ хийдийн доторх Балдан санаг жүд дацангийн чого чаглэн, дэг дэглэм, гар тиг ян сүмийн ёсоор Заяын хүрээ Гандангэжайлинд цогчингоос тасалж Санаг жүд дацан байгуулж нууц тарнийн түргэн мөр шашныг сэргээн босгоод дээш дээш нь арвижуулсан мөн. Арван гуравдугаар жарны гал туулай жилийн Сажон хэмээх хөхөгчин туулай жилийн хаврын дунд сарын шинийн арванд таалал төгсчээ.

ЗАЯ БАНДИДА ГЭГЭЭНТНИЙ 12-Р ХУВИЛГААН ЗАЯ ЛУВСАНЖИГМЭДДОРЖ

Монгол улсын шастир зарлигаар тогтоогдсон ван гүнгүүдийн 8-р бүлэгт 49-т бичигдсэн эшлэлээс:

Дөрөвдүгээр үеийн хувилгаан Лувсанжигмэддорж Сайн ноён хан аймгийн чин ван Чингүнжавын гэрт хувилгаан гарчээ. 35-р /100а/ онд харьяат шавьд нийлүүлэн суулгажээ. 39-р онд хоёр улирал дэвсгэр олгуулжээ. Сайшаалт Ерөөлтийн 7-р онд улбар шар бүрээстэй тэрэг, Жүн жан тянд ном уншихад Давхар дотоод үүдний дотор тэргэнд сууж оруулах хүрээний үүдэнд олон өнгө шөргөн хашаа байгуул хэмээжээ. 8-р онд жанч халсанд хойдын буянд мөнгө 300 лан, номын нөмөргө нэг буулгажээ.

Л.Чинбатын Богджавзандамба тамгатай хутагт хувилгаадын намтар ойллого Огторгуйн чандмани хэмээх номноос эшлэвэл:

ЗАЯ БАНДИДА ЛУВСАНЖИГМЭДДОРЖ

Сайн ноён хан аймгийн чин ван Цэнгүнжавын гэрт хувилгаан гаржээ. Тэнгэр тэтгэгчийн 35-р (1770) онд харьяат шавь нарт нийлүүлэн суулгажээ. Зая бандида Лувсанжигмэддорж Заяын хүрээг өргөжүүлэн Булган уулын энгэрт суурьшуулан төвхнүүлжээ.

Төр Гэрэлтийн онд энэ хутагт өөрийн хүчээр уул нутаг Норбулин хэмээх газар сүм байгуулж, Богд эзний түмэн өлзийд хичээнгүйлэн залбирч, сүмийн нэр шагнахыг гуйж айлтгасанд зарлигаар “Амгаланг хамгаалагч сүм” -ийн нэр шагнажээ. Энэхүү сүмд тогтсон хурал дөрвөн цагт зун, өвлийн адаг” хаврын эхэнд хурал мөн өдөр бүрийн сахиус нарын тахилга дүйцэн хурал номын сургууль тогтжээ. Лувсанжигмэддорж хутагт Сайшаалт Ерөөлтийн 2-р (1798) оны шороо эр морин жил 6 сарын 16-ны өдөр шашны уг үндэс хайлангийн зан үйл эхийг үүсгэн тогтоож, үүнд өдөр дараалан хурах үе завсрын их, бага дүйцэнгүүд дөрвөн цагийн тогтмол их хурлыг дараалан хурсаар шинийн хуучны хурал хүртэл байгуулсан нь тухайн цогчин хурлын тогтсон эх тойм төдийг монголчлон бичжээ. Энэ хутагтын 37 сүүдрийн үед өөрийн мутраар урлан бүтээсэн Балданлхам нөхөр сэлтийн их хөрөг олны мөргөх задгай газар залахыг Гэгээн тугдамд айлдан, олон

мэргэдээс асуусанд, урьдын заншлыг хааж, эрхэм нууц болгон залах болсноор 61 сүүдрийн модон хулгана жил (1804/-ийн цогчин их дуганы дотоод нандинд залаад, мөн урьдын адил их хөргийг дахин шинэ урлан бүтээх тухайд хийдийн лавринд залжээ. Гол их цогчин дуганд ерөөл, магтаалын хурал зэрэг номын сургууль тогтоон дагажээ. 39-р (1774) онд хоёр улирлын дэвсгэр олгуулжээ. Сайшаалт Ерөөлтийн 7-р (1802) онд улбар шар бүрээстэй тэрэг, Жүн ван тьянд ном уншихад давхар дотоод үүдний дотор тэргэнд сууж оруулах, хүрээний үүдэнд олон өнгө шөргөн хашаа байгуул хэмээжээ. Энэ хутагт 1803 оны намрын тэргүүн сарын шинийн 8-нд ном бясалгаж байгаад жанч халсанд хойдын буянд мөнгө 300 лан номын хөмрөг нэг буулгажээ.

Зая Лувсанпрэнлайн товч намтар гэх түвд бичмэл судраас орчуулан эшлэвэл:

ЗАЯ ГЭГЭЭН ХУВИЛГААН ЛУВСАНЖИГМЭДДОРЖ.

Сайн ноён хан аймгийн Чин ван Чингүнжавын хүү болон тэнгэр тэтгэсний 32 онд төржээ. Өвөг эцэг Эфүцэрэнгийн адил төр, шашны болон манжийн хааны үйл хэрэгт хүчин зүтгэсний учир зэрэг цол нэмэгдэж, Зая гэгээнд өргөмжлөгдөн 1802 онд Манжийн хаанаас түүнийг шар бүрээстэй сүйх тэргээр шагнажээ. Зая гэгээн Лувсанжигмэددорж Бээжинд Жүн-Вангийн ордны давхар хаалганы дотор тэрэгтэйгээ орж ном айлддаг эрх ямба бүхий том хутагт байсан байна. Тэрээр шашин амьтны тусын тулд олон боть ном зохиосон боловч сүм бариулаагүй байна. Тэр 1803 онд таалал төгсжээ.

Түүний хувилгаан нь Чингэс хааны язгуур угсаа Халхын чин ван Цэгонжавын наймдугаар хүүгийн ёсоор бүгдийг номохтгогч хэмээх улаан гахай жилийн шинэдээр сонин гайхамшигт ёр бэлгэстэй мэндэлсэн. Тэнгэр тэтгэгч хааны гучин дөрөвдүгээр он цагаан барс жилийн (1770) ширээнд залж даншиг мандал өргөсөн байна. Найман насныхаа хөх морин жилд (1774) эзэн хааны амгаланг айлтгав. Тэр эзэн хаан нь жаран жилийн турш хаан төрийг номын ёсчлон тэтгээд наян гурав, дөрвөн настай ихэд өвгөрснөөр хаан төрийг хүү Сайшаалт Ерөөлтөд улаан луу жилд (1796) залгуулсан байна.

Гуравдугаар дүрийн хувилгаан Лувсанжигмэددорж гучин долоон нас хүртлээ Үй занд залраагүйгээс биш шашин амьтны

тусыг ямагтад Лавран цогчин Агва хамцангийн ая дан, дэг дэглэм тэргүүтнийг сайтар нарийвчлан сурч чойрт ариун чойрыг байгуулж шашны үндэс болсон Ши сүм чогыг хуруулж байв. Номлол бүтээл, заах суралцах, анагаах ухаан, зурхайд суралцах лаваа ловнирыг нарийвчлан өмнөх ёс журмыг сэргээсэн нь ханьцашгүй юм.

Сайшаалт Ерөөлт хааны зургаадугаар он нохой жил (1802) амгаланг айлтгасанд Манжийн эзэн хаанаас Халхын чин ван эфү Лхаваандоржийн дүү Зая бандида хутагт Лувсанжигмэддоржид урд дүрүүдэд хайрласан шар сүйх тэргэнд сууж нийслэл хотод ирээд ном унш хэмээн зарлиг болгосон. Харагчин гахай жилийн (1803) цагаан сар гармагц хаврын тэргүүн сарын шинийн найманд таалал төгсчээ.

Хүн чийг үлсэхийг гэгдэн бодсон ч үлсэхгүй |
Хүн чийг үлсэхийг гэгдэн бодсон ч үлсэхгүй |
Хүн чийг үлсэхийг гэгдэн бодсон ч үлсэхгүй |

**Урьдын дээдсийн мөрөөр түвдэд заларч
Урсах гангын рашааныг нутагтаа салаалан
Агь тарнийн номыг эцэслэн агуйг сахигч
Аглаг даяанч Лувсан Намжилд залбирнам.**

АРВАНГУРАВДУГААР ХУВИЛГААН ЛУВСАНЖИГМЭДНАМЖИЛ

Монгол улсын шастир зарлигаар тогтоогдсон ван гүнгүүдийн 18-р бүлэгийн 49-т бүртгэгдснийг эшлэлээс:

Тавдугаар үеийн хувилгаан Лувсанжигмэднамжил Сайн ноён хан аймгийн ван Сампилдоржийн хошууны тайж Дамирангийн гэрт хувилгаан гарчээ. 13-р онд харьяат шавь нарт нийлүүлэн суулгажээ. Төр гэрэлтийн 9-р онд улбар шар бүрээстэй тэрэг олгуулжээ. 10-р онд их цэргийн хэрэглэлд хувиасаа тэмээ 130-ыг тусалсны учир торго гурван энтэйг олгуулжээ. 13-р онд харьяат шавийн нутаг Норовлин хэмээх газарт хувийн хүчээр сүм байгуулаад Хамгаалагч нэр олгуулжээ. Дараа басхүү Өлзийг бадруулагч нэр олгуулжээ. Бүрэнт Засагчийн тэргүүн онд булган дэвсгэр шагнан олгуулжээ. Бас Норовлин хэмээх газар сүм байгуулаад Бөх ерөөлт хэмээх нэр олгуулжээ. 6-р онд жанч халсанд хойтын буянд мөнгө 1100 лан буулгажээ.

ЗАЯ БАНДИДА ЛУВСАНЖИГМЭДНАМЖИЛ

Л.Чинбатын Богджавзандамба тамгатай хутагт хувилгаадын намтар ойллого Огторгуйн чандмани хэмээх номноос эшлэвэл:

Сайн ноён аймгийн Халхын умар замын баруун гарын дунд баруун этгээдийн буюу хожимын Зоригт засгийн хошууны тайж Дамирангийн гэрт хувиалан гарчээ. Сайшаалт Ерөөлтийн 13-р онд (1808) харьяат шавь нарт нийлүүлэн суулгажээ. Төр гэрэлтийн 9-р онд (1829) улбар шар бүрээстэй тэрэг олгуулжээ. 10-р онд их цэргийн хэрэглэлд хувиасаа тэмээ 139-ыг тусалсаны учир торго гурван энтэйг олгуулжээ. Хутагт Лувсанжигмэднамжил Үй Зангийн газарт заларч сургууль ном сайтар хийгээд эргэж залрахын үед хурал номыг ёсчлон сурч урин залж ирээд 24 сүүдрийн улаагчин гахай жил (1827)-д Булганы өврийн хийдэд тус бүрийн жанран барьж хурал номыг ёсчилон тогтоосон байна. Түгээмэл Элбэгтийн онд (энд оныг тодорхой бичээгүй байв) хутагт Лувсанжигмэднамжил Богд эзний түмэн өлзийг хичээнгүйлэн залбирч, ном унших учир уул нутаг Норовлин хэмээх газар сүм

бүтээгээд нэр шагнахыг гуйн Их журганаа уламжлан мэдүүлэхийг айлтгасанд, зарлигаар “Бүх ерөөлт сүм” хэмээн нэр шагнажээ. Дараа басхүү “Өлзийг бадруулагч” нэр олгуулжээ. Тогтсон хурал дөрвөн цагт Аюушийн чога, өдөр бүрийн жасаа хурал, сар бүрийн сахиус тахилга, дүйцэн хурал, ном тогтоон дагажээ. Бас Норовлин хэмээх газарт сүм байгуулаад “Бүх Ерөөлт” хэмээх нэр олгуулжээ. Бүрэлт Засагчийн 6-р онд (1867) жанч халсанд хойтын буянд мөнгө 1100 лан буулгажээ.

ЗАЯ БАНДИДА ХУТАГТ ЛУВСАНЖИГМЭДНАМЖИЛ

Д.Чулууны бичсэн Халхын Зая бандида гэгээн хэмээх номоос эшлэвэл:

Сайн ноён хан аймгийн Ван Сампилдоржийн хошууны тайж Дамраны гэрт төржээ. Тэр өмнөх хутагтын эдэлж явсан хувцас хэрэглэлийг эндүүрэлгүй таньж Хутагтад өргөмжлөгдөн ширээнд залагджээ. Төвдөд явж эрдэм номд суралцахдаа төв хэлээр чөлөөтэй сэтгэн бодож, ном зохиол туурвихын үлгэр жишээ үзүүлж байжээ. 1793 онд Занхан сүм, 1829 онд Дүйнхэрийн сүм бариулжээ.

1829 онд Манжийн хаанаас Лувсанжигмэднамжилыг улбар шарбүрээстэй жууз тэргээр шагнажээ.

1830 онд их цэргийн хэрэгцээнд хувиасаа 130 тэмээгээр тусалсан учир гурван эн торгоор шагнуулжээ. 1833 онд Норовлин уулын өвөрт /өлзий бадруулагч/ сүм бариулж байжээ. Мөн 1862 онд бүх ерөөлт нэртэй сүм бариулжээ. Лувсанжигмэднамжил 1867 онд таалал төгсчээ.

Зая Лувсанпрэнлайн товч намтар гэх түвд гар бичмэл судраас орчуулан эшлэвэл:

Түүний хувилгаан дөрөвдүгээр дүр нь бидний цог төгс лам дээд хувилгаан эрдэнэ Лувсанжигмэдчоглойнамжил нь Хангай хан хэмээх нурууны Түйн голын баруун эхийн орчим Чингис хааны язгуур угсаа гүн Дамдинжавын (Насан) хатнаас Мягмар хэмээх хөх хулган жилийн (1804) зуны эхэн сарын шинийн долоонд ням гарагийн довдон жорвоотой өдөр лагшин мэндэлжээ. Дөрвөн настайд нь арван дөрөвдүгээр жарны гал туулай жилийн хойд жил Сайшаал Ерөөлт хааны арван хоёрдугаар он шар луу

жилийн 1808 зуны эхэн сарын шинэдээр арслан ширээнд өргөн залж 50 лангийн мөнгөн мандал өргөж лагшин, зарлиг, тааллын шүтээнүүдийг өргөж байв.

Хойд жилийн намар Амарбаясгалант хийдэд морилж IV Богд Жэвзүндамба Лувсантүвдэнваанчүгжигмэджамцад бараалхаж мөргөв. Арван дөрвөн настайдаа Сайшаалт Ерөөлт хааны хорин нэгдүгээр он (1817) Манж эзэн хааны амрыг айлтгасан. Бас Манжийн эзэн хаан Төргэрэлтийн анхдугаар он цагаагчин могой жилд (1821) амгаланг айлтгаад хөх морин жилийн (1834) цагаан сарыг тэндээ зохиогоод Түвдийн Үй зангийн оронд хүрч Лхасын хоёр- Зуу болон Далай лам, Банчин Богдод бараалхан лаваа ловнир, сонсох судлах тэргүүтнийг айлтгаж соёрхолыг олоод улаагчин хонин жилд морилон явж Гүнбүм хийд тэргүүтнийг дайран Үй занд хүрч Цүлтэмжамц далай лам, Банчин Богд Лувсанбалдандамбийням чоглойнамжил тэргүүтэнд мөргөл айлтгалаар бараалхан Лхасын алдарт хоёр зуу тэргүүтэнд няндар тахил тэргүүтэнг өргөв. Сэра, Брайвүн, Гандан гурав, Лхас молон, Дашлхүмбэ зэрэг их бага хийдүүдэд манж дажа олныг өргөв. Банчин Богдоос гэлэн санваар залж олон номуудын зарлиг иш жанан ван тэргүүтэн хүссэн ном олныг сонссон. Бас Далай лам, Банчин богдын дэргэдээс Ганжуур номын лүн тэргүүтэн аль таалсан номын иш лүнг хүртэж таван жил хүртэл үргэлжид таалаад Банчин Богдод Гандангэжайлин хийдэд Галачакрааг байгуулахын сунтаг айлтгаж зарлиг соёрхлыг олж Дүйнхор ловон бидний Очирдара Гачин лам хийгээд чого чаглэн лугаа сэлтийг хорин дөрвөнийхөө гал гахай жил (1827) урин залж. Өөрийн хийдэд намрын дунд сарын арван гурванд морилсон. Түүнээс Дүйнхорын чого хийгээд Лүейвийн ёсны Дэмчгийн чого хоёрыг арван найман шавь нарт цээжлүүлсэн. Шар хулган жилд (1828) эзэн хааны амгаланг айлтгаж эзэн хаан бээр шарагчин үхэр жилийн хаврын тэргүүн сарын арван хоёронд урдах хоёр дүрийн хэргэлж байсан шар сүйх тэргийг хайрлав. Тэр жилийн хаврын адаг сард Цогт цагийн хүрдний Сачог дүлцон тэргүүтнийг үйлдэж бурхан багш Дүйхорын жүдийг айлдсан хаврын адаг сарын арван тавнаас долоо хоног Дүйнхорын авшиг хайрлав. Төргэрэлтийн арван хоёрдугаар он усан луу жилийн зуны эхэн сараас Норвуулин хийдэд эхлээд хөх морин жил, хөхөгчин хонин жилд хийдийн нэрийг эзэн хаанд айлтгасанд Гүндүцовилин хэмээн нэрлэжээ. Улаагчин тахиа жилийн (1837) намрын эхэн сард равнай үйлдэн Гэжайлин хийдийн журам ёсоор Гүдор чимийг хурах болсон. Лүейвийн ёсны Дэмчиг бурханы даавуун

зургын хот мандлыг байгуулсан. Лаврангийн симхан, симчүнд Дүйнхорын дуган Ондог жан, Уманжүгийн дуган тэргүүтнийг босгосон. Бас хувилгаан түүнийг шашин төрөөр тэтгэх Шанзодва Дармаад Манж эзэн хаанаас шар гахай жилд (1839) засаг болгов. Түүнээс хөх луу жилд (1844) Сэрхүг хийдийн Мамба дацангийн журмын дагуу намрын адаг сарын арван гурванд Мамба дацан Соригчимэднорвуулинг байгуулсан. Мөн Нүнай, Найжү, Цэдүв, Ритод зэргийг ч байгуулжээ. Манжийн эзэн хаан Түгээмэл Элбэгтийн анхдугаар он цагаагчин гахай жил (1851), хар хулгана (1852), харагчин үхэр (1853) энэ гурван жилд чулуун том хоёр суварга болон найман суврагыг дараалан байгуулсан. Хөхөгчин туулай жил (1855) хувилгааны шашин төрийг тэтгэх Шанзодва Балданцэрэнд эзэн хаанаас засаг болгов. Улаан луу жилийн хаврын дунд сарын арван нэгнээс хувилгаан өөрөө голлон торго тэргүүтнээр Майдар бурхан, Насны гурван бурханы дүр хөрөг хоёр томыг арав хоногийн дотор бүтээж дуусаад хорин хоёронд равнай өргөж Цогчин дуганд залсан байна.



АРВАНДӨРӨВДҮГЭЭР ХУВИЛГААН ЛУВСАНТҮВДЭНЧОЙЖИНЯМАА

Говь-савангад бичигдсэн үгсээс үзвэл, | Бүх дүрвэлс дүрвэлс үгсээс үзвэл, | Говь-саван
дүрвэлс үгсээс үзвэл, | Бүх дүрвэлс үгсээс үзвэл, | Говь-саван

**Хувилгаан журамт лагшинг эрхшээж
Хөг яруу зарлигаар олонд алдаршсан
Шоронд залравч энэрэхүйн таалалтай
Шамдалт дээдэс ЖамбаЦэрэнд залбирнам.**

ЗАЯ БАНДИДА ГЭГЭЭНИЙ ХИВ ДҮГЭЭР ХУВИЛГААН ЛУВСАНТҮВДЭНЧОЙЖИНЯМАА

Монгол улсын шастир зарлигаар тогтоогдсон ван гүнгүүдийн 18-р бүлэгийн 49-т бүртгэгдснийг эшлэлээс:

Долдугаар. Үеийн хувилгаан Лувсантүвдэнчойжинням тус шавийн зайсан Сономдоржийн гэрт хувилгаан гарчээ. 34-р онд харьяат шавь нарт нийлүүлэн суулгажээ. Дараа Богд гэгээнтнээс бурхан номын хувцас, шигсэр хадаг сэлтийг шагнажээ. Далай ламаас цагаан хүрээг шар болгож, лаврингийн баруун үүдэн дээр Баясгалан төгөлдөр бүхнийг тодорхой орд хэмээх ба хүрээний үүдэн дээр Хотол чуулганы есөн хүсэл цугларсан орд хэмээн цөмийг тарни, төвд, монгол үсгээр сийлж, гадуур хөвөөнд зургаан луу тойруулан үйлдэж хэрэгжүүлжээ. Монгол улсын олноо өргөгдсөний 4-р онд Шашин төрд туслах сайдаас хишиг зарлигаас хоцрогдсон гавьяа бүхий Зая бандида хутагт Жамбацэрэнд хишиг хүртээлгэхийг гуйж Дотоод яамнаас явуулан уламжлан айлтгасанд зарлигаар улбар шар хөшигт тэрэг шагнаж хэрэглүүлжээ. 5-онд орд сүмийн үйлдвэрт мөнгө туслан барьсан учир Төрөлх нэвтэрхий чин бишрэлт цол шагнаж хүртээжээ. 8-р онд Цогчин дуганы үйлдвэрт мөнгө туслан барьсан учир айлтгаад Номч мэргэн шадар бишрэлт цол шагнаж хүртээжээ. Мөн онд улсын санд мөнгө хариулан өргөсөн учир айлтгаад улбар шар жолоо шагнаж хүртээжээ.

ЗАЯ БАНДИДА ЖАМБАЦЭРЭН

Л.Чинбатын Богджавзандамба тамгатай хутагт хувилгаадын намтар ойллого Огторгуйн чандмани хэмээх номноос эшлэвэл:

Заяын шавийн зайсан Содномдоржийн гэрт 1905 онд хувилгаан гарчээ. 1909 онд харьяат шавь нараа захирах тамга хүртэж, бурханы шашны боловсролтой болж, улмаар Түвэд оронд очиж, ном үзэхийг ихэд хүсэмжлэж байсан боловч амжаагүй гэсэн байна. “Монгол Улсын Шастир” -т (59-р тал) шашин төрд энэ хувилгааны өргөсөн өргөл, гавьяаг үнэлэн шагнал хүртээсэн тухай тэмдэглэж: “Дараа Богд гэгээнтнээс бурхан номын хувцас, шигсэр хадаг сэлтийг шагнажээ.

Далай ламаас цагаан хүрээг шар болгож, лаврингийн баруун үүдэн дээр: “Баясгалан төгөлдөр бүхний тодорхой орд” хэмээх ба хүрээний үүдэн дээр “Хотол чуулганы есөн хүсэл цугларсан орд” хэмээн цөмийг түвэд, монгол үсгээр сийлж, гадуур хөвөөнд зургаан луу тойруулан үйлдэж хэрэглүүлжээ. Монгол Улсын Олноо Өргөгдсөний 4-р (1914) онд шашин төрд туслах сайдаас хишиг зарлигаас хоцрогдсон гавъяа бүхий Зая бандида хутагт Жамбацэрэнд хишиг хүртээлгэхийг гуйж Дотоод яамнаас явуулан уламжлан айлтгасанд, зарлигаар улбар шар хөшигт тэрэг шагнаан хэрэглүүлжээ. 5-р (1915) онд сүмийн үйлдвэрт мөнгө туслан барьсан учир “Төрөлх нэвтэрхий чин бишрэлт” цол шагнаан хүртээжээ.

8-р (1818) онд Цогчин дуганы үйлдвэрт мөнгө туслан барьсан учир айлтгаад “Номч мэргэн шадар бишрэлт” цол шагнаан хүртээжээ. Мөн онд улсын санд мөнгө хариулан өргөсөн учир айлтгаад улбар шар жолоо шагнаан хүртээжээ” гэсэн буй. Зая бандидын энэ дүрийн тухай нэгэн сонирхолтой мэдээ Оросын шинжилгээний ангийн ахлагч асан И.М.Майскийн “Автономит Монгол XX зууны гараан дээр” УБ 2001 номын “Зая гэгээн” гэсэн гарчигт буй. И.М.Майскийн анги 1919 онд Монгол оронд ирж ажилласан байх тул Гэгээнийг 14-15 орчим настай байсан гэжээ.

Харин Майский халхын Зая бандидын энэ дүрийг Ойрадын Зая бандидын хувилсан дүр хэмээн андуурсан байдаг. Ингээд уг номоос ишлэн сонирхуулбал: “Гэгээн шүүгээнээс зузаан орос ном гаргаж (номын нэрийг харж амжсангүй) номгүй хуудаснаас Сербид болсон байлдааны ажиллагааны зургийг гаргав.

-Энэ юу вэ? гэж тэр асуув.

-Бид зохих тайлбар өгөв.

-Аа тийм бий. Би газарзүй мэднэ шүү. Та нар харцгааж байна уу гэв.

Тэрбээр цаасан дээр Итали, Францын нутгийг дажгүй аятайхан зурав. Түүнийг зурахдаа Италид хаан, Францад ард түмэн төрийн жолоо барьдаг гэсэн санаагаа хавчуулж байгаа бололтой.

Гэгээнтэн өөр нэг шүүгээнээс Оросын газрын зураг гаргаж тэндээс мэдэхийгээ харуулах гэж байтал түүний шадар туслагчдын нэг нь яаруу сандруу орж ирээд чихэнд нь нэг юм шивэгнэтэл гэрийн найрсаг эзэн маань босон харайж яаралтай, гараараа дохин: -Эндээс явцгаа, явцгаа бушуу явцгаа миний багш ирж байна. Та нар түүнд харагдах ёсгүй. Би боломж гармагц хүн явуулна гэдэг байна...

Гэгээн элч довтолгон орос дугуйтай лацадсан захидал ирүүлснийг үзвэл” Бурханы” захидал байх бөгөөд түүнд кирил үсгээр монгол хэлээр “миний хиймэл ширэн чемодан, миний туслахын торон цамц хоёрыг энэ элчээр ирүүлнэ үү” гэсэн байв” гэжээ. Энд ишлэснээс үзвээс өсвөр насны энэ гэгээн тухайн цагийн бөглүү хөдөөгийн хийдэд суудаг гэхэд үнэмшимгүй боловсролтой харагдах ажээ.Тэрээр номын сандаа нэг бус орос номтой, Европын орнуудын түүх, газарзүй, улс төрийн тогтолцооны талаар тодорхой мэдлэгтэй, хэд хэдэн улсын газрын зургийг элдэв юм харалгүй шууд зурах чадвартай, тэгэхдээ төрийн байгууллын онцлогийг нь тусган харуулах мэдрэмжтэй, монгол хэлээр захиа бичихдээ тухайн цагт монгол газар огт ашиглаж мэддэггүй байсан кирил үсэг хэрэглэсэн зэрэг нэлээд боловсрол, чадвар, шаардах төвшинд хүрсэн байгаа нь харагдана. Тэрээр хожим нь цагийн эрхээр эрх ямба, цол хэргэмээс татгалзан жирийн хүний амьдралаар аж төрөхөөр шийдэж гэргий аван хөдөө гарч Тамир, Цэцэрлэгийн голоор хоёулаа ижилхэн жороо цоохор морь унаж айл хунараар бууж явсан гэдэг юм. Монгол улсын 1911 онд Жамбацэрэнг Нийслэл хүрээнээ авчирч эрдэм номд дахин сургах тухай МАХН-ын төв архивт буй бичигт: “Зая бандидыг засаж залруулахын тулд Нийслэл хүрээнээ дуудан, хүрээний хэргийг хутагтын багш Дарба бандида захируулан тохинуулах нь зүй” хэмээн дурдаж Сайн ноён хан аймгийн төлөөний түшмэл Доржпалам, Дамдин нар мутраа зурсан байжээ. МАХН-ын архивын ф-4, Т-1 хн. -14-д байгаа Зая бандидатай холбогдолтой уг бичигт дурдсанаар: “Зая бандида хутагтын биеийг Нийслэл хүрээнд ирүүл. Номын багшид чангалан, баримтлуулж зохицуулж, соён сургах, хойшийг цээрлүүлж, гэгээн түвэд удирдах зэргийг засгийн газраас эрхлэн гүйцэтгэхээр тогтоочухуй. Иймийн тул Зая бандида хутагтын эрх мэдлийг энэ удаа бүрнээ хасаж нийслэлд зарлан ирүүлж, энгийн лам нарын адил номын багшид өгч чангалан захируулж, соён сургах ба хэрвээ хаширч цээрлэхгүй эрх ямбаа эдэлбэл хүнд ялд унагамуй... Үүний тулд хичээнгүйн айлтгав” гэжээ.

1920 оноос хойш Зая бандидыг дөрвөн ч удаа баривчлан цагдаж 1924 оны өвөл дахин Дотоодыг хамгаалахын шоронд хоёр дахь удаагаа орж өвлийг өнгөрөөсөн ажээ. Хавар нь нутагтаа ирээд зунтай золгох гэтэл дуудаж, мөн Дотоодыг хамгаалахын шоронд “нууцыг задруулсан” гэх хэргээр зургаан сар суулгасан байна. Зая гэгээн 1925 онд засгийн газарт хандан бичсэн өргөдөлд: Жилээс жилд цагийн аяс муудан, хутагт хувилгаадыг

хялайн хавчих нь улам газар авч буй нь цөвүүн цаг хаалга тогших дохио гэмээр....” гэжээ.

Нэгэнт шар шувталж, эгэл хар хүн болж гэрлэсэн Жамбацэрэнг 1929 оны намар Цэцэрлэгийн голоос (Заяын хүрээнээс биш) дахин баривчилж 1930 онд цаазаар аваачсан байна. Зая гэгээнийг Нийслэл хотод авчиран одоогийн Сүхбаатарын талбайн урд талбайн өмнө этгээдэд буй Лениний нэрэмжит клуб буюу тэр үедээ Орос клуб гэгдэж байсан байшинд шүүх хурал хийж цаазаар аваачих ял шийтгээд буудан хороосон хойноо Маахуур Дамба гэгч хүнийг явуулж гэгээнтний “цогцсын толгойг таслаж авсан” ажээ.Сүүлийн Зая гэгээнтэн төрийн цаазанд автаж цаг бусаар жанч халсан оныг судлаачид 1930 эсвэл 1932 гэж янз бүрээр бичэн байв. Мөн төрсөн оныг нь 1905, 1906, эхийн нэрийг нь Лхамжав, Лхамсүрэн, эцгийн нэрийг нь Сономдорж, Содномдорж, эсвэл бутач гэх мэтээр бичсэнийг хойчийн судлаачид анхааран тодруулж бүрхэгдэлийг арилган тунгалагшуулна хэмээн итгэнэ.

Л.Хуушаан: “Төвшин билэгтэй Төвшрүүлэх сум” УБ 2004 номондоо: “Манай шавийнхан сүүлчийн Зая гэгээний ээжийг “Бааниа эмээ” хэмээн ахайлдаг байсан бөгөөд энэ эмээ 1950-аад оноос хойш Архангай аймгийн төвд амьдарч байв. Зая гэгээнийг Долгорсүрэн гэдэг бүсгүйтэй гэрлэж байсан хэмээн нутгийнхан ярьдаг байв. Мөн энэ эмээгийн ойрын садан бүсгүйтэй дотно харьцаатай байснаар Зая гэгээний (1928 оны орчим) хүү төржээ.

Гэгээнийг баривчлан аваачихад энэ бүсгүй хүүгээ дүүдээ өргүүлээд Цэцэрлэгийн голоос уул нутаг Бургатай руугаа 1930-аад оны орчим буцжээ. Зая гэгээний энэ хүү нь одоо наян таван настай Цэнхэр сумын Цэцэрлэгийн гол орчмоор нутаглаж буй” гэж бичжээ. Богд ба хутагт хувилгаадыг дахин тодруулахыг зогсоосон тухай” 1925 оны 2-р сарын 15-нд Засгийн газар албан ёсоор эцсийн шийдвэрийг гаргаж, Богд гэгээн зэрэг хутагт, хувилгаадын хойт дүрийг энэ өдрөөс эхлэн цаашид хүлээн зөвшөөрөхгүй болохыг мэдэгдсэн” гэж “БНМАУ-ын Үндсэн хууль, түүнд холбогдох зарим актын эмхэтгэл. УБ., 1972. 220 талд” нийтэлсэн байна. Энэ үеэс Монгол хувилгаадыг тодруулах Буддын шашны уламжлалт ёс тасарчээ. Харин ардчиллын шинэ үе эхэлж хүн амын шашин шүтлэг чөлөөтэй болсноор Зая хутагтын хойд дүрийг тодруулах уламжлал сэргэв.

Эрдэнэ Зая хутагтын хойд дүрийг тодруулах уламжлалт зан үйл нь 1909 онд VII үеийн хувилгаан Лувсандондовчойжиннямыг тодруулснаас хойш 1990 он хүртэл тасалджээ.

ЗАЯ ГЭГЭЭН ЛУВСАНТҮВДЭНЧОЙЖИЛНЯМ /ЖАМБАЦЭРЭН/

Д.Чулуун Халхын Зая бандида гэгээн товхимолоос эшлэвэл:

Сайн ноён хан аймгийн заяын шавийн нутаг Тээл гэдэг газар луу гүн ноёны хүү болон мэндэлжээ. 13-р Далай лам Түвдэнжамц түүнийг 4 настай нь тодруулан 1908 онд ширээнд залжээ. Ёнзон Гэлэгдорж лам, Дарва бандид Чойжүр Дондов ламаар ном заалгаж мэргэдийн зэрэгт хүрчээ. Зая гэгээн Жамбацэрэн 1914 онд Заяын дээд доод хүрээнд байнгын хуралтай 5 дацан, 23 сүм, 41 сан жастай, 2500 шахам ламтай, мөн 600 шахам шавьтай шашны сургууль байгуулжээ. 1918 онд Заяын шавийн нийт мал 70323 хүрч жасын хонь түм хүрсэн учир ган тулгатай байв. 1824 онд Заяын шавь 2400 өрх, 16169 хүн ам, 16 суманд хамрагдаж байжээ.

Зая гэгээн Лувсантүвдэнчойжилням буюу Жамбацэрэн 1914 онд улбар шар хөшигтэй сүйх тэргээр, 1915 онд төрөлх нэвтэрхий цэцэн, бишрэлт, 1918 онд товч мэргэн, шадар билэгт цол, улбар шар жолоогоор тус тус шагнагдаж байжээ.

1924 оны 12 дугаар сард шавийн төлөөлөгчдийн хурал хийж 80 төлөөлөгч оролцсоны 65-ын саналаар Засгийн газрын төлөөний түшмэл Гүж лам Батсуурийг Шанзовт сонгожээ. /Шашин төрийг нэгтгэн захирч удирдах яамны захирагчийг шанзов гэдэг байв/

1929 онд Жамбацэрэнг барьж хориход хураалгасан мал хөрөнгө, орд харш, алт эрдэнэс, цэмбэ торго, хадаг, хувцас зэргийн үнэ тэр үеийн ханшаар 23600 төгрөгийн зүйл байжээ.

Зая гэгээн Жамбацэрэнг ард олныг шашны суртлаар төөрөгдүүлсэн, Барон Унгернд уналга хөсөг тусалсан, ардын ангийн эсэргүү дайсан, шар харгисын нэгэн мөн хэмээн 1930 оны 2 дугаар сарын 20-ны өдрийн Засгийн газрын 8 дугаар тогтоолоор хуулийн дээд хэмжээгээр цаазлан хэлмэгдүүлсэн байна. /Зууны мэдээ 1999, №175/

Р.Өлзийбуян би, 1920- иод оны зун цаг Мухар хужиртын рашаанд Төвхөн хийдэд Зая гэгээн Жамбацэрэн залран ирэхэд аавтайгаа очиж мөргөсөн юм.

Тэр цагт Жамбацэрэн гэгээн халимаг үстэй, хар захтай бор саарал торгон дээлтэй, жөхөөн савхин гуталтай, цагаан царайтай залуухан хүн байлаа. Тэр үед Зая гэгээний шадар туслах нь Эрдэнэмандал сумын цагаан хэмээх Я.Шарав гэлэн байж билээ.

Тэгэхэд Төвхөн хийдийн хажууд 5 цагаан гэр барьсан, олон сүжигтэн мөргөлчин найр наадам болж байгаа мэт цугларсан байж билээ.

Тэр үед Жамбацэрэн хар болсон, эхнэр авсан, шинэ төрийн ёсыг дагаж явсан төрд харшгүй нэгэн байсан нь 1960-аад онд тодорхой мэдэгдэж байсан юм.

Д.Чулуун намайг 1960-70 онд Архангай аймгийн ҮЭ-ийн зөвлөлд албан үүрэг гүйцэтгэж байхад Жамбацэрэнгийн ээж Ваня гэж эмгэн байсан бөгөөд 80 насны ойгоо тэмдэглэж нэлээд хөлтэй найр болж байсан. Мөн Жамбацэрэнгийн эхнэр нь байсан Чангаанз нэртэй, жижгэвтэр биетэй, сэргэлэн цовоо хүүхэн эмнэлэгт ажиллаж байсан, Архангайн төв эмнэлгийн хүндэт самбарт “анхны сувилагч” гэсэн хаягтай зураг тавигдсан байж билээ.

Тэр Чангаанз Улаанбаатар хот яваад сураггүй болсон юм даг. Харин Жамбацэрэнгийн дүү нь Долгорсүрэн гэдэг эмэгтэй аймгийн төвд амьдарч байсан, одоо ч энх тунх байгаа байх.



Зүүн гараас: Зая бандида гэгээн Жамбацэрэн, Хүүхэн хутагтын гэгээн,
Егүзэр хутагт Галсандаш, Донхор хутагт Цэрэндорж, Дилов хутагт Жамсранжав,
Жалханз хутагт Дамдинбазар, Эрдэнэ хамба Лувсанданзан

ཅེས་བྱ་བ་འདི་ནི་རང་གི་སྐྱེན་

བཅེས་མཁའ་འགྲོ་སྐྱེད་དང་དབང་པོ་དོན་རྗེ་རྣམས་ར་ལ་ཇ་ཡ་དགེ་ཆུན་གི་ལ་འདོན་བྱེད་དགོས་པའི་ཆེད་དུ་དབང་ཆེན་རིན་པོ་ཆེས་ཇ་ཡ་ལྟོ་བཟང་འཛིགས་
མེད་ལ་བརྩམས་པའི་འབྲུང་རབ་གསོལ་འདེབས་སྐྱེས་ནས་དགའ་ལྷན་ཐེག་ཆེན་གླིང་གི་གྲ་བ་བ་གལ་དཀའ་བརྩུ་མིང་འཛིན་པ་འོད་ཉང་པ་ཡར་ནས་རབ་
ལྷུང་བརྩུ་བརྩུན་པའི་བྱང་ལུ་བཅེས་བྱ་པའི་ལྷགས་མོ་ཡོས་ལོ་གུན་ལ་རྒྱབ་བ་མའི་ཆེས་བཟང་པོ་གཉིས་པོར་བྲེས་ཡི་གེ་བཞི་རྒྱལ་སྐས་རྒྱ་མཚོ། ། **སངས་**
མཁྲ་ལྔ།། དགེའོ།།

**Ардчилалын ногоо монголд үрсэлж
Ардууд сүсгээр хойд дүрийг хайхад
Далай багшаас Архангайд энэ хэмээсэн
Данзанпүлжин Жигмэд дор залбирнам.**

**Учир шалтгаан бүрдсэн монголд
Уг санааг ерөөлчилэн бүтээсэнд
Зая Бандидын дүр бүхэнд залбирнам бид
Заяат дээдийн номыг дэлгэрүүлж адисла.**

Энэхүү төрөл тутмын залбиралыг Миний хамаатан Хандсүрэн, Бавуудорж нар Зая Гэгээнтний уншлага хэрэгтэй байна хэмээсний дагуу Гандан хийдийн Лам нарын адаг Гавж нэрийг зүүгч Ц.Отгонбаяр бээр Ванчин Богдын зохиосон Зая Лувсанжигмэд гэгээний төрөл тутмын залбирлаас ишлэн илжиг хэмээх Туулай жилийн өвлийн адаг сарын Шинийн 7-нд үйлдэв ээ. Үсгийг бичиж шивсэн номын санч Г.ЖалсрайЖамц.



THE DALAI LAMA

། ཁལ་ཁ་རྩ་ཡ་པརྩི་ཉའི་ཡང་སྲིད་མཚོག་སྐྱལ་སྐོར་བརྟག་བྱའི་ས་པོན་མིང་
 མོ་འཕྱོར་བ་ལྟར། བརྟག་བ་ཞིབ་ནན་བཀྱིས་བར། མེ་དང་པོ་དགོན་པའི་ཉེ་འབྲེལ་གྱི་
 བ་བཟང་པོའི་བྱ་བ་ཡར་ཐས་ཞེས་བ་མོ་སྐྱར་ཤིན་ཏུ་བཟང་པོ་གར་བས་བྱ་དེ་རྩ་
 པརྩི་ཉའི་ཡང་སྲིད་ཏུ་རོས་འཛིན་བྱེད། སྐྱལ་སྐྱུ་ནས་དམིགས་བརྩེ་མ་དང་། འཇམ་
 དབྱེད་ས་གྱི་གཟུང་ས་སྐྱགས་རྒྱན་གསོག་བྱེད་རྒྱ་དང་། སྐོབ་གཉེར་བྱེད་གལ་ཆེ། མཚན་
 བསྟན་འཛིན་ཕུལ་བྱུང་འཛིགས་མེད་ཅེས་འདོགས་རྒྱ་བཅས། སྤྱུའི་དགེ་སྲོང་ཏུ་ལའི་
 རྩ་མ་བསྟན་འཛིན་རྒྱ་མཚོས། བོད་རྒྱལ་ལོ་ ༢༡༢༩ རབ་བྱུང་ ༡༧ བའི་ས་ལོས་རྩ་ ༧
 ཚེས་ ༢༩ ཟ࿳་ལོ་ ༡༩༩༩ རྩ་ ༩ ཚེས་ ༡༠ ལ།



Төвд хэлнээс орчуулав.

Далай багш

Халхын Заяа бандидийн хувилгааны тухай Архангайн 15-25 насны 513 хүүхдийн нэрсийг үндэслэн авсан дагуу.

Нарийн шинжлээд Архангайн аймгийн газар нутгийг 16 хуваасны анхны хэсэг хийдийн ойрхон эцэг Самбуу хүү Баяртай хэмээх машид сайн төлөг гарсан тул тэр хүүг Заяа бандидийн хойд дүр гэж батлаж байна.

Хувилгаан Мэгзэм Жамъяангийн Сүн-аг үргэлж тоолох хэрэгтэй. Ном сурах чухалтай.


Алдар нь Дэнзан Пүлжин Жигмид нэр хайрлаж байна.

Шагзайн гэлэн Далай лам

Данзанжамцаас

Түвдийн 2126 он 17 дугаар жаран шороон туулай жил 4 сарын 26.

Европын 1999 оны 6 сарын 20-нд.



Архангай аймгийн Төгс баясгалант
буяндэлгэрүүлэх хийд

1997 оны 07 дугаар
сарын 25 ны өдөр

Дугаар 18.

Эрдэнэбулган

БНЭ Улсын Дарма сала хот.Буддын Шашны
Төргүүн Далай Лам танаа.

Халхын Зая Бандидаг
тодруулах тухай.

Монголын Анхдугаар Зая Гэгээнийг эхлэн 6 дүрийг Далай
Ламаас тодруулж байсан түүхтэй билээ.Ардчилал, шинэчилэл
хөгжисөн өнөө үед Монгол Улсд шашин дэлгэр ч байна.Иймд
манай хүрээг үндэслэн байгуулагч Зая Гэгээний 7 Р дүрийг
тодруулан залж өгхийг эрхэмлэн хүсч байна.Үүний өмнө сунтаг
шүүлдгэхээр таны дэргэдийн лам Жода ринбучи манайд ажиллаад
буцсан билээ.



Хамба лам

Дарга

Handwritten signature and date: 19/07

Г.Дамчаабадгар.

С.Жигжидогрэн.



МОНГОЛ УЛС
АРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

1997 оны 7 дугаар
сарын 29 ны өдөр

Дугаар 3/1022


Цэвэрлэн
хот

БУРХАНЫ ШАШНЫ ТӨРГҮҮН
ДАЛАЙ ЛАМ ТАНАА

Зая гэгээнийг тодруулах
тухай

Таны амар амгаланг айлтгая. Манай аймгийн бурханы шашны хийдээс Халхын Зая бандид гэгээнтний VII дүрийг тодруулж өгөх асуудлыг 1995 онд танд өргөн толидуулж байжээ.

Иймд манай аймгийн хийдийн лам хувраг сүсэгтэн олноос гаргасан хүсэлтийг ёсоор болгож Зая гэгээнтний VII дүрийг тодруулахад орон нутгийн төр, захиргааны байгууллагаас татгалзахгүй гэдгийг айлтган:




АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН

[Signature] Л. ЧАДРААБАЛ

Улаанбаатар

| | |
|----|-------------|
| 1 | Улаанбаатар |
| 2 | Дундговь |
| 3 | Хэнтий |
| 4 | Ховдговь |
| 5 | Хөвсгөл |
| 6 | Хөвсгөл |
| 7 | Хөвсгөл |
| 8 | Хөвсгөл |
| 9 | Хөвсгөл |
| 10 | Хөвсгөл |
| 11 | Хөвсгөл |
| 12 | Хөвсгөл |
| 13 | Хөвсгөл |
| 14 | Хөвсгөл |
| 15 | Хөвсгөл |
| 16 | Хөвсгөл |



Дээрхийн гэгээнтэн 14-р Далай лам Данзанжамцын
Зая гэгээнтний хойд дүрийг тодруулахад 16 хуваан үйлдсэн
Архангайн тойм газрын зураг



1992 онд Дээрхийн гэгээнтэн 14-р Далай ламтанд Жодо рэнбүүчитэй хамт бараалхан гэгээнтний хойд дүрийг тодруулах бичгийг гардуулж буй нь



Дээрхийн гэгээнтэн 14-р Далай ламын төлөөлөгч Архангайд 2 жил багшилсан Даваадаш лхаарамба

ЗАЯ БАНДИДА ХУТАГТ ЛУВСАНДАНЗАНПҮЛЖИНЖИГМЭД ГЭГЭЭНТЭН

Зая гэгээнтэн тодрох болсон шалгаан үр байдлын талаар авч үзвэл 1930 онд Жамбацэрэн буюу Зая лувсантүвдэнчойжиням гэгээнтэн тэр үеийн засгийн газрын тогтоолоор ялын дээд хэмжээ авч цаазаар аваачсан боловч Эжийдээ Байнаа хэмээх алдар хайрлан олон жил ганц гэр байлган Гэгээнтнийг эргэж ирдэг байсан гэж хуучилдаг байсан ба нутгынхан нь нөгөө талаас шоронгийн цоож гэмтээлгүй хүнд харагдалгүй гараад явчихдаг байсан учир шоронгийн хуягууд үйлээ бараад биднийг дарга нар тантай хуйвалдсан гэж алах гээд байна таны цаг болсон та үйлээ үүрээд хамаг амтаны тус бодоод томоотой байхыг гуйгаад тэгээд л цаазаар авахуулсан тэрнээс биш гэгээнтэн тэнд явж байна энд явж байна гэж байнга яригддаг хороогдсоноос хойш ч бас тиймэрхүү яриа гарч ард түмний сэтгэл зүрхэнд аврал болон гэрэлтэж айж ичэхээрээ гэгээнтнээ гэгээнээ дууддаг идээ цайныхаа дээдийг гэгээндээ өргөдөг байсаар иржээ . Нэгэн явган яриа хүүрнэвэл шавийн нэгэн адуучин аргамжаатай морио алдчихаад хойноос нь явган хөөж яваад аргамжааны үзүүр ойртохоор нь ээ гэгээн минь ЭЭ гэгээн минь намайг битгий явгалаарай гээд л үглээд морь нь холдоод явахаар зэрэг нь өө хөх зая өө хөх зая гэж загнаад байлаа гэх шиг гэгээнтэнийхээ алдрыг дуудахаас илүү авралгүй улаан засгийн үеийг туулж, ардчилалын үед шүтэх бишрэх эрх нь чөлөөтэй болсноор хөгчүүл ар Богд, Зая гэгээнийгээ яаж тодруулах залах тухай яриа гарч эхлэв. Энэхүү яриа газар авсаар 1983 онд Шашины дээд сургуульд элсэн орж 1987 онд төгсөөд Гандан хийдийн голч, Унзад гэх алба хашиж байсан намайг Чи жинхэнэ лам учираас хөөцөлдөх ёстой гэж Бүдүүн хэмээх Сүръяа овогтой Аюуш, Гэгээний жорвон Баатар, Д.Ломбо, Чойдор, С.Цэндхүү, Адилбиш, миний аав Г, Цэрэнбатаа, хотоос Жоомбой хэмээх М.Самбуу, Цоргон хэмээх Самдан гэвш нар манай гэрт цуглан Гэгээнтний дайчид хурж би ламтаж хурал хурсаны дараа тэд эхлээд саалиа хураахаар саваа хураа гэгчээр эхлээд зөвшөөрөл хөөцөлдөж хуралаа Сандуй хувилгааны сүмд нээхээр болж Д, Ломбо тэргүүтэй хэсэг аймаг орж хурал хурах

сүмээ зөвшөөрүүлэхээр Аймагийн дарга нартай Та нар хэнээс авчихаад хэнд харамлаад байгаа юм гэж заргалдсаар байж бүтээж 1990 онд хурлаа хурж эхэлсэн. Түүний дараа Би Бакула багшийн ивгээл дор Энэтхэгийн Дарамсалаад Далай багшийн намжираа дацанд Жадо багштайгаа хамт дүйнхорын ном үзэж эхлэв. Энэ үеэр Миний аав Г.Цэрэнбатаагаар Далай Багшид гэгээнтнийг тодорлуулах Буян дэлгэрүүлэх хийдийн анхны бичгийг 1992онд дамжуулан бараалхуулаж байв. Дээрхийн гэгээнтэн маш их болгоомжтой хандан танай хуулинд хувилгаан тодруулахыг хорисон хууль хэвээрээ гэж би дуулсан тиймээс заавал төрийн байгууллагын зөвшөөрсөн бичиг байхгүй бол дараа нь асуудал гарна гэж айлдсанд буцаж аймгийн зохих шатны байгууллагаас бичиг аван дахин өргөсөнд Дээрхийн гэгээн Найчин болон Гадон Чойжингоо буулгаж хаана төрснийг нь эндүүрэлгүй тодлон Архангайдаа төрсөн байна гэж соёрхсон. Түүний дараа Сира хийдтэй урьдын барилдлагаар холбоо тогтоон ажлын хэсэг байгуулагдан төлөвлөгөө гаргаж авснаар ажил жигдэрч урагшлав. Сира хийдийнхэн урьдын үүх түүхийг судлан гаргаж уйггүй хөөцөлдсөний дүнд Жадо Ренбучи, Гэвш Түвдэндаши, Намжил дацангийн их лам Агваанжамц , Донсон, Агваансамдан нарын лам нарын бүрэлдэхүүнтэй хэсгийг архангай аймагт 12 хоног явуулан газар байдал болон хийдүүд тэй танилцуулан тойм газрын зураг хийлгэсэн бөгөөд тэр газрын зургаар Далай багш баримжаа авч 16 хуваасны анхны хэсэг буюу заяын хийдийн ойролцоо гэдэг дээр тогтон тэнд төрсөн 1970 оноос 1985 онд төрсөн бүх хүүхдийн 1658 нэрийг авч төрсөн он сар өдөр аав ээжийн нэрс нас хүйстэй анкет бүрдүүлэн би өөрийн биеээр Далай багшид гардуулсан юм. Хэсэг хугацаа өнгөрсний дараа намайг гүгэр эгцанаас дуудаж анкетийг эр эмээр нь дараа нь гахай, луу, үхэр жилтэнгүүдийг ялган бичих ажилд оруулан 154 хүүхэд үлдсэн шиг санагдаж байна түүнээсээ дахин ямар шалгуураар орсныг нь бүү мэд Сира хамба надад хэлэхдээ одоо 50 хүүхэд үлдсэн ажлыг 100% гэж үзвэл 90% болсон шүү гэж хэлээд нэг хэсэг чимээ тасрав . Архангайн гэгээнийгээ хүлээсэн өвгөчүүл тэн хагас нь тэн хагас нь ертөнцийн мөнх бусыг үзэж зарим нь намайг жинхэнэ Далай ламд бичгээ өгсөн биз гэж эргэлзэж эхэлсэн үе боллоо. Энэ тухайгаа Пакула багшид айлтгасанд бас санаа нь зовж Архангайд очиж Жигжэдийн жинан өгөнгөө цааш чулуут сум орж Сүхээр хүний толгой уруу

цохидог Пүжэ хүүтэй уулзахаар намайг эхлэн явуулж дараа нь өөрөө дуудаж уулзан анкетийг бүрдүүлэн дипломат шугамаараа Далай багшид албан бичиг хүргүүлэв . Үүнийг дуулсан нутгын түмэн би ч мөн Тэр ч хойд дүр мөн гэж яриа гарав бөгсөндөө очиртой хүн ч би болж ид шидтэй хүмүүс огцом нэмэгдэв . энэтхэгт сурч буй монгол хүүхдүүдийн зарим эцэг эх хүртэл Далай багшийн гүгэр эгцанд анкет бүрдүүлж өгсөн байдаг.Гэтэл архангайн хийдийн Лувсан гуай хүртэл Заяын хойд дүр хэмээн нэгэн хүүг хийд дээр суулгав. Ингэж замбараагүй болох тийшээ хандаж эхлэж буйг Далай багшид айлтгахад сайн Гэвш Лхарамба Даваадаш багшийг архангайд ном заалгуулахаар томилож намайг бүх зардлыг хариуц гэв. Тэгээд Даваадаш лхарамбийг би өөрийн зардлаар гэртээ авчирч хэд хонуулаад архангай аймагт аваачин хэдэн хүүхдүүдтэй харилцаж чадах хүртэл би 3н сар гандангийн да ламын ажлаа орхин байж архангайд буудлаар хоноглож байлаа. Тэгээд 3 жил ном архангайн хүүхдүүдэд заалгаад өөрийн биеэр Дарамсала хүргэж өгөв. Гэтэл нэг өдөр Гүрү дива ренбучи намайг дуудан одоо нэг асуу болохгүй бол бид нэг аргаа олно доо гэж хэлсэн би Дарамсалаа уруу лавлан асуухад бараг бэлэн болж буй баярт мэдээ сонслоо. Тэгээд ч удалгүй есөн жил хөөцөлсөний үр дүнд 1999 оны зуны эхэн сард Жадо ренбучи монголд ирмэгцээ онгоцны буудал дээрээс намайг сураглан дуудуулсан байлаа. Би хөдөө ойрхон явж байснаа гэнэт буцаж жадо багшид бараалхвал за чиний мөрөөдөл биелэсэн хувилгаан тодорсон гэж баярлуулав. Ингээд залахаар хамба Д.Чойжамц Жадо ренбучи Түвдэндаши бид дөрөв хамбын машинаар архангай зорьж Заяын симчин дуганд хүмүүсийг цуглуулан хуралдаж Жадо багш дугтуйг задлан Самбуугийн Баярт хэмээн уншихад тэсэлгүй би гүйж очин дугтуйт бичгийг дахин дахин харж билээ. Тэгээд овог нэр таарсан дөрвөн хүн байснаас Цагдаагийн орлогч дарга С, Базаррагчаа бичиг баримтыг шалган байж ямарч эндүүрэл үгүй тодолсон Энэхүү тодорх цаг хугацаа нь зүй зохисоороо болж буй нотлох нэгэн баримтыг дурьдваасу: билиг дэмбэрэл дэгнэхийг эрхэмлэн үзэхүйн үүднээс засгийн газрын архивт эх нь хадгалагдаж буй Богд живзүндамбийн төмөр хайрцагны ном хэмээх 18 зүйл бүхий бичгийн зөвхөн нэгэн хэсгийг Эрдэмтэн Аким гуай Б.Тунгалагаар крилл үсгэнд хөрвүүлүүлэн Цог сэтгүүлд гаргасныг уг эхтэй нь дахин тулгаж хэл бичгийн ухааны эрдэмтэдээр хянуулан ямар нэгэн найруулгагүйгээр бичсэнээ сонордуулья.

Богд Жавзандамба хутагт монгол улсын хаан сууж байхдаа 1924 онд таалал төгсөв.

Орд харшид эд хогшлыг хурааж дансалсанаа тэмдэглэжээ. Гэтэл нэгэн жижиг төмөр хайрцагтай юм гаргасанд задалж үзэх хэмээвээс түлхүүр нь үл олдох тул нярав байсан Дамдинг баривчилж ял тулган байцааваас Дамдины хүзүүнээс булигаар гэртэй түлхүүр гарсныг авч уул хайрцгийг задлан үзвээс арван найман зүйлийн гэрээ бичиг байв. Энэ гэрээ бичгийн үндсэн зүйлүүдийг ирээдүй цагт гадаад улстай 1, 2, 3 дугаар цуст дайн болох тухай хэлэлцэн тоймлон тогтоосон байв.

1. Энэ 3 дугаар гэрээ бичгийг бадаргуулт төрийн 18-р оны үед (1892 он) Утайн таван үзүүрт ууланд дэлхийн 5 гүрний хаадууд болон богд хутагтуудын хамтаар чуулган чуулж 3 дугаар гар бичгийг баталжээ. Энэ таван гүрний хаадын болон Ванчин богд, Далай лам, Сажи богд, Жавзандамба хутагт, Дамбийжанцан богд эдгээр хамтаар байж гар бичигтээ дурдсан нь : халх монгол оронд төмөр хулганаас усан бичин жил /1960-1992 он/ хүртэл халх монголын хойд зүгээс хүний дүрстэй адууны байдалтай олон янзын шар нүүртэй \ Си яан \ хэмээх нэртэй хүмүүс ирж монголын Цогт эрдэнийг булаан авч энэ үед эм хүмүүн төрийн эрхийг баримой. Лам хүн цэрэгт мордмой, Мөн лам хүн хар хүний боол болно. Ноён хүмүүс нохой мэт болно. Ядуу гуйлгачин хүн түшмэд болно. Худалдаачин хүн зарлага болно. Хууль байвч дагах хүнгүй. Ном байвч унших хүнгүй Уншдаг байвч цөөхөн, тэр цагт хүрээ хийд байвч цэрэг түшмэдийн балгас болно. Энэ цагт Монголын шашин төр төдийхөн болно хэмээсэн зарлиг бичгийг хаадын чуулганд өргөн мэдүүлээд 5-н гүрний хаадын чуулган богдуудын хамтаар 18 гэгээд 81 шидтэний хамтаар дагалдуулан ирүүлж. Ирээдүй цагт ямар ямар байдалтай болохыг тодорхой хэлэлцэгтүн хэмээснийг ёсоор болгон хэлэлцжээ. Эдгээр 81 шидтэний хамтаар Жагар, Намхай Бодалагийн орноос 12 хэлмэрч залж ирээд эдгээрийн хамтаар хэлэлцсэн нь Халх монгол орны Цогт эрдэнийг баруун хойд зүгээс оросууд ирж сая булаан авсны дараа ямар ямар болохыг дахин өгүүлснийг авч хэлэлцэгтүн хэмээн зарлиг буулгасан

нь Богд Жавзандамба хутагт халх орныг төмөр хулгана жилээс усан хулгана жил хүртэл даах, дараагаар нь гал барс жилээс төмөр морин жил хүртэл Заяын гэгээн даах, мөн түүний дараагаар өмнө зүгт хятад орны газарт төмөр морин жилээс эхлэн Жан -Зүй-Лин, Ү-Фи-Фүйн таван үед хямран байлдахад Жанжаа богд өөрийн биеэр эвсүүлнэ . Мөн түүний дараа хятад орны чанад буй Япон хэмээх нэгэн хүчирхэг гүрэн хятад орныг боолчилон улмаар Монгол орны зүг халдахаар төмөр хонин (1931 он)жилийн намрын эхэн сарын 10 ба 15, мөн сүүл сарын 22 ба 25 -ны өдөр Монголчууд Тан Шан улсын хавчилгаар хямран байлдах болно. Тэр үед Дамдин Дорлиг бурхан төрмой. Энэ үеэр тэнгэрийн дуу их ба салхи гармой, газар хөдөлж хүний сэтгэл номхотгомой. Эс бол хүний сэтгэл аяндаа номхорно хэмээн хэлэлцсэн бичгийг дэлхийн 5-н хаадын чуулганы 6-р зүйлд өргөн мэдүүлэв. Хутагт та нар Халх Монгол оронд ямар ямар бэрхшээл тохиолдох ба чухам аль аль орнуудад ямар болохыг дахин хэлэлцэгтүн хэмээн зарлиг айлтгасанд олон богд хутагт тэр ихэс нарын чуулганаар хэлэлцэн тогтоосон нь:

олж хойш залаад, сахиул чойжан Бэгзийн гүгийн хамт сандогт батлан залсан болой. Тэндээс бас ч илэрхий гайхамшигт тэмдэг үзүүлсэн нь гэгээний хоёрдугаар Богд Балдан-Эшийг³⁴ Бээжинд залрахын замд тосож бараалхахын хойгуур гэгээнд Пүрэвийн самдогоос ус нэвтрэн ихэд гоожихуйд гонир сандран харангаа авч тоссонд харанга дүүрсний даруй тамга хадгалсан хутагт лам Пэлдин хэмээхэд айлтгасанд, би мэдэхгүй миний мэтийн аманд багтаж өгүүлэх өчүүхэн юм үгүй. Урьд Банчин Лувсанжанцан-Эшийг нирваны дүр үзүүлсэн цагт энэ пүрэвээс хоёр харанга дүүрэн ус гарсан аж хэмээн айлдсанаас, удсангүй Банчин Балдан-Эши Бээжинд нирваны ёс үзүүлснийг сонсчээ. Түүгээр бөгөөс энэ пүрэв мөн Дарачирэвийн пүрэв лугаа ялгалгүй илэрхий гайхамшигт шүтээн мөн ажгуу. Нандин логоширийг³⁵залсан он нь мөн хоёрдугаар гэгээн Далай ламын зарлиг бошог ба тухайн Сэра хийдийн тэргүүн хамба эхлэн мэдээчинд шүтэж залах учрыг гаргаж дуртай шүтээнийг залах зөвшөөл соёрхлыг олоод, Сэрагийн дуганы олон шүтээнийг хийгээд мөргөхдөө логошири, үүнийг залсугай хэмээн тусгайлан өмнө нь мөргөх цагт логошири би өдгөө одсугай хэмээн зарлиг болж, зөн өлмийгөө өргөсхийн одохын завдлыг үзүүлсэн шүтээн, үүнийг гэгээний бие, цагаан зандан сандайбаян, улаан занднаар бүтээж адистадат шүтээнд орон хийддээ залж ирсний дараа хулгана жил(1684он)-д Галданы самуун³⁶ цэргийн хөл болохын цагт гонир нь энэ шүтээнийг үүрч, зүг чиггүй зайлан явахуйд нэгэн цагт бурхан дуун гаран хөл өдгөө намхарав гэдрэг буцсугай хэмээснээр гонир мөн үүрсээр эгэж ирсэн нь тодорхой ажгуу. Энэ шүтээний гэгээн биес угаас алтан будаг өргөсөнгүй, өөрийн өнгөөр оршсоныг гутгаар гэгээн Живзундамбын дөтгөөр дүрд³⁷ бараалхах цагт ядам логоширид будаг өргөж болохгүй. Логоширид алт өргөж болно. Халхын шажин дэлгэрэхэд логошири түүний адистад ач их хэмээн айлдаад, төө алтан пүрэвийг хайрласнаас үүсгэж алт өргөжээ.

Бас шүтээнийг эрхэн Ядам янсангийн суумал биеийг бүтээж байгуулсан ёс нь, мөнхүү хоёрдугаар Богд гэгээн цаст Түвдийн орноос залж ирсэн Ядамын нандин хөрөг ба пүрэв логошири тэргүүтнийг өнөд оршуулан залах сэржи хайлан дацан шинээр байгуулах ба ядамын аймгийн уншлагын ном нарийн нууцыг тогтоон, ялангуяа басхүү Ядам Бадма янсангийн их суумал гэгээн бие босгохыг ихэд тогтомнон өөрийн шавь Эрдэнэ лам

Ням хэмээхэд -Чи миний Ядам бурханыг их хамаг урлан бүтээж үйлдэж босгогтун хэмээн айлдсанд, тэр Цорж лам миний гарын урлах чадал өчүүхэн тул чадах үгүй хэмээн айлтгасанд, Гэгээний зарлиг, яавч чи бүтээх хэрэгтэй хэмээн хүнд зарлиг тушаавч тухайд цааргалан байж даруй зуны тэргүүн сарын шинийн наймны шөнө ламын зүүдний мөрд өөрийн байшингийн ард хөндөн урлаж болох улаан шороон овоо цоморлиг байснаас гал бадраад, байшин хашааг цөмийг гал дүүрсэнд өөрөө арайхийн зугтааж гарав хэмээх явдлыг сэрсэн даруйд огторгуйд харж үзвээс, үүр сая гэгээрчээ. Тэр зүүднээс аюун сэжиглэж аврал айлтгаар Гэгээний лавринд бараалхан зүүдэлсэн тухайг айлтгах цагт, унасан шороон овооноос гал бадарсныг умартаж эс айлтгасанд, Гэгээний зарлиг, чиний байшингийн ард улаан шорооны овоо буй юу, үгүй юу хэмээн айлтгаснаар, сочин санаж их гал чухам тийм шороо байснаас бадран үүссэн бөлгөө хэмээн айлтгасанд, Гэгээнтэн машид мишэлзэхийн дүрээр өдгөө сайн сайн. Миний зүүдэнд басхүү баруунтаа чигт болоод улаан хий үймж, Хүрээнд орж ирээд, чиний хашааны үүдээр орон, байшингийн ард дахь улаан шороо цоморлигт нэг байсанд шингэв хэмээн зүүдлэв. Чиний байшингийн ард юу байхыг би эс үзсэн бөгөөд бид хоёулан зүүдэнд зэрэг тохиолдсон нь илэрхий дээр би урьдын Ядам бурхан урлах үйлийг чамд тушаасаар бөгөөтөл энэ мэт Ядамын янсан бодитой залрахын дэмбэрэл зүүд болсон тул даруй тэр овооны улаан шороогоор бурханы биеийг босгож бүтээх хэрэглэй хэмээн айлтгасанд, Эрдэнэ лам ч их бишрэлээр лавлан санаа шуудаж, Ядам бурханд зүрхнээс залбиран овооны улаан шороогоор бурханы биеийг машид шамдан босгож төгсгөсөнд, Гэгээний зарлиг Дамдин янсангийн нүүрнээс бусдад алтан будаг өргөх хэрэггүй, мөн улаан шорооны өнгөөр орштугай равнай эс өргөвч болмуй хэмээн айлтгажээ. Тийнхүү нүүрийн гэгээнд алтан өргөөгөөд будаг өргөхийг завдтал огт салхи үгүй цаг бөгөөтөл гэнэт их хий дэгдэн шороо будаг хийсгээд будаг өргөж эс болвоос, түүний хойно дахин гурвантаа өргөхийг завдавч цөмд урьдын адил их хий дэгдэн босохуйд хойно алтан өргөсөн болмуй. Мөн Ядам шүтээн үүн нь анхдацанд залах замд хашааны өнцөг тохиолдож мутрын нэгэн чигчий шилжин унасанд олноор аюулзан дахиж орлох эсэхийг Гэгээнд айлтгасанд гэм үгүй буй за. Тэр мутрыг алганд нь тавь хэмээсэн зарлигаар айлдсанд, маргааш

нь бүгдээр үзэхүйд урьдын янзаар бүтээжээ. Тэр мэт гайхамшиг үзэгдэл олон болсон болой.

Шүтээн үүн нь оршсоны өчүүхэн товч, Хүмүүний эрхэт Баатар чин ван³⁸ барс жилтэй. Жил, сар хоногийн гурван барс тохиолдсоны барс цагт бүхий газрын өндөр баримжаад уул бүхэл сарын оройгоос авсан болой. Бурхан үүнийг бүтээсэн Эрдэнэ лам хэмээх тэр хоёрдугаар гэгээний бодит шавь бөгөөд хоёрдугаар гэгээн мөн Ядам раншины ван авшигийг үндэслэсэн ловон аж. Тэр тухай Гүшүг дацангийн шавь нар мөн дагалдан ван жинан эши хөтөлбөрийг сайтар олсон Ядам янсангийн үргэлжийн уншлагыг үйлдүүн, сонсох, санах бас бүтээлд шамдан хичээжээ. Басхүү дээд төрөлхт түүний зүүдний мөрд залбирлын цагаан хүрээнээс Ядам бодитой зүүн тийш залран дацангийн баруун талд хүрэх үе мөн Эрдэнэ ламын өмнөөс шогдон сэлдэн Гэгээнд уулзав хэмээсэн нь ядам зүүдэнд буусан болой.

Басхүү гэгээнтэн Эрдэнэ лам хоёулаа нэгэн өндөр уулын оройд заларсанд Эрдэнэ ламд айлдсан нь, баруун зүгийн дээдэд харж үзэн юу үзэгдмүй хэмээсэн зарлигаар, лам дээш ажиглан үзвээс, солонго адил орд харшийг үзэж айлтгасанд чи машид хувь төгөлдөр аж. Орд харш тэр Жанрайсэгийн хот мандал мөн хэмээн айлдсан болой. Нандин эдгээрийн эрхэн учрыг огт олж харсангүй, нуруу бүтээл төдийг нинжүдээс эвлүүлж бичсэн (нь энэ) төдий бөгөөд тухайд Сэржавд чойр шинэ цүгэлсэн үе төдийн товч нь, Тэнгэрийн тэтгэсний тавиндолдугаар он, Хоёрдугаар гэгээн дүрийн хорин долоон сүүдрийн Усан эм үхэр жил (1793 он)-ийн намрын сүүл сарын арвандолооны эхлэн цүгэлсний лам нь Эрдэнэ Ранжамба, гэбхүй нь Балбан хэмээх бөгөөд эдүгээ дөтгөөр дүрийн зарлигаар уг эхийг тодорхойлон, Түгээмэл элбэгтийн дөрөвдүгээр он Модон эм туулай жил (1855 он)-д хүртэл дацан тогтсон нэгэн зуун есөн он, чойр цүгэлсэн нь жарангурван он болсон болой. Булган уулын өвөрт дацан байгуулж хурдаг хурал жилийн найман чойр, өдөр бүрийн дамжаа, сар бүрийн дара эхийн дүйцэн, өвлийн дунд сард Санжидмомолочинмо³⁹, мөн энэ дацангийн Бадмайогийн сүмд⁴⁰ дөрвөн цагт дүвжид хавар намар ганшаг⁴¹, өвлийн адаг сард бадмайогийн уритал, сар бүрийн шинийн найман, арван таван, битүүн нарт их дүйцэн өдөр бүрийн жасаа, мөн энэ дацангийн Дара эхийн сүмд⁴² өдөр бүрийн жасаа хурал номын сургууль тогтоон дагажээ.

Гүшүг дацангийн тогтсон эх товч адилгүй, Ачит гэгээний хувилгаан гэгээн дүр ариун Цастны орноо ухааны таван оронд мэргэшсэнээр асар хэтэрхий гол ёсыг өгүүлэгч хэмээх алдар нэр өргөмжлөгдсөн Их бандидын бие өөрийн гучин найман сүүдрийн эр Шороо хонин жил (1679 он)-д Үй Зангийн газраас эхэлж эн тэргүүн Халх орноо заларч ирэхүйд орон нутгийн ихэс ноёд эхлэн угталцан мөргөсөн олны дотор Их тойн Данзан лхаван өөрийн хан эцгийн хувилгаан хэмээн бишрэн мөргөснөөр Булган уулын өвөрт бүхий бяцхан хийддээ залаад хүссэн номуудыг хүртэж хийд сүмээ бүрмөсөн өргөх цагт үргэлжийн жасаа болгож сурах их Манлын чога ба Аюуш бурханы насны бүтээлийн сүмээ хамт дагалдуулан харьяат албат нарын дотроос жаран баялаг өрхийг сонгож өргөн, тавиглал үйлдвэрд бэлтгүүлрүүн үүрдийн буяны үндэсд зориулан өргөсөнд, тугтам баясах тааллаар Түвд орноос үндэслэсэн түмэн насны шидийг оршигч Аюуш бурхан Есүтийн авшиг соёрхолыг төдийд шавь нарт дэлгэр хайрлаад Түвдээс залж ирсэн олон адистэдтийг оршуулан залж өөрийн тухайд лаврин дацан болгосонд ойрхи зах нийлсэн нутгийн үлэмж бишрэлт засаг Урбилгэн хөрөнгөтэй ард дөчин өрхийг өргөсний отог даргаар өглөгийн эзэн ихэс ноёд өөр өөрийн тухайн албат нараас өрх ам олон тоотойг энэ дацангийн шавь болгон өргөхөд удалгүй шар, хар шавь нар нэн нэмэгдэх болсонд уг хийдийн гол сүм эфо ба дацангийн нэгэн хос дацан хурал байгуулахыгтаалан язгуурын нутаг орноо Ямандагийн егүзэри хэмээн алдаршсан номч лам Дашнамжилаар дацан хурлын тэргүүн лам болгоон болгоод Богд Зонхова⁴³ ламын чога лугаа барилдсан Ямандаг⁴⁴ гагц баатраар эрхэмлэн нууц тарнийн дацангийн тиг дэглэм тэргүүлэн нэгэн хос адил болгож, Булган уулын өвөрт дацан байгуулж хурдаг хурал энэ дацанд дөрвөн цагт Минтүг, Аюуш, Дүйнхор¹⁵, Манлын, зуны эхэн сард Аюушийн санчога, дүвчид, өвлийн дунд сард Даншигийн хангал, сар бүрийн шинийн найман, арвантаван, битүүн нарт их дүйцэн өдөр бүрийн жасаа хурал номын сургууль тогтоон дагажээ.

Сандуй дацангийн⁴⁶ тогтсон эх товч нь, Өндөр дүр арван нэгэн сүүдрийн үед Загдзүсэм хаан цогт санвийн түйгийн зан үйлийн⁴⁷ хувь хурал гүйцэд нэгийг тогтоохыг таалан их сүм байгуулсанд, Хөндлөн цөхүр бэйл хоёр зуун өрх хүмүүн өргөсний доторх хуврагуудыг Сандуйн чога цүглүүлж, бас бус их ноёдуудын шавь нарыг ч мөн сургуульд судлуулан, нууц гүн тарнийн шашны

эхийг тогтоожээ хэмээсэн ба арван есөн насан сүүдрийн үед Түвд орноо заларч өргөл мөргөлийг үйлдэн хоёр Богдын⁴⁸ номлол сонссоныг ихэд хүртсэн хийгээд ялангуяа Далай ламын гэгээнээс их санваарыг дэвшиж олон номыг сонсохуйд өөрийн оронд эргэсэнд, Сандуйн зан үйлийн хурлыг шинэ тогтоохын тулд дацан нэгийг байгуулах санаа буй билээ. Дацанд нэр, шүтээний эрхэм тэргүүтнийг айлтгалтай хэмээсэнд дацангийн нэрийг Ганданпунцаглин, шүтээний өргөн эрхэн хэр хүчин энэ пүрэв ялангуяа хайрлан, Гомбо⁴⁹ тэргүүтэн чойжингуудын гансод шамдваас сайн хэмээн айлтгажээ. Тэндээс гучин найман сүүдрийн Шороон хонин жил(1679он)-д Халх орноо нутагтаан заларч ирэхэд, өвлийн сүүл сарын шинийн гуравны өдөрт өөрийн хийддээ залраад, урьдахь дуганд Ганданпунцаглин хэмээх нэрийг алдаршуулан адистад пүрэв шүтээн ялангуяа шүтээний эрхэнд оршуулж, урьдын хурал дээр Далай ламын соёрхсон уншлагын зүйлийг нэмж өдгөө хүртэл улам ихэд дэлгэн дэлгэрүүлсэн баялаг Ганданпунцаглин дацан Ринбүчийн тогтоосон ёс хийгээд дөрвөн цагийн хурал ба үргэлжийн жасаа уншлага хурлын дэглэм ямар мэт бичгийг байгуул хэмээн айлдсанаар, энэ дүрийн тавин хоёр сүүдэр Түгээмэл Элбэгтийн тавдугаар он, Модон туулай жил(1855 он)-д бичигт байгуулав хэмээжээ.

Булган уулын өвөрт дацан байгуулж энэ дацанд дөрвөн цагт сандуйн чога, зуны эхэн сард сацог дүвчид, өвлийн дунд сард даншагийн хангал, сар бүрийн арван таванд их дүйцэн өдөр бүрийн жасаа хурал, мөн энэ дацангийн Ямандагийн сүмд дөрвөн цагт Дагжүг дүвчид, өдөр бүрийн жасаа хурал номын сургууль тогтоон дагажээ.

Гүнрэг дацангийн тогтсон эх нь, Сэрагийн бүжгээр цэнгэгч гэгээний хувилгаан дүр Лувсанпринлэйбалсанбо хэмээн алдаршсаны тавин таван сүүдрийн үе Энх-Амгалангийн гучин дөрөвдүгээр он Гал хулгана жил(1695 он)-ийн сага сарын хорин тавнаа ловон, цорж нар тэргүүлэн хорин таван шаеь нарт Дэмчог лхавангийн дөрвөн ванг төгсгөн хайрласнаас үүссэн Далай Манзушири хутагт өөрийн бие ба бүрэн эдлэл бурсан хуврагуудын аймагхэрэгслэл сэлтийг бодь мөрийн угд зориулан өргөсөн нь Богд гэгээн тусгайлан тогтоож Дэмчог дацан шинэ байгуулсны дээр Булган уулын өвөрт Гүнриг дацанг тогтоож байгуулжээ. Энэ дацанд дөрвөн цагт гүнригийн чога, зуны эхэн сард сачогдүвчид,

өвлийн дунд сард даншогийн хангал, хаврын адаг сард Ганжуур, сар бүрийн гурван дүйцэн өдөр бүрийн жасаа, мөн энэ дацангийн Очирваанийн сүмд дөрвөн цагт Очирваанийн чога, Манла, сар бүрийн дүйцэн өдөр бүрийн жасаа хурал номын сургууль тогтоон дагажээ.

Дэмчог дацангийн⁵⁰ тогтсон эх, эл Сэрагийн бүжгээр цэнгэгч анхны хувилгаан гэгээн Лувсанпринлэйбалсанбо гэвш тавин таван сүүдрийн үед Энх-Амгалангийн гучин дөрвөн он Гал хулгана жил(1696 он)-ийн сага сарын хорин дөрвөн ба тавны дагинас чуулах их дүйцэнг тохиолдуулан тухайд шавийн ловон цорж нар тэргүүлэн хорин таван шавь нарт дэмчог лхавангийн дөрвөн ванг огоот хайрласанд өгүүлш, сэтгэшгүй үйлсийн гэрэл огторгуй мэт дэлгэрэхийн дэмбэрэл үүсэн, Далай Манзушири хутагт өөрийн бие ба бүрэн эдлэл бурсан хуврагийн аймаг хэрэгслэл сэлтийг бодь мөрийн угд зориулан өргөснийг Богд гэгээн тугдамаар тэдгээр өргөлийг самшаал үгүй тусгайлан Дэмчогийн үндэсний дацанг шинэтогтоох соёрхлыг айлдан, шашин амьтны тусд таалан, Булган уулын өвөрт дацан байгуулж, тогтсон хурал нь дөрвөн цагт Дэмчиглханайгийн чога, сар бүрийн арван, хоринтаван бүрт их дүйцэн, өвлийн адаг сар, зуны адаг сард их дүйчид, сар бүр сахиус дүйцэн, бас Майдарын чога дэлгэр бол өвлийн дунд сард даншогийн хангал, өдөр бүрийн жасаа, мөн энэ дацангийн хамтат Нэйжийн сүм хэмээгчид дөрвөн цагт Манла нэйжийн ерөөл¹зул аль дэлгэрээр хурдаг. Хаврын дунд сарын шинийн нэгнээс арвантаван хүртэл Чоймпрүлийн дэлгэр их тахил, сар бүрийн шинийн найман, арван таван, битүүнд, дүйцэн өдөр бүр жасаа хурал номын сургууль чуулж тогтон дагажээ.

Мөн энэ дацангийн зуны хуй хэмээх анх дугаар дүр Лузсанпринлэй хөдөө ордонд хурж байсан хурал хэв ёсоорын дээр тухай дацангийн сахиулс нарыг тайдаг хурал голын дэнж дээр дуган барьж суурьшсан өдөр бүрийн жасаа хурал тасралтгүй сэлтэс хурал ном сургууль тогтоон дагажээ.

Эл ёсоор харьяат шавийн доторхи дацан бүрт зуны цаг хөдөө газруудад хурдаг хуй хурал дуган нээлгээд буй.

Мөн Дэмчог дацангийн аймагт Хануйн Рашаантын Хужирт⁵¹ хэмээх газарт анхдугаар дур Лувсанпринлэйн мэндэлсэн газарт байгуулсан сүм цагийн тахил дэлгэр хурал тогтож буй.

Жанрайсэг дацангийн тогтсон эх товч нь, хоёрдугаар гэгээн

дүр шажны эзэн Лувсанвадаггэлэгнамжилбалсанбо урьдахь шажны үргэлжлэлийг улам дээшид дэлгэрүүлэн тэтгэхийн үед, дээд дүрийн дахин зохиосон Дүвчилшанбан хэмээх уншлагын зан үйлийг тусгайлан хурах тугтамаар нэгэн сүм шинэ байгуулан, хориндөрвөн сүүдрийн эр морин жил (1738он)-д Үй Зангийн зүг заларч, мөн он есдүгээр сард Түвэд орноо хүрээд, Далай лам Галсанжамцын алтан гэгээнээ учирсанд ихэд тонилохын тааллаар сонсол саналын соёрхол сургууль зарлиг олныг соёрхон Сэра хийдэд сууригнах үе дахин өөрийн Халх орноо хийдэд Жанрайсэг дүвчилийн зан үйлийг үүсгэн хурах нэгэн сүм шинэ байгуулсанд нэр айлтгах ба түүнд үргэлжийн унших хурал жасаа эрхэмнэл залж оршуулах шүтээн нэгнийг хайрла хэмээн айлтгаснаар шинэ дацангийн нэр Ганданчоймпэллин үргэлжийн уншлага Доржжигжид, Аюуш, Оточийн зан үйл эхлэн тухайд цогчин манла, цогчин чогагийн гансу тэргүүтэн олон зүйлийн уншлагыг айлдаад, тугдумын шүтээн нь дотроос их адистэдт Бурхан багшийн лим гүнда нэгийг залах шүтээнд хайрласан бөгөөд, гэгээн дүрийн мөн зургаан он сурах судлахыг шамдан судар тарнийн гүн номуудыг сонсож мэргэн хэтэрхий шалгараад хоринесөн сүүдрийн усан гахай жил(1743 он)-д Далай ламаас их санваарыг дэвшиж винайг баригчдын манлай болон, мөн он Үй, Зангаас инагш залран Халх орон хийддээ хүрч ирээд, шинэ тогтсон дацанд адистэдт шүтээн бурхан багшийг залан хуучин Жанрайсэгийн зан үйлийн дээр Жалбаринбүчийн айлдсан үргэлжийн уншлага олон зүйлийг нэмж дацангийн нэрийг Ганданчоймпэллин хэмээн Булган уулын өвөрт дацан байгуулж, энэ дацанд дөрвөн цагт Жанрайсэгийн чога дүвчид, зуны сард сацог дүвчид, өвлийн дунд сард даншогийн хангал, сар бүрийн гурван дүйцэн өдөр бүрийн жасаа хурал номын сургууль тогтоон дагажээ.

Самалу гачэн Шадувпилжайлингийн тогтсон эх нь, Энэтхэг, Түвэдийн орноос эхлэн эрхэм бандидын дүр барьж үргэлжлэн арвандөрвөн үе болсны догроос Ар Халх орноо анхны хувилгаан дүр хойд зүгийн шажныг тодорхойлогч хотол олныг авран итгэл Богд Зая бандидын хоёрдугаар шажны эзэн Лувсанвадаггэлэгнамжилб алсанбогийн гэгээн урьдахь шажны гол ёсыг улмаар дэлгэрүүлэн өөрийн хорин дөрвөн сүүдрийн Шороон морин жил (1738 он) Уй Зангийн орноо эалраад, Далай ламын алтан гэгээнтнээ учирч дотнологдон хайрлагдахын агаараас

Сэра хийдэд сууригнан сурах судлахыг шамдсанаар судар тарнийн ёсонд Шалгадаг Мэргэн алдрыг олсны үед шажны өнө ёсыг дэлгэрүүлэхийн тул Саналу гачангийн дэглэлийг залсугай хэмээн айлтгаж, соёрхол бошог нарийн нягт үүсгэн олоод, шороон эм гахай жил(1743 он)-ийн хорин есөн сүүдэр дээр Халх орон хийддээ залран ирээд, гучин нэгэн сүүдрийн Модон эм үхэр жил (1745 он)-д шар малгайтны шажин өнид оршихын гол ёс Самалу гачангийн дэг дэглэм нарийн нягт байгуулан Булган уулын өвөрт Шадувлилжайлин хэмээх сүм хурал тогтсон болой. Үүнд өвлийн эхэн сард гансо сор цамтай бол хорин хоногийн гүрэмчимо дэлгэр тахил, дөрвөн хоног Дашилхагама энэ мэт хоёр сарын тугдум хурал, сар бүрт гурван дүйцэн өдөр бүрийн жасаа хурал номын сургууль дагажээ.

Дөрөвдүгээр хутагт Лувсанжигмиднамжил⁵² Үй Зангийн газарт заларч сургууль ном сайтар хийгээд эгэж залрахын үед лам Чойжин, жирагчойжин нар жилийн шажин хурлын бат сахисугай гүдамба дуудагтун хэмээн айлдсан бошогийг дагаж, тус бүрийг Гүдамба нарт удирдагч хурал номыг ёсчлон сурч урин залж ирээд хорин дөрвөн сүүдрийн Улаагчин гахай жил(1827 он)-д Булганы өврийн хийдэд тус бүрийн жанран барьж хурал номыг ёсчлон тогтоосон бөлгөө.

Мөн тавдугаар хутагт Гомбожав⁵³ энэ хорин хоёр сүүдэр Шарагчин үхэржил (1889 он)-д Принлэйжамбогийн сахиулсан гэнэтэд Гүдамбад оршсонд Норовлин хийдэд жанран барьж айлтгасан бошог мэтээр хурал номыг ёсчлон тогтоожээ. Мөн энэ дүрийн гучин гурван сүүдэр Цагаагчин хулгана жил(1900 он)-д Хүрээний урьд зүг Тамир голын зах дээр лаврин байгуулж, Богд дээдэс нарын шавдйхад өдөр бүр найдан цогчид дэлгэр, лам цэдэв цогчидтой, ловон Бадамжунайн дүвчид Чилханамригийн цэдүв сэлтсийг тогтоожээ.

Лаврингийн гол их сүмийн шүтээний сүмд дөрвөн цагийн их хурал, сар бүрийн таван өдөрт дүйцэн өдөр бүрийн жасаа хурал бас сар бүрийн цогчид сахиус нарын тахилга тогтоожээ. Мөн лавринд дээд дээд дүр нарын гурван гүдэн, тавдугаар хутагтын гүдэнгүүдийн сүмд сар бүрийн догчид, өдөр бүрийн жасаа хурал тогтоон дагажээ.

Тавдугаар хутагт Гомбожавын арван гурван сүүдрийн цагаагчин луу жил (1904он)-д Далай лам, Банчин богд нарын

эши бошог мэтээр тухайт Булган уулын тахилгын сүм байгуулж, өдөр бүрийн жасаа хурал цаг цагт дэлгэр их дүвчид, Шарагчин үхэр жил (1889 он) Дүйнхор дацан байгуулж, хаврын их дүвчид эхлэн дөрвөн цагийн дүйнхор, өдөр бүрийн жасаа хурал тогтсон нь сүүлд Норовлингийн хийд байгуулсанд тухайт сүм байгуулж, хуучин ёсоор хурал ном сургууль тогтон дагажээ.

Мөн энэ дүрийн дөчин хоёр сүүдрийн Хөхөгчин луу жил⁵⁴(1904 он)-д Манба дацан⁵⁴ байгуулж дөрвөн цагийн хурал, сар бүрийн гурван, дүйцэн өдөр бүрийн жасаа хурал номын сургууль дагажээ. Мөн тэр жилд мянган бурханы сүм байгуулж, сар бүрийн догчид, өдөр бүрийн жасаа хурал номын сургууль дагажээ. Мөн тэр үеэс эхлэн жил бүр Жинжогийн хурал тогтон хуржээ. Мөн тэр дүрийн дөчин хоёр сүүдрийн Харагчин хулгана жил” (1912 он)-д Нүгнэйн сүм⁵⁶ байгуулж, жил бүрийн зуны эхэн сар тутамд нүгнэй, сар бүрийн гурван дүйцэн өдөр бүрийн жасаа хурал тогтон байсан нь тавдугаар хутагт Гомбожавын үеэс өдөр бүрийн мөнх нүгнэй болгон тогтоожээ.

Мөн дөтгөөр хутагтын тавин сүүдрийн шарагчин үхэр жил(1889 он)-д Лхамын сүм⁵⁶ байгуулж өвөл, зуны хоёр цагт лхамын ганду диндүй хоёрыг бүтээж, сар бүрийн гурван дүйцэн өдөр бүрийн жасаа хурал номын сургууль тогтон дагажээ.

Олноо өргөгдсөний есдүгээр он⁵⁷.

Есдүгээр сарын арван долоон.

ЗАЯЫН ГЭГЭЭНИЙ НОМЫН САНД ХАДГАЛАГДАЖ БАЙСАН НОМ СУДРУУДЫН БҮРТГЭЛ

Нинжбадгар

Заяын гэгээний номын санд Түгээмэл элбэгтийн 11-р он буюу 1861 оны байдлаар монгол, тод, түвд, манж, хятад хэлээр бичигдсэн 1288 дэвтэр, 63 боть, 25 судар, 41 дугтуй зохиол бүтээл, 314 ширхэг захидал хадгалагдаж байжээ.

Эдгээр ном судруудыг ангилвал:

1. Шашин номын холбогдолтой “Шашны оршил”, “Шамбалын замын бичиг”, “Алтангэрэл”, “Банзрагч”, “Цагаан шүхэрт”, “Доржзодво”, “Шашны оршил бичиг”, “Цагаан дара эх”, “Хамчунинбо” зэрэг судрууд,
2. Зову атиша, Гэсэр, Ушандар хан хөвгүүн, Чойжид дагина, Милбогд, Марав, Бадамжунай, Зая бандида равжамба, Далай лам, Банчин-Эрдэнэ, Утайн таван үзүүрт алдаршсаны товч намтар, Арьяандэв нарын намтар, Богд Зонховын намтар, Түшээт ханы барьсан Чингисийн цагаан түүхийг хуулж авсан судар, Зарлигаар тогтоосон гадаад Монгол, Хотон аймгийн ван гүнгүүдийн илтгэл шастир, Тогоонтөмөр хааны түүх, Сэнгүр гэгээний барьсан Хөх нуурын гэгээн гүүш хааны түүх, лам Егүзэрийн уг эхийн дэвтэр, Зая бандидагийн шавь Ганжуур номун ханы зохиосон гэгээний бичмэл намтар зэрэг хаад ноёд язгууртнууд, хутагт хувилгаад, лам нарын-намтар, Монголын түүх соёлтой холбоотой зохиол бүтээлүүд.
3. Анагаах ухаан, зурхайн холбогдолтой “Рашаан зүрхэн найман гишүүнт нууц увидасын үндэснээс номлох, номлохын үндэс”, “Эмт усан шинжлэх бичмэл судар”, “16 эгшиг үсгийн үзлэг” зэрэг бүтээлүүд;
4. “Хангайн сан”, “Чингисийн сан тахилгын судар”, “Гэсэрийн сан”, “Долоон одны тахилга”, “Сангийн тахилгын судар” зэрэг сан тахилгын судрууд;
5. Сэра, Гандан, Утай, Занданзуу хийдүүд байгуулагдсан тухай өгүүлсэн намтар түүхүүд;
6. “Эрдэмтний дурьдатгал үг”, “Жинангийн үөийн номлол”,

- “Эрдэмтний дурьдатгал”, “Богд далай ламын айлтгасан сургаалын судар” зэрэг сургаал номлол дурьдатгалууд;
7. Хишиг даллага, сүнс сүлд, зүүдний шинжийг тайлах судрууд;
 8. “Морины холч хурдан ба гүйх үл гүйх сайн муу бэлгэс засал, идэш, ууш тэргүүтнийг шинжлэх таних”, “Морины шинж” зэрэг хурдан морьд шинжих шинжийг хэрхэн танин мэдэх тухай өгүүлсэн судрууд;
 9. “Сувадийн өрөөл”, “Лам Ядамын залбирал” зэрэг ерөөл залбирлууд;
 10. Хятад, монгол, манж, түвд үсгийн толь бичгүүд
 11. Манжийн хаад, Далай лам, Банчинэрдэнэ, Сажабандида, Түвд хаан, Богд гэгээн, богдын засаг лам нараас ирсэн захидал бичгүүд
 12. Аймаг шавиудаас аврал эрэн ирүүлсэн захидал бичгүүд;
 13. Хутагт хувилгаадын дүрийг тодруулах тухай өгүүлсэн захидал бичгүүд;
 14. Заяын гэгээний хүрээний лам нар, шавь, малын тоог гаргасан данс бичгүүд зэрэг Монголын түүх, соёл, шашин суртахуун, аж ахуй, эдийн засагт холбоотой судар ном, баримт бичгүүд хадгалагдаж байсан байжээ.

Заяын номын сангийн ном судруудыг тоолж бүртгэсэн энэхүү данс одоо УННС-ийн монгол гар бичмэлийн хөмрөгт хадгалагдаж байна. Монгол, түвд, манж, хятад хэлээр бичигдсэн эдгээр ховор ном судруудын ихэнх нь он цагийн болон цаг бусын аюулд өртөж үрэгдсэн боловч нилээдийг УННС анх байгуулагдах үеэс Онходын Жамъян зэрэг ном бичгийн хүмүүс сурвалжлан олж, Улсын төв номын санг анх байгуулагдах үеэс удаа дараа татан авчирч сан хөмрөгийг нь баяжуулж байсан юм. Үүнийг бид монгол бичгээс кирилл бичигт хөрвүүлэн анх удаа нийтлүүлж байна.

“Зая бандида хутагтынд одоо буй ном судрын тэмдэглэл данс”
Шүтээний сүмд буй монгол ном нь:

Жоу Адишийн намтар 1, Мидар зогийн намтар 1, Далай ламын намтар 1. Гэсэрийн товч 1, Шамбалын замын бичиг 1, Шашны оршил 1, Чин бишрэлт хир үгүй хотол төгсгөсөн наран гэрэл, хан Манибадар, Ушандар хан хөвгүүн, Чойжид дагина,

Мидар зоги, Тансан лам нарын тууж 1, 1 есөн хэсэг Милбогдын сав шимийн намтар 1, мөн Гүр 1, мөн зурагтай намтар 1 боть, Марвын намтар 1, Гүр Бадамжунайн намтар 1, Тарвачинбо 1, Зуун үйлт судар 1, Молон тойны тууж 1, Аптангэрэл 1, Банзрагч 1, Үлгэрийн далай 1, Жарунгэсүр 1, Заябандида Равжамбын намтар, Мадижадар 1, үнэхээр төрөлт сайн хан, Үлэмж туст чухал хэрэгт эд 1, Гэсэрийн дармал тууж 7н бүлгийн дээр бичиж нэмсэн 2 бүлэг, Гэсэрийн төлгөний судар 1 дэвтэр, хуучин барын Үлгэрийн далай 1 боть, монгол хотон аймгийн шастир 1 боть, Тансан ламын Райчүндоржданбагийн толь хэмээх 1 боть, Арван хоёр давхарлаг хэмээх 3 дэвтэр 1 боть, Утайн 5 үзүүрт уулын 500 бандида хэмээн алдаршсаны товч 1 боть, дармал Доржзодво 1 боть, сонсоод тонилгогчийн судар 1 боть, Тан улсын бичиг хэмээх 24 дэвтэр монголоор хураангуйлан орчуулсан хятад, монгол үсэг хавсарсан дэвтэр 3, манж дэвтэр 3 нэгэн боодолтой, Дайчин улсын Минзүн хуанди богдын сургаал монгол үсгийн 6-р дэвтрээс эхлэн 12-р хүртэл 7 дэвтэр, бас 14, 15, 17, 18, 12, 52, 55-р хүртэл ийм 15 дэвтэр буй амой. Саран хөхөөний дармал тууж 1 баринтагтай, Рэвү Зана намтар хэмээх муутуу цаасан дээр монголоор бичсэн дэвтэр 5, хувилгаан өргөмжилсөн хэмээн нэгэн анги 40 дэвтэр, нэгэн анги 12 дэвтэр буй амой. Мөн үүний боть, жин ван залгаж нэмсэн хууль зүйлийн бичиг хэмээх Монгол үсгийн дэвтэр 1, Түвд хэлт бүгдийн эрхэм гэрэлт хэмээх хэтэрхий гэрэл сацарсан хэмээх монгол үсгийн дэвтэр баруун Хан улсын бичиг хэмээх монгол үсгийн дэвтэр 1, Хан улс хэмээсэн эш сүүл үгүй болсон дөтгөөр хэмээсэн дэвтэр 1, Ложин горлоо хүрдэний судар 1, рашааны зүрхэн 8-н гишүүнт нууц увидасын үндэснээс номлохын үндэс хэмээх эмийн судар 1, 16 эгшиг үсгийн үзлэг хэмээх зурхайн бололтой судар 1, 7 одон нугуудыг тайх судар 1, 3-н богд лам эрдэнэ бурхан бодисад нарын лам иогийн судар 1, хангайн сангийн судар 1, богд далай ламын айлдсан сургаалийн судар 1, чулууг тоолох ёсны судар 1, бас хүрдний лаян 1, Сувадид төрөхийн ерөөл 1, морин чимэг хэмээсэн судар 1, Чингисийн сан тахилын судар 1, ганжуур дуудах судар 1, Логдонгапсангийн судар 1, эрдэмтний дуртгалын үг хэмээх судар 1, сүнс дуудах судар 1, усан билгийн тайлбар хэмээх судар 1.1, Аюушийн судар 1, Цагаан шүхэрт 1, Сангийн судар эд 1 баринтагтай, хааны бичсэн уулын бичгийн оршил хэмээх монгол үсгийн дэвтэр, Чойда чинбо хэмээх

Балданбарайвун, Сэра хийдийн гандан хийд байгуулан тогтсоны монгол үсгээр бичсэн дэвтэр 8, Жову туужаас буй 7 дэвтэр бөгөөд дутууг гүйцээсэн үгүй хэмээн бичсэн монгол үсгийн дэвтэр 7, Даяг бичиг хэмээсэн тууж монгол үсгийн дэвтэр буйг 11 бөгөөд бусдыг дутуу хэмээжээ. Тан улсын хөх мандарва хэмээх түүх 7-оос эхлэн 10-р бүлэг хүртэл буй бөгөөд бусдыг дутуу хэмээсэн буй амой.

Мөн сүмийн баруун шүүгээнд буй ном нь:

Хангай доржиг хэмээх судар 1, Манзушрийн таалапын толь хэмээх үзлэгийн судар 1, Ногоон дара эхийн судар 1, эд 1 баринтагай, Жоу адишагийн судар 1, Мидари зогийн судар 1, морины сэтэр татах, хишиг дуудах судар 1, Дэмбэрэлжоннай-ийн сахиусны судар 1, ялгуусан оюутын судар 1, гүвэдийн дохионы шастир 1, зурхайн хэрэгтэй бололтой хэмээсэн судар 1, төгс гурван санваарт чандмань даян хэмээх судар 2, өлзий хутаг ерөөлийн хаан Гүнрэг жинангийн үгийн нийтийн номлол, лам Ядамын залбирал судар 1.1, хангайн сан бодьсад норсан хийгээд охин тэнгэр харилцан өгүүлсэн хэмээх судрууд 1.1, баатар шастир 34-ийн үлэгдэл хар малгайт Доёд очир бээр зохиосон төрөл үес, наадмын судар 1, Норсан хааны намтар хэдэн анги орчуулсан судрууд хэмээсэн 1 боодол, Лхачингомборавсалын залбирал 3 хэсэг, үзэсгэлэнт эрдэнийн эрхэс хэмээгдэх намтар их зорилго судар хэмээсэн судар 1, Гэсэрийн сан Заябандида бээр равжамбын тууж тод монгол үсгийн тууж 1, Цэрэнгансурын намтар, Шамбалын ламрингийн судар, алтаар бичсэн уншлага, бизъяа цагаан суварганы гарчиг, Дашдондовын судар 1.1, Ногоон дара эх 8, утай зандан зуугийн намтарууд, Доржзодовын судар, эмийн судар бололтой 3 хэсэг судар хамт 1 баринтагай, Аву нонлин хэмээх дан манж үсгийн дэвтэр 14, Санжил хэ хэмээх дан манж үсгийн дэвтэр 1, гүрний хэмээсэн дан манж үсгийн дэвтэр 5, хүйтэн уулын хулгай нарын ангийн тууж монгол үсгийн 24 дэвтэр, 1 боодолтой, ямар ном болохыг нь үл мэдсэн манж үсгийн сул дэвтэр.

Түгээмэл Элбэгтийн 11-р онд дэргэдэх тууж түүх, аливаа данс бичгийг товчлон томилсны данс болой.

Лабрангийн дотоод монгол номыг тоо бичигт байгуулсан нь.

Ум сайн амгапан болтугай.

Хоёр чуулганы ёсны их сангаас гарсан, хотолтан түгээмэл

айлдахуй эрдмийн гэрэл бадарсан хурц самбаа увдисыг өгүүлэхүй хэлний эрхэт Хутагт гэтэлгэгч Манзушри дор бишрэн мөргөмүү.

Байшингийн дотор жагсааж оршоосон намтар үлгэрүүд, тоолсон бурхан гүр Бадам самбуу тэрүүнтэн, тодорхой хувилгаан ридитэний явдлын домог, Энэтхэг, Түвд, Хятад, Монгол тэргүүтэн тоолшгүй олны дотроос Монголоор орчуулсан хэвийн дармал ба хэсэг аймгаар ботилж бичсэнийг тойм гарчигт байгуулсан нь:

Шинэ барын үлгэрийн далай 1 боть, хуучин барын үлгэрийн далай 1 боть Бадамхатан дармал 1 боть, манийн гамбо дармал 1 боть, Пачой, Пүчой хэмээх Жоу адиша, Борон домбийн намтар бичмэл

Бачойринбум дармал 1 боть, Богд Зонхувагийн дармал дэлгэр намтар 1 боть, богд Милийн намтар дармал 1 боть, богд Милийн зурагтай намтар бичмэл 1 боть, алтаар бичсэн судар 1 бээжин/ийн цагаан суварганы дармал эвхмэл гарчиг 1, найман гзгээний дармал судар 1, Хутагт өлзий хутагийн дармал судар 1, ногоон дарь эхийн дармал судар 8, хоньсам бодьсад 2 дарь эх, Богд Зонхавын хураангуй бичмэл намтар, Жоу адишагийн бичмэл намтар 1, Мидарзогийн гадаад дотоод нууц гуравын тууж бичмэл 1 боть, суварга босгохын тус эрдмийг номлосон 2, сайн галавын судар 1, дармал тарбачинбо 1 боть, бичмэл 100 үйлт хэмээх судар 1 боть, дармал жуши 1 боть, дармал саран хөхөөний тууж 1 боть, дармал Сажайлагшид 1 боть, мэргэн ламын сүм бумын 5 боть, марба ложойгийн сайн бичигтэй намтар 1 боть, марба Ложойгийн намтар 1 боть, Райчун дорж дамба бичмэл намтар 1 боть, Ванчин богдын дэлгэр дармал намтар 1 боть, богдын бичмэл дундаж намтар 1 боть, Хутагт Үшэнихи бизъяа хэмээх хар цаасан дээр бичмэл 1 боть, түүний шавь ганжуур номун хааны зохиосон гэгээний бичмэл намтар 1 боть, дарь эхийн бичмэл хураангуй тууж 1, цагаан дарь эхийн бичмэл тууж 1, арлугагийн бичмэл намтар 1, эмт усан шинжлэх бичмэл судар 1, Лянхуа нэрт хан хөвгөний бичмэл тууж 1, цагаан бор хулганы дамжин хэмээх судар 1, Жиранг гашурийн бичмэл намтар 1 боть, Шамбалын замын бичиг 1, Утайн дармал намтар 1 боть, Доржзодво 1 боть, Занданзуугийн бичмэл намтар 1 боть, бичмэл өлзий хутагийн судар 1, хутагт Римандагийн судар 1, ерөөлийн хаан 1, Зн санваартны чандманийн даяг хэмээх судар 2, морины сэтэр татах хийгээд хишиг дуудах судар 2, зурхайн хэрэгтэй

боллолтой судар 1, морин эрдэнийн бэлгэс унуулагч мэргэн товч хэмээх шастир 1, морины холч хурдан ба гүйх үл гүйх сайн муу ер бэлгэс засал идэш ууш тэргүүтнийг шинжлэх таних хэмээх судар 1, хутагт Римандагийн судар 1, Түвдийн дохионы шастир Самдог хэмээх 1, Дэмбэрэл зүүх сахиус 1, ялгуусан оюут хэмээх 1, дармал гүнгрэгийн судар 1, бичмэл Чимайжүд 1, Жинангийн үеийн номлол 1, лам Ядамын залбирал 1, бичмэл Хамчүнинбо 1, маанийн төлгө 1, сангийн тахилын судар 1, хаш хуурцаг хэмээх үзэл 1, Зүрхэн тольт хэмээх монгол үсэг 1, Манзушрийн тааллын толь хэмээх 1 боть, дармал ногоон дара эх 1, зандан зуугийн домог 1, бичмэл галиг үсэг 1, долоон одны тахилга 1, цагаан бурханы сан 1, Чингэсийн сан тахип 1, цагаан шүхэрт 1, богд далай ламын дутуу сургаал 1, усан балингийн тайлбар 1, морины чимэг хэмээх судар 1, Гурван богд ламын зохиол хэмээх судар 1, цагаан бурханы судар 1, Сувадийн ерөөп 1, зүүдний шинж 1, нэгэн жилийн гайны чулууг тоолох судар 1, хангайн сан 1, ганзага дуудах судар 1, хүрдний паян 1, газрын шинж 1, сүнс дуудах судар 1, бэрийн зурхайн судар 1, бас нэгэн үзлийн судар 1, эрдэмтний дуртгал 16, эгшиг үсгийн үзлэгийн судар 1, дармал молон тойны тууж 1 боть, бичмэл сонсоод тонилгогч 1 боть, бичмэл Далай ламын дүрийн намтар 1 боть, Сүмбэхамбын сүмбум дэх гэсэрийн товч явдал, Шамбалын зам үйзангийн газрын байдлыг өгүүлсэн бичиг 1, шарын шашны оршил бичиг 1 боть, чин бишрэлт хааны тууж 1 боть, хир үгүй хотол төгсгөсөн хан хөвгүүний тууж 1, наран гэрэлт дагинын тууж 1, эндүүрэлт хан хөвгүүний тууж 1, манибадар хан хөвгүүний тууж 1, ушандра хан хөвгүүний тууж 1, утайн намтар 1, мидар зогийн намтар 1, тансан ламын төрсөн үеийн цадиг 1, чойжид дагинын тууж 1, энэхүү туужийн адил өргөн муутуу цааснаа бичсэн 1 боть, сайшаалтай хааны явдал бичмэл 1 боть, шидэт хүүрийн бичмэл тууж 1 боть, Галдан жононгийн үйлдсэн бичмэл түүхийн гарчиг, ноёд лам нарын уг зхийн бичиг 1 боть, бичмэл чодин жирангэсурийн намтар, үнэхээр төрөлхтөн сайн хааны тууж, үлэмж туст чухал хэрэгт хэмээх судар, равжамба заябандидын намтар Миди жидар хийгээд Арьяандэв нарын намтар, эд 1 боть, бичмэл жи дияан хуушингийн тууж 1 боть, түшээт ханы Чингэсийн цагаан түүхийг хуулж авсан судар 1 боть, тансан ламын тууж 5 боть, жи дияан хуушааны тууж 2 боть, бичмэл хувилгаан өргөмжилсөн хэмээх Ли

улсын тууж 5 боть, жүн овогт хувилгаан дагинын тууж 3 боть, 7 улс хэмээх бичмэл тууж 1 боть, баруун хан улсын тууж 2 боть, бичмэл сан гурван улсын бичиг 6 боть, Хөх хотын түмэд орчуулгатай бичмэл сан 3 улсын бичиг 6 боть, гэсэрийн дармал тууж 1 боть, гэсэрийн хуучин цаасны бичмэл тууж 1 боть, олон улсын бичмэл түүх. 5 боть, Хүй хэмээх хүйтэн уулын хулгайч нарын анги 3 боть, бичмэл 5т саран хэмээх тууж 2 боть, хятад судраас орчуулсан тууж 3 боть, ШиҮЧиүфа-ны шийтгэсэн хэргийн тогтоол хэмээх тууж 2 боть, ли-си-ан шийтгэсэн хэргийн тогтоол, Зао гүнгийн хувилгаан аргаар төр улсын самуун шилмүүг ялган шийтгэсэн түүх, ЗиТап га хэмээх 18 мужийн газар орон ба, хот хаалга газрын хол ойрыг жагсаан бичсэн боть, бичмэл Хи Вап 1 боть, зарлигаар тогтоосон гадаад монгол хотон аймгийн ван гүнгөдийн илтгэл шастирын 4 боть, бичмэл Гинпансима хэмээх бичиг 6 боть, дэргэдэх манж Сайшаалт ерөөлтийн шийтгэсэн хэргийн бичиг 20 дугтуй, үүний дугтуй нь цөм шар, засаг Пэлжээгийн хошууны гэлэн ламын барьсан 3 хэлний толь бичиг 11 дэвтэр, дэргэдэх манж үсгийн Хи (еп д!уап зургаан дугтуй, 37 дэвтэр.үүний дугтуй нь цөм хөх, дэргэдэх хөх хотын ширээт гэгээнтэний барьсан манж үсгийн сан хи дугтуй, 24 дэвтэр, үүний дугтуй нь хөх, дэргэдэх манж тэнгэрийн тэтгэсний хэргийн бичиг 20 дугтуй 149 дэвтэр, үүний дугтуй цөм хөх, Донбома 1 дэвтэр, модон хавтастай, Равла бололтой судар 1 дэвтэр, манж дэвтэр 3, дөрвөн хэлний толь бичгийн гарчиг 1 дэвтэр, бусад 8 дэвтэр ийнхүү 9 дэвтэр бүрэн гүйцэд нэг цоохор даавуун дугтуйтай, дангаар манж хэлний 2 дэвтэр нэгэн улаан ямбуу боодолтой, дэргэдэх монгол олон улсын бичиг 4 дугтуй, 20 дэвтэр, үүний дугтуй хар хөх болоод өргөн дөрвөлжин буй, дэргэдэх монгол хэмээх тууж 8 дугтуй 50 дэвтэр, үүний дугтуй багашиг болоод цөм хөх, дэргэдэх монгол тууж 8 дугтуй 29 дэвтэр, үүний дугтуй багашиг бөгөөд цөм хөх, дэргэдэх 1-р зурхайн монгол үсгийн 9 дэвтэр 1 дугтуй, дэргэдэх 2-р зурхайн монгол үсгийн 6 дэвтэр 1 дугтуй, дэргэдэх оросоос ирсэн сав шим ертөнцийн тогтсоны ёс оросийлсэн монгол үсгийн дэвтэр 1, буулган авсан тууж орчуулгатай 11 дэвтэр 1 боодол, Тансан ламын тууж хуучирсан цаасны 34 дэвтэр 1 их боодол, бичүүлэн авсан Ли дигип-и тууж 40 дэвтэр 1 боодол (хи хэмээх хүйтэн уулын хулгай нарын анги тууж 2 дэвтрийн 1 нь дутуу, бусад 24 дэвтэр 1 боодолтой, Хөх хотын ширээт гэгээнтнээс ирсэн тууж 10

дэвтэр 1 боодол, Тогоонтөмөр хааны түүх 7 дэвтэр 1 боодол, Ли улсын туужийн дутуу 7 дэвтэр үүнийг бичүүлж эхлээд 3 дэвтэр тууж, энэ нь Сайшаалтай хаан мөн, Ли улсын тууж 3 дэвтэр, дэргэдэх тууж 1 дэвтэр, морины шинж 1 дэвтэр, Сэнгүр гэгээний барьсан Хөх нуурын гэгээн гүүш хааны түүх 2 дэвтэр, манж монгол үсгээр хавсран тайлсан бичиг 1 дугтуй 4 дэвтэр, үүний дугтуй хөх, сэмбэргэсүмийн намтар 2 дэвтэр, Галданжинонгийн барьсан сав шим тогтсоны учир 1 дэвтэр, Сэнгүвийн хуварын маяг 1 дэвтэр, эдийг зосоор будсан бяцхан модон самбартай, гэсэрийн дармал төлөг судар 1, алтан хээтэй самбартай, 10 -р оны шавь, 7 дацангийн өргөсөн чуулганы данс 8 дэвтэр, бичмэл дэвтэр 6, 7, 8, 9, 10, 11, 12, 14, 15, 16, 18, 19, 21, 22, 24 ийм 18 дэвтэр буй 1 боодол.

3 а\ хэмээх бичмэл дэвтэр 3, 4, 5, 6, 13, 16, 18, 25, 28, 31, 34 ийм 11 дэвтэр 1 боодол, ном судар.

ДЭЭД ХҮРЭЭН ДЭХЬ ЛАВРИНГИЙН БИЧГҮҮД НЬ

Шар үсгийн бичиг, Далай лам, Банчин богд, Сажа бандида, Түвдийн хан, Богдын засаг лам нараас ирсэн бичгүүд 1 боодол, зуу, Амдуугийн лам нараас ирсэн бичгүүд хамт буй. Сэраас ирсэн бичгүүд 1 боодол, номын товъёог 1, дээр нэмсэн зураг зурах бичиг, шүтээний бололтой бичиг 1, намшигийн бичиг, эдгээр шар үсгийн бичгүүд цөм нэг их боодолтой.

Тангуд үсгийн бичгүүд: 7-н дацангийн хурлын шавь нарын нэрс 1 боодол, сан, жас, нирчан, дивүдийн сүргийн данс 1 боодол,

Монгол үсгийн бичгүүд нь: Аливаа хийгээд ноён лам нар ба, газар бүрээс ирсэн хуучин оны захидлууд 1 их боодол, Мингүр хааны түүх, цэцэн вангийн уг эхийн дэвтэр, Тэнгэрийг тэтгэсний 57-р оны бүгд шавь нарын цагаан бүртгэлийн дэвтэр 1, Сайшаалт ерөөлтийн 17-р оны цагаан бүртгэлийн хагас дэвтэр 1, Төр Гэрэлтийн тэргүүн оны жи, гүшүг, гүнрэг, дамцог, жасрай таван дацангийн цагаан бүртгэлийн дэвтэр 5, Төр Гэрэлтийн, Түгээмэл Элбэгтийн онуудад суудлын дэвтэр 13, 11-р онд Дундад яамны өргөөг шинэтгэхэд ирүүлсэн ягаан дэвтэр 1, Түгээмэл Элбэгтийн онуудад шинийн амгаланд бараалхуулах бэлэг ирүүлэх хийгээд ноёдын цол нэрийг бичсэн дэвтэр, шүтээний галч нарын дэвтэр 5, хуучин хуримын хуудас, хуучин онуудын хэрэг дуусгасан аар саар хуудас 1 боодол, хэрэг дууссан хуанли 3, Тэнгэрийн тэтгэсний улаан шугамын бичиг, Төр Гэрэлтийн 11-р онд дархан сүргээс аймгийн элчид улаа шүүс хэрэглэхгүйгээр да нараас тушаасан улаан шугамын бичиг, Түгээмэл Элбэгтийн тэргүүн оноос хойш 8-р он хүртэл дархан сүргүүдийн бүртгэн тоолсон хуудас дэвтэр. Түгээмэл Элбэгтийн тэргүүн оноос 10-р он хүртэл гэгээнтнээ даншиг мандлын наадам, Богдын даншигийн наадам эдний бөхийн онооны дансыг өргөсөн 20 дэвтэр, бөхийн ангийн хуудас 5, Түгээмэл элбэгтийн тэргүүн оноос 10-р он хүртэл сан, жас, нирзан, дивүүдийн сүргийн тооны данс 1 боодол, бас Төр

Гэрэлтийн сан, жас, нирзан, дивүүдийн сүргийн тооны данс, Төр Гэрэлтийн түгээмэл элбэгтийн онуудын дивүүдийн сүргийн тангуд үсгийн данс 1 боодол, Төр Гэрэлт, Түгээмэл Элбэгтийн онуудад гэгээнтнийг Утай гүмбэн, Бээжинд залрахад өргөсөн бэлгийн дансны дэвтрүүд, хожайн сүмийн зүйлийн бичиг, цолтон хийгээд суудлын бичиг, Түгээмэл элбэгтийн оны хурдан морины анги, хэрэг дуусгасны хуанли 5, Тогоонтөмөр хааны манж дэвтэр 2, гэгээн шавдангийн тухай баруун сангийн далай лам Банчинэрдэнэ эхлэн олон мэргэдээс аврал айлтгасныг хариу эрхэм хэрэгтэй шар үсгийн бичиг, бас гэгээнтний хувилгааныг тодруулах тухайд Банчинбогд эхлэн Зуугийн мэргэдэд аймаг шавиас аврал эрсэн бичгүүд чойжин, равжамба лам нарын учир бичиг, Хуандийн зарлиг шар бичгийн хуулга 1, Ноёдын түүх дугариг дөрвөлжин зураг дэвтрүүд, сүрэг адууны тухай Хөх хотын хамт мэдэгч яаманд явуулсан бичиг 1, харьяат газраас да-д мэдүүлсний хуулга 1, ил хуудас 1, гэгээнтний эцэг гүнгийн хамжлага буюу сумын эрийн улаач шугамын амбан сайн ноёнтноос бариулсан хуудас 1, 9-р оны хавар цаг да-гаас цэрэг боловсруулах учир бариулсан хуулга, лам Егүзэрийн уг эхийн дэвтэр 1, Жавзундамбаас Банчинбогдод айлтгуулсан ба хариу ирсэн зүйлийн дэвтэр 1, баруун санд гэгээнтээ шавдангийн тухай айлтгуулсны хуудас, хуучин дууны бичиг 1, цэргийн ном 3 дэвтэр, дээд дүрийг ирэх тухай Үй жанжны газраас уламжлан айлтгасан хэргийн манж үсгийн дэвтэр, намсиг нүнжийн дэвтэр 1, жасын бодлогын хуудас, хожай-н сүмийн бичиг, ойрын онд гадагш явуулсан жасааны дис, Баруун зуу, Гүмбум, Утай, Бээжингийн газар усны нэрийг бичиглэсэн дэвтэр 4 хуудас 3, аливаа газраас ирсэн ойрд хэрэг багатай захидал, Баруун сан ба газар бүрээс ирсэн хэрэг багатай сав үсгийн бичиг, Түгээмэл Элбэгтийн 10-р он хүртэл дархан сүргүүдээс татаж зарсан, ирсэн зүйлийн хэрэг багатай аар, саар хуудас 1.

Гэгээнтний өргөсөн захидлууд нь: амбан сэцэн ханаас 3, амбан сайн ноёноос 80, сайн ноён вангаас 12, цэцэн ван Цэдэнбаяр Дарам нараас 31, Жанжидвангаас 11, да бэйл Гончигжаваас 17, говь түшээ гүнгээс 18, хотын Ширээт гэгээнээс

11, Сэнгүр гэгээнээс 15, лам Егүзэрийн хийдээс 10, ван Дарамбазараас 12, ван Доржжав, Дүйнхэржав, Ерэнтэй нараас 15, бэйл Намжилдорж, Сэрбазаржав нараас 18, их Номун дарь ахай, дайчин туслагч нараас 5, бэйс Гунгаадорж, Цэдэвдорж нараас 6, говь гүн Сэдбазараас 5, хожайн сүмийн шавь нар, зангм Базаржав нараас 11, засаг Хажбалаас 6, амбан бэйс, түшээтхан, жанжид ван, да лам, эрдэнэ шанзав нараас ирсэн 19 захидал, эдгээр 20 боодол захидлыг 1 их боодолд агуулав.

Эрхэм эрдэмтэн Нинжбадгар гуайн өөрийн тэмдэглэлээс сийрүүлэн бичсэн болно.

*“Wherever the Buddha’s teachings have flourished,
either in cities or countrysides,
people would gain inconceivable benefits.
The land and people would be enveloped in peace.
The sun and moon will shine clear and bright.
Wind and rain would appear accordingly,
and there will be no disasters.
Nations would be prosperous
and there would be no use for soldiers or weapons.
People would abide by morality and accord with laws.
They would be courteous and humble,
and everyone would be content without injustices.
There would be no thefts or violence.
The strong would not dominate the weak
and everyone would get their fair share.”*

*** THE BUDDHA SPEAKS OF
THE INFINITE LIFE SUTRA OF
ADORNMENT, PURITY, EQUALITY
AND ENLIGHTENMENT OF
THE MAHAYANA SCHOOL***

GREAT VOW
BODHISATTVA EARTH-TREASURY
(BODHISATTVA KSITIGARBHA)

**“ Unless Hells become empty,
I vow not to attain Buddhahood;
Till all have achieved the Ultimate Liberation,
I shall then consider my Enlightenment full !”**

**Bodhisattva Earth-Treasury is
entrusted as the Caretaker of the World until
Buddha Maitreya reincarnates on Earth
in 5.7 billion years.**

**Reciting the Holy Name:
NAMO BODHISATTVA KSITIGARBHA**

**Karma-erasing Mantra:
OM BA LA MO LING TO NING SVAHA**

Taking Refuge with a mind of Bodhichitta

**In the Buddha, the Dharma and the Sangha,
I shall always take refuge
Until the attainment of full awakening.**

**Through the merit of practicing generosity
and other perfections,
May I swiftly accomplish Buddhahood,
And benefit of all sentient beings.**

The Prayers of the Bodhisattvas

**With a wish to awaken all beings,
I shall always go for refuge
To the Buddha, Dharma, and Sangha,
Until I attain full enlightenment.**

**Possessing compassion and wisdom,
Today, in the Buddha's presence,
I sincerely generate
the supreme mind of Bodhichitta
For the benefit of all sentient beings.**

**"As long as space endures,
As long as sentient beings dwell,
Until then, may I too remain
To dispel the miseries of all sentient beings."**

With bad advisors forever left behind,
From paths of evil he departs for eternity,
Soon to see the Buddha of Limitless Light
And perfect Samantabhadra's Supreme Vows.

The supreme and endless blessings
of Samantabhadra's deeds,
I now universally transfer.
May every living being, drowning and adrift,
Soon return to the Pure Land of Limitless Light!

*** The Vows of Samantabhadra ***

I vow that when my life approaches its end,
All obstructions will be swept away;
I will see Amitabha Buddha,
And be born in His Western Pure Land of
Ultimate Bliss and Peace.

When reborn in the Western Pure Land,
I will perfect and completely fulfill
Without exception these Great Vows,
To delight and benefit all beings.

*** The Vows of Samantabhadra Avatamsaka Sutra ***

DEDICATION OF MERIT

May the merit and virtue
accrued from this work
adorn Amitabha Buddha's Pure Land,
repay the four great kindnesses above,
and relieve the suffering of
those on the three paths below.
May those who see or hear of these efforts
generate Bodhi-mind,
spend their lives devoted to the Buddha Dharma,
and finally be reborn together in
the Land of Ultimate Bliss.
Homage to Amita Buddha!

NAMO AMITABHA

南無阿彌陀佛

《外蒙文：蒙古佛教明燈-釋迦尊者 扎雅班智達 羅桑津雷巴桑波 傳記》

財團法人佛陀教育基金會 印贈

台北市杭州南路一段五十五號十一樓

Printed and donated for free distribution by

The Corporate Body of the Buddha Educational Foundation

11F, No. 55, Sec. 1, Hang Chow South Road, Taipei, Taiwan, R.O.C.

Tel: 886-2-23951198 , Fax: 886-2-23913415

Email: overseas@budaedu.org

Website: <http://www.budaedu.org>

Mobile Web: m.budaedu.org

This book is strictly for free distribution, it is not to be sold.

ЗАРЖ БОРЛУУЛАХЫГ ХОРИГ ЛОНО

Printed in Taiwan

3,500 copies; September 2018

MO034 - 16012

